




ГОПОМТ БАНК

Сайн сайхныг санхүүжүүлнэ

ЖИЛИЙН
ТАЙЛАН
2011





АГУУЛГА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ.....	3
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ	7
ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ.....	12
ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ	12
ГАДААД ХУДАЛДАА	14
УЛСЫН ТӨСӨВ.....	15
ИНФЛЯЦИ.....	15
ВАЛЮТЫН ХАНШ.....	18
БАНК САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ	19
БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ.....	21
ХЭТИЙН ЗОРИЛГО, ЭРХЭМ ЗОРИЛГО	21
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ	21
БОДЬ ИНТЕРНЭШНЛ ХХК	22
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ	23
БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	24
УДИРДЛАГЫН БАГ.....	26
ХҮНИЙ НӨӨЦ.....	28
ДЭД БҮТЭЦ.....	30
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ	31
ИРГЭДИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	31
БАЙГУУЛЛАГЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	34
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА	35
САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУД БА ГАДААД ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТ	36
НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	37
САНХҮҮГИЙН ҮР ДҮН, ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ.....	38
САНХҮҮГИЙН ҮР ДҮН.....	38
ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	41
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА БА ХЯНАЛТ	42
КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА	55
БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ	57
САЛБАР СҮЛЖЭЭ.....	59
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	63

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Бид өмнөх амжилтаа бататган нийт активаа 558 тэрбум төгрөг (399 сая ам.доллар)-өөр буюу 35 хувиар өсгөж 2.13 их наяд төгрөг (1.53 тэрбум ам.доллар)-т хүргэв. Нийт хадгаламжийн хэмжээ 40 хувь буюу 523 тэрбум төгрөг (337 сая ам.доллар)-ийн өсөлт гаргаж 1,840 тэрбум төгрөг (1.32 тэрбум ам.доллар)-т хүрсэн нь нийт активын өсөлтийн гол бүрдүүлэгч болж байна.

Д.Баясгалан

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга

Эрхэм хүндэт харилцагчид, хувь нийлүүлэгчид, түнш байгууллагууд, ажиллагсад аа .

Та бүхэндээ банкныхаа тасралтгүй амжилт бүхий түүхийн 17 дахь жил болох 2011 оны үйл ажиллагааны үр дүнг тайлагнаж буйдаа нэн таатай байна.

Эдийн засгаараа дэлхийд тэргүүлэгч томоохон хоёр бүс нутаг хямралын эсрэг шаргуу тэмцэж байгаа билээ. Нэг талаас улс төрийн хоёр намын үзэл сурталд хязгаарлагдсан АНУ ажлын байр бий болгох, алдагдлаа бууруулах гэж чармайж байгаа бол нөгөө талаас Европ зүй зохист бодлого, бүтцийн өөрчлөлт шинэчлэлтээр алдагдлаа нөхөх гэж оролдож байна. 2011 онд эдгээр хөгжингүй эдийн засаг бүхий орнууд эдийн засгийн хямралыг давах гэж чармайж байхад манай жижигхэн Монгол Улсын нэрлэсэн ДНБ-ий өсөлт 28.7 хувь, бодит ДНБ-ий өсөлт 17.3 хувь гарч тогтвортой хөгжил бүхий эдийн засгийн үзүүлэлтээрээ дэлхийд гуравт орох өндөр өсөлтийг үзүүлээ!

Макро эдийн засгийн эерэг үзүүлэлт бүхий энэхүү нөхцөлд Голомт банк санхүүгийн болоод үйл ажиллагааны үр дүнгийн хувьд ололт амжилт бүхий дахин нэг жилийг үдлээ.

Өнгөрөгч 2011 оны эцсээр Голомт банкны анхны охин компаниар 100 сая төгрөгийн өөрийн хөрөнгөтэй Голомт Секюритиз ХХК харилцагчдад үнэт цаас, брокерийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан билээ. Ийнхүү шинээр үүсгэн байгуулсан анхны охин компаниа оруулсан санхүүгийн тайлангаа Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын дагуу банкны болоод группийн хэмжээнд тайлагнаж байна. Голомт Секюритиз ХХК нь шинэ он гарахаас өмнө ямар нэг худалдаа арилжаанд оролцоогүй тул дансны ялгаа маш бага (2.1 их наяд гаруй төгрөгийн нийт активаас ердөө 1.1 сая төгрөг) хэмжээнд бүртгэгдсэн.

Бид өмнөх амжилтаа бататган нийт активаа 558 тэрбум төгрөг (399 сая ам.доллар)-өөр буюу 35 хувиар өсгөж 2.13 их наяд төгрөг (1.53 тэрбум ам.доллар)-т хүргэв. Нийт хадгаламжийн хэмжээ 40 хувь буюу 523 тэрбум төгрөг (337 сая ам.доллар)-ийн өсөлт гаргаж 1,840 тэрбум төгрөг (1.32 тэрбум ам.доллар)-т хүрсэн нь нийт активын өсөлтийн гол бүрдүүлэгч нь болж байна. Монголбанкнаас гаргасан жилийн эцсийн албан ёсны статистик мэдээгээр Голомт банк харилцагчдынхаа хадгаламжийн хэмжээгээр тэргүүн байранд орсон нь дотоодын банкны системдээ хамгийн их итгэл хүлээсэн банк байгаагийн илрэл юм.

Актив талын өсөлт нь тэнцвэрт харьцаагаа хадгалж цэвэр зээл 461 тэрбум төгрөг (330 сая ам.доллар)-өөр буюу 59 хувиар өслөө.



Банк нь Монголын санхүүгийн системд сонгож үйлчлүүлэх тэргүүлэгч банк хэвээр байхын тулд тэнцвэртэй, тогтвортой өсөлттэй байхыг стратегийн хамгийн чухал зүйл болгож ирсэн. Энэхүү гол зорилго нь тайлан тэнцлийн гол гол үзүүлэлтүүдийн тогтвортой өсөлтөөр биелэгдсэн бөгөөд банкны актив 35 хувь, хадгаламж 40 хувь, эрсдэлтэй актив 59 хувиар тус тус өсч Төв Банкны ангиллаар нэгдүгээр зэрэглэлд багтах банкууд дундаа Голомт банкны хөрвөх чадвар хамгийн өндөр, хадгаламж зээлийн харьцаа хамгийн сайн байгаа билээ.

Харилцагчдынхаа итгэл найдварыг хүлээсэн хамгийн их хадгаламжтай шилдэг банкны хувьд бид цаашид ч энэхүү байр сууриа бататган үйлчилгээ, үйл ажиллагаагаа тэргүүн зэрэгт авч явахыг ямагт хичээх болно.

Ашигт ажиллагааны түлхүүр үзүүлэлтийн тухайд хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг өсгөх татварын дараах ашиг 10.2 тэрбум төгрөг (7.3 сая ам.доллар)-өөр өсч 30.2 тэрбум төгрөг (21.7 сая ам.доллар)-т хүрсэн нь 51 хувийн өсөлт бөгөөд энэхүү өсөлт нь тайлан тэнцлийн өсөлтийн үзүүлэлтээс дээгүүр байгаа юм. Үүнтэй уялдаад нэгж хувьцаанд ногдох ашиг 41 хувиар өсч 1,288.8 төгрөгт хүрэв.

Орлогын өсөлтийн гол бүрдүүлэлтэнд 65 хувийн өсөлттэй цэвэр хүүгийн орлого, мөн үйл ажиллагааны цэвэр орлогын 41 хувийг бүрдүүлэгч 101 хувийн өсөлттэй активын бус орлого тус тус нөлөөлсөн. Үйл ажиллагааны зардал 53 хувиар нэмэгдсэн ч (ашгаа нэмэгдүүлэх болон харилцагчийн үйлчилгээг сайжруулах үүднээс мэдээллийн технологи, хүний нөөцөд оруулсан хөрөнгө оруулалт) зах зээлд эзлэх байр сууриа тэлэхийн зэрэгцээ зардал ашгийн харьцаагаа 44 хувиас 37.5 хувь болгож үр дүнтэйгээр бууруулж чадлаа.

Энэхүү эерэг хандлагын эсрэг зээлийн алдагдлын зардал өссөн ба 2010 оны зээлийн төлбөрөөс үүдэлтэй 8.68 тэрбум төгрөгийн зардал 2011 онд бүртгэгдсэн. Эдгээр зардлын ихэнх хэсгийг татвартай холбоотой шүүхийн хэрэг бүхий нэг зээлдэгчид олгосон зээлтэй холбоотой юм. Гэвч банкны хувьд төлбөрийн баталгаа болгож авсан барьцаа хөрөнгө энэхүү зардлыг нөхөхөд хангалттай.

Эрсдэлийн сангийн зардал өндөр байсан хэдий ч оны эцэст чанаргүй зээл 2009 онд 4.4 хувь, 2010 онд 2.1 хувь байснаас буурч 2 хувь болсон. Харин чанаргүй зээлийн багцын эсрэг барьцаалсан барьцаа хөрөнгийн үнэлгээ нь 76.83 тэрбум төгрөг байгаа нь 22.56 тэрбум төгрөг бүхий чанаргүй зээлийн багцын үлдэгдлээс 3.4 дахин их

байгаа бөгөөд мөн чанаргүй зээлийн эрсдэлийн сангаар хамгаалагдсан хувь 2010 онд 70 хувь байснаас өсч 88.64 хувь болжээ.

Ашигт ажиллагааны хувьд сүүлийн хоёр жилд дундаж активын өгөөж 1.7 хувь, дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 26 хувь гарсан нь өөрийн хөрөнгийн 36 хувийн органик өсөлтийн нөлөө юм. Мөн үүнд 2011 оны 6-р сард хийгдсэн Швейцари улсын Swiss-Mo Investment AG компанийн нийт 2,632,551 хувьцаанд оруулсан 25 тэрбум төгрөг (20 сая ам.доллартай тэнцэх)-ийн хөрөнгө оруулалтын нөлөөг тооцох хэрэгтэй. Тус компанийг удирдагч нэрт бизнесмэн, хөрөнгө оруулагч ноён Урс Шварценбах нь Швейцари улс дахь Монгол Улсыг хариуцсан хүндэт консул бөгөөд Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлд нэгдэх бидний урилгыг хүлээн авсан юм. Түүний хамтын ажиллагаа, туслалцаа дэмжлэг, хөрөнгө оруулалт бидэнд чухал ач холбогдолтой билээ.

Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл болон толгой компани болох Бодь Интернэшнл ХХК нь 16 жилийн турш банкны дан ганц хувь нийлүүлэгч байсныхаа дараа 2007 онд анх удаа хувь эзэмшигчдийнхээ бүтцийг шинэчлэхээр шийдэж Кредит Свисс компанийг хүлээн авч хоёрдогч зээлийн хэлбэрээр хөрөнгө оруулалт хийснээр дэлхийд тэргүүлэгч санхүүгийн байгууллага Монголын банкны системд орж ирсэн. Түүний дараа буюу 2010 онд Абу Дабигийн Хөрөнгө Оруулалтын Зөвлөлийг (дэлхийд тэргүүлэгч хөрөнгө оруулалтын сангуудын нэг) төлөөлж Stanhope Хөрөнгө оруулалтын газар мөн хоёрдогч өглөгийн хөрвөх зээллэгийн хэлбэрээр банкинд хөрөнгө оруулсан юм.

Дэлхийд хамгийн өндөр өөрийн хөрөнгийн өгөөж бүхий манай банкны хувь нийлүүлэгчдийн тэлэлт нь Монголын эдийн засгийн хурдацтай хөгжлийн тусгал бөгөөд харилцагчдынхаа зээлийн улам бүр өсч байгаа хэрэгцээнд нийлүүлэх үүднээс хийсэн алхам юм.

Өнгөрөгч оны тайлан тэнцлийн дараахан буюу 2012 оны эхээр бид Нидерландын Trafigura Beheer B.V. байгууллагыг шинэ хувь нийлүүлэгчээр элсүүлж банкны 5.02 хувьтай тэнцэх 21.2 тэрбум төгрөг (тухайн үеийн 15.9 сая ам.доллартай тэнцэх) бүхий 1,300,000 энгийн хувьцааг гаргасан.

Жилийн эцэст нийт хөрөнгийн хэмжээ 189.1 тэрбум төгрөг (135 сая ам.доллар)-т хүрсэн нь 2010 оны сүүлээрх 127.8 тэрбум төгрөг (тухайн үеийн 101.7 сая ам.доллартай тэнцэх)-тэй харьцуулахад 61.3 тэрбум төгрөг буюу

48 хувийн өсөлт үзүүлжээ. Энэ нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцааг 13.3 хувьд (2010 онд 13.5 хувь) хүргэв. Үүний дараа 2012 оны нэгдүгээр улирлын сүүлээр Trafigura Beheer B.V. компани банкны өөрийн хөрөнгөд хөрөнгө оруулснаар нийт өөрийн хөрөнгө 220 тэрбум төгрөг (тухайн үеийн ханшаар 166.8 сая ам.доллар)-т хүрч өссөн ба өөрийн хөрөнгийн 79 хувийг I зэрэглэлийн өөрийн хөрөнгө эзэлж, өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 15 хувь хүртэл өсчээ.

Бид олон улсад тэргүүлэгч бизнесийн байгууллагуудаас хөрөнгө оруулах хүсэлтийг хүлээн авсаар байгаа бөгөөд цаашид ч харилцан ашигтай удаан хугацааны түншлэлийг хөгжүүлэхэд бэлэн байна.

Компанийн засаглалын олон улсын стандартын хүрээнд бид Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудит болон Эрсдэлийн Хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Цалин Урамшуулал, Нэр Дэвшүүлэх Хороог шинээр нэмж байгуулсан юм. Мөн Зээлийн Газрыг шинэчлэн зохион байгуулж зээл олгох, зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг тусгаарласнаар бизнес хөгжлийн болоод эрсдэлийн удирдлагын үүргүүдийг салангид, бие даасан болгосон.

Бүтцийн шинэчлэлт болон бизнесийн тэлэлтийн бас нэг амжилт болж банкны салбар нэгж 18-аар нэмэгдэж 88-д, АТМ-ийн тоо 132-т тус тус хүрч, цахим банкны үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тэлсээр байна.

Харилцагчдынхаа улам бүр өсөн нэмэгдэж буй санхүүгийн эрэлт хэрэгцээг хангаж, чанартай үйлчилгээ үзүүлэх зорилгоор тайлант онд ажилчдынхаа тоог 261-ээр нэмж 1,329-т хүргэсний зэрэгцээ тэдэнд зориулсан мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээ. Түүнчлэн ажилчиддаа өрсөлдөхүйц цалин, гүйцэтгэлд тулгуурласан урамшуулал санал болгохоос гадна Монголд анх удаа Тэтгэврийн Ууган Сан болон Ажилтнуудад Хувьцаа Эзэмшүүлэх Хөтөлбөр хэрэгжүүлж тэдний урт хугацааны ашиг сонирхлыг хангахыг зорьсон болно. Жилийн эцэст олон жил банкиндаа хувь нэмэр оруулсан 41 ажилтан, албан хаагчдаа шинээр хувьцаа эзэмшигч болгосон нь нийт өөрийн хөрөнгийн 0.1 хувь буюу 24,850 хувьцааг эзэлж байна.

Байгууллагынхаа нийгэмд тэргүүлэх байр суурийг хадгалах үүднээс бид банкныхаа орлогын нэлээдгүй хувийг Монгол Улсад хэрэгтэй хөтөлбөрүүд, ядуурлыг бууруулах, эрүүл мэнд болон боловсрол, спортын үйл хэргийг дэмжихэд зарцуулсан.

Мөн дэлхийд нэр хүндтэй санхүүгийн сэтгүүл The Banker, болон Euromoney-аас “Монгол Улсын Шилдэг Банк” шагналыг, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас “Шилдэг Банк” шагнал, цаашилбал 2012 оны эхээр дэлхийд тэргүүлэгч Global Finance сэтгүүлээс “Монгол Улсын Шилдэг Банк” шагналыг тус тус хүртлээ. Эдгээр шагнал урамшууллаас гадна бидний хамгийн том шагнал бол харилцагчдынхаа итгэл найдвараар бизнесээ тэлж, ололт амжилтаа бататгасаар байгаа явдал юм.

Энэ ялдамд Голомт банкныхаа хамт олны өмнөөс хүндэт харилцагч, хамтрагч түншүүддээ бидний үйл ажиллагааг дэмждэгт нь, мөн Монгол Улс дахь бүхий л иргэд харилцагчид, аж ахуйн нэгжүүд, байгууллагуудад манай банкинд итгэл найдвар үзүүлдэгт нь, цаашилбал Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, бусад албан тушаалтнуудын дэмжлэг туслалцаа, удирдлага чиглүүлэгт нь, дөрөвдүгээрт Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд, хүндэт хувь нийлүүлэгчид, Бодь Интернэшнл ХХК, Swiss-Mo Investment AG, Trafigura Beheer B.V. компаниудад чин сэтгэлийн талархал илэрхийлэхийн ялдамд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн болоод Удирдлагын багийнхаа өмнөөс манай банкны одоогийн болоод ирээдүйн амжилт бүтээлийн суурийг тавьсан 1300 гаруй чин сэтгэлтэй, шаргуу хөдөлмөрч ажилтан албан хаагчиддаа талархал илэрхийлье.

Бид 2012 он цаашлаад ирж буй он жилүүдэд Монгол Улс, Монголын ард иргэдэд тохиох олон эерэг үйл явдлуудад итгэл төгс урагшлах болно. Дэлхийн болоод зарим бүс нутгийн эдийн засаг тодорхойгүй төлөв байдалтай байгаа энэ үед бид саад бэрхшээл бүхий өмнөх жилүүдээ ардаа орхиж ашигт малтмалын экспортын өсөлтөөс үүдэлтэй тогтвортой хөгжлийн төлөө Монгол Улсдаа зүтгэх болно.

Монгол Улс дэлхийн хэмжээний ашигт малтмалынхаа нөөцийн олборлолт, үйлдвэрлэлээ эхэлснээр хурдацтай хөгжлийн замдаа орох юм. Гэвч огцом өсөлт бүхий эдийн засгийн эрсдэлийг тооцох ёстой бөгөөд ингэснээр урт хугацааны санхүүгийн тогтвортой хөгжилдөө хүрч чадна. Энэ нь өнөөгийн эрх баригчдад Монголын ард түмний хөгжлийн бат суурийг тавихад зөв шийдвэр гаргаж, аливаа эрсдэл, тогтворгүй байдлаас хамгаалах хүндхэн хариуцлагыг ноогдуулж байгаа хэрэг юм.

2012 он Монгол Улс болоод Монголын ард иргэдэд хоёр томоохон үйл явдал бүхий онцгой жил юм. Нэгдүгээрт, зургадугаар сард болох Улсын Их Хурлын сонгууль, хоёрдугаарт Оюу Толгой ордын алт, зэс, мөнгөний ашигт малтмалын төслийн үйлдвэрлэл эхлэх юм. Учир



нь энэхүү хоёр үйл явдал цаашдын эдийн засгийн өсөлт, экспортын болон бусад бүх боломжит өсөлтөд нөлөө үзүүлнэ. Мөн анх удаа манай Засгийн Газарт уян хатан санхүүгийн бодлого, орлогын тэлсэн зардлыг зохицуулах боломж олдож байгаа билээ. Тиймээс Монгол Улсын Засгийн Газар, эрх баригчид ирж буй жилүүдэд энэхүү хурдтай өөрчлөлт шинэчлэлд хэрхэн хурдан дасан зохицох, ашигт малтмалынхаа үр ашгийг тогтвортой хөгжлийн суурь болгоход зүй зохистой алхам хийх зэрэгт ард иргэдийнхээ өмнө хариуцлагатай үүргийг үүрч байгаа юм.

Голомт банкны хамт олон энэхүү хувьсал бүхий эдийн засгийн нөхцөлд үндэсний бүтээмжийг нэмэгдүүлэх, урт хугацаанд ашигтай байх зөв бодлого баримтлах, хамгийн ашигтай санхүүгийн сонголт хийхэд бүхий л харилцагч иргэд, байгууллага болон Засгийн Газраа дэмжихэд бэлэн байна.

Монголдоо анхаарлаа хандуулах байдлыг гол зарчмаа болгож, ингэснээр дэлхийн томоохон хөрөнгө оруулагчдад болон дотоодын харилцагчиддаа банк санхүүгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлж өрсөлдөөний давуу талыг эзэмших болно. Зорилгодоо хүрэхэд тулгарч болох аливаа саад бэрхшээл, эрсдэлийг бид ухамсарлаж байгаа бөгөөд энэхүү 18 дахь жилдээ ард иргэд, харилцагчиддаа хамгийн зохист санхүүгийн үйлчилгээг үзүүлсээр байх болно.

Д.Баясгалан

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Жон П. Финиган

Гүйцэтгэх Захирал

Эрхэм хүндэт харилцагч, түнш, хувь нийлүүлэгч, хамтран ажиллагсад аа

Тогтвортой, жигд өсөлт үргэлжилсэн харьцангуй таатай жил болох 2010 он улиран одсоны дараа 2011 он дэлхийн эдийн засгийн хувьд Евро бүсийн орнуудын өрийн асуудал санаа зовоосон, санхүүгийн зах зээл дэх тогтворгүй байдал улам нэмэгдсэн дахин нэг сорилтын үетэй тулгарав.

Томоохон эдийн засагтай улс орнуудын үйлдвэрлэл ашигтай ажиллаж, Европ болон АНУ-ын ажилгүйдлийн түвшин буурсан, олон улсын эдийн засаг сэргэх эерэг хандлагаар 2011 он эхэлсэн билээ. Хэдий тийм боловч оны сүүлийн хагаст хөрөнгө оруулагчдын эргэлзээ, тогтворгүй байдал нь эдийн засаг болон зах зээлд сөргөөр нөлөөлсөн. Дэлхийн эдийн засагт нөлөө бүхий үйл явдлуудыг дурьдвал Ойрхи Дорнод, Хойд Африкийн улс төрийн тогтворгүй байдал, Европын орнуудын өрийн хямрал, Япон улсад тохиолдсон байгалийн гамшгаас үүдэлтэй эдийн засгийн сүйрэл, АНУ-ын улс төрийн ээдрээ болон өсөн нэмэгдэх өрийн асуудал зэрэг болно.

Тайлант онд банкны өөрийн хөрөнгө 61.3 тэрбум төгрөг (44 сая ам.доллар) буюу 48 хувиар өсч 189.1 тэрбум төгрөг (135 сая ам.доллар)-т хүрлээ. Энэхүү өсөлт нь I зэрэглэлийн өөрийн хөрөнгө 67 хувиар буюу 56.4 тэрбум төгрөг (40 сая ам.доллар)-өөр өсч 140.2 тэрбум төгрөг (100 сая ам.доллар)-т хүрсэнтэй холбоотой.

Эдгээр шалтгааны улмаас 2011 онд дэлхийн ДНБ-ий өсөлт 2.5 хувьтай байсан ба энэ нь цаанаа эдийн засгийн хурдац ялгаатай хоёр эдийн засгийг агуулж байсан юм. Хурдтай өсч буй Азийн эдийн засгийн өсөлт 3.5 хувь, шилжилтийн эдийн засагтай улс орнууд (шинээр төрөн гарч, эдийн засгийн хөгжлийг дахин тодорхойлогчид)-ын эдийн засгийн өсөлт 3.8 хувь байхад АНУ-ын хувьд 1.8 хувь, Евро бүсийн орнуудын хувьд 1.7 хувь гэсэн эдийн засгийн өсөлттэй байв.

Дэлхий дахины энэхүү нөхцөл байдалтай харьцуулахад Монгол Улс эрдэс баялаг болон газар зүйн таатай байршлынхаа ашгийг хүртэж нэрлэсэн ДНБ-ий өсөлтийн хувь 28.7 болж 10.8 их наяд төгрөг (7.8 тэрбум ам.доллар)-т хүрч, бодит ДНБ нь 17.3 хувийн өсөлттэй байсан ба хэрэглээ 64 хувь, хөрөнгө оруулалт 58 хувь, худалдааны алдагдал 22 хувь тус тус эзэлж, гадаадын шууд хөрөнгө оруулалтын санхүүжилтээр тэнцвэржсэн байдалтай байлаа.

Тогтвортой үргэлжилсэн 4.7 тэрбум ам.долларын урсгал бүхий гадаадын шууд хөрөнгө оруулалтын нөлөөгөөр нийт экспорт 64 хувиар өсч 4.8 тэрбум ам.долларт, нийт импорт 104 хувиар өсч 6.5 тэрбум ам.долларт тус тус хүрч, худалдааны алдагдал 1.7 тэрбум ам.доллар





болов. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, тэр дундаа машин механизм, уул уурхай, барилгын салбарын тоног төхөөрөмж, машин техник нь нийт импортын 18.8 хувийг эзэлж байв.

Улсын төсвийн орлого 41 хувиар өсч 4.4 их наяд төгрөг (3.15 тэрбум ам.доллар)-т хүрч, төсвийн зарлага болон цэвэр зээл 56 хувиар өсөн 4.79 их наяд төгрөг (3.43 тэрбум ам.доллар)-т хүрсэн нь төсвийн алдагдлыг 391 тэрбум төгрөгт хүргэв. Жилийн турш импортын эрэлт хэрэгцээ маш их байсан хэдий ч ашигт малтмал импортлогч бусад орнуудад түгээмэл байдаг жишгээр гадаад валютын албан нөөц хамгийн дээд түвшиндээ хүрч, төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2010 онд 14 хувиар чангарсан бол 2011 онд 11.4 хувиар сулрав. Хятад улсаас импортлосон хүнсний бүтээгдэхүүн импортын ихээхэн хувийг эзэлж буйтай холбоотой инфляци нэлээд өндөр буюу 11.1 хувьтай байв.

Улс орны макро эдийн засаг дахь эдгээр эерэг хандлагууд нь Монгол Улсын банкны салбарын эрчтэй өсөлтөнд нөлөөлсөн бөгөөд Голомт банкны хувьд тайлант он нь дотоодын банкны системд хадгаламжийн хэмжээгээрээ тэргүүлэх байр сууриа бататгасан, нийт актив болон орлогын хувьд тэнцвэртэй өсөлт гаргасан дахин нэг амжилтын жил байлаа.

Энэ жил бид шинээр үүсгэн байгуулсан охин компани болох Голомт Секюритиз ХХК-ийн тайланг агуулсан банкны болон группийн хэмжээний санхүүгийн тайланг танилцуулж байна. Санхүүгийн үр дүн, тайлангийн шинжилгээг илүү тодорхой, бие даасан байдлаар тусгасан болно.

Банкны нийт актив 558 тэрбум төгрөг (399 ам.доллар)-өөр буюу 35 хувиар өсч 2.13 их наяд төгрөг (1.53 тэрбум ам.доллар)-т хүрсэн нь банкны системийн дунджаас илүү өндөр хувиар буюу 40 хувиар өссөн хадгаламжийн өсөлттэй холбоотой. Нийт хадгаламж 523 тэрбум төгрөг (374 сая ам.доллар)-өөр өсч 1.84 их наяд төгрөг (1.32 тэрбум ам.доллар)-т хүрсэн ба нийт 14 арилжааны банкинд байршиж буй аж ахуйн нэгж байгууллагын хадгаламжийн ихэнх буюу 31 хувь нь манай банкинд байршдаг, тэргүүлэгч байр сууриа хадгалсандаа таатай байна.

Өөрийн хөрөнгийн өсөлт нь банкны хувьд тайлант оны гол түлхүүр амжилтыг харуулсан үзүүлэлт байлаа.

Банкны өөрийн хөрөнгө тайлант онд 61.3 тэрбум төгрөг (44 сая ам.доллар) буюу 48 хувиар өсч 189.1 тэрбум төгрөг (135 сая ам.доллар)-т хүрлээ. Энэхүү өсөлт нь I зэрэглэлийн өөрийн хөрөнгө 67 хувиар буюу 56.4 тэрбум төгрөг (40 сая ам.доллар)-өөр өсч 140.2 тэрбум төгрөг (100 сая ам.доллар)-т хүрсэнтэй холбоотой. Нийт өөрийн хөрөнгийн 74 хувийг эзэлж байгаа I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 9.8 хувь ба банкны хувьд өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 13.3 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон хамгийн доод түвшин болох 11 хувиас илүү юм.

Энэхүү амжилтанд нөлөөлсөн өөрийн хөрөнгийн тогтвортой өсөлт нь банкны өөрийн хөрөнгийн бодит өсөлт болон олон улсад нэр хүнд бүхий хамтрагчтай хийсэн түншлэл гэсэн хоёр зүйлээс хамаарсан юм. 2011 онд Швейцари улсын Swiss-Mo Investment AG компани банкны шинэ хувь нийлүүлэгчээр нэгдэж өөрийн хөрөнгийн өсөлтөнд бодит хувь нэмэр оруулсан билээ. (2012 оны эхээр "Trafigura Beheer B.V." компани мөн шинээр хувь нийлүүлэгч болсон.)

Эдийн засгийн нааштай өсөлттэй уялдаад бид зээлийн багцаа 59 хувиар буюу 461.3 тэрбум төгрөг (330 сая ам.доллар)-өөр өсгөж 1,246 тэрбум төгрөг (892 сая ам.доллар)-т хүргэх замаар үйл ажиллагааны үр ашгаа эрчимтэй бөгөөд хянамгай байдлаар дээшлүүлсээр ирсэн. Зээлийн өндөр өсөлт бүхий оны эцэст зээл хадгаламжийн харьцаа 67.7 хувь байсан нь банкны системийн 1-р ангилалд багтах (Төв Банкнаас тогтоосноор) гурван банкуудтай харьцуулахад хамгийн сайн буюу системийн дундаж болох 83.4 хувиас доогуур байв.

Бид зээлийн үйл ажиллагаагаараа Монгол Улсын аж ахуйн нэгжүүдийг тасралтгүй дэмжиж, илүү их бүтээгдэхүүн үйлчилгээ, ажлын байр бий болгоход нь хувь нэмэр оруулсаар ирсэн билээ. Ингэхдээ зээл олгох шалгуураа өндөр тавьж, муу зээл бий болохоос сэрэмжилснээр чанаргүй зээлийн багц 2 хувь болж буурсан нь 2010 оны 2.1 хувиас болон банкны системийн дундаж болох 2.9 хувиас доогуур байна.

Банкны тайлан тэнцлээс тогтвортой өсөлтийг харж болох ба тайлант онд банкны актив 35 хувь, хадгаламж 40 хувь, өөрийн хөрөнгө 48 хувиар тус тус өссөн нь зээл 59 хувиар өсөхөд эерэгээр нөлөөлж, улмаар ашигт

ажиллагаа 51 хувиар өссөнөөр банк дахин нэг өндөр амжилтын жилийг үдлээ.

Түүнчлэн татварын дараах ашиг 10.2 тэрбум төгрөг (7.3 сая ам.доллар)-өөр өсч 30.2 тэрбум төгрөг (21.7 сая ам.доллар)-т хүрсэн ба дундаж активын өгөөж 1.7 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж хоёр жил дараалан 26 хувьтай байгаа нь банк бодит өсөлт бүхий тогтвортой байр суурьтай байгааг харуулж байна.

Банкны орлогын өсөлтөд голлох байр суурьтай цэвэр хүүгийн орлого 19.2 тэрбум төгрөг (13.8 сая ам.доллар)-өөр өсч 48.9 тэрбум төгрөг (35 сая ам.доллар)-т хүрсэн нь үйл ажиллагааны цэвэр орлогын 40 хувийг бүрдүүлдэг активын бус орлогын 100 гаруй хувийн өсөлтийн 65 хувийг эзэлж байна. Хүүгийн бус орлого нь 16.9 тэрбум төгрөг (12.1 сая ам.доллар)-өөр өссөн нь карт болоод төлбөрийн үйлчилгээ, зээлийн шимтгэл, харилцагчийн гадаад валютын арилжааны орлого хэрхэн тэлж байгаагийн илрэл төдийгүй Монгол Улсын гадаад худалдаа сүүлийн жилүүдэд 85 хувь өссөний тусгал юм.

Тайлант оны үйл ажиллагааны цорын ганц сөрөг үзүүлэлт бол зээлийн алдагдлын зардлын өсөлт бөгөөд энэ нь нэгэн том байгууллагын зээлтэй холбоотой улсын шүүхээр шийдвэрлэсэн алдагдал болон жижиг дунд үйлдвэрлэлийн чанаргүй зээлийн түвшин өндөртэй холбоотой юм. Гэсэн хэдий ч энэ хоёр тохиолдолд бид хангалттай барьцаа хөрөнгө авч үлдсэн нь алдагдлаа нөхөх баталгаа болж байгаа билээ.

Өнгөрөгч онд үйл ажиллагааны зардал 53 хувиар нэмэгдсэн нь ашигт ажиллагааны өсөлттэй бараг адил түвшинд байгаа бөгөөд энэ нь бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ уялдаа холбоо, харилцагчийн үйлчилгээг сайжруулж, ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор ажиллах хүч, үндсэн хөрөнгө, мэдээлэл технологийн салбартаа хөрөнгө оруулсантай холбоотой юм. Хүний нөөцийн зардал 64 хувиар өсч нийт зардлын 44 хувийг эзэлснээр үр ашгийн бүтээмж сайжирч нэг ажилтанд ногдох дундаж орлого 2010 онд 20.7 сая төгрөг байснаас 25.9 сая төгрөгт хүрч 25 хувийн өсөлт үзүүлэв. Банкныхаа ажилчдын тоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ зардал орлогын харьцаанд дорвитой ахиц гарган 2010 оны 44 хувиас 37.5 хувь хүртэл бууруулж улам бүр өргөжин тэлж буй эдийн засгийн нөхцөлд бодит хэмнэлттэй ажиллав.

Эдгээр орлого ашгийн хувьд эерэг үр дүн бүхий ололт амжилтуудаас гадна Голомт банк бусад чиглэлээр тэргүүлэх байр сууриа хадгалж, харилцагчид хүрэх бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ хүртээмжийг тэлж өргөжүүлсэн ба үүнээс заримыг нь онцлон дурьдвал:

- Swiss-Mo Investment AG компани, түүний дараа 2012 оны эхээр Trafigura Beheer B.V. компанийг банкны шинэ хувьцаа эзэмшигчээр угтан авлаа
- Шинээр 18 нэгж байгуулж, салбар нэгжийнхээ тоог 88-д хүргээд байна
- АТМ-ийн сүлжээгээ 32 хувиар нэмэгдүүлж 132-т хүргээд байна
- Монгол Улсад анх удаа явуулын АТМ үйлчилгээг нэвтрүүлэв
- Интернет банкны үйлчилгээгээ шинэчилж сайжруулахын зэрэгцээ ухаалаг утсанд зориулсан банкны аппликэйшнг нэвтрүүлэв
- Шинээр хадгаламжийн сертификатын бүтээгдэхүүн гаргав
- Төгрөг болон Юаниар төлбөр тооцоо хийх зээлийн карт гаргав
- Залуу гэр бүлд зориулсан орон сууцны зээлийн хөтөлбөрийг анх удаа хэрэгжүүлэв
- Санхүүгийн Зохицуулах Хорооноос үнэт цаасны андеррайтинг үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан
- 100 хувийн хөрөнгө оруулалттай охин компани болох Голомт Секюритиз ХХК харилцагчиддаа үнэт цаас, брокерийн үйлчилгээг хүргэж эхлэв
- Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яамтай хөдөө аж ахуйг хөгжүүлэх зээлийн хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх банкаар сонгогдов
- Дэлхийн хэмжээнд үнэлэгдэх Монгол Улсын уул уурхайн хоёр төслийн (Оюу толгой, Таван толгой) зөвлөгч банкаар сонгогдов
- Монголын үндэсний агаарын тээврийн МИАТ компанийн АНУ-ын Экспорт Импортын Банкны санхүүжилтээр худалдан авсан 21.6 сая ам. долларын үнэ бүхий “Боинг 767-300 ER” онгоцны урьдчилгаа төлбөрийг хийх цорын ганц банкаар сонгогдов
- Олон улсад тэргүүлэх үнэлгээний байгууллагууд болох “Moody’s” болон “Standard & Poor’s”—ээс (хамгийн анх олгосон үнэлгээ нь Монгол Улсад олгосон үнэлгээнээс өндөр байсан) баталгаат зээлийн үнэлгээ авав
- Олон улсад нэр хүнд бүхий санхүүгийн сэтгүүлүүд болох Euromoney, The Banker сэтгүүлээс, 2012 оны



эхэнд Global Finance сэтгүүлээс “Монгол Улсын Шилдэг Банк” шагналуудыг хүртлээ

- The Banker сэтгүүлээс шалгаруулдаг дэлхийн шилдэг 1000 банкны жагсаалтад активын өсөлтөөрөө дэлхийд 6-р байранд, I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн өсөлтөөрөө дэлхийд 10-р байранд тус тус орсон.

Байгууллагын бүтэц зохион байгуулалтын хувьд бид шинээр Зээлийн Газар байгуулж зээл батлах, хугацааг нь сунгах, хэрэгжилтэд нь хяналт тавих зэрэг үйл ажиллагааг бизнес хөгжлийн үүргүүдээс салгасан болно.

Банкны салбарт тэргүүлэх байр сууриа хадгалахын зэрэгцээ компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд бид орлогынхоо тодорхой хувийг нийгмийн хэрэгцээт салбаруудад тухайлбал ядуурлыг бууруулах, эрүүл мэнд болон боловсрол, спортын үйл хэргийг дэмжихэд зарцуулдаг.

Монголын эдийн засгийн форум, орон нутгийн хөрөнгө оруулалтын чуулганууд болон уул уурхайн салбарын тэргүүлэх арга хэмжээ болох Дисковер Монголиа зэрэг хурал, уулзалтуудад ивээн тэтгэгчээр оролцож Монгол Улсын дотоод болоод гадаадын хөрөнгө оруулалт, эдийн засгийн хөгжил дэвшлийг дэмжих Засгийн Газрын хөтөлбөрт идэвхитэй оролцов. Цаашилбал Дэлхийн Эдийн Засгийн Форум, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газраас зохион байгуулсан Хариуцлагатай уул уурхайн түншлэл болоод Авлигын эсрэг түншлэл (PACI) зэрэг үйл ажиллагаануудад тэргүүлэн оролцлоо.

Банкныхаа хамгийн үнэт зүйл болох хүний нөөцийн асуудалд онцгой анхаарч ажилчдынхаа тоог 200 гаруйгаар нэмж, улам бүр тэлсээр байгаа харилцагчдынхаа санхүүгийн эрэлт хэрэгцээг хангах үүднээс ажилтнууддаа зориулсан мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдийг эрчимтэй явуулав. Мөн түүнчлэн банкныхаа орлогын болон орлогын бус амжилтаа ажилтнуудтайгаа хуваалцах байдлаа үргэлжлүүлээ. Гүйцэтгэлд суурилсан цалин, урамшууллын хөтөлбөрөөс гадна анх удаа Ажилтнуудад Хувьцаа Эзэмшүүлэх Хөтөлбөрийг (АХЭХ) хэрэгжүүлсэн нь өмнөх жилийн Тэтгэврийн Ууган Сангийн үйл ажиллагааны үргэлжлэл болсон бөгөөд оны эцэст банкинд олон жил ажилласан 41 ажилтнаа шинээр хувьцаа эзэмшигчээр бүртгэв.

2010 онд шинээр батлагдсан Банкны тухай хуулийн дагуу

бид компанийн засаглалаа сайжруулах, эрсдэлд тавих хяналтаа дээшлүүлэхэд анхаарч Цалин Урамшуулал, Нэр Дэвшүүлэх Хороог шинээр байгуулав. Түүнчлэн шинэ хөрөнгө оруулагч Swiss-Mo Investment AG компанийн төлөөлөл болгож ноён Урс И. Шварценбахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнээр элсүүлэв. Цаашилбал хилийн чанад дахь Лондон, Бээжингийн төлөөлөгчөөрөө дамжуулан олон улсын бизнесээ өргөжүүлсээр байна.

Эцэст нь хэлэхэд Голомт банкныхаа хамт олны өмнөөс хүндэт харилцагч, хамтрагч түншүүддээ бидний үйл ажиллагааг дэмждэгт нь, мөн Монгол Улс дахь бүхий л иргэд харилцагчид, аж ахуйн нэгжүүд, байгууллагуудад манай банкинд итгэл найдвар үзүүлдэгт нь, цаашилбал Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, бусад албан тушаалтнуудын дэмжлэг туслалцаа, удирдлага чиглүүлэгт нь, дөрөвдүгээрт Төлөөлөн Удирлах Зөвлөлийн гишүүд, хүндэт хувь нийлүүлэгчид, Бодь Интернэшнл ХХК, Swiss-Mo Investment AG, Trafigura Beheer B.V. компаниудад бүгдэд нь чин сэтгэлийн талархал илэрхийлэхийн ялдамд өөрийн болоод Удирдлагын багийнхаа нэрийн өмнөөс манай банкны одоогийн болоод ирээдүйн амжилт бүтээлийн суурийг тавьсан бүх чин сэтгэлтэй, шаргуу хөдөлмөрч ажилтан албан хаагчиддаа талархлаа илэрхийлье.

Цаашид 2012 ондоо бид дэлхийн болоод бүс нутгийн эдийн засгийн төлөв байдлыг сайтар үнэлж цэгнэснээр аливаа тулгарах асуудалд үр дүнтэй хариу өгөх, хөрөнгөө өсгөх боломжийг зүй зохистой ашиглах банкныхаа байр суурийг тодорхойлох болно.

Мөнгөний бодлогын нөлөөллийг үл харгалзан дэлхийн эдийн засгийн дүр зураг ерөнхийдөө таагүй байсаар байна. Ихэнх орнуудын ерөнхий төлөв байдал суларч, худалдан авалтын индекс буурч, АНУ болон Европын хэрэглэгчдийн худалдан авах чадвар муудсан нь Азийн экспортод нөлөөлж, 2012 онд дэлхийн эдийн засгийн өсөлт 2.2 хувь хүртэл буурна гэсэн таамаглалд хүргэж байна.

АНУ-д зээл олгох нөхцөл харьцангуй хялбар болж, мөнгөний бодлого суларсан ч эдийн засгийн сул байдал болоод сонгуулийн жилийн нөлөөгөөр ажилгүйдэл, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн өсөлт доогуур түвшинтэй байна.

Тайлант хугацаанд Евро бүс дэх дарамт улам ихсэж санхүүгийн болоод өрийн хямрал нь хүүгийн ханшийн

өсөлтийг нэмэгдүүлснээр Европын банкны салбарт үзүүлж байгаа дарамтыг улам бүр хүндрүүлсээр байв. Төв банкуудын хувьд бодлогын зохицуулалт урьд хожид байгаагүйгээр тэнцвэрээ алдлаа. Европын Төв Банкаас тус тивийн 800 гаруй банкуудад хөнгөлөлттэй нөхцөлөөр нэг их наяд еврогийн (1.34 тэрбум ам.доллартай тэнцэх) санхүүжилт хийсэн ч банкууд шинээр тогтоосон хөрвөх чадвар, өөрийн хөрөнгийн түвшинг өндөрт барих шаардлагатай нийцүүлэхийн тулд тайлангаа балансжуулж зээл олголтоо зогсоосон. Евро бүсийн орнуудын энэхүү дарамт нь 2008 оны Lehman Brothers компанийн сүйрэл шиг дэлхийн эдийн засгийг дахин хямрал руу хөтлөхөөр нөхцөл байдалд байгаа тул тухайн хямрал бүхий улсуудыг Евро бүсийн нэгдлээс хүчээр гаргах магадлал өндөр болж байна.

Нөгөө талаар бидний томоохон худалдааны түнш болох Хятад улс хоёр том сорилттой тулгарсан нь экспортын бууралт болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн сул байдал юм. Энэ нь цаашид өсөлтөө дахин тодорхойлох санхүүгийн бодлогын шинэчлэлтийг шаардаж байгаа юм.

Гэвч Хятад улсын эдийн засгийн өсөлт буурахад Монгол Улсад үзүүлэх нөлөөллийг тооцвол хоёр орны эдийн засгийн эрс ялгаатай байдал шууд хамааралтай. Өөрөөр хэлбэл 6.7 их наяд ам.доллар бүхий Хятадын ДНБ нь албан ёсны ханшаар наад зах нь 7.5 хувийн өсөлттэй гэж тооцвол 500 тэрбум ам.долларын өсөлт үзүүлнэ гэсэн үг бөгөөд энэ нь Монголын ДНБ-ээс даруй 60 дахин их тоо юм.

Энэхүү бэрх нөхцөлд олон улсын хөрөнгө оруулагчдын эрсдэлээс зайлсхийсэн хандлага түүхий эдийн үнэд дарамт үзүүлнэ. Хямрал цаашид үргэлжлэх магадлал өндөр байгаа хэдий ч энэ нь Монгол Улсын өндөр зэрэглэл бүхий уул уурхайн экспортын ашгийн өгөөжийг бууруулах хүртлээ үргэлжлэхгүй гэж тооцож байна. Монголын эдийн засаг дэлхийн хэмжээний хоёр том уул уурхайн төсөл болох Оюу Толгой болоод Таван Толгойн олборлолт эхэлснээр экспортыг нэмэгдүүлж үнийн бууралтаас дархлаажих болно. Голомт банк энэхүү үндэсний чухал ач холбогдол бүхий төслүүдэд санхүүгийн дэмжлэг үйлчилгээ үзүүлэх онцгой үүргийг хүлээн авсан билээ.

Угтан буй хөгжил дэвшилтэй уялдаад олон улсын зах зээлд гарах гарцаа нэмэгдүүлэх зорилгоор манай

дотоодын тээвэр, дэд бүтцийн салбарт төмөр зам, засмал замын төслүүд эхэлж, үүнийг дагаад эрчим хүч, ус хангамж, барилга байгууламж маш хурдацтай өргөжин тэлж худалдаа, орон сууц, боловсрол, эмнэлэг, амралт жуулчны салбаруудыг хамарсан олон төрлийн төслүүд ч мөн хэрэгжээд байна.

Нөгөө талаас өргөжин тэлж байгаа нөхцөл байдалд макро эдийн засгийн эрсдэлийн талаар дурьдахгүй өнгөрч болохгүй. Үүнд төсвийн хэт тэлэлт, шууд хөрөнгө оруулалтын өсөлт нь инфляцийн өндөр түвшин, гадаад валютын тогтворгүй байдлыг бий болгоод байна. Түүнчлэн мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, Төв Банкаас тогтоосон хүүгийн өндөр түвшингээс үл хамаарах зээлийн эрэлтийн өсөлт зэргийг дурдаж болно. Тиймээс хувьсан хөгжиж буй бизнесийн мөчлөгийн зайлшгүй нөлөөг тооцож аливаа эрсдэлээс сэргийлэх нь зүйтэй.

Үүнээс гадна 2012 оны 6-р сард болох улс төрийн сонгуулиар эрх баригч ямар ч засгийн газар сонгогдсон хурдтай хөгжиж буй эдийн засгаа зөв жолоодож, тэнцвэрт байдлаа хадгалан, бодит өсөлт бүхий үйлдвэрлэлийн бүтээмж, ажлын байрыг нэмэгдүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Ийм тааламжтай нөхцөл байдалд Монгол Улс болон Монголчууд ирээдүйгээ илүү гэрэл гэгээтэй, өөдрөгөөр төсөөлж болох юм. Өндөр боловсрол мэргэжилтэй, чин сэтгэлтэй ажилтан, албан хаагчидтай, өргөжин тэлж буй олон улсын хамтын түншлэлтэй Голомт банк улсынхаа хөгжил цэцэглэлтэд гар бие оролцож буй бүхий л талуудад банк санхүүгийн хамгийн үр ашигтай, өргөн сонголт бүхий үйлчилгээг хүргэж, эдийн засгийн хөгжлөөрөө хамгийн таатай Монгол Улсад бизнесийг тань дэмжих нэн тэргүүний банк байх үүргээ биелүүлж, тусалж дэмжихэд хэзээд бэлэн байна.

Жон П. Финиган

Гүйцэтгэх Захирал




ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ


ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

Дотоодын Нийт Бүтээгдэхүүн (ДНБ)-ий өсөлт 2011 онд 2010 онд байсан 6.4 хувиас өсч 17.3 хувь буюу түүхэн дээд хэмжээнд хүрлээ. ДНБ нэрлэсэн дүнгээр өнгөрсөн оноос 28.7 хувиар өсч 10.8 их наяд төгрөгт (7.8 тэрбум ам.доллар) хүрчээ. Нийт эдийн засгийн өсөлтийн 42 хувь нь үйлчилгээний салбараас, 41.4 хувь нь бүтээгдэхүүний цэвэр татвараас, 16.3 хувь нь аж үйлдвэр, барилгын салбараас бий болжээ.

Эдийн засгийн өсөлт (%)



ДНБ-ий бүтэц (%)




Нийт хөрөнгө оруулалт 2010 онд ДНБ-ий 41 хувийг эзэлж байсан бол 2011 онд огцом нэмэгдэж 58 хувьд хүрсэн, эцсийн хэрэглээний эзлэх хувь (хувийн болон Засгийн Газрын хэрэглээ) 67 хувиас 64 хувь болон буурчээ. Түүнчлэн өнгөрсөн онд машин, тоног төхөөрөмж, дизель түлшний импортын хэмжээ их хэмжээгээр өссөний үр дүнд гадаад худалдааны алдагдал түүхэнд байгаагүй өндөр буюу ДНБ-ий 22 хувьтай тэнцэх хэмжээнд хүрэв.


Хөдөө аж ахуй

Цаг агаар харьцангуй тааламжтай байсны дүнд 2011 онд хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн хэмжээ нэрлэсэн дүнгээр 16.9 хувиар өсч, нийт малын тоо 3.6 сая толгойгоор нэмэгдэж 36.3 саяд хүрчээ. Үүнээс ямаа 15.9 сая, хонь 15.6 сая, үхэр 2.3 сая, адуу 2.1 сая, тэмээ 280 мянган толгойд хүрэв. Хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийн гол хүчин зүйл болох малчдын тоо жилд дунджаар 16 мянгаар буурч 311 мянгад хүрэв.

Малын тоо толгой (саяар)



Ургацын өсөлт (%)



Мөн түүнчлэн газар тариалангийн салбарын хувьд 2011 онд ургац арвинтай жил байлаа. Тухайлбал үр тариа хураалт 25.6 хувиар өсч 446,100 тонн, үүнээс буудай 26.2 хувиар өсч 435,900 тоннд хүрчээ. Мөн төмс хураалт 20.1 хувиар өсч 201,600 тонн, хүнсний ногоо 20.3 хувиар өсч 98,900 тоннд тус тус хүрчээ.

Аж үйлдвэр


Нүүрсний олборлолт 30.9 сая тоннд хүрч өмнөх оноос 22.6 хувиар, төмрийн хүдэр олборлолт 5.7 сая тоннд хүрч 77.3 хувиар, газрын тос олборлолт 2.5 сая баррельд хүрч 16.8 хувиар тус тус өсчээ.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл


		2009	2010	2011	'09-'10	'10-'11
Нүүрс	мян.тонн	13,163.9	25,246.4	30,940.1	91.8%	22.6%
Газрын тос	мян.баррель	1,870.0	2,181.4	2,548.9	16.7%	16.8%
Зэсийн баяжмал	мян.тонн	533.1	522.0	513.7	-2.1%	-1.6%
Молибдений баяжмал	тонн	5,263.6	4,348.0	3,977.0	-17.4%	-8.5%
Алт	кг	9,803.3	6,037.1	5,702.6	-38.4%	-5.5%
Төмрийн хүдэр	мян.тонн	1,379.0	3,203.2	5,678.3	132.3%	77.3%
Хайлуур жоншны баяжмал	мян.тонн	115.3	140.7	116.4	22.0%	-17.3%
Цайрын баяжмал	мян.тонн	141.5	112.6	104.7	-20.4%	-7.0%

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл өмнөх оноос 9.5 хувиар өссөн бөгөөд үүнээс тоо хэмжээний өсөлт 23.1 хувь, үнийн өсөлт 4 хувь байжээ. Нийт өсөлтийн 57.4 хувь нь уул уурхайн салбараас бий болсон байна. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 5.03 их наяд төгрөгт хүрч бодит дүнгээр өмнөх оноос 9.7 хувиар өсчээ. Үүнд эзлэх уул уурхайн салбарын хувь жил ирэх тусам өссөөр байгаа бөгөөд 2008 онд 64.5 хувь байсан бол 2011 онд 70 хувьд хүрээд байна.

Аж үйлдвэрийн салбарын өсөлт



Аж үйлдвэрийн салбарын бүтэц




Боловсруулах салбарын үйлдвэрлэл 11.6 хувиар өссөн бөгөөд үүнээс хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 10.5 хувиар, нэхмэл эдлэл 1.7 хувиар, төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн үйлдвэрлэл 40.5 хувиар тус тус өссөн бол төмөр боловсруулах үйлдвэрлэл 9.2 хувиар буурчээ. Мөн цахилгаан дулаан, эрчим хүчний салбар 2011 онд 2010 онтой адил 5.8 хувиар өссөн байна. Дээрх зурагт нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг салбаруудын эзлэх хувиар харуулав.




Барилгын салбар

Нийт барилга угсралт, их засварын ажил 2011 онд 450.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 99.9 тэрбум төгрөг буюу 28.5 хувиар өссөн байна. Үүний 84 хувийг дотоодын хувийн компаниуд, 8.1 хувийг улсын байгууллага, 7.9 хувийг гадаадын компаниуд тус тус гүйцэтгэсэн байна. Барилгын төрлөөр авч үзвэл орон сууцны барилга өмнөх оноос 44 хувиар өсч 134.4 тэрбум төгрөг, үйлдвэрийн барилга 37.9 хувиар буурч 4.6 тэрбум төгрөг, худалдаа үйлчилгээний барилга 21.8 хувиар өсч 14.6 тэрбум төгрөг, эмнэлэг сургууль, соёлын барилга 42.6 хувиар өсч 64 тэрбум төгрөгт тус тус хүрчээ.

Нийт барилга угсралт



Ашиглалтанд оруулсан барилгын бүтэц



Үйлчилгээ

Үйлчилгээний салбар нэрлэсэн дүнгээр 4 их наяд 431 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос бодит дүнгээр 17.1 хувиар өсчээ. Уг өсөлтөд хамгийн их хувь нэмэр оруулсан салбарууд нь дотоод худалдаа, тээвэр ба агуулахын үйлчилгээ байлаа. Үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь 2011 онд 40.9 хувьд хүрч өссөн. Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт 3 их наяд 231.3 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 55.7 хувиар өссөн бөгөөд үүнээс бөөний худалдаа 75.2 хувиар өсч нийт худалдааны 77.3 хувь, жижиглэн худалдаа 12.9 хувиар өсч нийт худалдааны 22.7 хувийг тус тус эзэлж байна.

ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт эргэлт 11.3 тэрбум ам.долларт (15.5 их наяд төгрөг) хүрч өмнөх оноос 85.1 хувиар өссөн бөгөөд үүнээс нийт экспорт 64.4 хувиар өсч 4.78 тэрбум ам.долларт (6.57 их наяд төгрөг), нийт импорт 104 хувиар өсч 6.52 тэрбум ам.долларт (8.97 их наяд төгрөг) тус тус хүрсэн байна. Ингэснээр гадаад худалдааны алдагдал 1.75 тэрбум ам.долларт (2.4 их наяд төгрөг) хүрч өмнөх оноос 6 дахин өсөв. Нийт импортын өсөлтөд уул уурхайн салбарын машин, тоног төхөөрөмж, дизель голлон нөлөөлсөн бөгөөд эдгээр нь ирээдүйд экспортыг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалт болох юм.

Нийт экспортын 87 хувийг нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть, цайр, алт зэрэг 6 нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлж байна. Ноолууртай нийлээд дээрх бүтээгдэхүүнүүд нийт экспортын 91 хувийг эзлэхээр байна. Нийт экспортын өсөлтийн 73.1 хувь нь нүүрснээс, 10.3 хувь нь зэсийн баяжмалаас, 9.8 хувь нь төмрийн хүдрээс, 5.2 хувь нь түүхий нефтээс хамаарчээ.


Нийт экспортын 92.1 хувийг БНХАУ-тай, 2 хувийг ОХУ-тай, 1.9 хувийг Канад улстай, 1.1 хувийг Итали улстай хийсэн худалдаа, нийт импортын 30.8 хувийг БНХАУ-тай, 24.5 хувийг ОХУ-тай (үүний 94.6 хувийг нефтийн импорт), 8.2 хувийг АНУ-тай, 7.4 хувийг Япон улстай хийсэн худалдаа тус тус эзэлж байна.

Монголд орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт 2010 онд 1.69 тэрбум ам.доллар байсан бол 2011 онд 178.7 хувиар өсч 4.71 тэрбум ам.долларт хүрээд байна. Ингэснээр төлбөрийн тэнцэл 2010 онд 873,1 сая ам.доллар алдагдалтай байсан бол 2011 онд 27.8 сая ам.долларын ашигтай гарчээ.


УЛСЫН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 4 их наяд 400.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 40.9 хувиар, төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 4 их наяд 792 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 55.6 хувиар тус тус өсчээ. Ингэснээр төсвийн нийт алдагдал 391.4 тэрбум төгрөг болж ДНБ-ий 3.6 хувьтай тэнцэж байна. Засгийн Газар 2012 онд төсвийн орлогоо өнгөрсөн оноос 39.7 хувиар өсгөж 6.1 их наяд төгрөгт хүргэхээр төлөвлөж байгаа нь нийт ДНБ-ий 38.1 хувийг эзлэхээр байна. Түүнчлэн татварын бус орлогоор 1 их наяд 70 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож байгаа нь нийт орлогын өсөлтийн 32.4 хувийг эзэлж байна. Мөн нэмэгдсэн өртөгийн албан татвараар 1 их наяд 671 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр байгаа нь өмнөх оноос 50.7 хувиар өсөх үзүүлэлт юм.

Төсвийн орлогын өсөлт (%)



Төсвийн зарлагын өсөлт (%)



Энэ оны төсвийн төслөөр нийт зарлага 6 их наяд 309 тэрбум төгрөг буюу өнгөрсөн 2011 оноос 31.7 хувиар өсгөх тооцоо гарсан. Төсвийн нийт зарлагын өсөлтийн 50.6 хувь нь хөрөнгө оруулалтын зардлаас, 36.6 хувь нь урсгал шилжүүлгийн зардлаас тус тус хамаарахаар байна.

ИНФЛЯЦИ

Импортын хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт, эдийн засгийн өндөр өсөлт, төсвийн зарлагын тэлэлтийн улмаас инфляцийн түвшин 2011 оны эхний хагас жилээс хоёр оронтой тоо руу орж эхэлсэн ба инфляци 2011 оны эцэс гэхэд 10.2 хувьд хүрэв. Үүнд хүнсний бүтээгдэхүүн 8.2 хувиар өссөн бөгөөд уг өсөлтөд мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оноос 19.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны эцсийн инфляцийн 30.3 хувь нь мах махан бүтээгдэхүүн, 18.3 хувь нь хувцас бөс бараа, 16.6 хувь нь тээврийн үйлчилгээ, 12.2 хувь нь орон сууц, ус, цахилгаан түлшний бүлгийн үнийн өсөлтөөс тус тус хамаарчээ.



ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ МӨНГӨНИЙ УРСГАЛ (2011)

Хэрэглээ

Хүчин зүйлийн төлбөр

Үйлдвэрлэлийн хүчин зүйлийн зах зээл:

Хүн ам: 2,834,206 (+1.9%)
Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт: +3.5%
Бүртгэлтэй ажилгүйдлийн тоо: 57,171 (+49.5%)
УБ хот: 29,331 (+222.7%)
Шинэ ажлын байранд ажилд орсон хүний тоо: 73,234
ХАА: 13,361
Барилга: 12,930
Дотоод худалдаа: 8,761
Уул уурхай: 7,260
Ажилгүйдлийн түвшин: 8.9%

Аж үйлдвэрийн салбарт ажиллагсад:

Уул уурхайн салбар: 16,500 (+0.6%)
Нүүрс олборлолт: 5,887 (+12.9%)
Төмрийн хүдэр олборлолт: 8,320 (-3.8%)
Боловсруулах аж үйлдвэрийн салбар: 25,866 (+9.3%)
Хүнс: 10,331 (+7.5%)
Нэхмэл: 4,580 (+8.4%)
Химийн: 1,166 (+17.8%)
Металлаг бус: 2,456 (+6.8%)
Металлаг: 1,426 (+24.2%)
Эрчим хүчний салбар: 14,431 (+1.5%)
Цахилгаан: 10,997 (+0.0%)
Ус түгээх: 3,434 (+6.5%)

Орлого

Өрх гэр:

Дундаж цалин: 450,000 ₮ (+18.7%)
ХАА: 194,000 ₮ (+13.1%)
Уул уурхай: 752,000 ₮ (+28.9%)
Боловсруулах: 433,000 ₮ (+27.4%)
Эрчим хүч: 424,000 ₮ (+14.4%)
Барилга: 455,000 ₮ (+67.3%)
Дотоод худалдаа: 312,000 ₮ (+30.2%)
Зочид буудал, зоогийн газар: 317,000 ₮ (+2.6%)
Харилцаа холбоо: 510,000 ₮ (+21.1%)
Санхүү: 992,000 ₮ (+36.7%)
Үл хөдлөх хөрөнгө: 353,000 ₮ (+12%)
Нийгмийн хамгаалал: 455,000 ₮ (+7.4%)
Боловсрол: 381,000 ₮ (+2.8%)
Эрүүл мэнд: 382,000 ₮ (+3.6%)

Санхүүгийн зах зээл:

M2 мөнгөний нийлүүлэлт: 6,427 тэрбум ₮ (+37.3%)
M1 мөнгөний нийлүүлэлт: 1,741 тэрбум ₮ (+50.4%)
Нөөц мөнгө: 1,660 тэрбум ₮ (+75.5%)
Гадаад валютын нөөц: 2,457 сая \$ (+8.4%)

Банкны систем

14 арилжааны банк (1 төрийн өмчит)
Нийт актив: 9,372 тэрбум ₮ (+50.1%)
- 3 том банк эзлэх хувь: 69.0%
- 5 том банк эзлэх хувь: 85.1%
Нийт депозит: 6,430 тэрбум ₮ (+41.9%)
Цэвэр зээл: 5,337 тэрбум ₮ (+78.3%)
Цэвэр ашиг: 184 тэрбум ₮ (+180.2%)
Гол харьцаанууд:
Хугацаа хэтэрсэн зээлийн хувь: 1.3%
Чанаргүй зээлийн хувь: 3.2%
Хөрвөх чадварын харьцаа: 36.8%
Зээл депозитын харьцаа: 83.4%
Дундаж активын өгөөж: +2.4%
Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж: +34.8%
Хөшүүргийн харьцаа: 12.8
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ: 15.0%

Монголбанкны бодлогын хүү: +12.25%
Repo хүү: +16.25%
Overнайт хүү: +21.25%
Барьцаат зээлийн хүү: +20.25%
Дундаж зээлийн хүү: +16.1%
Дундаж хадгаламжийн хүү: +10.5%

Хөрөнгийн зах зээл

76 брокер дилерийн компани
332 бүртгэлтэй хувьцаат компани
Зах зээлийн нийт үнэлгээ: 2,169 тэрбум ₮ (+57.8%)
ТОП 20 индекс: 21,687 (+46.9%)

Даатгалын зах зээл

17 даатгалын компани
Даатгалын нийт хураамж: 5.4 тэрбум ₮ (+93.8%)
Нийт хөрөнгө: 78 тэрбум ₮ (+69.2%)

Банк бус санхүүгийн байгууллага

192 банк бус санхүүгийн байгууллага
Нийт хөрөнгө: 189 тэрбум ₮ (+55.3%)

Хадгаламж зээлийн хоршоо

170 хадгаламж зээлийн хоршоо
Нийт хөрөнгө: 59 тэрбум ₮ (+39.1%)

Байгууллагын хадгаламж

Иргэдийн хадгаламж

Улсын хадгаламж

Татвар

Дээрх схем нь эдийн засаг дахь мөнгөний эргэлтийг илүү бодитойгоор харуулж байна. Шар хайрцагууд нь өрх гэр, пүүсүүд, засгийн газар гэсэн эдийн засгийн үндсэн агентуудыг илэрхийлнэ. Цэнхэр хайрцагууд нь бараа үйлчилгээ, хөдөлмөрийн, санхүүгийн гэсэн үндсэн зах зээлийн төрлийг илэрхийлнэ. Эдгээрийг холбосон шугамууд нь зах зээл, агентуудын хоорондын мөнгөний урсгалыг харуулж байна.



Пүүсүүд:

Бүртгэлтэй компанийн тоо: 67,409 (-8.7%)
Идэвхтэй: 48,086 (+17.5%)
Ажиллагсадын тооны бүлгээр:
1-9: 38,797
10-19: 4,363
20-49: 3,256
50+: 1,670

ДНБ 2011: 10.8 их наяд ₮ = 7.8 тэрбум \$

Бүтэц:
Эцсийн хэрэглээ: 64.4%
Хөрөнгө оруулалт: 58.1%
Цэвэр экспорт: -22.5%

Эдийн засгийн өсөлт: +17.3%

ХАА: +0.3%

Малын тоо толгой: 36.3 сая (+11%)

Аж үйлдвэр: +9.7%

Уул уурхай: +9.5%

Нүүрс: +22.6%
Түүхий нефть: +16.8%
Төмрийн хүдэр: +4.1%

Боловсруулах: +11.6%

Хүнс: +10.5%
Нэхмэл: +1.7%
Металлаг: -9.2%
Металлаг бус: +40.5%
Химийн: +45.8%

Эрчим хүч: +5.8%

Барилга: +14.3%

Үйлчилгээ: +17.1%

Дотоод худалдаа: +42.5%

Тээвэр: +13.8%

Зочид буудал, зоогийн газар: +14.6%

Мэдээлэл холбоо: +5.8%

Санхүү: +11.4%

Үл хөдлөх хөрөнгө: +5.7%

Мэргэжлийн ШУ, техник: +8.5%

Захиргаа, дэмжлэг: +19.6%

Төрийн удирдлага: +1.2%

Боловсрол: 7.8%

Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал: +6.3%

Урлаг, үзвэр: +7.1%

Бүтээгдэхүүний цэвэр татвар: +52.2%

Бүтээгдэхүүн үйлчилгээний зах зээл:

Суурь инфляци: +10.0%

ХҮИ инфляци: +10.2%

Хүнс: +8.2%

Согтууруулах ундаа: +3.3%

Хувцас: +13.9%

Орон сууц, ус цахилгаан: +14.1%

Гэр ахуйн бараа: +8.9%

Эрүүл мэнд: +3.5%

Тээвэр: +16.1%

Харилцаа: +0.3%

Соёлын бараа: +7.1%

Боловсрол: +11.9%

Зочид буудал, зоогийн газар: +7.0%

Бусад: +11.2%

Төгрөгийн ханш:

Ам.доллар = 1,374.2 (+11.4%)

Евро = 1,806.8 (+8.7%)

Иен = 18.0 (+16.7%)

Юань = 221.6 (+16.5%)

Фунт = 2,155.3 (+10.6%)

Рубль = 43.4 (+5.1%)

Орлого

Хөрөнгө оруулалт

Татвар

ЗГ-ын худалдан авалт

Засгийн газар:

Нийт орлого: ₮4,401 тэрбум (+40.9%)

- Урсгал орлого: 4,141 тэрбум ₮ (+34.5%)
 - Татварын орлого: 3,637 тэрбум ₮ (+35.3%)
 - Орлогын татвар: 832 тэрбум ₮ (-14.7%)
 - ААНБ: 545.3 тэрбум ₮ (+39.5%)
 - Хүн амын: 230.7 тэрбум ₮ (+43.3%)
 - Гэнэтийн ашгийн: 56 тэрбум ₮ (-86.8%)
 - НД-ийн шимтгэл: 450.4 тэрбум ₮ (+36.0%)
 - Бараа үйлчилгээний: 1,429 тэрбум ₮ (+65.1%)
 - НӨАТ: 1,108 тэрбум ₮ (+91.4%)
 - Онцгой татвар: 294 тэрбум ₮ (+9.5%)
 - Гаалийн: 337 тэрбум ₮ (+74.5%)
 - Бусад: 572 тэрбум ₮ (+84.7%)
- Татварын бус орлого: 504 тэрбум ₮ (+29.3%)
- Хөрөнгийн орлого: 17 тэрбум ₮ (+195.2%)
- Тусламжийн орлого: 2 тэрбум ₮ (-96.0%)

Нийт зарлага & Цэвэр зээл: 4,792 тэрбум ₮ (+55.6%)

- Урсгал зардал: 3,234 тэрбум ₮ (+43.4%)
 - Бараа, үйлчилгээний: 1,528 тэрбум ₮ (+31.0%)
 - Цалин хөлс: 801 тэрбум ₮ (+23.6%)
 - Нийгмийн халамж: 75 тэрбум ₮ (+20.5%)
 - Бараа үйлчилгээний: 727 тэрбум ₮ (+40.3%)
- Татаас, шилжүүлэг: 1,669 тэрбум ₮ (+59.3%)
 - Татаас: 111 тэрбум ₮ (+38.5%)
 - Нийгмийн даатгал: 498 тэрбум ₮ (+21.6%)
 - Нийгмийн халамж: 128 тэрбум ₮ (+31.2%)
 - Бусад: 151 тэрбум ₮ (+9.9%)
- Хөрөнгийн зардал: 1,067 тэрбум ₮ (+80.6%)
 - Дотоодын: 925 тэрбум ₮ (+82.6%)
 - Цэвэр зээл: 491 тэрбум ₮ (+110.2%)

Алдагдал: 391 тэрбум ₮ /ДНБ-ий 3.6%/

Гадаад худалдаа:


Нийт экспорт: 4,780 сая \$ (+64.4%)

- Нүүрс: 2,250 сая \$ (+155.1%)
 - 21.1 сая тонн (+26.2%)
- Зэсийн баяжмал: 964 сая \$ (+25.0%)
 - 572.8 мянган тонн (+0.7%)
- Төмрийн хүдэр: 437 сая \$ (+72.3%)
 - 5.8 сая тонн (+61.4%)
- Газрын тос: 252 сая \$ (+63.4%)
 - 2.5 мянган баррель (+22.7%)
- Ноолуур: 190 сая \$ (+9.2%)
 - 3,370 тонн (-17.4%)
- Цайрын баяжмал: 143 сая \$ (+6.4%)
 - 120,700 тонн (+0.8%)
- Алт: 113 сая \$ (-36.6%)
 - 2.7 тонн (-47.5%)

Нийт импорт: 6,527 сая \$ (+104.0%)

- Ачааны автомашин: 578 сая \$ (+177.2%)
 - 24,435 ширхэг (+99.9%)
- Суудлын автомашин: 438 сая \$ (+166.4%)
 - 56,120 ширхэг (+112.8%)
- Дизель түлш: 706 сая \$ (+77.5%)
 - 635,300 тонн (+27.2%)
- Автобензин: 346 сая \$ (+51.4%)
 - 322,500 тонн (+13.3%)
- Уул уурхайн машин: 373 сая \$ (+267.8%)
 - 1,918 ширхэг (+148.8%)
- Хүнсний бүтээгдэхүүн: 329 сая \$ (+37.2%)
- Төмөрлөг бүтээгдэхүүн: 587 сая \$ (+188.9%)
- Химийн бүтээгдэхүүн: 253 сая \$ (+50.2%)
- Хуванцар бүтээгдэхүүн: 229 сая \$ (+108.6%)

Худалдааны алдагдал: 1,747 сая \$ (+6 дахин)

**Инфляцийн задаргаа**

Инфляци өндөр байсантай холбоотойгоор Монголбанкнаас мөнгөний хатуу бодлого баримтлан бодлогын хүүгээ шат дараатайгаар өсгөж 12.25 хувьд, заавал байлгах нөөцийн хэмжээг 9-өөс 11 хувьд хүргэсэн байна. 2011 оны төсвийн гүйцэтгэлээс харахад нийт зарлага 4.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 55.6 хувиар өссөн нь инфляцийн хүлээлтийг нэмэгдүүлсээр байна.

Түүнчлэн, гадаад худалдааны алдагдал нэмэгдсээр байсан нь төгрөгийн ам.доллар болон бусад гадаад валюттай харьцах ханшийг сулруулсан нь инфляцийг өсгөх нэг шалтгаан болжээ. Энэхүү төгрөгийн ханшийн сулралт нь цаашид экспортыг дэмжиж, импортын үнийг өсгөх болно. Монгол Улс шиг импортоосоо хүчтэй хамаардаг улсуудын хувьд валютын ханшийн хэлбэлзэл нь импортын бараа бүтээгдэхүүний үнийг өсгөж, тухайн улсын мөнгөн тэмдэгтийн үнэ цэнийг бууруулдаг. 2011 оны хувьд нийт эрэлт, нийт нийлүүлэлт аль алинаас нь шалтгаалсан инфляцийн дарамт өндөртэй байжээ.


Бодлогын хүүгээ өсгөх зэрэг макро эдийн засгийн бодлого нь инфляцийг бууруулахад чиглэгддэг боловч нөгөө талдаа тухайн улсын хувийн хэвшлийн бизнесийн үйл ажиллагаанд хөрөнгийн зардлыг нэмэгдүүлснээр эдийн засгийн бодит үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлдэг. Цаашид инфляци өндөр байсаар байвал бодлого боловсруулагчид мөнгөний хатуу бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр байна.

ВАЛЮТЫН ХАНШ

Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт – төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино. Үндэсний мөнгөн тэмдэгт тогтвортой байна гэдэгт тогтвортой бага инфляцитай, валютын ханш нь огцом савалгаагүй тогтвортой байхыг ойлгодог. Хамгийн сүүлийн үеийн мэдээнээс харахад өнгөрсөн 2011 онд инфляци 10.2 хувьтай байв. Төгрөгийн бусад гадаад валюттай харьцах ханш 2010 онд 14.7 хувиар чангарсан бол төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2011 оны 3-р сард 1,195.27-д хүрч чангаран, оны эцэст 1,396.37-д хүрч сулран, жилийн хугацаанд 16.82 хувийн савалгаатай, 3.8 хувийн вариацийн коэффициенттэйгээр хувьсчээ.

Сүүлийн хэдэн жилүүдэд валютын ханш гадаад худалдаа, хөрөнгийн дотогшлох урсгалаас хүчтэй хамаарах болов. Тоног төхөөрөмж, машин, дизелийн импорт үлэмж хэмжээгээр өссөн хэдий ч түүнээс илүүтэйгээр нийт экспорт, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2.27 тэрбум ам.долларт хүрэхэд нөлөөлжээ.

Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкны албан ханш (2009 - 2011 оны эцэс)




Төгрөгийн ханш богино хугацаанд гадаад худалдаа болон хөрөнгийн дотогшлох урсгалаас хамаарсаар байна. Гэсэн хэдий ч Оюу Толгой, Таван Толгой гэх мэт томоохон уул уурхайн төслүүдийн хүрээнд экспортын хэмжээ огцом өсөхөөр хүлээгдэж байгаа нь дундаас урт хугацаанд гадаад худалдааг ашигтай болгож төгрөгийн ханшийг чангаруулах болно.

Гадаад валютын цэвэр албан нөөц 2011 оны эцэст өмнөх оноос 182.8 сая ам.доллараар буюу 8.7 хувиар нэмэгдэж 2.27 тэрбум ам.доллар болж, манай улсын импортын 18.2 долоо хоног буюу 4.6 сарын хэрэгцээг хангахаар байна.


БАНК САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Санхүүгийн зах зээлийн хөгжлийг илэрхийлэгч үзүүлэлт болох M2 мөнгөний ДНБ-д эзлэх хувь 2009 онд 43.7 хувь, 2010 онд 55.6 хувь байсан бол 2011 онд 59.3 хувь болж өссөн байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт (M2)



Банкны системийн үзүүлэлтүүдийн өсөлт






Өнөөдрийн байдлаар нийт 14 арилжааны банк, үүнээс 1 төрийн эзэмшлийн банк, 76 брокер дилерийн компани, 200 гаруй банк бус санхүүгийн байгууллага, 17 даатгалын компани, 170 орчим хадгаламж зээлийн хоршоо үйл ажиллагаа явуулж байна.

Санхүүгийн зах зээлийн 90 гаруй хувийг банкны сектор дангаар эзэлж байгаа бөгөөд 2011 оны эцсийн байдлаар банкны системийн нийт актив 9.37 их наяд төгрөгт (6.8 тэрбум ам.доллар) хүрч өмнөх оноос 50.1 хувиар, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 6.43 их наяд төгрөгт (4.7 тэрбум ам.доллар) хүрч 41.9 хувиар, нийт зээл 5.64 их наяд төгрөгт (4.1 тэрбум ам.доллар) хүрч 72.8 хувиар тус тус өсчээ. Өнгөрсөн онд зээлийн эрэлт өндөр байсан нь банкуудын ТБҮЦ худалдан авах сонирхолыг бууруулж нийт банкууд дахь ТБҮЦ-ны хэмжээ 2011 оны 2-р сард 1 их наяд 330 тэрбум төгрөг байсан бол оны эцэс гэхэд 879.8 тэрбум төгрөгт хүрч буурчээ. Ингэснээр банкны системийн хөрвөх чадвар буурч, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2010 онд 48.1 хувь байсан бол 2011 оны эцэст 36.8 хувь, зээл татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа 2010 онд 66.6 хувь байсан бол 2011 онд 83.4 хувь хүртэл өсчээ.

Банкны системийн чанаргүй зээлийн хэмжээ тогтмол буурсаар байгаа бөгөөд нийт зээлд эзлэх хувь 2010 онд 6.5 байсан бол 2011 оны эцэст гэхэд 2.9 хувьд хүрэв. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зээлд байршуулснаар банкны системийн ашигт ажиллагаа нэмэгдэж банкуудын нийт ашиг 2010 онд 65.8 тэрбум төгрөг байсан бол 2011 оны эцсийн гүйцэтгэлээр 2.8 дахин өсч 184.3 тэрбум төгрөгт хүрчээ.


Инфляцийн өсөлтийг сааруулах, хүлээлтийг удирдах зорилгоор Монголбанк мөнгөний бодлогыг бага зэрэг чангаруулсан ч зээлийн өсөлт хямралын өмнөх үеийнхтэй адил өндөр түвшинд хүрээд байна.

Төв банкны бодлогын хүү



- Зээлийн өсөлт (баруун тэнхлэг)
- Инфляци (зүүн тэнхлэг)
- Бодлогын хүү (зүүн тэнхлэг)

Хүүгийн түвшин



- Зээлийн хүү
- Хадгаламжийн хүү
- ТБ-ын жигнэсэн дундаж хүү

Банкуудын төгрөгийн дундаж зээлийн хүү 15.5 хувь, хадгаламжийн хүү 10.5 хувь байсан бол гадаад валютын хувьд дундаж зээлийн хүү 12.1 хувь, хадгаламжийн хүү 4.5 хувь байжээ. Ингэснээр хүүгийн маржин 2010 онд 7.2 хувь байсан бол 2011 онд 5 хувьд хүрч буураад байна.

БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ


ЭРХЭМ ЗОРИЛГО, ХЭТИЙН ЗОРИЛГО

Эрхэм зорилго

Монголын банкны салбарт тэргүүлэгч, дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаатай, нэр хүнд бүхий найдвартай банк байна.

Хэтийн зорилго

Санхүүгийн цогц үйлчилгээ үзүүлдэг, өндөр үр ашиг бүхий хөгжих чадвартай, нийгмийн хариуцлагатай, тэргүүлэгч банк байна.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Банк санхүүгийн салбарт тэргүүлэгч банкны хувьд бид үр бүтээмжтэй удирдлага болон зөв компанийн засаглалын хэрэгжилтэд чухал ач холбогдол өгч Олон Улсын Санхүүгийн Тайлагналын Стандартыг дагаж мөрдөн үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй байлгахыг эрхэмлэн ажилладаг.

Компанийн засаглалын бүтцийг дэмжих үүднээс бид дотоод хяналт шалгалт, тэнцвэрт байдлын тогтолцоог Хороодын үйл ажиллагаагаараа дамжуулан хэрэгжүүлж, олон улсын жишигт нийцүүлдэг. Банкны удирдлага нь томоохон хувь эзэмшигчид болон бусад талуудын аливаа зохист бус нөлөөллөөс ангид бие даасан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Төлөөлөн Удирдах Зөвлөл, Аудитын Хороо, Цалин Урамшуулал, Нэр Дэвшүүлэх Хороо болон Эрсдэлийн Удирдлагын Хороонд тус тус хараат бус гишүүдтэй юм.

2010 онд шинэчлэгдэн батлагдсан Банкны тухай хууль, олон улсын жишигт нийцүүлэн 2011 онд Төлөөлөн Удирдах Зөвлөлөө 6 гишүүнтэй болгож, компанийн засаглалын хэм хэмжээний цогц байдлыг улам илүүтэйгээр ханган ажиллалаа.

Банк нь 2011 онд шинэчлэгдэн батлагдсан Компанийн тухай хуульд нийцүүлэн "Голомт банкны дүрэм"-ийг шинэчлэн сайжруулан баталж, мөн ТУЗ-ийн дэргэд Цалин Урамшуулал, Нэр Дэвшүүлэх Хороо (ЦУНДХ)-г шинээр байгууллаа. ЦУНДХороо нь ТУЗ, хороодын гишүүд болон Банкны гүйцэтгэх удирдлага, бусад удирдлагуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшууллыг зөв зохистой тодорхойлж ТУЗ-д санал болгох, эргээд тэдгээрийн ажлын үр дүнг хэлэлцэж дүгнэх зорилго үүрэгтэй хороо юм.

Ийнхүү ТУЗ-д харъяалагдан үүрэг хариуцлага хүлээдэг хороодуудын бүтцэд зарим өөрчлөлтүүд орсон нь одоо байгаа болон шинээр бий болсон хувьцаа эзэмшигчдийн нөлөөгөөр улам сайжран бэхжсээр байна.





Компанийн засаглалын бүтэц



Хувь нийлүүлэгчид

	31/12/2011	31/03/2012
Бодь Групп	89.19%	84.71%
Swiss-Mo Investment AG	10.70%	10.16%
Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр	0.10%	0.09%
Trafigura Beheer B.V.	-	5.02%
Нийт	100%	100%

Swiss-Mo Investment AG компани нь 2011 оны 6-р сард Голомт банкинд хөрөнгө оруулж банкны үүсгэн байгуулагч Бодь Интернэшнл ХХК-ийн дараах 2 дахь том хувь нийлүүлэгч болсон юм. Мөн түүнчлэн 2011 оны санхүүгийн тайланг эцэслэсний дараа бид шинэ хөрөнгө оруулагч Trafigura Beheer B.V.-г хүлээн авсан билээ. Trafigura Beheer B.V. нь 1993 онд үүсгэн байгуулагдсанаас хойш дэлхийн газрын тосны гурав дахь том, төмөр агуулаагүй баяжмалын газрын тосны том арилжаалагч болж чадсан юм.

БОДЬ ИНТЕРНЭШНЛ ХХК

Бодь Интернэшнл ХХК нь Бодь Группийн толгой компани бөгөөд банк санхүү, барилга, үл хөдлөх хөрөнгө, хөдөө аж ахуй, худалдаа үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, энтертэймент зэрэг бизнесийн 7 салбарт идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг Монголын тэргүүлэгч группуудын нэг юм.

Групп нь байгуулагдсан цагаасаа эхлэн дэлхийн томоохон компаниудтай бизнесийн хамтын ажиллагааг тасралтгүй өргөжүүлж дэлхийн шинэлэг, шилдэг технологийг Монголд нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Тайлант оны эцэст Бодь Групп нь Голомт банкны 89,19 хувийг дангаар эзэмшиж байсан бөгөөд 2012 оны 1-р улиралд Trafigura Beheer B.V. компани банкинд хувь нийлүүлэгч болсноор Бодь Групп 84,71 хувийг эзэмших болсон.

Групп нь Монгол Улсын томоохон татвар төлөгч байгууллагуудын нэг бөгөөд компанийн засаглал, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэн ажилчид, хэрэглэгчид, хамтран ажиллагчид бизнесийн бусад бүхий л оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн өндөр ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд онцгой анхаарч Монголын нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн билээ.

Монгол Улсын стратегийн хамгийн том орд болох Оюу толгой төсөл нь Монголын түүхэн дэх хамгийн том уул уурхайн төсөл бөгөөд Бодь групп энэхүү төслийн их бүтээн байгуулалтад өөрийн хувь нэмрийг бодитой оруулан Оюу толгойг үйлдвэрлэлийн зориулалттай цахилгаан эрчим хүчээр хангах цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтын ажил, төмөр тулгуурын нийлүүлэлт болон бусад томоохон төслүүд дээр хамтран ажиллалаа.

Мөн Засгийн газраас атар газар эзэмших, газар тариаланг хөгжүүлэхэд идэвхитэй анхааран ажиллаж байгаатай уялдан Бодь группийн зүгээс 2011 онд улсын зүүн бүсэд сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий хамгийн том усалгааны системийг барьж байгуулсан бөгөөд эхний ургацаа амжилттайгаар хураан авсан.

Группийн Санхүүгийн үзүүлэлт

Бодь групп нь санхүүгийн тайлангуудаа хараат бус аудитын компани болох KPMG Самжонг-оор Олон Улсын Санхүүгийн Тайлагналын Стандартын дагуу хянан баталгаажуулдаг.

Санхүүгийн гол үзүүлэлтүүд

(мянган ам.доллар)	2010	2011
Нийт актив	1,349,029	1,648,902
Өөрийн хөрөнгө	104,701	157,781
Борлуулалт	124,225	167,018
Үйл ажиллагааны ашиг	22,292	32,303
Татварын дараах цэвэр ашиг	21,475	24,886

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь банкны бодлого, стратегийг удирдан чиглүүлж, зээлийн, эрсдэлийн болон хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлон тухайн жилийн төсөв, хөрөнгийн зарцуулалт, бизнес төлөвлөгөөг баталдаг. Түүнчлэн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь ээлжит болон ээлжит бус хуралдаануудаараа банкны төсөв, төлөвлөгөөний биелэлттэй танилцан, төсвийн бодлогод шаадлагатай бол нэмэлт өөрчлөлт оруулдаг. Банкны Төлөөлөн Удирдах зөвлөл нь санхүүгийн хяналт, дотоод аудит, хянан нийцүүлэх үйл ажиллагаа болон эрсдэлийн удирдлагын хяналтын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй.

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь банк, санхүү, бизнесийн салбарт олон жил ажилласан, арвин туршлага бүхий зургаан гишүүнээс бүрддэг. 2011 онд ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Швейцарийн хөрөнгө оруулалтын Swiss-Mo Investment AG-ийг эзэмшигч ноён Урс И.Шварценбахаар өргөжүүлээ. Тэрбээр Швейцари улсын нэрт санхүүч, бизнесмэн бөгөөд Швейцари дахь Монгол Улсын Өргөмжит консул юм.

Аудитын Хороо

Аудитын Хороо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилогддог бөгөөд зөвлөлд ажлаа шууд тайлагнан банкны үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор хяналтын систем, зохих баримтлал, тооцооны аргуудаар санхүүгийн бүхий л асуудалд шударга, үр дүнтэй санал зөвлөмжүүдийг гаргах замаар хяналт тавин ажилладаг.

2010 оны Банкны тухай хуулийн дагуу Дотоод Аудитын Газрыг банкны удирдлагаас хараат бус байхаар зохицуулсан ба бүтцийг шинэчлэн, түүний төсөв, орон тоог батлах, удирдлага, ажилтныг томилох, үйл ажиллагааны журмыг тогтоох, цалин,

урамшууллын хэмжээг тогтоох чиг үүргийг ТУЗ хариуцан ажиллахын хажуугаар тус газрын хөндлөнгийн аудитор Эрнст Янг ХХК-тай хийх хамтын ажиллагааг удирдан ажилладаг.



Арын эгнээнд зүүн гар талаас : Ж.Үнэнбат, Урс И. Шварценбах, Д.Баясгалан, Марк Н. Кютис
Эхний эгнээнд зүүн гар талаас: М.Зоригт, Л.Болдхуяг

Эрсдэлийн Удирдлагын Хороо

Эрсдэлийн Удирдлагын Хороо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилогдон, үйл ажиллагаагаа Зөвлөлд шууд тайлагнан ажиллах бөгөөд банкны эрсдэлийг урьдчилан илрүүлэх зорилгоор эрсдэлийн өсөлт болон хязгаар, тоон хэмжээ, хэмжилт дээр үндэслэн зохих санал зөвлөмжийг гарган ажилладаг.

Цалин Урамшуулал Нэр Дэвшүүлэх Хороо

Цалин Урамшуулал Нэр Дэвшүүлэх Хороо нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэд байгуулагдсан гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудын цалин урамшуулал, нэр дэвшүүлэх бодлогыг боловсруулдаг хөндлөнгийн 3 гишүүнтэй хороо юм. Хороо нь Банкны гүйцэтгэх удирдлага, бусад удирдлагуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн цалин урамшууллыг зөв зохистой тодорхойлж ТУЗ-д санал болгох, эргээд тэдгээрийн ажлын үр дүнг хэлэлцэж дүгнэх зорилго үүрэгтэй хороо юм.


БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ

Бид банкныхаа харилцагч төвтэй байгууллага байх үндсэн зорилтыг үндэслэн өдрөөс өдөрт өргөжин тэлж байгаа бизнесийн цар хүрээ, зах зээлийн эрэлт хэрэгцээнд тохируулж байгууллагын бүтэц зохион байгуулалтаа тогтмол өөрчлөн сайжруулж байна.

2011 оны Компанийн тухай хуульд гарсан өөрчлөлтийн хүрээнд дараах бүтцийн чухал шинэчлэлтийг хийсэн билээ.

- Бүх төрлийн зээлийг батлах, сунгах болон хяналт тавих үйл ажиллагааг сайжруулахын тулд хуучнаар Зээлийн Эрсдэлийн Удирдлагын Хэлтсийг газрын статустай болгож 4 нэгж (Том Байгууллагын хэлтэс, Жижиг Дунд Байгууллагын хэлтэс, Мониторингийн хэлтэс, Мэргэжлийн экспертүүдийн алба)-тэй болгосон.

- Эрсдэлийн Удирдлагын Газар дотор дотоод болон бүс нутаг, олон улсын зах зээлд үүсэх эрсдэлийг тодорхойлох үүрэгтэй Эдийн засгийн судалгааны албыг шинээр байгуулсан.
- Хөрөнгийн Удирдлагын Газрын Санхүүгийн Байгууллагын хэлтсийн үйл ажиллагааг тэлж, Хятад төслийн нэгж болон Хөрөнгө Оруулагчийн Харилцааны нэгжийг шинээр байгуулсан.
- Бүртгэл тооцооны газарт худалдааны санхүүжилтийн хяналт, гүйцэтгэлийг зохицуулах үүрэгтэй Худалдааны Санхүүжилтийн хэлтсийг шинээр байгууллаа.





УДИРДЛАГЫН БАГ

Банк нь мэргэжлийн өндөр ур чадвар бүхий туршлагатай удирдлагын багтай бөгөөд энэ нь үйл ажиллагааны болон санхүүгийн үр дүнгээс тодорхой харагддаг. Тэдний зарим нь банк байгуулагдсан цагаас эхлэн өнөөг хүртэл ажиллаж байна. Бүтэц зохион байгуулалтын дагуу Гүйцэтгэх захирал, Үйл Ажиллагаа Хариуцсан Тэргүүн дэд захирал, Тэргүүн Дэд захирал бөгөөд Иргэдийн банкны группын захирал, Дэд захирал, Газрын захирал, Хэлтсийн захирал гэсэн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.



Д.Мөнхтөр

Үйл ажиллагаа хариуцсан
Тэргүүн Дэд захирал



Г.Ганболд

Тэргүүн Дэд захирал,
Иргэдийн банкны группын захирал



М.Чимэгмөнх

Дэд захирал, Санхүүгийн
Удирдлагын Газрын захирал



Л.Оюун-Эрдэнэ

Дэд захирал, Байгууллагын
Банкны Газрын захирал



М.Чингүн

Дэд захирал, Эрсдэлийн
Удирдлагын Газрын захирал



Ж.Ганбат

Дотоод Аудитын Газрын захирал



Б.Загал

Дэд захирал, Хөрөнгө Оруулалтын
Банкны Газрын захирал



Б.Энхтуяа

Дэд захирал, Иргэдийн Банкны
Газрын захирал



Б.Мөнхбаатар

Хөрөнгийн Удирдлагын Газрын
захирал



Т.Нямсүрэн

Зээлийн Газрын захирал



Ё.Пүрэвбат

Бүртгэл Тооцооны Газрын захирал



Б.Түвшинзаяа

Санхүүгийн Байгууллагын
Хэлтсийн захирал



Төлөөлөн Удирдах Зөвлөл	Д.Баясгалан Л.Болдхуяг М.Зоригт Ж.Үнэнбат Марк Н. Кютис Урс И. Шварценбах Б.Түвшинзаяа	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Нарийн бичгийн дарга
Аудитын Хороо	О.Ганжолоо Ж.Үнэнбат Марк Н. Кютис Урс И. Шварценбах Б.Тамир М.Шинэжаргал	Дарга, мэргэшсэн нягтлан бодогч Нарийн бичгийн дарга, мэргэшсэн нягтлан бодогч
Эрсдэлийн Удирдлагын Хороо	Л.Болдхуяг М.Зоригт Урс И. Шварценбах Жон П. Финиган М.Чимэгмөнх М.Чингүн	Дарга Нарийн бичгийн дарга
Цалин Урамшуулал, Нэр Дэвшүүлэх Хороо	Д.Баясгалан М.Зоригт Ж.Үнэнбат З.Солонго	 Нарийн бичгийн дарга
Удирдлагын Баг	Жон П. Финиган Д.Мөнхтөр Г.Ганболд М.Чимэгмөнх Л.Оюун-Эрдэнэ М.Чингүн Б.Загал Б.Энхтуяа Ж.Ганбат Б.Мөнхбаатар Т.Нямсүрэн Ё.Пүрэвбат Н.Цэрэндаваа Б.Түвшинзаяа З.Хайдар	Гүйцэтгэх захирал Үйл ажиллагаа хариуцсан Тэргүүн Дэд захирал Тэргүүн Дэд захирал, Иргэдийн банкны группын захирал Дэд захирал, Санхүүгийн Удирдлагын Газрын захирал Дэд захирал, Байгууллагын Банкны Газрын захирал Дэд захирал, Эрсдэлийн Удирдлагын Газрын захирал Дэд захирал, Хөрөнгө Оруулалтын Банкны Газрын захирал Дэд захирал, Иргэдийн Банкны Газрын захирал Дотоод Аудитын Газрын захирал Хөрөнгийн Удирдлагын Газрын захирал Зээлийн Газрын захирал Бүртгэл Тооцооны Газрын захирал Мэдээллийн Технологийн Газрын захирал Санхүүгийн Байгууллагын Хэлтсийн захирал Картын Удирдлагын Төвийн захирал



ХҮНИЙ НӨӨЦ

Банкны ажилтнууд маань мэргэжлийн өндөр чадвартай, туршлагатай, ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг байх нь бидний амжилтыг тодорхойлогч гол хүчин зүйл юм.


Бид чадварлаг ажилтнуудыг татах, хөгжүүлэхийн тулд ажлын дэвшилтэт орчин нөхцлийг бүрдүүлэх, шагнал урамшууллын нэгдсэн бодлого журам, албан тушаал ахиж дэвших зэрэг өргөн боломжуудыг бий болгохыг зорьж ажилладаг.

Чадварлаг ажилтнуудыг татах

Банкны өсөлт, хөгжилтэй холбоотойгоор хүний нөөцийг бүрдүүлэх, зөв зохистой удирдах нь 2011 оны гол зорилт байлаа. Банкны зүгээс өргөжин тэлж байгаа бизнесийн хэрэгцээ, орчинд нийцсэн, байгууллагын үнэт зүйл болсон хүний нөөцийн төлөвлөлтийн хүрээнд “хамгийн шилдэг”-ийг татах бодлогыг хэрэгжүүлсээр ирлээ. Ажил олгогч байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэхэд баримталдаг зарчим, соёлыг илтгэн харуулж, сонгон шалгаруулалт хийх шилдэг аргачлал, брэндийг Монголдоо бий болгож чадсан юм.

“Ажлаа зөв сонгохоос амжилт эхэлдэг” уриан дор бүрдүүлэлтийн аяныг өнгөрсөн жилийн турш амжилттай эхлүүлж, хэрэгжүүлсэн бөгөөд банк санхүүгийн салбарын чадварлаг мэргэжилтнүүдийг татах, түүнчлэн залуу, шинэ төгсөгчдөд чиглэсэн байснаараа онцлог байлаа. Үүний үр дүнд 200 гаруй ажилтан манай гэр бүлийн гишүүн болсон юм.

Ажилтнуудын тоо



Оны эцсийн байдлаар 1329 ажилтан байгаагийн 61 хувь нь 88 салбар нэгжээр дамжуулан харилцагчдад үйлчилгээ хүргэдэг тэргүүн шугаманд ажиллаж байна. Үлдсэн 39 хувь нь төвийн нэгж болон дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй ажиллаж байна.

Хүний нөөцийн үзүүлэлтүүд

	2010	2011
Нийт ажилтнуудын тоо	1,068	1,329
Салбар, тооцооны төв	651	809
Төвийн нэгж	417	520
Хүйсийн харьцаа (Эрэгтэй/Эмэгтэй)	30/70	30/70
Салбар, тооцооны төв	21/79	25/75
Төвийн нэгж	40/60	32/68
Дунд түвшний удирдлага	45/55	46/54
Удирдлагын баг	70/30	75/25
Нийт ажилтнуудын дундаж нас	26.7	26.9
Мэргэжил, боловсрол		
Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, бүрэн дунд	10%	10%
Бакалаврын зэрэг /Дотоодын их дээд сургууль/	72%	73.4%
Магистрын зэрэг /Дотоодын их дээд сургууль/	13%	11.5%
Бакалаврын зэрэг /Гадаадын их дээд сургууль/	3%	3.6%
Магистрын зэрэг /Гадаадын их дээд сургууль/	1%	1.5%

Банкны зүгээс мэргэжлийн ур чадвар, бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын байрны сэтгэл ханамжийг өндөр байлгах зорилгоор үйлчилгээ харилцагчийн ажилтнууд болон төвийн нэгжийн ажилтнуудын сэлгээг өргөн хүрээтэй хийж байна. Энэ нь ажлын байран дээрх сургалтын нэгэн хэсэг билээ.

Манлайллыг дэмжих нь

Банкны зүгээс нийт ажилтнууддаа мэргэжлийн болоод хувь хүний ур чадвараа хөгжүүлэх, ингэснээр албан тушаалын өсөлт, хөгжилд чиглэх талаар төрөл бүрийн сорилт, боломжуудыг бий болгохыг зорьж ажилладаг.

Үүнийг мөн албан тушаалын хөгжилд чиглүүлсэн сургалт, хөгжлийн хөтөлбөрүүд, төлөвлөлтийн модуль зэрэг олон арга хэмжээнүүдийн хүрээнд зохион байгуулдаг бөгөөд ингэснээр хариуцлага, албан тушаалаа ухамсарлах, өөрийн үүрэг хариуцлагын талаар илүү нухацтай бодох талаар ажилтнууд маань анхаардаг.

2011 онд Удирдах ажилтнууддаа хөгжүүлэх үүднээс “Шилдэг менежер” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд түргэн хугацаанд өсч хөгжих боломжтой дунд түвшний менежерүүдийг энэхүү хөтөлбөртөө хамруулсан. Хөтөлбөр нь багаар болон хувь хүнд чиглэсэн, халамжлах, дагалдах, дасгалжуулах хэсгүүдийг багтаасан удирдах ур чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн агуулгатай байсан.

Банкны зүгээс халамжлах, сургах үйл ажиллагаа нь ажилтнууддаа мэргэжлийн, удирдлагын, манлайллын ур чадваруудыг эзэмшүүлэх зорилготой бүхэл бүтэн соёлыг хамруулсан байдаг билээ. Энэ зорилгод хүрэхийн тулд сургагч багш нар шинээр томилогдсон захирлууд, салбарын менежерүүдэд сургалт хийгээд зогсохгүй, дагалдуулагч ажилтан шинэ ажилтнууддаа сургалт, чиглүүлэх хөтөлбөрийг зааж өгөх уламжлал тогтсон.

Банкны албан тушаалын төлөвлөлт, хөгжлийн бодлоготой нийцүүлэн ажилтнуудын төлөвлөлт хийдэг бөгөөд ирээдүйн удирдах ажилтнууддаа бэлтгэх зорилготой “Мэргэшсэн менежер” хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэ хөтөлбөрт хамрагдсан оролцогчид удирдлагын болон борлуулалтын ур чадвараа нэмэгдүүлэх сургалтанд хамрагдаж, тусгайлан боловсруулсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, даалгавар биелүүлэх зэргээр туршилтын, хөгжлийн үйл ажиллагаанд оролцдог.

Ажилтнууддаа урамшуулж, хөгжүүлэх нь

Ажилтнууддаа урамшуулж, хөгжүүлэх зорилготой “Урамшууллын багц хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байгаа бөгөөд ажилтнууд маань ажилдаа илүү анхаарах, ажлаа дээд зэргийн чанартай, стандарттай гүйцэтгэхэд энэхүү хөтөлбөр чиглэгддэг.

- Тэтгэврийн ууган сан: Олон жил тогтвор суурьшилтай ажиллаж байгаа ажилтнууддаа урамшуулах, тэтгэвэрт гарсны дараа санхүүгийн хувьд баталгаатай байх боломжийг бий болгох зорилгоор Тэтгэврийн Ууган Санг байгуулсан бөгөөд 2011 оны 12-р сарын байдлаар гишүүдийн тоо 174-өөр нэмэгдэж, хуримтлалын хэмжээ 194,7 сая төгрөгөөр өссөн байна.
- Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр — Ажилтнууддаа урт хугацаанд тогтвортой ажиллахад нь хөшүүрэг болох АХЭХ-ийг боловсруулсан бөгөөд банкны хувь эзэмшигч болж, өөрийн гэсэн үл хөдлөх хөрөнгөтэй болгох зорилготой. 2011 оны эцсээр 41 ажилтан хувь эзэмшигч болсон байна.
- “Эрүүл мэндийн үзлэг” — Ажилтнууд эрүүл, аюулгүй ажиллах нь хамгийн чухал тул Монголдоо хамгийн томоохонд тооцогдох УБ-Сонгодо эмнэлэгтэй хамтран банкны нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан оношлогоо, шинжилгээнд хамруулсан. Үзлэг оношлогооны зардлыг банк, ажилтан ижил тэнцүү хуваан гаргасан.
- Цалин урамшууллын бодлого хөтөлбөр нь гүйцэтгэлд суурилсан байхад чиглэж байна.

Сургалт ба хөгжил

Манай ажилтнууд бол бидний хамгийн үнэт нөөц гэдэгт бид итгэдэг бөгөөд мэргэжлийн сургалт хөгжлийн олон талт хөтөлбөрийг тасралтгүй зохион байгуулсаар ирсэн. Бүх түвшний ажилтнуудад чиглэсэн хөтөлбөрүүд, мэргэжлийн сургалтуудыг албан тушаалын онцлогт нийцүүлэн зохион байгуулж байна.

**Сургалтын үзүүлэлтүүд**

	2009		2010		2011	
Сургалтын зардал /төгрөг/	144,940,942		190,555,054		315,800,659	
Тоон үзүүлэлтүүд	Сургалтанд оролцогчид	Сургалтын цаг	Сургалтанд оролцогчид	Сургалтын цаг	Сургалтанд оролцогчид	Сургалтын цаг
Гадаад сургалт	20	1,120	24	1,176	34	1,512
Дотоод сургалт	1,518	15,410	2,055	39,403	2,573	30,392
Гадны сургалт	581	5,328	516	5,544	624	8,632
Бүгд	2,119	21,858	2,595	46,123	3,231	40,536

- Дээрх хүснэгтэд харуулсанчлан 2011 онд 239 сургалт зохион байгуулсан бөгөөд 3231 оролцогч 40,000 цагийн хөтөлбөрт хамрагдсан байна.
- Шинэ ажилтнуудад зориулсан чиглүүлэх сургалтыг шинэчилсэн хөтөлбөрийн дагуу “Голомтын Гоёо-Голомтын Соёл” нэртэйгээр нийт 178 ажилтныг хамруулан зохион байгуулсан. Энэхүү сургалтанд хамрагдсанаар ажилтнууд маань мэргэжлийн болон зайлшгүй шаардлагатай мэдлэг, мэдээллийг олж авахын зэрэгцээ банкны соёл, бодлого, үйл явцтай танилцаж, ажилдаа түргэн хугацаанд дасан зохицдог.
- Гадаад сургалтын тоо, үргэлжлэх хугацааны хувьд өнгөрсөн онтой харьцуулахад өссөн бөгөөд Ази, Европ, Хойд Америк, Ойрхи Дорнод зэрэг 17 оронд зохион байгуулагдсан 31 сургалтанд ажилтнуудаа хамруулсан.
- Салбарын захирал, харилцааны менежерүүд, харилцагчийн үйлчилгээний ажилтнуудад зориулсан сургалтуудын тоо, давтамж ихсэхийн зэрэгцээ агуулга, хөтөлбөр илүү боловсронгуй болж, мэргэжлийн хөгжил талдаа илүү анхаарах болсны зэрэгцээ ажилтнууд маань харилцагчид үйлчлэх, дээд зэргийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн мэргэжлийн хувьд өсөөд зогсохгүй, албан тушаалын хувьд өсөж хөгжиж байгаа сайн тал харагдаж байна.

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ ДЭД БҮТЭЦ

Банкны үйл ажиллагааны цар хүрээ өдөр ирэх бүр өргөжин тэлж мэдээллийн технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээний тоо, хамрах хүрээ нь нэмэгдсээр байна. Өнгөрөгч онд бид банкныхаа мэдээллийн технологийн аюулгүй байдалд мэргэжлийн байгууллагаар аудит хийлгэх, цаашид хэрхэн ажиллах талаар зөвлөмж авах зорилгоор аудитын Deloitte & Touche Enterprise Risk Services Pte Ltd компаниар мэдээллийн технологийн аюулгүй байдлын аудит хийлгэлээ. Энэ ажлын хүрээнд компьютерын систем, сүлжээ, програм хангамжийн ажиллагааны зарчим, найдвартай, аюулгүй байдал, нууцлалын аудит хийлгэж, өдөр ирэх бүр өсөн нэмэгдсээр байгаа мэдээллийн технологийн хэрэгцээ, шаардлагад хэрхэн нийцэж ажиллах талаар зөвлөмж авсан нь бидний ажилд ихээхэн дэмжлэг үзүүлэв.

Банкны системийн өсөлт, системийн тасралтгүй ажиллагааг хангах, дэвшилтэт технологийн үр бүтээмжийг бий болгох зорилгоор банкны нэгдсэн удирдлага бүхий сервер систем, тоног төхөөрөмжийн технологийг шинэчлэн сайжруулав. Монгол Улсын банк санхүүгийн системд анхлан интернет банкны цогц үйлчилгээг нэвтрүүлсэн билээ. Энэхүү байр сууриа бататган интернет банкны үйлчилгээг шинэ технологид тулгуурлан ашиглахад хялбар, нууцлал, найдвартай байдлыг сайжруулан бусад онлайн үйлчилгээг удирдах нэгдсэн удирдлага бүхий цогц систем болгон өргөжүүллээ. Мөн “Лавлах төв”-ийн телефон утасны аналог системийг дижитал системд шилжүүлж, орчин үеийн лавлах төвийн хэрэгцээ шаардлагад үндэслэн програм хангамж суулгаж, серверийг шинэчиллээ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ



ИРГЭДИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА


Иргэдийн банкны бизнес нь банкны тогтвортой өсөлтийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Банк нь эрсдэлтэй активын багцын 43 хувийг эзэлдэг иргэдийн бизнесийн үйл ажиллагааны өсөлтөнд анхаарал хандуулахын зэрэгцээ Монгол Улсын эдийн засгийн эрчимтэй өсөлтийг даган улам бүр өргөжин тэлж буй жижиг дунд үйлдвэрлэл, өсөн нэмэгдэж буй дунд орлоготой иргэдийг санхүүгийн үйлчилгээгээр дэмжих чухал үүргээ гүйцэтгэсээр байна.

Биет салбар, тооцооны төв болон цахим банкны үйлчилгээний сувгаараа дамжуулан харилцагч, үйлчлүүлэгчиддээ санхүүгийн иж бүрэн үйлчилгээг чанарын өндөр түвшинд хүргэх нь иргэдийн банкны бизнесийн хамгийн чухал зорилго юм. Үйлчилгээнийхээ хурд, түргэн шуурхай байдлыг улам сайжруулах үүднээс цахим банкны үйлчилгээ, сувгийг хөгжүүлэхэд онцгойлон анхаарч байна. Бид Монгол Улсад төлбөрийн картын үйлчилгээгээрээ манлайлагч байр сууриа хадгалахын зэрэгцээ харилцагчдад санхүүгийн үйлчилгээг илүү үр ашигтай, иж бүрэн хүргэх байдлаар салбар, тооцооны төвийнхөө үйл ажиллагааг шинэчлэн сайжруулав. Төлбөр тооцооны системд одоогоор давамгайлж буй бэлэн мөнгөний гүйлгээний тоо хэмжээг бууруулах, электрон худалдаа, төлбөр тооцоог дэмжих зорилгоор Төлбөр Тооцооны Үндэсний Зөвлөлийн үйл ажиллагааг бүх талаар дэмжиж ирлээ.

Салбар нэгжийн суваг, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах

Хүн ам, бизнесийн төвлөрөл бүхий газар нутаг, ирээдүйд Монгол Улсын эдийн засгийн эрчимтэй өсөлтийн тулгуур төв болох бүс нутгуудад банкны салбар нэгжийг өргөжүүлэх стратегийнхаа дагуу нийтдээ 18 нэгжийг шинээр нээгээд байна. Тухайлбал Улаанбаатар хотод 7, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд, Дорноговь зэрэг аймгуудад нийт 11 нэгжийг шинээр байгуулах, үйл ажиллагааг нь өргөжүүлэх ажлыг хийлээ. Одоогийн байдлаар банк нийт 88 нэгжтэй байгаагийн 51 нь Улаанбаатар хотод, 37 нь орон нутагт, нийт 21 аймгийн 12-т нь үйл ажиллагаа явуулж байна.

Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага, бизнес эрхлэгчид, ханган нийлүүлэгчид болон тэдгээрийн ажилчдад санхүүгийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх, үр ашигтайгаар хамтран ажиллахын тулд Монголын зэс, алт, мөнгөний олборлолтоор тэргүүлэгч Оюу толгой уурхайд, Өмнөговийн Гашуун сухайт болон Ховдын Ярант хилийн боомтуудад банкны нэгжүүдээ нээлээ.





Банкны салбар, тооцооны төвүүдээс гадна банкны электрон сувгууд болох АТМ-ийн өргөн сүлжээ, Монгол Улсын хамгийн өргөн сүлжээ бүхий Картаар үйлчлэгч байгууллагуудаараа дамжуулан, цаашлаад интернэт банк, мобайл банк, мессеж банк зэрэг цахим банкны үйлчилгээгээр харилцагчиддаа түргэн шуурхай үйлчилж байна. Бид АТМ-ийн сүлжээгээ 132-т хүргэж, Монгол Улсад анх удаа хөдөлгөөнт АТМ-ийн үйлчилгээг нэвтрүүлсэндээ таатай байна. Түүнчлэн манай банк Монгол Улс дахь нийт картын төлбөр тооцооны 60 хувийг дангаар гүйцэтгэж байна. Тайлант 2011 онд Картаар үйлчлэгч байгууллагын тоог 44 хувиар өсгөж, Монгол Улсад дэлхийн бүх төрлийн брэнд картуудыг хүлээн авдаг цорын ганц банк бөгөөд Монгол Улсад төлбөрийн картын хамгийн өргөн сүлжээтэй банк гэсэн байр сууриа хадгаллаа. Голомт Банкны картаар үйлчлэгч байгууллагуудад хийгдсэн нийт бэлэн бус төлбөр тооцооны хэмжээ 82 хувиар өссөн бол уг байгууллагуудад олон улсын банкуудын төлбөрийн картаар хийгдсэн бэлэн бус төлбөр тооцооны хэмжээ 59 хувиар нэмэгдсэн байна.

Тайлант онд интернэт банкаар хийгдсэн гүйлгээний хэмжээ 101 хувиар, интернэт банкаар хийгдсэн банк хоорондын гүйлгээний хэмжээ 64 хувиар тус тус өслөө. Мөн интернэт банк, мессеж банк болон дансны орлого зарлагын мэдээллийг мессежээр илгээх Easy info үйлчилгээний боломжийг нэмэгдүүлж шинэчлэн сайжрууллаа. Жилийн турш хийсэн цахим үйлчилгээний сайжруулалт, хөгжүүлэлтийн үр дүнд уг үйлчилгээний хэрэглэгчдийн тоо эрс нэмэгдсэн ба:

- Идэвхитэй интернэт банкны хэрэглэгчдийн тоо 103 хувиар
- Онлайн данс эзэмшигчдийн тоо 260 хувиар
- "Easy Info" мессежээр орлого, зарлагыг мэдээлэх үйлчилгээний хэрэглэгчдийн тоо 260 хувиар
- Мобайл банкны хэрэглэгчдийн тоо 139 хувиар тус тус өссөн.

Иргэдийн банкны бизнест өрсөлдөх давуу талаа нэмэгдүүлэх, харилцагчдынхаа өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангахын тулд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлсээр байна. Үүнд:

- Blackberry, iPhone, Android гэх мэт ухаалаг утсанд зориулсан банкны аппликэйшн буюу Смарт банк үйлчилгээ
- Залуу гэр бүлд зориулсан орон сууцны зээлийн үйлчилгээ
- Хувийн сууц худалдан авах зээлийн үйлчилгээ
- Шинэчилсэн төрлийн хадгаламжийн сертификатын үйлчилгээ
- Харилцагчдад амьдралынхаа зорилгод хүрэх боломжийг олгох зорилготой "Зорилготой хадгаламж" үйлчилгээ

Жижиг дунд бизнесийн банкны үйл ажиллагаа

Үйл ажиллагааны цар хүрээгээ хурдацтайгаар тэлж буй жижиг дунд бизнес эрхлэгчид нь Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжлийн нэн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Жижиг дунд бизнес нь хүн амын амьжиргааны түвшин, эдийн засгийн өсөлтийг хангахад голлох үүрэг гүйцэтгэж, ажлын байрны тоо болон бага, дунд орлоготой иргэдийн орлогыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой байдлыг хангах замаар чадварлаг хувийн хэвшлийг Монгол Улсад хөгжүүлэхэд голлох үүргийг гүйцэтгэж байна. Тиймээс Банк бизнесийн үйл ажиллагааныхаа стратегид Монгол Улсын эдийн засгийн өсөлттэй шууд хамааралтай байдаг жижиг дунд бизнесийн салбарт үзүүлж буй үйлчилгээний төрөл, хүртээмж, зах зээлд эзлэх хувь хэмжээгээ нэмэгдүүлэхийг зорьж байна. 2011 оны байдлаар жижиг дунд бизнесийн зээлийн хэмжээ 86.3 тэрбум төгрөгөөр (75 хувиар) өсч 201.9 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны нийт зээлийн багцын 16 хувийг бүрдүүлж байна.

Бизнес эрхлэгчдийн бизнесийн болон хувийн санхүүгийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахуйц банкны цогц үйлчилгээг санал болгох зорилгоор банкны бүсчилсэн салбарын загвар болгож "Бизнес Төв"-ийн үйл ажиллагааг эхлүүллээ. Уг Бизнес төвөөр жижиг дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн иж бүрэн үйлчилгээг нэг дороос, цогц байдлаар авах, банкны бүтээгдэхүүн үйлчилгээг хослуулан авах боломжийг бүрдүүлсэн. Энэхүү бүсчилсэн салбарын загвар нь ажилтнуудын ажил үүргийн хуваарь, борлуулалтын арга барилд өөрчлөлт оруулж одоо байгаа салбарын үйл ажиллагааг илүү үр өгөөжтэй болгон сайжруулж байгаа юм. Улмаар харилцаан дээр тулгуурласан борлуулалтын үйл ажиллагаагаар харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг санал болгоно.

Мөн түүнчлэн Банк нь үйл ажиллагаа явуулж буй орон нутгууддаа жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан сургалт, зөвлөгөө, бизнес инкубаторын үйлчилгээг үзүүлсээр байна.

Банк нь жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Засгийн газрын болон Олон улсын байгууллагуудтай хамтран олон төрлийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнд:


- “Ноос, ноолуурын төслийн зээл” , “ЖДҮХСангийн төслийн зээл”-ийг дамжуулан зээлдүүлэх хүрээнд нийт 29.3 тэрбум төгрөгийн зээлийг ЖДБ эрхлэгчдэд олгосон
- ХХААХҮЯамны ЖДҮХСангийн ЖДҮ эрхлэгчдийг дэмжих төслийн зээлийг дамжуулан зээлдүүлдэх тухай хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулж тус төслийн зээлийг Улаанбаатар хот төдийгүй орон нутгаар олгож эхэлсэн
- Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллагаас “ЖДҮХ, БО хамгаалах 2 үе шаттай зээлийн төсөл”-ийн 2-р шатанд оролцогч албан ёсны санхүүгийн байгууллагаар шалгарсан.

Үндэсний хэмжээний томоохон 5 аудитын газраас жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих төслийн зээлийн үйл ажиллагааг хянан шалгасан ба Банк Монгол Улсын арилжааны банкуудаас хамгийн сайн үзүүлэлттэй буюу 95 хувийн амжилттай ажилласан дүгнэлтийг авсан.

Орон сууцны зээлийн үйл ажиллагаа

Хүрээлэн буй орчныг хамгаалах, хүн амыг орон сууцжуулах замаар хотын хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах зорилгын хүрээнд Банк иргэдийн шаардлагад нийцсэн хамгийн таатай нөхцөл бүхий орон сууцны зээлийн үйлчилгээг санал болгож байна.

Орон сууцны зээл (тэрбум төгрөг)



Орон сууцны зээлийн багцын хэмжээ өмнөх оноос 140 хувиар өсч, 112.5 тэрбум төгрөгөөс 192.6 тэрбум төгрөгт хүрсэн. Орон сууцны зээлээр орон сууцтай болсон өрхийн тоо 2011 онд 105 хувиар өсч 4090 өрхөд хүрсэн. Залуу гэр бүлийг дэмжих, өөрийн эзэмшлийн хөрөнгөтэй болоход нь туслах зорилгоор Залуу гэр бүлд зориулсан орон сууцны зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр нэвтрүүлээ.


Банк харилцагч албан байгууллагуудынхаа түлхүүр ажилтнуудад хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцны зээлийг санал болгож, ажилтан тухайн байгууллагадаа урт хугацаанд тогтвортой ажиллах боломжийг олгож дэмжлэг үзүүлдэг. Эдгээр зээл нь манай нийт орон сууцны зээлийн багцын 43 хувийг эзэлж байна.

Банк нь иргэдийг орон сууцжуулах, чанартай орон сууц худалдан авах боломжийг бий болгох зорилгоор дотоодын тэргүүлэгч барилгын компаниудтай нягт хамтран ажилладаг.

Хэрэглээний зээлийн үйл ажиллагаа

Эдийн засгийн бүхий л салбаруудад гарсан хурдацтай өсөлтийн үр дүнд дунд орлоготой иргэдийн тоо нэмэгдэж байгаа билээ. Дундаж давхаргын иргэдийн худалдан авах чадвар сайжирч байгаа нь тээврийн хэрэгсэл, өргөн хэрэглээний

Хэрэглээний зээл (тэрбум төгрөг)



бараа, электрон хэрэгсэл болон боловсролын салбарын үйлчилгээний эрэлт өсч буйгаас харагдаж байна. Банк харилцагчдын өсөн нэмэгдэж буй энэхүү эрэлтийг хангахын тулд хүчин чадлынхаа зохистой хэм хэмжээний хүрээнд хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнээ санал болгон тогтмол өргөжүүлэн хянаж байна. Тайлант онд хэрэглээний зээл 60.4 тэрбум төгрөгөөр өсч 126.6 тэрбум



төгрөгт хүрсэн нь 2010 оны эцсийн үзүүлэлт болох 66.2 тэрбум төгрөгөөс даруй 91 хувиар өссөн үзүүлэлт юм. Банк хэрэглээний зээлийн боломжийг нэмэгдүүлэн машин, гэр ахуйн тавилга зэрэг өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг худалдан авах харилцагчийн санхүүгийн хэрэгцээнд нийцүүлэн 270 гаруй худалдааны байгууллагатай хамтран ажиллаж байна.

Банк сар бүр тодорхой хэмжээний хуримтлал үүсгэн ирээдүйд зорилгоо биелүүлэх боломжийг олгодог уян хатан нөхцөл бүхий “Зорилготой хадгаламж” нэртэй шинэ хадгаламжийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн. Харилцагчдын бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийн хүү нөхцлийн талаарх мэдлэгийг өргөжүүлэх тал дээр бид ач холбогдол өгөн ажилладаг бөгөөд харилцагчдын хэрэгцээ шаардлагыг тодруулах, түүнд нь зориулсан тохиромжтой бүтээгдэхүүнийг санал болгох үүднээс харилцагчдын дунд сургалт семинарыг тогтмол зохион байгуулдаг.

БАЙГУУЛЛАГЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Байгууллагын Банкны Газар нь өөрийн харилцагчид болох Монгол Улсын томоохон аж ахуйн нэгжүүдээс хүлээлгэсэн итгэлийн дүнд амжилт бүтээлээр дүүрэн бас нэгэн жилийг ардаа орхилоо. Бид чадварлаг баг бүрэлдэхүүнээрээ дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд, олон улсын байгууллагуудад банк санхүүгийн иж бүрэн үйлчилгээг хүргэж ажилладаг. Бид харилцагчиддаа байгууллагын харилцах, хадгаламжийн данс, зээл, худалдааны санхүүжилт, хамтарсан санхүүжилт, санхүүгийн түрээс, төслийн санхүүжилт, экспортын санхүүжилт, валютын арилжаа, бэлэн мөнгөний менежмент зэрэг олон төрлийн банк санхүүгийн үйлчилгээг санал болгон ажилладаг.

Мөн түүнчлэн дэлхийд тэргүүлэгч олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран экспортыг дэмжих урт хугацааны санхүүжилтийн хэрэгслийг Экспортын Санхүүжилтийн Агентлагтай хамтран Монголын зах зээлд нэвтрүүлсэн нь Европын холбоо болон Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа Хөгжлийн Байгууллагын гишүүн орнуудаас Монгол Улс руу чиглэсэн худалдаа, хөрөнгө оруулалтын урсгалыг дэмжих зорилготой юм. Тиймээс уг үйлчилгээ нь импортлогчид урт хугацаанд зах зээлийн хүүгээс бага хүүтэйгээр зээлээ эргүүлэн төлөх боломжийг олгодгоороо давуу талтай юм. Голомт банк нь дэлхийд нэртэй олон улсын банк санхүүгийн байгууллага болох Credit Suisse, Czech Export Bank, US EXIM Bank, Sumitomo Mitsui Banking Cooperation мөн Чех улсын Komerční Bank-тай хамтран ийм төрлийн зээлийг харилцагчдадаа санал болгож байна.

Байгууллагын Банкны Газар нь дэд бүтэц, барилга байгууламж, усжуулалтын төслүүд, зам тээвэр, эрчим хүч, уул уурхайн мөн Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй төслүүд дээр хамтран ажиллаж, банкны үйлчилгээг амжилттай үзүүлж ирсэн. 2011 онд гүйцэтгэсэн эдгээр төслүүдээс дурьдахад:

- Улаанбаатар хот дахь 20 мянган өрхийн орон сууцны төсөл
- Эрдэнэс Таван Толгойн анхны хувьцаа гаргалтанд зөвлөхөөр ажилласан дотоодын банк
- Оюу-Толгой ХХК-д эргэлтийн хөрөнгийн зээл олгох эрх бүхий дотоодын банкуудын нэг
- МИАТ ХК-ийн B-767 300ER Boeing онгоц худалдан авалтын урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг хийсэн банк
- Олон Улсын Агаарын Тээврийн Холбооны төлбөр тооцоог гүйцэтгэгч Монгол дахь цорын ганц банк.

Төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, санхүүгийн харилцаагаа өргөтгөх зорилгын хүрээнд:

- Гаалийн ерөнхий газар болон Авто Тээврийн Газартай хамтран ажиллах гэрээ
- Монголын автозамын барилга угсралтын компаниудыг дэмжих зорилгоор Зам Тээвэр Барилга Хот Байгуулалтын Яамтай санамж бичгийг тус тус байгууллаа.

2011 онд бид дотоодын бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Засгийн Газар, Азийн Хөгжлийн Банк, Дэлхийн Банк зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажилласан. Байгууллагын Банкны Газар нь Азийн Хөгжлийн Банктай Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийг дэмжих төслийн хүрээнд Нэмэгдсэн өртгийн гинжин холбоо, Хөдөөгийн дэд бүтэц болон



үйлчилгээг хөгжүүлэх, мөн Төслийн удирдлагын бүрэлдэхүүнүүдийг хөгжүүлэх чиглэлээр хамтын санхүүжилтийн гэрээг байгуулсан. Үүнээс гадна Дэлхийн банктай хамтран Хувийн Хэвшлийг Хөгжүүлэх-2 Төслийн зээл, Техник Тусалцааны төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан.

Уул уурхайн салбарт зориулсан банкны үйлчилгээ

Бид Монгол Улсын тэргүүлэгч арилжааны банкны хувьд уул уурхайн салбар болон уг салбарт бүтээгдэхүүн үйлчилгээ ханган нийлүүлэгчдэд зориулсан бизнесийн зээл, гадаад худалдааны санхүүжилт, санхүүгийн түрээс, хамтын санхүүжилтын зээл болон төлбөр тооцооны үйлчилгээ зэрэг бүхий л төрлийн банк санхүүгийн үйлчилгээг харилцагчиддаа хүргэсээр байна.

Түүнчлэн бид Монгол Улсын төрийн өмчит Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани болох Эрдэнэс Таван Толгой ХК-тай хамтран ажиллахаар итгэмжлэгдсэн ба уг хамтын ажиллагааны хүрээнд тус компанийн коксжих нүүрсний олборлолтыг эхлүүлж БНХАУ-руу экспортлох үйл ажиллагааг дэмжигч дотоодын санхүүжүүлэгч анхны арилжааны банк болж чадсан нь бидний бас нэгэн бахархал юм.

Бид бүх төрлийн банк санхүүгийн үйлчилгээгээ уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагууд болон тэдгээрийн ажиллагсад түргэн шуурхай, найдвартай хүргэхийн зэрэгцээ Монгол Улсын томоохон уул уурхайн төсөл хэрэгжиж буй орон нутагт тэдгээрт зориулсан банкныхаа салбар нэгжээр дамжуулан харилцагчдынхаа санхүүгийн эрэлт хэрэгцээнд бүрэн нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэн ажиллаж байна. Бид цаашид ч бүтээгдэхүүн үйлчилгээгээ өргөжүүлэн зах зээлд тэргүүлэгч байр сууриа улам бэхжүүлэхийг зорин ажиллах болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөрөнгө Оруулалтын Банкны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хувийн болон төрийн эзэмшилтэй компаниуд, төрийн агентлагууд, байгууллагуудад санхүүжилтийн эх үүсвэрээр хангахад зуучлах, тохиролцох, хөрөнгө босгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлэх болно.

Хөрөнгө оруулалтын банкны газрын бизнесийн хэтийн зорилго нь хөрөнгө оруулалтын банкны хамгийн чанартай үйлчилгээгээр эрхэм харилцагчдынхаа бизнесийн хөгжлийг дэмжиж, улмаар урт хугацааны харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгоход оршино. Банкны арвин туршлага, мэргэжлийн ур чадвар бүхий хөрөнгө оруулалтын мэргэжилтнүүд, банкируудаас бүрдсэн баг нь харилцагч нэг бүрийнхээ эрэлт хүсэлтэнд тулгуурласан үйлчилгээг хүргэснээр урт хугацааны харилцааг бий болгох юм.

Харилцагч нэг бүрийнхээ бизнесийн үйл ажиллагаа, стратегийн талаар нарийвчилсан ойлголтыг авч ажилласнаар бид харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж, улмаар тэдгээрт тохирсон санхүүжилтын стратегийг боловсруулан, түргэн шуурхай үйлчлэх боломжтой болдог. Голомт банкны Хөрөнгө Оруулалтын Банкны Газрын үйл ажиллагааны хүрээ:

- Санхүүжилт босгох, хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох, зээлийн болон эргэлтийн хөрөнгийн санхүүжилт, үйл ажиллагааны цар хүрээг өргөтгөн шинэ зах зээлд нэвтрэх болон үндсэн бизнесийн өсөлтийн санхүүжилт
- Боломжит хөрөнгө оруулагчидтай харилцаа холбоог тогтоох
- Монголын зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын танилцуулга, судалгааг хийх
- Хамтын хөрөнгө оруулалтыг бий болгох
- Хөрөнгө оруулагчидтай боломжит санхүүжилтийн тохиролцоог хийх
- Зах зээлийн шинжилгээ судалгааг хийх
- Бичиг баримт бүрдүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэх.



Хөрөнгө Оруулалтын Банкны Газар нь харилцагч байгууллагуудынхаа дотоодын өргөжилт, шинээр компани худалдан авч өөртөө нэгтгэх төсөл, ногоон бизнестэй холбоотой төслүүд зэрэг өргөн цар хүрээ бүхий төслүүдийн хэрэгцээ шаардлагад нь нийцсэн зээлийн болон хөрөнгийн санхүүжилтийн үйлчилгээг үзүүлдэг. Байгуулагдсан цагаасаа хойш Голомт банк нь санхүүгийн олон байгууллагуудтай үр ашиг бүхий харилцааг бий болгож чадсан бөгөөд Банкны уламжлалт санхүүгийн хамтрагч нараас гадна томоохон хувийн хөрөнгө оруулалтын институтууд, шинэ үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулагч сангууд, бүсийн болон төвлөрсөн банкууд, даатгалын болон үндэсний хөгжлийн сангууд зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудтай хөрөнгийн удирдлагын ажлыг амжилттай гүйцэтгэж байна. Хувьцаа болон үнэт цаасны бүтээгдэхүүнээс эхлээд хоёрдогч өглөгийн зээлээр болон санхүүжилтээр хамтран ажиллах гүүр хэлбэрээр хөрөнгө босгох боломжийг олгодог. Хамтрагч байгууллагуудын маань хөрөнгө оруулалтын салбарт хуримтлуулсан туршлага, ухаан болон Голомт банкттай үүсгэсэн бат харилцаа нь харилцагчдад хөрөнгө оруулалтын олон боломжийг санал болгох, зах зээлээ мэдэрч чадсан санхүүгийн багц үйлчилгээг үзүүлэх, үйлчилгээний нөхцөл, чанар, хэмжээг сайжруулах замаар сэтгэл ханамжийг дээд зэрэгт хүргэх боломжийг бүрдүүлж байна.

Түүнчлэн Хөрөнгө Оруулалтын Банкны газар нь өөрсдийн харилцагчиддаа хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээ үзүүлэхийн тулд Андеррайтерын тусгай зөвшөөрөл болон Голомт Банкны анхны 100 хувийн хөрөнгө оруулалттай брокерийн компани болох "Голомт Секюритиз" ХХК-ийг байгуулж харилцагчиддаа үзүүлэх хөрөнгө оруулалтын үйлчилгээний цар хүрээгээ өргөжүүлсэн. Голомт Секюритиз ХХК харилцагчиддаа дотоод, гадаадын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаанд оролцох бололцоог олгож, хөрөнгийн зах зээлийн чанартай судалгаанд үндэслэсэн хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгч ажиллаж байна.

Голомт Секюритиз ХХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаа хийх суудал, олон улсын хөрөнгийн биржүүдэд арилжаанд оролцох эрхийг авч харилцагчийн өмнөөс арилжаа гүйцэтгэх, санхүүгийн зуучлах үйлчилгээг үзүүлж эхлээд байна.

ГАДААД ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТ БА ОЛОН УЛСЫН ТӨЛБӨР ТООЦОО

Манай банк дэлхийд тэргүүлэгч олон банкттай тал бүрийн хамтын ажиллагааг бэхжүүлсэн бөгөөд өнгөрсөн хоёр жилийн хугацаанд үйлчлүүлэгчдийнхээ төрөл бүрийн валютын хэрэгцээ шаардлагыг хангаж байх зорилгоор олон улсын гол банкууд болох Bank of China, Citigroup, CIBC, Wells Fargo, Construction Bank of China Intesa, Sanpaolo, Agricultural Bank of Russia, ING, ANZ, Barclays, Kazkommertsbank, VTB Bank зэрэг банкуудтай шинээр харилцаа тогтоон хамтарч ажиллаж байна. Мөн SWIFT-ийн сүлжээнд тулгуурласан банк хоорондын электрон шилжүүлгээс гадна, 200 гаруй оронд үйл ажиллагаагаа явуулдаг, хамгийн өргөн хэрэглэгддэг мөнгөн шилжүүлгийн компаниудын нэг болох Western Union үйлчилгээг тус тус үзүүлж байна.

Бид олон улсад тэргүүлэгч банкуудыг харилцаандаа нэгтгэснээр стратегийн чухал ач холбогдол бүхий түншлэлийг бий болгож чадсан бөгөөд Stanhope-ийн хөрөнгө оруулалтаар дамжуулан Credit Suisse болон Abu Dhabi Investment Council-ийн хоёрдогч өглөгийн зээлийг нэвтрүүлээд байна. Энэхүү стратегийн түншлэл нь манай өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон хөрвөх чадварыг нэмэгдүүлэхэд, мөн олон улсын шилдэг туршлагыг эрсдэлийн удирдлага болон үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд гол түлхэц болсон.

Тайлант онд олон улсын болон бүс нутгийн тэргүүлэгч банкуудтай харилцах корреспондент банкны хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн ажилласан ба улмаар банкны тайлант онд гүйцэтгэсэн олон улсын төлбөр тооцооны хэмжээ 28.4 хувиар, дотогш чиглэсэн олон улсын төлбөр тооцооны хэмжээ 12,1 хувиар, гадагш чиглэсэн олон улсын төлбөр тооцооны хэмжээ 37,5 хувиар тус тус өсчээ.

Валютын арилжаа гүйлгээний өргөн туршлага, банкны түншлэлийн нягт харилцаа, санхүүгийн зөв менежменттэйгээрээ нийтэд танигдсан зэрэг нь эх үүсвэрээ байршуулах Монголын санхүүгийн байгууллага хайж буй гадаадын үйлчлүүлэгчдийг татахад давуу байр суурийг олгож байдаг. Банкны нягт түншлэлийн харилцааны тусламжтайгаар бид үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээг хангах үүднээс цогц шийдэл бүхий худалдааны санхүүжилтын үйлчилгээг санал болгодог. Энэхүү үйлчилгээ нь мөнгөн урсгалыг зөв зохицуулах мөн гадаад худалдаанаас үүсч болох эрсдэлийг бууруулж өгдөг. Манай худалдааны санхүүжилтийн гол үйлчилгээнд импорт экспортын аккредитив (худалдааны санхүүжилтийн нийт хэмжээ 2011 онд 72 хувиар өссөн), стандбай аккредитив, батлан даалт, баримтын инкасс, зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээнүүдээс гадна дэлхийд тэргүүлэгч харилцагч банкуудаар дамжиж буй бусад төлбөр тооцоо болон холбогдох валют арилжааны гүйлгээнүүд багтдаг. Үүний зэрэгцээ бид үйлчлүүлэгч байгууллагууддаа валют арилжаа болон валютын форвард хэлцлийн үйлчилгээг үзүүлдэг.

НӨӨЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хөрөнгийн Удирдлагын Газар нь банкны төлбөрийн чадвар, мөнгөний зах зээл дээрхи үйл ажиллагаа, валютын арилжаа болон нөөцийн үйл ажиллагааг удирддаг ба 2011 онд банкны төлбөрийн чадварыг хамгийн өндөр түвшинд байлгаж дотоодын банк санхүүгийн зах зээлд тэргүүлж ажиллалаа.

Хөрөнгийн удирдлага болон хөрвөх чадварын удирдлага

Хөрөнгийн Удирдлагын Газар нь банкныхаа өдөр тутмын төлбөрийн чадварын хэрэгцээ болон илүүдэл нөөцийг удирдаж, банкны нөөцийг Монголбанк болон дэлхийд тэргүүлэгч корреспондент харилцаатай банкуудад байршуулж, түүнчлэн Төв Банкны Үнэт Цаас, Засгийн Газрын Үнэт Цаас болон бусад төрлийн үнэт цаасны хөрөнгө оруулалтанд хийж ажиллалаа. Тус газар нь аливаа арилжаанд оролцохдоо банкны Эрсдэлийн хорооноос тогтоосон хязгаарлалтын хүрээнд оролцдог. Мөн нөөц хөрөнгийг эрсдэлээс хамгаалах үүднээс хүүгийн болон валютын санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг ашигладаг хэдий ч богино хугацааны ханшийн өөрчлөлтөөс ашиг олох зорилгоор ашигладаггүй.

Тус газар нь илүүдэл нөөц хөрөнгийг удирдахдаа зээлийн, ханшийн, хүүгийн болон бусад эрсдэлүүдийг харгалзан үзэхийн зэрэгцээ аль нэг сектор, зах зээл, нэг төрлийн валют эсвэл дан ганц байгууллагад төвлөрсөн хөрөнгө оруулалтаас зайлсхийж хамгийн найдвартай санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулалт хийдэг. Түүнчлэн банкны өдөр тутмын мөнгөн урсгалд хяналт тавьж удирддаг. Банк нь голлох нөөц хөрөнгөө Төв банкны үнэт цаас /ТБҮЦ/-нд байршуулдаг. Оны эцсийн байдлаар манай банкны эзэмшиж байгаа үнэт цаас нийт үнэт цаасны 20 хувийг эзэлж байсан ба түүнчлэн дотоодод шинэлэг зах зээл болох Засгийн Газрын үнэт цаасны арилжаанд зонхилох байр суурьтай оролцож оны эцсийн байдлаар олон нийтэд нээлттэй арилжаалсан Засгийн Газрын үнэт цаасны 22,8 хувийг эзэмшиж байна.

Валютын арилжаа

2011 онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 3 дугаар сард 1195.27 байсан бол 12 дугаар сард 1396,37 хүрч 16.82 хувиар хэлбэлзсэн нь гадаад худалдаанд гарсан алдагдал болон инфляцийн хүлээлттэй холбоотой байлаа. Валютын ханшийн хэлбэлзэл өндөр байсан тул дотоодын валютын зах зээл дэх гол оролцогчийн хувьд дотоодын валютын зах зээлийг хөгжүүлэхэд илүүтэй анхаарч ажилласан ба харилцагч гадаад худалдаа эрхлэгчид болон хөрөнгө оруулагчдын ханшийн эрсдэлийг үр ашигтайгаар хамгаалах үүднээс гадаад валютын своп, форвард хэлцлүүдийг зах зээлд анхлан нэвтрүүлж хөгжүүлэн ажиллаж байна. Мөн түүнчлэн банк нь дотоодын санхүүгийн зах зээлийн хөгжилд тэргүүлэгчийн хувьд дотоодын санхүүгийн зах зээлийн боломж, цар хүрээг нэмэгдүүлэх арга замууд, ханшийн ил тод байдал болон эрсдэлээс хамгаалах боломжуудыг бий болгохын тулд Валют Арилжааны Мэргэжилтнүүдийн Дөрөвдүгээр Зөвлөгөөнийг Монголбанкттай хамтран амжилттай зохион байгуулсан.



САНХҮҮГИЙН ҮР ДҮН, ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ


САНХҮҮГИЙН ҮР ДҮН

2011 онд Голомт Банк нь харилцагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хувь хэмжээгээрээ хамгийн том банк гэсэн байр сууриа хадгалж чадсан ба балансын гол үзүүлэлтүүдээ 40 орчим хувиар нэмэгдүүлсэн амжилттай ажиллалаа.


Томоохон амжилтуудаас дурьдвал:

- Нийт активын хэмжээ 557.7 тэрбум төгрөг (35 хувь)-өөр өсч 2.13 их наяд төгрөг (1.53 тэрбум ам.доллар)-т хүрсэн нь банкны системийн нийт активын 23 хувийг эзэлж байна
- Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 522.6 тэрбум төгрөг (40 хувь)-өөр өсч 1.84 их наяд төгрөг (1.32 тэрбум ам.доллар)-т хүрсэн нь банкны системийн нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 28 хувийг эзэлж байна
- Харилцах дансны хэмжээ 112 тэрбум төгрөг (23 хувь)-өөр нэмэгдэж 589.5 тэрбум төгрөгт хүрсэн
- Хугацаагүй хадгаламжийн хэмжээ 79.7 тэрбум төгрөг (27 хувь)-өөр нэмэгдэж 374.9 тэрбум төгрөгт хүрсэн бол хугацаатай хадгаламж 330.9 тэрбум төгрөг (61 хувь)-өөр нэмэгдэж 875.8 тэрбум төгрөгт хүрлээ.

Нийт актив (тэрбум төгрөг)




Нийт харилцах, хадгаламж (тэрбум төгрөг)




- 30.2 тэрбум төгрөгийн цэвэр ашиг болон 20 сая ам.долларын Swiss Mo Investment AG-ын хөрөнгө оруулалтын үр дүнд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө 56.4 тэрбум төгрөгөөр өсч 140.2 тэрбум төгрөгт, хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө 48.9 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт өөрийн хөрөнгө 48 хувиар өсч 189.1 тэрбум төгрөг (135.4 сая ам.доллар)-т хүрсэн байна.
- Цэвэр зээлийн хэмжээ 461.3 тэрбум төгрөг (59 хувь)-өөр өсч 1.25 их наяд төгрөг (0.9 тэрбум ам.доллар)-т хүрсэн нь банкны системийн хувьд олгосон нийт зээлийн 23 хувийг эзэлж байна.

Нийт өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)




Цэвэр зээл (тэрбум төгрөг)




- Цэвэр ашгийн хэмжээг 2010 оны үзүүлэлт болох 20.1 тэрбум төгрөгөөс 10.2 тэрбум төгрөг (51 хувь)-өөр өсгөж 30.2 тэрбум төгрөгт хүргэж чадлаа

- Үйл ажиллагааны орлогын хэмжээ 36.2 тэрбум төгрөг (78 хувь)-өөр өсч 82.6 тэрбум төгрөг (59.2 сая ам.доллар)-т хүрсэн
- Цэвэр хүүгийн орлогын хэмжээ 19.2 тэрбум төгрөг (65 хувь)-өөр өсч 48.9 тэрбум төгрөг (35 сая ам. доллар)-т хүрсэн ба Цэвэр хүүгийн ахиуц харьцааг 3.6 хувьд барьж ажиллалаа
- Цэвэр хүүгийн бус орлогын хэмжээ 16.7 тэрбум төгрөгөөс 16.9 тэрбум төгрөг (101 хувь)-өөр өсч 33.7 тэрбум төгрөгт хүрсэн
- Валют арилжааны орлого 11,7 тэрбум төгрөгөөр өсч 19,5 тэрбум төгрөгт хүрсэн
- Шимтгэл хураамжийн орлого 5.6 тэрбум төгрөг (44 хувь)-өөр өсч 18.2 тэрбум хүрсэн бөгөөд нийт өсөлтийн 35 хувь нь карттай холбоотой үйлчилгээнээс бүрдсэн байна.


Үйл ажиллагааны орлого (тэрбум төгрөг)




Зардал орлогын харьцаа (%)



Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (%)




Чанаргүй зээлийн харьцаа (%)




Тайлант онд банк нь системийн хэмжээний 14 арилжааны банкуудаас санхүүгийн хамгийн хүчирхэг үзүүлэлтээр ялгарах давуу талаа хадгалж ажиллалаа.

- Цэвэр зээл хадгаламжийн харьцаа 67.7 хувьтай байсан нь зохистой түвшинд буюу банкны системийн дундаж үзүүлэлт болох 83.4 хувиас харьцангуй бага байна
- Зардал орлогын харьцаагаа 2010 оны 44 хувиас 37.5 хувьд хүргэж бууруулж чадлаа
- Чанаргүй зээлийн харьцаа буурч 2 хувьд хүрсэн нь өрсөлдөгч банкуудтай харьцуулахад хамгийн сайн үзүүлэлт бөгөөд энэхүү үр дүн нь зээл олгох хатуу бодлого болон зээлийн сайн хяналтын илэрхийлэл юм
- Зээлийн эрсдэлийн сан чанаргүй зээлийн харьцаа нь 2010 оны үзүүлэлт болох 63.6 хувиас өсч 79.8 хувьд хүрсэн байна
- Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 13.3 хувь нь Монголбанкны тогтоосон 12 хувийн шаардлагыг хангаж байна
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 38.9 хувьтай байсан нь банкны системтэй харьцуулахад хамгийн сайн үзүүлэлт байлаа.

Зээл эх үүсвэрийн харьцаа (%)



Төлбөрийн чадварын харьцаа (%)





Таван жилийн санхүүгийн үр дүн

	2007	2008	2009	2010	2011
Балансын үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Нийт актив	652,051	697,179	1,013,109	1,573,413	2,131,065
Нийт харилцах, хадгаламж	512,485	505,171	795,251	1,317,499	1,840,136
Цэвэр зээл	323,026	447,787	505,299	784,605	1,245,919
Өөрийн хөрөнгө	54,871	63,548	78,471	127,774	189,087
Үр ашгийн үзүүлэлтүүд (сая төгрөг)					
Хүүгийн орлого	44,564	69,318	81,832	111,157	165,165
Хүүгийн зардал	(30,228)	(43,569)	(57,905)	(81,448)	(116,240)
Цэвэр хүүгийн орлого	14,336	25,749	23,927	29,708	48,925
Цэвэр хүүгийн бус орлого	7,231	8,912	13,333	16,749	33,686
Үйл ажиллагааны зардал	(10,078)	(15,178)	(16,712)	(21,242)	(32,545)
Эрсдэлийн сангийн зардал	(2,299)	(3,958)	(3,240)	983	(8,681)
Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт	-	-	-	-	(1,450)
Татварын зардал	(1,811)	(3,324)	(4,138)	(6,145)	(9,691)
Татварын дараах ашиг	7,378	12,201	13,170	20,053	30,244
Санхүүгийн бүтцийн харьцаанууд					
Нийт харилцах, хадгаламж/Нийт актив	78.6%	72.5%	78.5%	83.7%	86.3%
Өөрийн хөрөнгө/Нийт актив	5.9%	7.3%	6.3%	5.3%	6.6%
Цэвэр зээл/Нийт актив	49.5%	64.2%	49.9%	49.8%	58.5%
Цэвэр зээл/Нийт харилцах, хадгаламж	63.0%	88.6%	63.5%	59.6%	67.7%
Чанаргүй зээл/Нийт зээл	4.2%	3.9%	4.4%	2.1%	2.0%
Хөшүүргийн харьцаа (дахин)	10.9	10.0	11.9	11.4	10.3
Ашигт ажиллагааны харьцаанууд					
Дундаж активын өгөөж (%)	1.6%	1.8%	1.6%	1.7%	1.7%
Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (%)	17.3%	24.3%	22.5%	26.6%	26.3%
Цэвэр хүүгийн ахиуц (%)	4.1%	4.2%	4.1%	3.6%	3.6%
Зардал орлогын харьцаа (%)	46.7%	43.8%	44.9%	44.0%	37.5%
Эрсдэлийн үзүүлэлтүүд					
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ >12%	14.4%	12.8%	13.4%	13.5%	13.3%
Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлтүүд:					
Нийт гадаад валютын хувьд <+/-40%	8.1%	11.9%	11.8%	17.1%	10.5%
Нэг гадаад валютын хувьд <+/-15%	5.8%	9.5%	10.0%	11.2%	-5.1%
Нэг зээлдэгч болон түүнд холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөд эзлэх хувь <20%	17.5%	19.5%	19.9%	17.6%	19.7%
Холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөд эзлэх хувь <5%	2.7%	3.7%	3.5%	3.4%	3.4%
Холбогдох этгээдэд олгосон нийт зээлийн нийт өөрийн хөрөнгөд эзлэх хувь <20%	8.8%	10.5%	15.9%	10.3%	12.6%
Төлбөрийн чадварын харьцаа	49.3%	37.0%	51.7%	51.2%	38.9%
Үндсэн хөрөнгийн харьцаа <8%	1.0%	1.0%	0.7%	1.6%	1.4%

ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

2011 оны 11 сард санхүүгийн үнэлгээний байгууллага болох Standard & Poor's нь манай банкны тогтвортой төлөв бүхий, урт хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт BB, богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт B үнэлгээнүүдийг тус тус өгсөн бөгөөд үүгээрээ банк нь Standard & Poor's- ээс үнэлгээ авсан анхны Монголын банк болж байгаа билээ.

2012 оны 1 сарын 2-нд Standard & Poor's нь зөвхөн Монголд үйл ажиллагаа явуулж буй банкуудын тулгуур оноог тогтоохын тулд, Монголын эдийн засаг болон аж үйлдвэрийн эрсдэлийн түвшингээс шалтгаалан тус үнэлгээний байгууллагын дотоод үнэлгээний аргачлалд өөрчлөлт оруулснаар Голомт банкинд өгсөн урт хугацааны үнэлгээг B+ эерэг төлөвтэй болгож өөрчилсөн. Түүнчлэн Standard & Poor's нь манай банкны бизнесийн үйл ажиллагааг хүчирхэг гэж дүгнэж байгаа нь манай банк дотоодын салбартаа зах зээлийн байр суурь сайн эзэлж буйг илтгэж байна. Манай зээлийн сайн бүтээгдэхүүн үйлчилгээ, олон улсын худалдааны санхүүжилт, арилжааны үйлчилгээ болон салбар нэгжүүдийн өндөр бүтээмжтэй байдал зэрэг нь зах зээлд үйл ажиллагаа явуулж буй бусад байгууллагуудтай харьцуулахад илүү тогтвортой, олон талын эх үүсвэрийг бий болгоход гол түлхэц болдог. Санхүүгийн үнэлгээний байгууллагын үзэж байгаагаар, аливаа санхүү эдийн засгийн хүндрэлийн үед Голомт Банк нь систем дэх чухал банкны хувьд Монголын Засгийн Газраас ямар нэгэн далд хэлбэрийн дэмжлэг хүртэх магадлалтай хэмээн үзэж байна.

Энэхүү үнэлгээний нэг үе шатаар буурсан байдал нь Монголын эдийн засаг, үүнтэй холбогдох банкны өөрийн бизнесийн үйл ажиллагаа нь ямар нэгэн байдлаар доройтсоноос болсон гэсэн утгатай биш, харин уг үнэлгээний байгууллагын үнэлгээний аргачлалд гарсан өөрчлөлтийг өмнөх сул талууд дээр тусгаснаас үүдэлтэй билээ.

Түүнчлэн 2011 оны 11 сард Голомт Банк нь Moody's олон улсын санхүүгийн үнэлгээний байгууллагаас банк санхүүгийн чадамжийн үзүүлэлтээр D- үнэлгээ авсан ба энэ нь урт хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадвараар Ba3 түвшинд хүрч байгаа юм. Мөн гадаад валютын нөөцөөрөө B2, дотоод валютын нөөцөөрөө Ba3 үнэлгээнүүдийг тус тус авч тогтвортой төлөв байдалтай байна. Энэхүү үнэлгээнд хүрэхэд дотоодын салбаруудын ашигт үйл ажиллагаа, хадгаламж харилцахын хувьд салбартаа тэргүүлэгч, мөн байгууллагын зээл, худалдааны санхүүжилт, ашигт үйл ажиллагаа бүхий хангалттай хөрөнгийн байр суурьтай байгаа зэрэг нь гол хүчин зүйл болсон.

Саяхнаас олон улсын санхүүгийн үнэлгээний байгууллага болох Moody's нь манай болон бусад үнэлгээ авсан Монголын банкуудын үнэлгээг дахин хэлэлцэж эхэлсэн юм. Энэхүү алхам нь Moody's-ийн дэлхий нийтийн үнэлгээний хэрэгжүүлэлтийн зааварчилгаа шинэчлэгдэж голч шалгуур үзүүлэлт нь тухайн улсын болон санхүүгийн байгууллагын зээлийн үнэлгээнүүдийн уялдаа холбоог тусган дахин боловсруулагдаж байна.

Санхүүгийн үнэлгээний байгууллагуудын дунд гардаг түгээмэл жишгийг харуулан, Standard & Poor's-ийн нэгэн адилаар Moody's нь банкны болон Монголын Засгийн Газрын санхүүгийн тогтвортой байдал, эдгээрийн чадамжид ямар нэгэн доройтсон нөхцөл байдал үүсээгүй байхад өөрсдийн дотоод үнэлгээний аргачлалд өөрчлөлт оруулсан. Moody's-ийн энэхүү алхам нь Европын зэргэлдээ орнууд, тэдгээрийн засгийн газрын төсвийн алдагдлыг өөрсдийгөө ороосон байдлаар санхүүжүүлж байсан банкны салбарынханд өгсөн үнэлгээнд гаргасан алдаа нь уг үнэлгээний аргачлал өөрчлөгдөхөд нөлөөлсөн гэдэг нь илт байгаа билээ. Гэсэн хэдий ч Голомт Банк болон манай улсын бусад банкууд Монгол Улсын Засгийн Газрын өр зээлийг санхүүжүүлэхэд ямар нэгэн байдлаар оролцоогүй гэдэг нь Moody's-ийнхэнд илт байгаа юм.





ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА БА ХЯНАЛТ

Зээлийн эрсдэлийн удирдлага

Зээлийн эрсдэл бол харилцагч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа биелүүлээгүйгээс үүдэх эрсдэл юм. Бидэнд учирч болох зээлийн эрсдэл нь зээлийн багц, хөрөнгө оруулалтын актив болон хүлээж болзошгүй өр төлбөрүүд болно. Зээлийн эрсдэлийг зээлдэгч тус бүрээр болон эдийн засгийн салбараар зээл, баталгаа, батлан даалт, аккредитив, банк хоорондын хадгаламж, санхүүгийн бусад хэрэгслүүдийг хамруулан цогцоор нь хэмжээ хязгаарлалт тогтоох замаар удирддаг. Мөн түүнчлэн хөрөнгийн удирдлагын бүхий л үйл ажиллагаанд шаардлагатай гэж үзвэл хэмжээ хязгаарлалт тогтоох замаар эрсдэлийг удирддаг.


Голомт банкны зээлийн үйл ажиллагаа, стратеги, бодлого, журмууд нь Базелын хорооноос баталсан Зээлийн эрсдэлийн удирдлагын үндсэн 16 суурь зарчмыг мөрдлөг болгодог. Энэхүү 16 суурь зарчим нь нэгд зохистой зээлийн эрсдэлийн орчинг бий болгох, хоёрт ул суурьтай зээл олгох, гуравт зээлийн хэрэг бүртгэл, хэмжих хэмжүүр, тайлагналын тогтолцоог бий болгох, дөрөвт ул суурьтай үр дүн бүхий хяналтын тогтолцоог бий болгох зэрэг үндсэн 4 бүлэг 16 зарчмыг тогтоосон байдаг.

Голомт банкны зээлийн бодлого нь банкны өсөлтийг дэмжих үндсэн стратегийн хүрээнд зээлийн эрсдэлийг боломжит хамгийн бага түвшин хүртэл бууруулахад чиглэгддэг. Бидний таамаглаж буйгаар Монгол Улсын эдийн засгийн өсөлт дунд хугацаанд хадгалагдах учир зээлийн багц, зээл олголтын хэмжээ өсөх хэдий ч бид зээл олгох үйл ажиллагааг ул суурьтай дүрэм журмын хүрээнд удирдаж ажиллах ёстой. Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл, Эрсдэлийн Удирдлагын Хороо, удирдлагын баг нь зээлийн бодлого, стратегийг батлах, хэрэгжилтийг тогтмол хугацаанд хянах үүрэгтэй. Мөн түүнчлэн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь эрсдэлийн удирдлагын үндсэн харьцаануудаас гадна нийт актив, өөрийн хөрөнгийн харьцаа, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл-хадгаламжийн харьцааг тогтоох, удирдах үүрэгтэй.

Бид дотоод зээлийн үнэлгээний системийг хөгжүүлснээр том байгууллагын болон жижиг дунд байгууллагын 50 сая төгрөгөөс дээш дүн бүхий зээл хүсэгчдийн зээлээ эргэн төлөх чадварыг судлах, зээлийн зарцуулалтыг нарийвчлан судлах замаар бие даасан хараат бус дүгнэлт өгдөг. Уг систем нь гурван хүчин зүйлийг дэлгэрэнгүй тооцоолдог. Энэ нь зээлдэгчийн үйл ажиллагааны үндсэн болон туслах салбар, бизнесийн үндэс суурь, хэтийн төлөв (зээлдэгчийн туршлага, хэрэглэгчид болон бизнесийн сегментийн диверсификаци, зах зээлд эзлэх хувь болон брэнд) болон зээлдэгч тус бүрийн санхүүгийн ил тод байдал юм. Эдгээр зээлийн үр дүн, үнэлгээг Зээлийн Хороо, Зээлийн Дэд Хороо болон Салбарын Зээлийн Хороогоор хэлэлцүүлэн шийдвэрлэдэг ба зээлийн үлдэгдэлд хяналт тавьдаг.

Бид том байгууллагын болон жижиг дунд байгууллагын зээлийг судлахдаа зээлдэгчийн зээлийн түүх, чадамж, салбар, маркетинг ба хэрэглэгчийн зан төлөв, менежмент болон хяналт, санхүүгийн нөхцөл байдал, зээлийн барьцаа зэргийг бусад зүйлсээс илүү ач холбогдолтойгоор авч үздэг.

Бид иргэдийн зээлийн судалгаанд зээл хүсэгчийн ажлын түүх, цар хүрээ, одоогийн ажилдаа ажилласан жил, сар бүрийн төлбөр-орлогын харьцаа 45 хувиас хэтрэхгүй (орон нутагт 55 хувиас хэтрэхгүй) байх, мөн зээлдэгчийн ажил олгогчоос гаргасан баталгаа, батлан даалт авах зэргийг бусад зүйлсээс илүү ач холбогдолтойгоор авч үздэг. Харилцагчийн 30 сая төгрөгөөс дээш дүнтэй зээлийг заавал Зээлийн Дэд Хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг. Орон сууцны зээлийн хувьд бид зээлдэгчид гурван жилээс доошгүй хугацаагаар хөдөлмөрийн гэрээ хийсэн байхыг, тэдний сарын төлбөрийн дүн нийт орлогын харьцаа 45 хувиас хэтрэхгүй байхыг тус тус шаарддаг. Бүх орон сууцны зээл Зээлийн Дэд Хорооны хурлаар хэлэлцэгдэн шийдвэрлэгддэг.



Зээл олгох бодлого, үйл явц

Бид зээлийн эрсдэлийг нягт нямбай хяналт ба зээл, хөрөнгө оруулалтын багцуудын чанарт менежмент хийх байдлаар удирддаг. Зээлийн Хороо нь бидний зээлийн бодлоготой холбоотой бүхий л асуудлыг ТУЗ болон Эрсдэлийн Удирдлагын хорооны чиглэлтэй уялдуулан хариуцан ажилладаг. Зээлийн Хороо нь зээлдэгчийн зээлийн эрсдэлийн түвшинд хязгаарлалт тавьж ажилладаг бөгөөд нэг зээлдэгч болон холбоо бүхий бүлэг зээлдэгчийн зээлийн хэмжээг хязгаарлах үзүүлэлтийг балансын эхний болон сүүлийн үзүүлэлтүүдэд тулгуурлан дээд лимит тогтоодог.



Зээлийн Хороо нь зээлийн эрсдэлийг улирлаар болон илүү нарийн давтамжтайгаар хийгдсэн мэдээлэл дүгнэлтэнд үндэслэн тасралтгүй хянадаг. Бид томоохон зээлдэгч бүрийн дэлгэрэнгүй мэдээлэл, дүгнэлтийг жилдээ нэгээс багагүй удаа хийдэг.

Зээлийн хороо нь мөн дэд хороотой бөгөөд энэ нь боломжит зээлийн шийдвэрийг батлах ажлыг хариуцдаг. Зээлийн Хороо нь 300 сая төгрөгөөс дээш дүнтэй зээлд тохирох нөхцлийг баталдаг бөгөөд Зээлийн Дэд Хороо нь 300 сая төгрөгөөс бага дүнтэй зээлд тохирох нөхцлийг баталдаг.

Дээр дурьдсанчлан салбар бүр тогтоосон хязгаарлалтын хүрээнд салбарын зээлийн хороогоор хэлэлцэн зээлийн шийдвэрийг гаргадаг. Салбар бүрийн зээл шийдвэрлэх эрхийн хэмжээг Зээлийн Хороо тогтоодог. Салбарын зээл бие даан шийдвэрлэх эрхийн хэмжээг зээлийн бодлоготой нийцэж байгаа байдал, тэдний ажлын туршлага, эдийн засгийн орчин зэргээс хамааруулан нэмэгдүүлэх ба бууруулдаг.

Зээл олгох үйл явц

Зээл шийдвэрлэх үйл явцыг доорхи байдлаар тайлбарлаж болно.

- Том байгууллагын зээл: Том байгууллагын зээлийн үзүүлэлтүүд нь манай зээлийн активт хамгийн их хувийг эзэлдэг. Том байгууллагын зээлийн хүсэлтийг бизнес хөгжлийн менежер хүлээн авдаг. Том байгууллагын харилцагчид бизнес хөгжлийн менежертэй урьдчилж хүсэлтээ танилцуулан уулзалт хийдэг. Уулзалт бүрийн үр дүнд бизнес хөгжлийн менежер хүсэлтийн нөхцлийг Зээлийн Газрын Том Байгууллагын Хэлтэстэй зөвшилцөн тогтоох ба уг зээлийг Зээлийн Газрын гишүүд хэлэлцэн боломжтой гэж үзвэл Зээлийн Хороо, Зээлийн Дэд Хороо болон салбарын зээлийн хороонд танилцуулахаар бэлддэг. Дараа нь зээлийн мэргэжилтэн хүсэлтийг хүлээн авч, харилцагчийн тухай болон түүний ажилладаг салбарын талаар гүнзгий мэдлэгтэй болохын тулд санхүүгийн шинжилгээг хийдэг. Уг шинжилгээ нь том байгууллагын зээлдэгчийн зах зээлд эзлэх байр суурь, нэр хүнд, зээлжих чадвар, туршлага болон боломжит бүх судалгаа, шинжилгээг багтаасан байдаг. Бид зээлдэгчийн бусад банкууд дахь зээлийн үлдэгдэл, зээлдэгчдийн зээлийн түүхийг хадгалж байдаг Монгол банкны зээлийн мэдээллийн сангаас лавлагаа авдаг ба, хэрэв боломжтой бол татварын газар гэх мэт төрийн байгууллагууд болох гуравдагч этгээдээс зээлдэгчийн талаарх бусад лавлагааг олж авдаг. Хэрэв зээл барьцаагаар хангагдсан бол санал болгосон барьцаа хөрөнгийн үнэлгээг бид дотооддоо бие даасан экспертээр үнэлүүлдэг ба хөрөнгийг барьцаалах тал дээр мэргэжлийн хууль зүйн зөвлөгөөгөөр хангагддаг.
- Жижиг дунд байгууллагын зээл: Жижиг дунд байгууллагын зээл нь 300 сая төгрөгөөс дээш дүнтэй бөгөөд том байгууллагын зээл олгох үйл явцтай ижил юм. 50 сая төгрөгөөс 300 сая төгрөг хүртэлх дүнтэй жижиг дунд байгууллагын зээлийг салбарын болон Зээлийн Газрын Жижиг дунд байгууллагын гишүүд хэлэлцэн боломжтой гэж үзвэл Зээлийн Дэд Хороо болон салбарын зээлийн хороонд танилцуулдаг. Салбарууд болон Зээлийн Газрын Жижиг Дунд байгууллагын хэлтэс зээлийн хүсэлтэд зээлийн үнэлгээ өгч, дотоод үнэлгээний системээр шинжилгээ хийн дүгнэлт гаргаж, Зээлийн Хороо болон салбарын зээлийн хороогоор хэлэлцүүлдэг. Шаардлагатай тохиолдолд олгогдсон зээл дээр ч мөн адил шинжилгээ хийдэг. 50 сая төгрөгөөс дээш дүнтэй бүх зээлүүд Зээлийн Газрын Мониторингийн Хэлтсийн эрсдэлийн дүгнэлттэйгээр холбогдох Зээлийн хороодоор хэлэлцэгдэн батлагддаг.
- Эрсдэлийн үнэлгээ хийх явц: Зээлийн газар нь Байгууллагын Банкны Газар буюу Салбарууд, Жижиг Дунд Байгууллагын Хэлтсээс ирүүлсэн зээлийн хүсэлтүүдэд бие даасан шинжилгээ хийдэг. Уг хүсэлтүүд нь зээлийн програмд “Зээл батлагдахаар хүлээгдэж байгаа” төлөвт бүртгэлтэй байдаг. Зээлийн газар нь ихэвчлэн дотоод ажиллагааны хүчин зүйлд тулгуурлан шинжилгээ хийдэг. Энэ нь олон төрлийн эдийн засгийн салбар, бүтээгдэхүүний салбарын хязгаар, нэг болон хоорондоо холбоо бүхий бүлэг этгээдийн хязгаар, хүссэн зээлийн үнэлгээг тогтоох, зээлийн багцын дуусах хугацааг тодорхойлох, зээлийн багцад харьцуулалт ба жигнэлт хийх болон бусад макро эдийн засгийн үзүүлэлтүүд ба Зээлийн Газрын бодлогод заасан бидний зээл шийдвэрлэх дотоод зааварчилгааны дагуу үнэлгээг хийх юм. Зээлийн хүсэлтүүдийг туршлагатай зээлийн мэргэжилтнүүд судалж зээлийн судалгааг зээлдэгчийн зээл төлөх чадварын үнэлгээнд тулгуурлан бэлтгэдэг. Бид статистикийн мэдээ болон гадны эх

сурвалжаас зээлдэгчийн зээл төлөх чадварын үнэлгээг авч ашигладаг. Зээл шийдвэрлэх бодлогын дагуу зээлийн хүсэлтүүд хэмжээнээсээ хамаарч Зээлийн Хороо, Зээлийн Дэд Хороо болон салбарын зээлийн хороогоор орж шийдвэрлэгддэг.

Эрсдэлийн үнэлгээ хийх үйл явц нь тоон болон чанарын хүчин зүйл дээр үндэслэн харилцагч бүрийн зээлийн эрсдэлийн тус бүрд нь тодорхойлогдоход чиглэгдсэн байдаг ба бүх зээлүүдэд дараах үзүүлэлтүүдийг харгалзан эрсдэлийн үнэлгээ хийдэг. Үүнд: 1- Зээлийн түүх; 2- Зах зээлд эзлэх байр суурь (зах зээлд эзлэх хувь, нэр хүнд); 3-Удирдлага (Ашигт ажиллагаа, маржин, нийт активийн өгөөж, маркетинг, борлуулалтын өсөлт, үйлдвэрлэлийн чадамж, нийт активийн эргэц, дансны авлага, түүхий эд материал); 4- Санхүүгийн байдал (хөрвөх чадвар, өр төлбөр, нийт актив). Зээлийн эрсдэлийн үнэлгээ нь харилцагч зээлдэгчийн бизнесийн үйл ажиллагаа, бизнес эрхэлж буй салбарын тогтвортой байдал, харилцагчийн зан төлөв, өрсөлдөөн, засгийн газраас тогтоосон хязгаарлалтууд, зах зээлийн багтаамж зэрэг өргөн хүрээнд үнэлдэг. Зээлийн эрсдэлийн үнэлгээ нь 1-9 гэсэн тоогоор илэрхийлэгдэх ба 1 гэсэн үнэлгээ нь хамгийн бага, 9 гэсэн үнэлгээ нь хамгийн өндөр эрсдэлтэй байна. Зээлийн эрсдэлийн үнэлгээ ямар байх нь зээлдэгчийн зээлээ хугацаандаа эргүүлэн төлөх чадварыг илтгэдэг ба зээл олголтын хязгаарыг тогтоох, тухайн зээлийн хүсэлтийг зөвшөөрөх, татгалзах эсэхэд нөлөөлдөг.

- Жижиг зээлүүд: Жижиг зээл олгох үйл явц том зээл олгох үйл явцтай ижил. Ихэнх жижиг харилцагчид салбарын зээлийн мэргэжилтнүүдэд хүсэлтээ гаргадаг. Хэрэв жижиг харилцагчдын хүссэн зээлийн нөхцөл, зээлийн материалууд банкны шаардлага хангаж байвал зээлийн мэргэжилтэн хүсэлтийг Зээлийн Газар бүртгүүлж, холбогдох судалгаа дүгнэлтүүдийг салбарын зээлийн хороонд танилцуулах ба зээлийг шийдвэрлэх эрх нь Салбарын Зээлийн Хороонд байдаг. Хэрэв зээлийн дүн салбарын зээл шийдвэрлэх эрхийн хэмжээнээс өндөр бол зээлийн бодлогын дагуу салбарын зээлийн хорооны хурлаар хэлэлцээд, зээлийн хүсэлтийг шийдвэрлэх эрхийг Зээлийн Хороо болон Зээлийн Дэд Хороонд шилжүүлнэ.

Зээлийн мониторинг

Бид зээлдэгчийн зээлээ эргүүлэн төлөх чадварыг тодорхойлохдоо зээлдэгчийн нөхцөл байдал, барьцаа хөрөнгө, зээлдэгчийн зээл, хүүгийн төлбөрийг төлөх боломж зэрэгт шинжилгээ хийж зээлийн хэмжээ, төлөгдөх хугацаа зэргийг тодорхойлдог. Зээлийн Газрын Мониторингийн Хэлтэс зээлийн багцыг бүхэлд нь хянадаг ба “watch list-хянах жагсаалт”-ын аргаар байнгын хяналтыг хэрэгжүүлдэг ба энэ нь сард нэгээс доошгүй удаа байна. Энэхүү хяналтын хүрээнд эрсдэлийн үнэлгээ болон бизнесийн салбарын эрсдэлийг харгалзан үзэж, зээлийн ангиллыг хийдэг. Хяналтын үйл явц нь зээлийн багцын эрдсэл ба эдийн засгийн салбаруудын эрсдэлийн түвшинг ерөнхийд нь үнэлдэг. Харилцааны менежерүүд энэхүү тогтмол хяналтанд оролцдог ба харилцаа холбоон дээрээ тулгуурлан анхаарал, шаардлагуудаа тавьж ажилладаг. Зээл “watch list-хянах жагсаалт”-д орсон тохиолдолд харилцааны менежер харилцагчтай холбогдож зээлийн төлбөр төлөгдөхгүй байх эрдсэлийг бууруулахаар төлөвлөгөө гарган ажилладаг. Мөн энэ үйл ажиллагаанд тухайн зээлийг хариуцсан хэлтэс болон зээлийн мэргэжилтэн, зээлийн ахлах мэргэжилтэн оролцдог. Зээлийн Газрын Мониторингийн Хэлтэс нь холбогдох ажилтнуудын оролцоотойгоор зээлийн багцын харьцаа, тэнцвэрийг үнэлж, удирдахад зориулж эцсийн дүгнэлт тайлангуудыг бэлтгэдэг. Ингэснээр зээлийн чанар, эрсдэл, үр ашиг хэмжүүрийг тодорхойлох, үнэлгээнд хамаарах бусад чухал үзүүлэлтүүдийг онцгойлон авч үзэх ач холбогдолтой юм.

Зээлийг эргүүлэн төлүүлэх үйл явц

Зээлийг эргэн төлүүлэх ажиллагааг харилцааны менежерүүд хариуцдаг. Бүх харилцагчдад зээлийг эргүүлэн төлөхтэй холбоотой аливаа мэдээллийг бичгээр болон аман хэлбэрээр өгдөг ба зээлийг эргэн төлүүлэх чиглэлээр гэрээний дагуу эрчимтэй ажилладаг. Зээлийг эргэн төлөх хугацаа хэтэрснээс хойш 5 хоногийн дотор зээлийн түүх болон, өмнө хугацаа хэтрүүлж байсан эсэх, зээлийн хэмжээ зэргээс хамаарч харилцагчидтай зээлийн эргүүлэн төлөх талаар холбоо тогтоодог. Зээлийн өрийн хэмжээ өндөр байгаа болон зээлийг эргүүлэн төлөх үйл явц удаашралтай байгаа харилцагчдыг түлхүү анхаарч, тогтмол эргэх холбоотойгоор ажилладаг. Байгууллагын Банк болон Иргэдийн Банкны Газрын удирдлага зээлийн хугацаа хэтрэлтэй харилцагчдад анхны удаад утсаар мэдэгддэг ба уг харилцааны үр дүн



ямар байгаагаас хамаарч дараагийн арга хэмжээг хэрэгжүүлдэг. Бүх зээлдэгчидтэй харилцах аман болон бичгийн харилцаа нь мэргэжлийн өндөр түвшинд, ёс зүйн шаардлагыг хангасан байдлаар явагддаг.

Зээлийг эргүүлэн төлүүлэх үйл явцыг тоймловол:

- Бид бүх зээлдэгчиддээ зээлийн дансны хуулга, зээл төлөгдсөн байдал, зээл төлөх хэмжээ, хугацаа хэтрэлтийн мэдээллийг агуулсан тайланг сар бүр илгээдэг. Харилцааны менежер хариуцсан зээлийн дансуудаа тогтмол хянах ба зарим нэг сонгогдсон дансуудыг Зээлийн Газрын зүгээс хамтран хянадаг. Явцын хяналтын үндсэн дээр хугацаа хэтэрсэн болон муудсан зээл дээр зээл эргэн төлүүлэх хөтөлбөрийг боловсруулдаг.
- Эдгээр харилцагчид төлбөрөө 30 хоногоос дээш хугацаа хэтрүүлбэл зээлийн мэргэжилтэн зээлдэгчийн зээлээ төлөх чадварыг дахин үнэлж, тэдгээр харилцагчдад бизнесийн боломжит хувилбаруудыг санал болгодог. Үүнд харилцагчийн өнөөгийн болон ирээдүйн мөнгөн урсгалын чадамжийг бэхжүүлэхийн тулд дансны авлагын бодлого, маркетингийн стратеги, борлуулалтаа өсгөх стратеги, үнийн бодлого болон түүхий эд, барааны эргэлтийг өсгөх зэрэг орно.
- Бүхий л шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч хугацаа хэтрэлт хэвээр байсаар, 90-ээс дээш хоног болсон тохиолдолд уг зээлийн удирдлага, хяналтыг Эрсдэлийн Удирдлагын Газрын Тусгай Активын хэлтэст шилждэг.
- Зээлийг эргүүлэн төлүүлэх бүхий л боломжийг судалж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн хэдий ч зээл төлөгдөөгүй, зээлдэгч зээл төлөх чадваргүй нь тогтоогдсон, эсвэл ямар нэг маргаан гарсан тохиолдолд Тусгай активын хэлтэст шилжүүлж, 30 хоногийн дотор хуулийн дагуу төлүүлэх арга хэмжээг авдаг.


Зээлийн эрсдэлийн загварчлал ба багцын чанар

Бид зээлийн хугацаа хэтрэлт (PD), алдагдлын магадлал (LGD) болон зээлийн эрсдэлийн бусад үзүүлэлтүүдийг тооцоолох загварчлалыг боловсруулан ашиглаж байна. Уг аргачлал нь IAS 39 болон Базелийн хорооноос гаргасан Зээлийн эрсдэлийн загварчлалын шаардлагуудыг бүрэн хангаж, хүлээгдэж буй хугацаа хэтрэлт, алдагдлын хэмжээг тооцоолон зээлийн эрсдэлийн хязгаарлалтууд, бусад зохистой үзүүлэлтүүдийг тогтоох замаар зээлийн эрсдэлийг хянах үр ашигтай хэрэгсэл болж чадсан юм. Чанаргүй зээлд хугацаа нь хэтэрч үнэ цэнэ нь буурсан зээлүүд хамаарна. Зээлийн үнэ цэнийн бууралтыг IAS 32-ын дагуу тогтоодог бөгөөд уг стандартын дагуу зээлийн өнөөгийн үлдэгдэл нь ирээдүйн мөнгөн урсгалаас төлөгдөх зээл, хүүгийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээс их байх зээлүүдийг чанаргүй буюу үнэ цэнэ буурсан зээл гэж үзнэ. Энэхүү дүрэм зээлийн чанарын ангилалд зээлдэгчийн санхүүгийн чадавхаас гадна гадаад хүчин зүйлсийг авч үздэгээрээ давуу талтай юм.

Салбарын шинжилгээ ба төвлөрөл

Бид зээлийн багцын чанарыг урьдчилан тодорхойлсон түвшинд барих үүднээс төвлөрлийн хязгаарлалтыг тогтоож, хэрэгжүүлдэг. Бизнесийн нэг салбарт, эсвэл эдийн засгийн аль нэг сегментэд зээлийн хэт төвлөрөл үүсэхээс зайлсхийх зорилгоор банкны зээлийн бодлогод эдийн засгийн нэг салбарт олгох зээлийн дээд хэмжээг нийт багцын 30 хувиас хэтрэхгүй байхаар заасан. Нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээ, холбоотой буюу хамааралтай зээлдэгчдэд олгох зээлийн дээд хэмжээ болон рейтинг, улс орны хязгаарлалт зэрэг үзүүлэлтүүд ч зээлийн бодлогод тусгагдсан байдаг. Манай зээлийн төвлөрлийн үзүүлэлтүүд өнөөгийн Монгол Улсын эдийн засгийн бүтэц төвлөрсөн, төрөлжилт муутайг харуулж байгаа бөгөөд удирдлагууд салбарын төвлөрлийн эрсдэлийг бууруулах боломжтой гэж үзэж байгаа ба зээлийн багцаа төрөлжүүлэх боломжуудыг олж харахын тулд эдийн засгийн салбарт тогтмол шинжилгээ хийж байдаг. 2011 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт зээлийн багцын 13.3 хувийг уул уурхайн салбар, 9.7 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбар тус тус эзэл байгаа нь багцад хамгийн өндөр дүнг эзэлж байгаа юм.

Зээлийн эрсдэлийг хэмжих аргачлал



Зээлийн ангилал ба зээлийн алдаглыг хүлээн зөвшөөрөх бодлого

Зээлийн хороо нь зээлийн багцын чанарыг зохицуулж, сайжруулахыг хариуцдаг. Эрсдэлийн Удирдлагын Газрын Багцын Эрсдэлийн Удирдлагын хэлтэс нь төвлөрсөн систем ашиглан зээлийн багцын чанарыг үнэлэх ба зээлийг алдагдал болсон үед шаардлагатай нөөцийг бүрдүүлж зээлийн багцыг бүхэлд нь хянаж байдаг.

Зээлийн ангилал: Зээлүүд тогмол хяналтанд байдаг ба энэ нь зээлд байгаа аливаа асуудлыг эрт илрүүлэхэд тусалдаг. Мөн 1 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй зээлүүдийн хувьд

улирал бүр болон төлбөрийн график хуанлийн 14 хоногоос илүү зөрчигдсөн тохиолдолд зээлдэгч бүрийн санхүүгийн нөхцөл байдалд гүнзгий шинжилгээг хийдэг. Бид барьцаа хөрөнгийн төлөв байдалд үнэлгээг жилд дөрвөөс багагүй удаа хийдэг. Зээлийн эргэн төлөлт нэг өдрөөр хоцроход л Зээлийн Газар уг асуудлыг арилгах ажлаа эхэлдэг.

Зээл болон балансын бус үзүүлэлтүүд нь дараах зүйлсээр ангилагддаг: Харилцагчийн санхүүгийн гүйцэтгэл, үндсэн зээлийн ба хүүгийн эргэн төлөлтийн хугацаа, барьцаа хөрөнгийн чанар, зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулсан эсэх, бусад зээлүүдийн эргэн төлөлтийн хугацаа, зээлийг зориулалтын дагуу ашигласан эсэх, бусад зээлүүдийн хувьд уг зээлдэгч алдагдал учруулсан эсэх болон харилцагчийн үнэлгээ болно.

Багцын Эрсдэлийн Удирдлагын Хэлтэс нь зээлийн багцын эрсдэлийн шинжилгээг хийж сар бүр тайлагнадаг. Зээлийн Газар нь зээлийн эргэн төлөлтийн хугацаа ба ангилагдсан зээлүүд, болзошгүй өр төлбөрүүдийн талаарх нарийн анхааруулгыг уг тайланд тусгадаг. Хэрэв үндсэн болон хуримтлагдсан хүүгийн эргэн төлөлтөнд асуудал үүсвэл зээлийн эргэн төлөлтөнд хяналт тавин хариуцан ажилладаг хэлтсүүд шууд арга хэмжээ авдаг. Зээлийн багцад хамаарах хөрөнгүүдийн чанар болон болзошгүй өр төлбөрүүдийн талаар бүхэлд нь Зээлийн Газар мэдээлэл хийдэг.

IFRS зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх: Бидний санхүүгийн тайлан болон уг тайланд тусгагдсан санхүүгийн бусад мэдээллүүд IFRS-ийн дагуу бэлтгэгддэг. IFRS санхүүгийн тайланд тусгасан зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх тооцоолол нь хагас жилийн санхүүгийн мэдээлэлд үндэслэн хийгдсэн ба хяналт болон зээлийн алдагдлын тооцоолол нь өдөр тутмын мэдээнд үндэслэн хийгддэг. Бид IFRS -ын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэхийн тулд зээлийн алдаглыг хүлээн зөвшөөрөхдөө бүх зээлүүдийг хамааруулан тооцдог.

Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь банк өөрийн санхүүгийн үүргүүдээ цаг хугацаанд нь зах зээлийн үнээр гүйцэтгэж чадахгүйд хүрэх эрсдэл юм. Санхүүгийн үүргүүд гэдэгт хадгаламж эзэмшигчдэд өгөх өглөг, санхүүгийн хэрэгслүүдийн гэрээний дагуух төлбөрүүд, үнэт цаас, зээл, худалдан авалтын төлбөр тооцоонууд болон хөрөнгө оруулалт, зээлтэй холбоотой бүхий л үүргүүдийг ойлгоно. Хөрвөх чадварын эрсдэл нь позицийг удирдах, санхүүжилт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахад тохиолддог эрсдэл. Уг эрсдэлд тухайн актив талын багцын хугацаа болон хүүгийн зөрүүнээс шалтгаалсан хүлээгдээгүй зардлын өсөлтийг хамааруулан авч үздэг.

Голомт банкны хөрвөх чадварын удирдлагын тогтолцоо нь зах зээлийн хэвийн болон хэвийн бус нөхцөлд дээр дурьдсан санхүүгийн үүргүүдээ бүрэн гүйцэтгэж чадахуйц хөрвөх чадварын баталгаат түвшингүүдийг тогтоох, хянах, удирдахад чиглэдэг. Түүнчлэн хөрвөх чадварын эрсдлийг удирдах бодлого нь хэрэглэгчийн бэлэн мөнгөний хэрэгцээ шаардлагыг хангахуйц сан, хөрвөх чадвар өндөртэй нөөцтэй байх, үйл ажиллагааны өөрийн хөрөнгийн хүрэлцээг хангуулах, хүүгийн болон бусад орлогыг нэмэгдүүлэх зэрэгт чиглэгддэг.




Хөрөнгийн Удирдлагын Газар банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг банкны бүх салбар нэгжээр дамжуулан зохистой түвшин болон таамаглалын үндсэн дээр удирддаг. Хөрөнгийн Удирдлагын Газрын захирал нь банкны хөрвөх чадварыг хангах үүднээс зээлийн шийдвэр гаргалтад шууд оролцдог. Мөн Актив Пассивын Хорооны хурал нь сард хамгийн багадаа 2 удаа хуралддаг бөгөөд уг хурлаар хөрвөх чадварыг удирдах бодлогоос гадна шаардлагатай өөрчлөлт, шийдвэрүүдийг гаргаж, хөрвөх чадварын стандарт болон бусад бодлогуудтай нийцсэн дахин хяналтыг тавьж ажилладаг. Эрсдэлийн Удирдлагын Хороогоор банкны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, олон улсын практик туршлага болон хуулийн шаардлагуудад нийцүүлэн хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын стандартыг гаргадаг.

Актив Пассивын Хороо нь дараах зүйлүүдэд хяналт тавин, хэрэгжүүлэх шийдвэр гаргадаг. Үүнд, (i) богино болон урт хугацааны мөнгөн урсгалын удирдлага, (ii) баланс тайлангийн бүтэц, (iii) гадаад валютын хөрвөх чадварын удирдлага, (iv) татан төвлөрүүлсэн хөрөнгийг тогтвортой байлгах, (v) хөрвөх чадварын стресс тест гүйцэтгэх, (vi) хөрвөх чадварыг хангах зорилгоор хөрөнгийн хүрэлцээг хангуулан ажиллах зэрэг багтана.

Актив Пассивын Хорооны хурлын мониторингийн процесс нь дотоод болон гадаад хяналтын системээр дамжин хэрэгждэг. Уг дотоод болон гадаад хяналтын системүүдийн тусламжтайгаар хөрвөх чадварын эрсдэлийг дараах

Хөрвөх чадварын харьцаа



арга хэрэгслүүдээр үнэлж, хэрэгжүүлдэг. Үүнд (i) сарын давтамж дээр үндэслэсэн хүү, хугацаа, гадаад валютын зөрүүний шинжилгээ, (ii) өдөр бүрийн мөнгөн урсгал, гарах мөнгөн урсгалын таамаглал, тайлан балансын урт хугацааны таамаглал, (iii) Санхүүгийн Удирдлагын Газраас сар бүрээр гаргасан актив пассивын оновчтой бүтцэд хяналт тавих, (iv) төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаанууд, өдрийн давтамжтайгаар тооцсон хамгийн бага нөөцийн шаардлагууд, (v) Хөрөнгийн Удирдлага, Байгууллагын банк, бусад дотоод газар хэлтсээс гаргасан аналитик тайлан, хөрөнгийн зах зээлийн таамаглал, хөрвөх чадварын тайлан зэрэг дээр үндэслэсэн хүлээгдэж буй хөрвөх чадвартай холбоотой үйл ажиллагаа, (vi) Эрсдэлийн Удирдлагын Газраас гаргасан үйл ажиллагааны хязгаарлалтууд, хөрвөх

чадварын харьцаанууд, зөрүүний хэмжээний хязгаарууд, нэг сарын зээлийн хязгаар гэх зэрэг багтана.

Эргэн төлөгдөх хугацааны шинжилгээ нь хөрвөх чадварыг балансын бүтцийг удирдах, үр ашигтай цогц удирдлагын тогтолцооны суурь болдог. Хүлээгдэж буй мөнгөн урсгал нь эргэн төлөгдөх хугацаа өөрчлөгдөх бүрт тодорхой дүнгээр өөрчлөгдөж байдаг. Иймд банкны хөрөнгө, эх үүсвэр болон тэнцлийн гадуурх үүргүүдийг эргэн төлөгдөх хугацааны хувьд шинжлэхдээ хугацаа нь тодорхойгүй, эсвэл хугацаанаас өмнө хэрэгжих магадлалтай үүргүүдийг чанараар нь ангилж, хугацааны боломжуудыг тодорхойлдог. Энэхүү үйл явц нь балансын бүтэц алдагдсанаас үүсэх хөрвөх чадварын эрсдэл, түүнийг нөхөхөд зарцуулагдах нэмэлт эх үүсвэрийн хэмжээг тодорхойлоход ашиглагддаг. Хугацааны ялгаатай үеүд дэх хүлээгдэж буй орох, гарах хөрөнгийн урсгалын зөрүүг тодорхой хязгаарт барих, хөрвөх чадварын харьцааг хангалттай өндөр түвшинд байлгах үүднээс зохих хязгаарлалт, шаардлагуудыг тогтоон мөрддөг. Энэхүү хязгаарлалт, шаардлагуудыг хангуулах үр ашиг бүхий механизмуудыг нэг нь богино хугацааны хөрөнгө, эх үүсвэрийн харьцааг тооцож, үр ашигтайгаар удирдах юм. Эдгээр түгээмэл хэрэглэгддэг харьцаануудыг дараахь байдлаар тооцдог:

- Цэвэр зээл / Харилцах, хадгаламж
- (Монголбанкинд байршуулсан хадгаламж + Мөнгөн хөрөнгө)/Харилцах, хадгаламж
- Нэг сар хүртэлх хугацааны актив / Нэг сар хүртэлх хугацааны пассив

- Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө / Харилцах, хадгаламж
- Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламж / Харилцах, хадгаламж
- Хөрвөх актив / (Харилцах, хадгаламж + Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө)
- Хөрвөх актив / (Харилцах, хадгаламж + Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө + Хүлээж болзошгүй үүргүүд)
- Хөрвөх актив / Нийт актив
- Цэвэр зээл / Нийт актив
- Цэвэр зээл / Харилцах, хадгаламж
- Цэвэр зээл / (Харилцах, хадгаламж + Банк санхүүгийн байгууллагуудаас татсан хөрөнгө)
- Хугацаатай хадгаламж / Нийт пассив
- Гадаад валютын актив / Нийт актив
- (Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл + Гадаад валютын хадгаламж) / Гадаад валютын харилцах, хадгаламж
- Гадаад валютын цэвэр зээл / Нийт актив
- Гадаад валютын хөрвөх актив / Гадаад валютын харилцах, хадгаламж
- Том харилцагчдын харилцах, хадгаламж / Харилцах, хадгаламж
- Засгийн Газрын харилцах, хадгаламж / Харилцах, хадгаламж
- Бусад харьцаа үзүүлэлтүүд.

Гадаад валютын хөрвөх чадварын удирдлага

Гадаад валютын ханшийн эрсдэл нь банкны балансын актив болон пассивын дүн төгрөгөөс өөр бусад валютаар байршсанаас хамааран гарч ирдэг эрсдэл юм. Гадаад валют тус бүрээр байгаа татан төвлөрүүлсэн хөрөнгөтэйгөө уялдуулан зээлээ ямар валютаар олгох шийдвэр гарган ажилладаг. Бидний гадаад валютын эрсдэлийг удирдах бодлогын зорилго нь тухайн валютаар байршиж буй актив, пассив хөрөнгүүдийн хоорондын зөрүүг бага байлгахыг хичээдэг. Банк гадаад валютын эрсдэлийг байнга удирдан ажиллаж байгаа бөгөөд уг хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх гол бодлогын сонголт нь гадаад валютаар олгох зээлийн хэмжээг тухайн валютаар татсан эх үүсвэртэй нь уялдуулах явдал юм.

Төвлөрөл багатай багц буюу хөрөнгийн тараан байршуулалт

Банкны хөрөнгө, эх үүсвэрийг эдийн засгийн салбарууд болон том, групп харилцагчдаас хэт хамааралтай болохоос урьдчилан сэргийлэх, төвлөрлийг сааруулах зорилгоор төвлөрлийн эрсдэлийн хязгаарлалтуудыг тогтоодог. Эх үүсвэрийн дийлэнхийг урт хугацаат харилцах, хадгаламж болон харилцагчдын оновчтой түүврээс (том, жижиг харилцагчдын хувьд) бүрдүүлэх замаар төвлөрлийн эрсдэлийг бууруулдаг.

Хөрвөх чадварын стресс тест

Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас банкны хөрвөх чадварт үүсч болзошгүй нөлөөллийг үнэлэх зорилгоор тусгайлсан болон системчилсэн стресс сценаруудыг гарган, тэдгээрт нийцсэн мөнгөн урсгалын төсөөллүүдийг хийдэг. Сценарууд нь түүхэн эсвэл төсөөлсөн үйл явдлын (жишээ нь нэг банкны санхүүгийн нөхцөл байдал хүндэрсэн нь түүхэн явдал бол үүнээс банкны системд үзүүлэх нөлөөллийг тооцох нь төсөөлсөн явдал юм) аль алинд суурилж болох бөгөөд стресс тестийн үр дүнгүүд нь хөрвөх чадварын зорилтот түвшингүүдийг тодорхойлох, төлөвлөхөд хамгийн зөв, оновчтой өгөгдлүүд болдог.

Хөрвөх чадварын нөөц төлөвлөгөө

Эдийн засаг зогсонги байдалд орсонтой холбоотойгоор банк хөрвөх чадварын нөөц төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлдэг. Энэ нь хөрвөх чадварын хүндрэлийг хохиролгүйгээр даван туулахуйц түвшний итгэлцлийг зах зээлд бий болгох, хувь нийлүүлэгчдийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн цогц төлөвлөгөө бөгөөд хямралын үед баримтлах тодорхой стратегид суурилсан, хямралыг урьдчилан мэдээлэх өргөн хүрээтэй үзүүлэлтүүдийг агуулсан



байдаг. Урьдчилан мэдээлэх үзүүлэлтүүд нь тодорхой давтамжтайгаар, нарийвчлалын өндөр түвшинд хянагдан шинэчлэгддэг бол хямралын эсрэг стратеги нь эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд зохион байгуулагдаж, дотоод гадаад харилцаа, хөрвөх чадвар болон нөхцөл байдлын шаардлагаар бий болох нэмэлт мэдээллийн шаардлагуудыг тусгасан байдаг. Үүний эсрэг бидний баримтлах төлөвлөгөө бол дотоод, гадаад харилцаанд баримтлах стратеги, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх боломжуудыг олох, мэдээлэл олох, банкны хувь эзэмшигчид болон хууль тогтоогчдын хоорондын мэдээллийн солилцоо, хамтын ажиллагаа юм.

Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл нь хүүгийн түвшин, гадаад валютын ханш, өөрийн хөрөнгийн үнэ цэнэ гэх мэт зах зээлийн хэлбэлзэлтэй холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийн сөрөг өөрчлөлтийн нөлөөгөөр банкинд үүсч болзошгүй эрсдэл юм. Банк арилжааны болон арилжааны бус багцын аль алианаас нь зах зээлийн эрсдэлд өртөж болох бөгөөд энд банкны хөрөнгийн удирдлагын үйл ажиллагаа ч хамаардаг.

Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс банкны эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд зах зээлийн эрсдэлийн ерөнхий хязгаарлалт болон түүнд агуулагдах үзүүлэлт нэг бүрийн нарийвчилсан хязгаарлалтуудыг тогтоож, хэрэгжилтийг Актив Пассивын хороо хянадаг. Энэхүү хяналт нь банк одоо болон ирээдүйд хүү, ханшийн өөрчлөлтөөс хүлээж болох эрсдэлийн нийт багцын тодорхойлох, тогтмол хянах зарчмаар хийгддэг.

Хөрөнгийн Удирдлагын Газар Эрсдэлийн Удирдлагын Хорооноос тогтоосон бодлого, журмын хэрэгжилтийг хангуулах, бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалтын төрлүүд, арилжааны хэлцлүүд болон санхүүгийн хэрэгслүүдийн хувьд танигдсан хязгаарлалтуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох замаар зах зээлийн эрсдэлийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгэж ирсэн. Хөрөнгийн Удирдлагын Газар нь зах зээлийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд голлох үүрэгтэйгээр оролцож үйл ажиллагаагаа Актив Пассивын Хороо болон Гүйцэтгэх захиралд шууд тайлагнадаг.

Хүүгийн эрсдэл

Банкны арилжааны бус багцаас урган гардаг зах зээлийн гол эрсдэл нь хүүгийн түвшний өөрчлөлтөөс банкны ашиг, эсвэл өөрийн хөрөнгөд үзүүлэх сөрөг нөлөөлөл буюу хүүгийн эрсдэл юм. Банк дараах шалтгаануудын улмаас хүүгийн түвшний эрсдэлд өртдөг.

- Хөрөнгө, эх үүсвэрийн дахин үнэлэгдэх эсвэл төлөгдөх хугацаа ялгаатай байх (жишээ нь, хөрөнгө нь эх үүсвэрээс хурдан хугацаанд дахин үнэлэгддэг тохиолдолд хүү буурвал ашиг буурна)
- Хөрөнгө, эх үүсвэр ижил хугацаанд ялгаатай дүнгээр дахин үнэлэгдэх (жишээ нь, зах зээл дэх хүүгийн түвшин буурахад Банк эх үүсвэрийн хүүгээ түүнээс бага түвшнээр бууруулах)
- Богино болон урт хугацаанд зах зээлийн хүүгийн түвшин ялгаатай дүнгээр өөрчлөгдөх (жишээ нь, өгөөжийн муруй шинээр олгогдож буй зээлийн өгөөж болон эх үүсвэрийн зардалд өөрөөр нөлөөлөх)
- Хүүгийн түвшний өөрчлөлтөөс хамаарч хөрөнгө, эх үүсвэрийн үлдсэн хугацаа уртсах эсвэл богиносох (жишээ нь, хэрэв урт хугацаат моргейжийн хүү огцом буурвал моргейж төлөвлөсөн хугацаанаас өмнө ихээр төлөгдөж, орлого буурна).

Хүүгийн эрсдэлийг удирдах үйл ажиллагааны үндсэн зорилго нь хүүгээс хамаарсан активыг удирдах замаар цэвэр хүүгийн орлогыг өсгөх, хүүгийн сөрөг өөрчлөлтийн банкинд үзүүлэх нөлөөг хязгаарлах замуудаар ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгддэг. Бид хүүгийн эрсдэлийг удирдахдаа хүүгээс хамаарсан хөрөнгүүдэд хяналт тавих, хүүгийн эрсдэлийг хамгийн бага байлгах, хэмжээнд хязгаарлалт тавих зэрэг арга хэрэгслүүдийг ашигладаг. Эдгээр арга хэрэгслүүд нь хүүгийн зөрүүний шинжилгээ, хугацааны зөрүүний шинжилгээ, хүүгийн орлогын төсөөлөл зэргийг тооцоход ашиглагддаг. Хүүгийн хязгаарлалтын систем нь дараах хэсгүүдээс бүрддэг. Үүнд: (i) хамгийн их алдагдлын хязгаар, (ii) хүүгийн зөрүүний хязгаар, (iii) нөөцийн хуваарилалтад хүүг хамгийн бага байлгах зэрэг болно.

Зах зээлийн хүүгийн түвшин болон актив пассивын хугацааны зөрүүгээс хамаарсан цэвэр хүүгийн орлогын хоорондын

хамаарлаар хүүгийн мэдрэмж тодорхойлогддог. Сөрөг хүүгийн зөрүү нь балансын пассив талд мэдрэмжтэй бөгөөд энэ тохиолдолд хүүгийн түвшин буурах нь цэвэр хүүгийн орлогод эерэг, харин өсөх нь хүүгийн орлогод сөрөг нөлөөтэй. Бид хүүгийн эрсдэлд хяналт тавихдаа хүү болон хүүгийн маржины өөрчлөлтөөс хамаарах хөрөнгүүдийг үнэлэх, тогтоосон хязгаарлалтуудтай харьцуулан дүгнэлт өгөх болон хүүгийн позицт нөлөөлөх банкны бусад шинэ бүтээгдэхүүн, арга хэрэгслийг ашигладаг. Түүнчлэн бид банкны актив, пассив, балансын бус тайлан, арга хэрэгслүүдийн үр дүнд шинжилгээ хийн уг эрсдлээс хамгаалдаг.

Гадаад валютын ханшийн эрсдэл

Арилжааны багцын гол эрсдэл нь гадаад валют болон санхүүгийн хэрэгслүүдийн хүү, зах зээл дэх хөрвөх чадвар, үнийн өөрчлөлтөөс үүсдэг. Эрсдэлийн үндсэн хүчин зүйлс нь хүүгийн түвшин, ханш, хувьцааны үнэ юм.

Банкны арилжааны үйл ажиллагааны гол цөм нь харилцагчдад өрсөлдөхүйц үнээр бүтээгдэхүүн, үйлчилгээгээ нийлүүлэх буюу харилцагчдад чиглэсэн үйл ажиллагаа юм. Үүнд:

- зах зээлийн давуу байдлаа ашиглан авах, зарах үнийн зөрүүгээр ашиг олох зорилгоор валютын арилжаа хийх,
- хоорондоо холбоотой өөр өөр зах зээлийн төгс бус байдлаас ашиг олох зорилгоор позиц үүсгэх,
- ирээдүйд давуу тал олох зорилгоор санхүүгийн хэрэгслүүдийг эзэмших гэх мэт.

Бизнесийн үйл ажиллагааныхаа явцад зах зээлийн эрсдэлтэй холбогддог банкны бүтцийн бүхий л нэгжүүд банкны арилжааны бодлогыг дагаж мөрдөх ёстой. Зах зээлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл нь нарийвчлан тогтоосон, хатуу хязгаарлалтууд бөгөөд эдгээр нь дилерийн эрх хэмжээ гэх мэт эрсдэлийн удирдлагын үндсэн үзүүлэлтүүдийг бүхэлд нь тогтоосон байдаг. Хязгаарлалтууд зөрчигдсөн тохиолдолд авах арга хэмжээнүүдийг арилжааны бодлогод мөн тусгасан байдаг.

(мянган төгрөгөөр)	Delta Normal	Monte Carlo	Historical Simulation
Оны эцэст	94,723	82,478	146,194
Өдрийн дундаж	104,820	107,649	141,578
Хамгийн их	339,147	362,101	477,653
Хамгийн бага	8,632	9,046	11,103

Бид валютын арилжаа болон хөрөнгийн багцын зах зээлийн эрсдэлийг хэмжихийн тулд гурван төрлийн VaR аргыг ашигладаг. VaR аргаар тухайн сонгосон багцын зах зээлийн үнэ цэнийн боломжит сөрөг өөрчлөлтийг гаргаж авахад ашигладаг. Бид нэг болон арван өдрийн хугацаатайгаар VaR-ыг тооцож байгаа бөгөөд үүнийг өнгөрсөн үеийн бодит ашиг алдагдлын утгатай нь харьцуулах байдлаар загвараа буцааж тест хийн шалгадаг. Арван өдрийн VaR-т 99 хувийн ач холбогдлын түвшинд Монголбанкнаас суурь хязгаарлалтуудыг тавин ажилладаг. Түүнчлэн бид VaR-аар олж авсан боломжит алдагдлын хэмжээгээр банкны стресс тест хийж гүйцэтгэдэг.

Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь дүрэм журам, системийн нийцгүй байдал эсвэл үл хэрэгжилт, хүний санамсаргүй алдаа, санаатай үйлдлүүд болон гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр банкинд шууд ба шууд бусаар учирч болох эрсдэл юм.

Бид үйл ажиллагааны эрсдэлийг амжилттай удирдсаныг харуулах гол үзүүлэлтүүдийн нэг нь үйл ажиллагааны эрсдэлийн алдагдлыг 2011.12.31-ний байдлаар үйл ажиллагааны орлогын 0.02%-д барьж чадсан явдал юм. Банк энэ үзүүлэлтийг 2 хувиас ихгүй байлгах зорилт тавьж ажилласан.

Хяналтын тогтолцоо болон боломжит эрсдэлийг хаах, тогтмол хяналт хийх замаар групп болон банкны үйл ажиллагааны эрсдэлийг хянах боломжтой. Хяналт нь үүрэг хариуцлага, хандалт, зөвшөөрөл болон тохиргоо хийх ажиллагаа, ажилтнуудын боловсрол, тогтмол сургалт болон үнэлгээний үе шатуудын үр ашигтай хуваарилалтыг агуулдаг.



Банк үйл ажиллагаагаа саадгүй, тасралтгүй хэвийн явуулахыг хангах зорилго бүхий өргөн цар хүрээтэй даатгалын бодлогыг хэрэгжүүлж, хүлээж болзошгүй эрсдэлийг бүрэн хаах боломжийг бүрдүүлсэн. Энэхүү даатгалын бодлого нь бүтээгдэхүүн, үйл ажиллагааны эрсдэлийг зэрэг бууруулахын хамт мөн давагдашгүй гадаад хүчин зүйлсээс үүссэн банкны хэвийн үйл ажиллагааны тасалдлыг сэргээх үйл ажиллагааны зардлыг бууруулахад чухал нөлөө үзүүлэх юм. Мөн бид үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд банкны түлхүүр ажилтнуудын амь нас, эрүүл мэндийн даатгал, удирдлагын баг болон ажилтнуудын хариуцлагын даатгал гэх мэт “Banker’s Blanket Bond”-ийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Банкны бүхий л ажилтнуудыг ажил үүргийн хуваарилалт, үйл ажиллагааны уялдаа холбоог ойлгомжтой тодорхойлсны зэрэгцээ, тэдгээрт тавигдах дотоодын болон зайны хяналтыг сайжруулсан ба үйл ажиллагааны эрсдэлийг үр дүнтэйгээр бууруулах зорилгоор дараах чиглэлүүдээр зөвлөмж, чиглэлүүдийг тодорхойлж, анхаарал хандуулан ажилласан болно. Үүнд:

- Хүчирхэг, бие даасан дотоод хяналт
- Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын дагуу өндөр чанартай хөндлөнгийн хяналт шалгалт
- Үр ашигтай, нэгжийн эрсдэлийн удирдлагын систем
- Бизнесийн чиглэл, үйл ажиллагаа бүрээр нарийн тодорхойлсон ажил үүргийн хуваарь, хяналтын систем
- Хүний нөөцийн эргэц, сэлгээ зэрэг асуудлуудыг хамруулсан бодлогод суурилсан хүний нөөцийн үр ашигтай эрсдэлийн удирдлагын сайжруулалт
- Базелийн хорооны зөвлөмжийн дагуу үйл ажиллагааны эрсдэлийн сан байгуулах шийдэл
- Үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх болон таамаглахад шаардлагатай үйл ажиллагааны эрсдэлийн сангийн хэрэглээ, сайжруулалт
- Аюулгүй байдлыг бэхжүүлэх, газар дээрх хяналтыг нэмэгдүүлэх
- Нэгжийн арын албадын үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах болон урьдчилан сэргийлэхэд шаардлагатай гарын авлагуудын хангамж
- Салбар нэгжүүдийн эрсдэлийг таних, үнэлэх, бууруулах зорилго бүхий үйл ажиллагааны эрсдэлийн стандарт, тэдгээрийн хэрэгжилт
- Мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлагын бодлого, журмын шинэчлэлт
- Бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг тогтмол сайжруулах, турших
- Салбар нэгжид зайны хяналт хийх зорилго бүхий өдрийн хяналтын хуудасны хэрэгжилт
- Үйл ажиллагааны эрсдэлээс хамгаалах зорилгоор салбар нэгжүүдийн ажилтнуудад зориулсан газар дээрх тогтмол сургалт
- Салбар нэгжийн үйл ажиллагааны хяналт, хязгаарлалтын тогтолцоог боловсронгуй болгох
- Салбар нэгжүүдэд зориулан онлайн болон хэвлэмэлээр гаргаж буй бодлого, журам, гарын авлагуудын төсөлд эрсдэлийн хяналт хийх
- Данс нээх үйл ажиллагааны стандарт
- Хугацаа хэтрэлтийг удирдах процессийг сайжруулах

Бид үйл ажиллагааны эрсдэлийг амжилттай удирдсаныг харуулах гол үзүүлэлтүүдийн нэг нь үйл ажиллагааны эрсдэлийн алдагдлыг 2011.12.31- ний байдлаар 0.02 хувьд барьж чадсан явдал юм. Банк энэ үзүүлэлтийг 2 хувиас бага буюу тэнцүү байлгах зорилготойгоор ажилласан.

Мэдээллийн эрсдэлийн менежмент

Мэдээллийн эрсдэл гэдэг нь санаатай болон санамсаргүй байдлаар мэдээллийн эх сурвалжуудыг ашиглах, өөрчлөх, задлах эсвэл устгах замаар банкны мэдээллийг хадгалах чадвар, бизнесийн тасралтгүй ажиллагаа, мэдээллийн нууцлалыг хамгаалах асуудлууд болон банкны нэр хүндэд сөргөөр нөлөөлөхийг хэлнэ. Бид мэдээллийн аюулгүй байдлын удирдлагыг хэрэгжүүлэхдээ олон улсын туршлагууд болон холбогдох хууль, дүрэм, журмуудыг баримтлан ажиллаж байна. Бид мэдээллийн технологийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хэрэглэгчийн эрхийн зохицуулалт, мэдээлэл татах журам, сүлжээний мониторинг, хэрэглэгчийн хандалт, хийсэн үйлдлийн бүртгэлийн хяналтын програмын тусламжтайгаар өдөр тутмын хяналтыг гүйцэтгэж байгаагийн зэрэгцээ өдөр тутмын чиг үүрэг бүхий Мэдээллийн аюулгүй байдлын албатай хамтран ажиллах, чиглэл өгөх, давхар хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна.

Бизнесийн тасралтгүй ажиллагааны менежмент

Бизнесийн тасралтгүй ажиллагааны менежмент нь урьдчилж хараагүй элдэв осол, саатлын улмаас бизнесийн хэвийн үйл ажиллагаа тасалдахад түүнийг богино хугацаанд хэвийн байдалд нь оруулах, системийн ажиллагааг бүрэн сэргээх, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулалтайгаар хэрэгжүүлэхэд чиглэдэг. Бид осол, саатлын үед системийг хэвийн байдалд эргүүлэн оруулах хугацааг боломжит хамгийн богино түвшинд байлгахыг чухалчилж, үүнтэй холбоотой банкны чадавхийг улам бэхжүүлэхийг зорин ажилласан. Бид осол саатлын үеийн хүндрэлүүдийг удирдах үйл ажиллагааг зохион байгуулалттай, хянагдахуйц хэлбэрт оруулах зорилгоор бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг тогтмол сайжруулсаар ирсэн. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэлтэс нь банкны бизнесийн тасралтгүй байдлыг хянаж удирдах, уг төлөвлөгөөний биелэлтийг хангуулах үүргийг гүйцэтгэхээс гадна уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг бүхий “Ослын үед ажиллах баг” болон “Бизнесийн үйл ажиллагааг сэргээх баг”-уудтай нягт хамтран ажиллаж байна.

Луйврын шинжтэй эрсдэлийн менежмент

Луйврын шинжтэй эрсдэлийн удирдлага нь үйл ажиллагааны эрсдэлийн нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь төлбөр тооцоо болон бизнесийн үйл ажиллагаатай холбоотой гарсан алдаанд голчлон төвлөрдөг бол луйврын шинжтэй эрсдэлийн удирдлага нь санаатайгаар шударга бус үйлдэл хийснээс гарах эрсдэлийн магадлалд үнэлгээ хийдэг. Банкны удирдлагын гол үзэл баримтлал нь боломжит луйврын үйлдлийг илрүүлэх, түүнийг таслан зогсоох явдал юм. Банк нь данс бүртгэлийн алдаа, залилан гэх мэт луйврын шинжтэй бүхий л төрлийн үйл ажиллагаанаас сэргийлэхээр хичээнгүйлэн ажиллаж, банкны үйл ажиллагааны бүхий л түвшинд бодлого журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, хуйвалдан мэхлэх болон луйврын шинжтэй бусад үйлдлийн эсрэг тэмцэх зохицуулалт, стратегийг иж бүрэн утгаар нь боловсруулан хэрэгжүүлсэн. Түүнчлэн бид банкны бизнесийн бүхий л үйл ажиллагаа, нэгжүүдэд эрсдэлийн дүгнэлт гаргасан бөгөөд боломжит гэмт хэрэг, гэмт хэрэгтнүүдийг таних болон төрөлжүүлэх замаар луйврын шинжтэй эрсдэлүүдийн ангиллыг гаргасан.

Хянан нийцүүлэх үйл ажиллагаа

Хянан нийцүүлэх чиг үүрэг нь банкны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, журам, эрхзүйн баримт бичиг, ёс зүйн стандартыг зөрчсөнөөс санхүүгийн болон нэр хүндийн эрсдэлд орохоос сэргийлдэг. Голомт банкны үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомж эрх зүйн зохицуулалтаас гадна Олон улсын холбогдох гэрээ, конвенц, нийтлэг зан заншил, ёс зүйн хэм хэмжээнд нийцэж буй байдалд хяналт тавьж, хуулийн хариуцлага хүлээх, санхүүгийн алдагдалд орох, нэр хүндээ алдах зэрэг эрсдэлээс хамгаалах зорилгоор Хянан нийцүүлэх алба ажиллан, банкны хэмжээний эрх зүйн бичиг баримтуудыг хянаж, үйл ажиллагаанд байнгын хяналт тавин ажиллаж байна.

Тусгай активын хэлтэс

Банкны тусгай активын үйл ажиллагаа нь чанаргүй зээлийн хяналт болон эргэн төлөлтийг хариуцдаг. Зээлийн эргэн төлөлт асуудалтай болох нь хэд хэдэн объектив болон субъектив үзүүлэлтээр тодорхойлогддог. Үүнд, харилцагчийн дансны гүйлгээний хэмжээнд огцом өөрчлөлт орох, зээлийн нөхцөлийг өөрчлөх хүсэлтүүд ирэх, зээлийн гэрээний нөхцлийг зөрчих, харилцагч банкны ажилтнуудтай харьцахаас зайлсхийх зэрэг үзүүлэлтүүд хамаарна.

Зээл асуудалд орох нь тодорхой болоход тусгай активын хэлтсийн менежерүүд зээлдэгчийн хөрөнгө, үл хөдлөх болон бусад үнэ цэнэтэй хөрөнгөнд үнэлгээ хийж, холбогдох зээлийн ажилтан болон бусад мэргэжилтнүүдтэй хамтран арга хэмжээ авдаг. Тусгай активын менежерүүд асуудалтай зээлүүдийг аль болох богино хугацаанд төлүүлэх, хөрөнгийг найдвартай хамгаалах үүднээс бүхий л боломжит арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Тусгай активын хэлтэс нь зээлийн ангилал муудахад зээлдэгчийн үүргийг хангуулах зорилгоор харилцах дансны авлагыг хуримтлуулах, үл хөдлөх хөрөнгийг зарж борлуулах, зээлдэгчийн үйл ажиллагааны бүтээмж үр ашгийг нь сайжруулан зээлдэгчтэй хамтран ажилладаг. Зээлдэгчийн банктай харьцаж байсан түүх, зээлийг эргэн төлөх чадвар, банкаас санал болгож буй эргэн төлөлтийн нөхцөлийг хүлээн зөвшөөрөх байдал зэргээс шалтгаалан дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг.

Шаардлагатай тохиолдолд бид зээлийн нөхцлийг өөрчлөх бодлого баримтална. Энэ тохиолдолд Тусгай Активын Хэлтэс нь зээлийн торгуулийн хүүгээс чөлөөлөх, хугацааг сунгах, сарын төлбөрийг багасгах зэрэг зээлийн эргэн



төлөлтийг аль болох ихэсгэх боломжийг олгож эзэлдэгчтэй хамтран ажилладаг. Зээлийн нөхцөлд өөрчлөлт орсон тохиолдолд зээлийн хэмжээнээс хамааран Зээлийн Хороо, Зээлийн Дэд Хороо эсвэл Эрсдэлийн Удирдлагын Газрын захиралд танилцуулж батлуулна.

Зээл нь муу ангилалаас хэвийнд шилжсэн тохиолдолд ч тусгай активын хэлтэс нь тухайн зээлийг үргэлжлүүлэн 6 сарын турш хяналтандаа байлгадаг. Зээлийг шүүхийн байгууллагад шилжүүлж төлүүлэх ч тохиолдлууд гардаг бөгөөд шүүхийн байгууллагаар асуудал шийдвэрлүүлэх хугацаа дунджаар 6-аас 12 сар байдаг. Шүүхийн байгууллагад асуудлыг шилжүүлэхээс өмнө банк нь мэргэжлийн экспертийн зөвлөгөөтэйгээр тусгай үнэлгээ хийж, барьцаа хөрөнгийн бодит үнэлгээ, шүүхээр эргэн төлүүлэх нөхөн төлбөрийн хэмжээ зэргийг тогтоодог.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль журамд санхүүгийн байгууллага нь харилцагчийг таних, мэдээллийг хадгалах болон сэжигтэй үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, холбогдох эрх бүхий байгууллагад мэдээлэх зэрэг үүргүүдийг хүлээдэг. Банк нь өөрчлөгдөж буй хууль эрхзүйн орчин нөхцөлд тохируулан бодлого, түүнийг хянах механизмаа сайжруулах замаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаагаа илүү өндөр түвшинд хүргэж ажиллалаа. Банк нь МУТСТ үйл ажиллагааны хэрэгжилт хариуцсан ажилтан томилох; хэрэгжилтийн хяналтыг хангах зорилгоор дотоод хяналтын системийг бий болгох; банкны бүх ажилтнуудад сургалт зохион байгуулах; банкны дотоод хөтөлбөрийг хянах хөндлөнгийн хяналт явуулах зэрэг 4 гол хэсгээс бүрдсэн дотоод хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого журам, түүний хяналтын механизмд “Харилцагчаа Тань буюу Know Your Customer” хяналтын зарчим, ажилтнуудад мэдлэг олгох сургалт, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, түүнийг тайлагнах, эрсдэлийг тодорхойлох үйл ажиллагаанууд хамаарагдаж байна. Өөрөөр хэлбэл, банкны өдөр тутмын гүйлгээнд хяналт тавих ажлыг автоматжуулан, өндөр мөнгөн дүнтэй болон хэвийн бус гүйлгээний талаарх мэдээллийг банкны сэжигтэй гүйлгээг хянах систем болон дотоод журмаараа илрүүлэхэд анхаарал тавин ажиллав. Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Монголбанкны Санхүүгийн Мэдээллийн Албанд холбогдох тайлан мэдээг тогтмол хүргүүлж хамтран ажиллаж ирэв.

Түүнчлэн, банкны үйл ажиллагааны нэгжийн ажилтнууд, дотоод хяналтын үүрэг бүхий ажилтнууд болон онцлог үйл ажиллагаатай нэгж болох Хувийн банкны албаны ажилтнууд энэ чиглэлээр мэргэжлийн сургалтанд хамрагдсан. Банкны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нэгж нь банкны удирдлагыг энэ чиглэлээр мэдээллээр байнга хангаж, ТУЗ-д ажлын тайлангаа улирал тутам танилцуулж ирсэн.

Банк нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг чухалчилж үзэн энэ чиглэлээр мэргэжлийн боловсон хүчинтэй болохыг эрмэлздэгийн нэг жишээ нь банкны хэрэгжилт хариуцсан ажилтан нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх мэргэжилтэн гэсэн нэр алдрыг хүртээд байгаа явдал юм.

Мөн хамтын ажиллагааны хүрээнд гадаадын харилцагч банкуудад Голомт Банкны мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны талаар үнэн зөв ойлголт өгөх, түүнийг бататгах, эргээд эдгээр харилцагч банкуудаас баталгаа авах ажлыг US Patriot Act-ын дагуу хийж, манай банкаар дамжсан гадаад гүйлгээний талаарх асуулгуудад түргэн шуурхай үнэн зөв мэдээлэл хүргэж гадаад харилцааны хамтын ажиллагааг байнга сайжруулсаар ирсэн.

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Голомт банк бизнесийнхээ бүхий л түвшинд хариуцлагатай ханддаг нь бидний урт хугацааны ололт амжилтыг тодорхойлогч гол хүчин зүйл болдог. Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд бид эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, спорт, нийгмийн хөгжил гэсэн салбаруудад санхүүгийн болон материаллаг тусламж үзүүлж ажиллалаа. Тайлант онд хэрэгжүүлсэн нийгмийн хариуцлагын чиглэлийн санал санаачлагууд нь дараах хэсгүүдэд хуваагдаж байна.

Боловсролыг дэмжих чиглэлээр

Монгол Улсын нийгэм, соёл болон эдийн засгийн ирээдүйн хөгжилд өндөр үр чадвартай, боловсролтой залуус чухал хувь нэмэр оруулна гэдэгт бид итгэдэг. Иймээс бид олон жилийн турш боловсролыг дэмжин ажиллаж байна. Тайлант онд:

- Монголбанктай хамтран Монголын тэргүүлэгч их дээд сургуулиудын оюутнуудын дунд Голомт банкны нэрэмжит Эрдэм Шинжилгээний Бага Хурлыг 10 дахь удаагаа амжилттай зохион байгууллаа
- Шилдэг 100 оюутанд сар бүрийн тэтгэлэг олгодог Голомт банкны нэрэмжит оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг 9 дэх жилдээ амжилттай хэрэгжүүллээ
- Монголын оюутны төлбөрийн картын үйлчилгээг үзүүлэгч цорын ганц банкны хувьд Монгол Улсын Засгийн Газраас их дээд сургуулийн оюутнуудад олгох тэтгэлгийн үйл ажиллагааг дэмжиж ажиллаж, сарын тэтгэлэг болох 70000 төгрөгийг төлбөрийн картаар олгох үйлчилгээг үзүүлж байна
- Төгсөх курсын оюутнуудад ажлын байраа сонгох, хөдөлмөрийн зах зээлд гарахад нь туслах зорилготой “Ажлаа зөв сонгохоос амжилт эхэлдэг” нэртэй хүний нөөцийн бүрдүүлэлтийн аяныг амжилттай зохион байгуулав
- Шастины нэрэмжит Клиникийн 3-р Төв Эмнэлгийн ажилчдад зориулсан шинэ номыг санд мэргэжлийн болон судалгааны тусгай номуудаар дэмжлэг үзүүлэв.

Хүрээлэн буй орчноо хамгаалах чиглэлээр

Хүрээлэн буй байгаль орчноо хамгаалах нь одоо цагт тулгараад байгаа томоохон асуудлуудын нэг юм. Хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах асуудал нь Банкны бүхий л түвшинд анхаарал тавьдаг томоохон асуудал юм. Бид үйл ажиллагааныхаа үе шат бүхэнд хүрээлэн буй орчинд үзүүлж буй үр нөлөөг анхаарч үздэг.

- Зээлийн судалгаа: Зээлийн судалгаа шинжилгээ хийх явцад тусгайлан анхаарч үздэг зүйл нь тухайн бизнесийн байгаль орчинд үзүүлэх нөлөө бөгөөд банк нь байгаль орчинд хор хөнөөлтэй бизнесийн төслийг дэмждэггүй. Мөн зээлийн бодлогоороо дамжуулан эрчим хүчний хэмнэлттэй бизнес болоод байгаль орчинд тустай үйл ажиллагааг дэмжин ажилладаг
- Байгальд ээлтэй бизнесийг санхүүжүүлэх: Банк нь Сангийн яамтай хамтран Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлагийн санхүүжилтээр Жижиг дунд бизнесийг дэмжих, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай төслийн зээлийг хэрэгжүүлдэг
- Байгаль орчинд ээлтэй хэрэглээг дэмжих: Цахим банкны үйлчилгээгээ сайжруулан хэрэглээг нь улам дэмжсэнээр албан байгууллага, иргэдийн цаас, захидал, шатахууны зардлыг багасгаж байгаль орчинд ээлтэй хэрэглээг дэмжин ажиллаж байна. Мөн цахим банкны үйлчилгээний суваг болон бүтээгдэхүүнийг эрчимтэй сайжруулан хөгжүүлж байна. Түүнчлэн байгууллагын дотоод холбоо харилцаанд цаасны хэрэглээг багасгах, цаасгүй харилцаа холбооны хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Share point JIRA системийг банкныхаа үйл ажиллагаанд нэвтрүүлээд байна
- Ажилтнууд хүмүүнлэгийн үйл ажиллагааг дэмжих: Ажилтнуудаа нийгмийн сайн сайханд чиглэсэн хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцохыг уриалснаар тэднийг бусад хүмүүсийн аж амьдралын хэрэгцээг ойлгон дэмжих, хувь хүн болон багаар ажиллах үр чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг болж байна
- Голомт банкны нийт ажилтан, албан хаагчид тайлант онд болсон аймшигт гамшиг болох Цунамид өртсөн Японы иргэдэд нэг өдрийн цалингаа хандивлалаа
- Ногоон дэлхий, ногоон эдийн засгийн талаарх ойлголт мэдлэгийг тэлэх үүднээс бүх ажилтнуудаа оролцуулан



“Ногоон дэлхий надаас эхтэй” аяныг зохион явууллаа

- “Ногоон дэлхий надаас эхтэй” аяны хүрээнд ажилчидтайгаа болон Голомт банкны “Алтан түлхүүр” хадгадамж эзэмшигчидтэйгээ хамт мод тарих төслийг хэрэгжүүлсэн
- MasterCard Worldwide, Visa International, American Express, Union Pay байгууллагуудтай хамтран “Жаргалтай Хүүхдүүд” цэцэрлэгийг Үндэсний соёл амралтын хүрээлэнд байгуулав.

Спорт, урлаг соёлыг дэмжих чиглэлээр

Спорт, соёл, урлагын салбарт дэмжлэг үзүүлэх нь бидний үүрэг бөгөөд энэ нь Монголын нийгмийг хөгжүүлэн тэлэхэд чухал ач холбогдолтой юм. Энэхүү үйл ажиллагаа маань Олимпын наадам, хөл бөмбөг, мөн уламжлалт урлаг, уламжлалт дуу хөгжим болох Монголын онцгой өв соёлд голлон анхаарч байна. Урлаг соёлын залуу авъяасыг дэмжин дэлгэрүүлэх:

- Сонгодог урлагийг хөгжүүлэх, ард иргэдийн сонгодог урлагын боловсролыг дээшлүүлэх зорилгоор Дуурь Бүжгийн Эрдмийн Театрт үзүүлэх дэмжлэгээ үргэлжлүүлэв
- Олимпын наадамд оролцох тамирчдаа дэмжиж, Монголын Үндэсний Олимпын Хорооны албан ёсны алтан түнш байгууллагаар ажиллаж байна
- Монголын улалжлалт хөгжмийн зэмсэг болох Морин хуур хөгжмийг сурталчилан таниулж буй Монгол Улсын Морин Хуурын Чуулгын “Хайрыг хөгжимдөхүй” мөн “Туужийн Хайлал” цомгийг гаргахад ивээн тэтгэлэг үзүүлэв
- Монголын Дуурь Бүжгийн Эрдмийн Театрт тавигдсан Ж.Вердийн “Айда” дуулалт жүжгийн анхны нээлтэнд ивээн тэтгэлэг үзүүлэв
- Хятадын Юнион Пай байгууллагатай хамтран Shenzhen 2011 Зуны наадамд оролцсон Монголынхоо оюутны баг тамирчдын албан ёсны түнш банкаар ажиллав
- Монголын Үндэсний Шатрын тэмцээн мөн Ж.Чулууны нэрэмжит өсвөрийн хөгжимчдийн тэмцээнд ивээн тэтгэлэг үзүүлэв.

Засгийн Газрын санал санаачлагыг дэмжих чиглэлээр

Банк нь Монгол Улсын гадаад харилцааг өргөтгөх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр Монгол Улсын Засгийн Газраас санаачлан хэрэгжүүлж буй үйл ажиллагааг оюуны болон санхүүгийн хөрөнгө оруулалт үзүүлэн дэмжин ажилладаг.

- Дэлхийн Эдийн Засгийн Чуулган, Олон Улсын Санхүүгийн Институт, Хөгжиж Буй Орнуудын Зөвлөх Консул зэрэг байгууллагын гишүүнчлэлээрээ дамжуулан Монгол Улсын эдийн засгийн хөгжил цэцэглэлтэнд хувь нэмэр оруулж байна
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газраас Женев дэх Дэлхийн Эдийн Засгийн Форумтай хамтран зохион байгуулсан Авилгын эсрэг түншлэл санаачлагын “Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх нь”, “Авилгын эсрэг түншлэл” уулзалтуудын цор ганц ивээн тэтгэгчээр ажиллав
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар анх удаа зохион байгуулсан “Шүүх Эрх Мэдэл ба Шударга Ёс Форум”-ын ивээн тэтгэгчээр ажиллав
- Монголбанктай хамтран 4 дэх удаагийн “Арилжааны Мэргэжилтнүүдийн Чуулган”-ыг амжилттай зохион байгуулав
- “Дисковер Монголиа-2011” уул уурхайн хөрөнгө оруулагчдын чуулганы албан ёсны банкаар ажиллав
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын Кувейт, Катар, Арабын Нэгдсэн Эмират, ОХУ, Хятад, Хонконг мөн Америкийн Нэгдсэн Улсад хийсэн албан ёсны айлчлалыг дэмжсэн.
- Англи, Бүгд Найрамдах Чех улс, Сингапур, Герман, Австрали зэрэг улсуудын айлчлалын үеэр улс орны эдийн засгийн байдлыг тайлагнасан илтгэлийг тавьсан
- Монгол Улсын Засгийн Газраас зохион байгуулсан “Монголын Эдийн Засгийн Чуулган”-ы ивээн тэтгэгчээр 3 дахь удаагаа ажиллав.

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД:

Хадгаламж, харилцах дансны үйлчилгээ

- Байгууллагын харилцах данс
- Байгууллагын хадгаламжийн данс
- Эскроу данс

Зээлийн үйлчилгээ

- Эргэлтийн хөрөнгийн зээл
- Зээлийн шугам
- Хөрөнгө оруулалтын зээл
- Санхүүгийн түрээс
- Ашигт малтмалын зээл
- Зээлийн шугам
- Ногоон зээл
- Төслийн зээл

Банкны баталгааны үйлчилгээ

- Тендерийн баталгаа
- Урьдчилгаа төлбөрийн баталгаа
- Гүйцэтгэлийн баталгаа

Худалдааны санхүүжилтийн үйлчилгээ

Гадаад валютын арилжаа

Картын үйлчилгээ

- Байгууллагын дебит/кредит карт
- Ко-брэнд карт
- Картаар үйлчлэх байгууллагын үйлчилгээ

И-банкны үйлчилгээ

- Интернет банк
- Ухаалаг утсанд зориулсан Смарт банк
- И-биллинг
- Электрон худалдаа

Төлбөр тооцооны үйлчилгээ

- Дотоодын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
- Олон улсын төлбөр тооцооны үйлчилгээ
- Цүнхээр мөнгө хураах үйлчилгээ
- Хадгаламжийн хайрцаг үйлчилгээ
- Инкассын үйлчилгээ
- Дансны лавлагаа

Бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Хөрөнгө оруулалтын банк





ИРГЭДЭД:

Хадгаламж, харилцах дансны үйлчилгээ

- Харилцах данс
- Хугацаатай хадгаламж
- Хугацаагүй хадгаламж
- Хөвөгч хүүтэй хадгаламж
- Урьдчилсан хүүт хадгаламж
- Хадгаламжийн сертификат
- Алтны хадгаламж
- Хуримтлалын хадгаламж
- "Алтан түлхүүр" хүүхдийн хадгаламж
- "Зорилготой" хадгаламж

Эскроу дансны үйлчилгээ

Зээлийн үйлчилгээ

- Жижиг дунд бизнесийн зээл
- Эргэлтийн хөрөнгийн зээл
- Зээлийн шугам
- Хөрөнгө оруулалтын зээл
- Санхүүгийн түрээсийн зээл
- Төслийн зээл
- Жижиг дунд бизнесийг дэмжих зээл
- Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төслийн зээл
- Азийн Хөгжлийн Банкны ажлын байр нэмэгдүүлэх зээл
- Хэрэглээний зээл
- Цалингийн зээл
- Өрхийн зээл
- Орон сууц засварын зээл
- Автомашины зээл
- Сургалтын зээл
- Хадгаламж барьцаалсан зээл
- Орон сууцны зээл
- Залуу гэр бүлд зориулсан орон сууцны зээл
- Хувийн сууц худалдан авах зээл

Гадаад валютын арилжаа

Хувийн банкны үйлчилгээ

- Хөрөнгийн удирдлага

Дебит/Кредит картын үйлчилгээ

- Виза карт гаргах/ төлбөрт хүлээж авах үйлчилгээ
- Мастеркарт гаргах/ төлбөрт хүлээж авах үйлчилгээ
- Юнион-пэй карт гаргах/ төлбөрт хүлээж авах үйлчилгээ
- Amex карт төлбөрт хүлээж авах үйлчилгээ
- Ко-Бренд картын үйлчилгээ
 - МИАТ milleage
 - Air Network карт
 - МҮХАҮТ-ийн Виза алтан карт
 - JCI гишүүнчлэлийн карт
- Бэлгийн карт
- Нандин карт
- Оюутны карт (Маестро & Электрон)

Е-банкны үйлчилгээ

- Интернэт банк
- Ухаалаг утсанд зориулсан Смарт банк
- Мобайл банк
- И-биллинг
- Мессеж банк
- Мессежээр мэдээлэх үйлчилгээ
- АТМ, Явдаг АТМ
- Лавлах төв

Төлбөр тооцооны үйлчилгээ

- Дотоодын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
- Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
- Вестерн юнион мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
- Хувийн гуйвуулгын үйлчилгээ
- Цүнхээр мөнгө хураах үйлчилгээ
- Хадгаламжийн хайрцаг үйлчилгээ
- Инкассын үйлчилгээ
- Дансны баталгаа гаргах үйлчилгээ

Санхүүгийн зөвлөгөө өгөх үйлчилгээ

Хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ

САЛБАР СҮЛЖЭЭ

Төв оффис: Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар 210620А, Монгол

Утас: +(976-11) 311971, 311530

Факс: +(976-11) 313155, 312307

Е-мэйл: mail@golomtbank.com

Веб: <http://www.golomtbank.com>



Жилийн Тайлан 2011

59

УЛААНБААТАР ДАХЬ САЛБАРУУД

Банкны нэгж	Хаяг	Холбоо барих
Төв салбар	Худалдааны гудамж 6/2, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976-11)-311530 Факс: +(976-11)-326231 Дотуур утас: 705
Сансар салбар	Баянцээл худалдааны төв, 15 хороолол, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-456980 Факс: +(976-11)-456829
100 айл салбар	"Анд интернэйшнл", Б корпус, 7 хороо, 11 хороолол, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-350542 Факс: +(976-11)-350544
Ард салбар	Он энд Он ХХК-ийн байр, Бага тойруу гудамж, 1 хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-320712 Факс: +(976-11)-330436
Солонго салбар	Солонго үйлчилгээний төв, Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-320814 Факс: +(976-11)-318479
Саппоро салбар	Бармон ХХК-ийн байр, 1 хороолол, Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-681267 Факс: +(976-11)-680367
Москва салбар	Бодь интернэйшнл ХХК-н байр, 4 хороолол, Баянгол дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-305419 Факс: +(976-11)-368602
120'000 салбар	120 мянгат үйлчилгээний төв, 1 хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-70130080
Моннис салбар	Моннис тауэр, 1 хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-321291 Факс: +(976-11)-321273
Баянзүрх салбар	"Бо-Бо" худалдааны төв, 15 хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-458250 Факс: +(976-11)-462892
Зээлийн төв салбар	"Бурхан халдун групп" ХХК-ийн байр, 2 хороо, Энхтайваны өргөн чөлөө, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-330072 Факс: +(976-11)-330621
Голомт хотхон салбар	"Голомт хотхон" цогцолборын 1-р блок, 5 хороо, Үндсэн хуулийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-322943 Факс: +(976-11)-322943
Нисэх тооцооны төв	"Чингис хаан" нисэх онгоцны буудал, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-283205 Факс: +(976-11)-283205
Гааль тооцооны төв	Гаалийн газрын байр, Баянгол дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-242943 Факс: +(976-11)-242943
Багануур тооцооны төв	Хэрлэн худалдааны төв, Багануур дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-01-21)-22333 Факс: +(976-01-21)-20818
Цамбагарав тооцооны төв	Цамбагарав худалдааны төв, 1 хороолол, Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-680762 Факс: +(976-11)-680763
Цэцээ Гүн тооцооны төв	"Цэцээ Гүн" дээд сургуулийн байр, 4 хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-316395 Факс: +(976-11)-316395
13 хороолол тооцооны төв	Эм Жи Эл ХХК-ийн байр, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, 25 хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-457018
Тамир тооцооны төв	"Ханна Импекс" ХХК-ийн байр, Ард Аюушийн гудамж, 3 хороолол, Баянгол дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-304959 Факс: +(976-11)-304959



Нарантуул тооцооны төв	Нарантуул ОУХТөвийн захиргааны байр, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-457018
Их дэлгүүр тооцооны төв	Зан интернэйшнл ХХК-ийн байр, 4 хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-311530 Факс: +(976)-70111352 Дотуур утас: 1050
Номин тооцооны төв	Улсын их дэлгүүрийн байр, Энхтайвны өргөн чөлөө, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-313232 Факс: +(976-11)-314242
Сэнтрал тауэр тооцооны төв	Сэнтрал тауэр, Сүхбаатарын талбай, 4 хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-326474 Факс: +(976-11)-326494
32 тойрог тооцооны төв	“Сансар32” худалдааны төв, 32-р тойрог, 12 хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976)-77443232 Факс: +(976)-77443131
Сонгинохайрхан тооцооны төв	Жавхлант төвийн байр, 19 хороо, Сонгинохайрхан дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-636205 Факс: +(976-11)-636217
ИБМУТ тооцооны төв	ИБМУТөвийн байр, Цагдаагийн гудамж, 11 хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-350267
ШУТИС тооцооны төв	ШУТИС-ийн төв байр, 8 хороо, Бага тойруу, Залуучуудын өргөн чөлөө, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70111530
Кино үйлдвэр тооцооны төв	Асгат ХХК-ийн байр, 5-р хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-455341
Макс моол тооцооны төв	Макс моол худалдааны төв, Баянгол дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976)-70111227
Өргөө тооцооны төв	“ХОТУ” ХХК-ийн байр, 3 хороолол, Баянгол дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-368276,
Варьете тооцооны төв	“Газар холдинг” ХХК-ийн байр, 4 хороо, Баянгол дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976)-70129701
10 хороолол тооцооны төв	Олд Чех ХХК-ийн байр, 5 хороо, 10 хороолол, Баянгол дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976-11)-682108,
Тэнгис тооцооны төв	Виктори центр, Самбуугийн гудамж, 5 хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976)-70120520 Факс: +(976)-70120522
Баянзүрх бизнес төв	“Мөнгөн гүүр” ББСБ-н байр, 12 хороолол, 3 хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70157094
Да хүрээ тооцооны төв	Да хүрээ ХХК-ийн худалдаа үйлчилгээний 3-р төв, Шар хадны гудамж, 17 хороо, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот	Утас: +(976)-70151533,
Жапан таун тооцооны төв	Жапан таун, Махатма Гандигийн гудамж, 1 хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар	Утас: +(976)-70129702
Зайсан тооцооны төв	Билэг төв, Зайсангийн гудамж, 1 хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар	
Хувийн банкны алба	Бодь тауэр, Сүхбаатарын талбай, Улаанбаатар	Утас: +(976-11)-311530 Факс: +(976-11)-326840

ОРОН НУТАГ ДАХЬ САЛБАРУУД

Банкны нэгж	Хаяг	Холбоо барих
Орхон салбар	Амарын гудамж, Баян-Өндөр сум, Орхон аймаг	Утас: +(976)-70355100 Факс: +(976)-70355100
Дархан салбар	Голомт банкны байр, 13 баг, Дархан сум, Дархан-Уул аймаг	Утас: +(976)-70373928 Факс: +(976)-70377136
Ховд салбар	Монголбанкны байр, Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг	Утас: +(976)-70432115 Факс: +(976)-70432195
Баян-Өлгий салбар	Голомт банкны байр, 5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг	Утас: +(976)-70442012
Өмнөговь салбар	Голомт банкны байр, 3-р баг, Даланзадгад хот, Өмнөговь аймаг	Утас: +(976)-70533990 Факс: +(976)-70533991
Дорнод салбар	"Хишиг-Агро" ХХК-ийн Үйлчилгээний төвийн байр, 7-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг	Утас: +(976)-70582703 Факс: +(976)-70582702
Дорноговь салбар	Ц.Ванжилдоржийн хувийн эзэмшлийн байр, 1-р баг, Сайншанд сум, Дорноговь аймаг	Утас: +(976)-70523177
Дорнод-Хэрлэн тооцооны төв	24-р байр, 6-р баг, Хэрлэн сум, Дорнод аймаг	Утас: +(976)-70582704
Замын-Үүд тооцооны төв	Замын-Үүд төмөр замын өртөө, 1-р баг, Замын-Үүд сум, Дорноговь аймаг	Утас: +(976)-025-245)-43773 Факс: +(976)-025-245)-43773
Тирлик тооцооны төв	"Армон" их дэлгүүр, 5-р баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг	Утас: +(976)-70422008
Орхон Пирамид тооцооны төв	"Тод жаргал" ХХК-ийн байр, Согоот баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг	Утас: +(976)-70353789 Факс: +(976)-70353789
Орхон зээлийн төв	"Орхон Чандмань" ХХК-ийн байр, Уурхайчин баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг	Утас: +(976)-70357058
Сүхбаатар тооцооны төв	Монос төв, 7-р баг, Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг	Утас: +(976)-70512006
Дархан зээлийн төв	Мандах Баясах ХХК-ийн байр, 8-р баг, Дархан сум, Дархан-Уул аймаг	Утас: +(976)-70375098 Факс: +(976)-70375098,
Хөвсгөл салбар	Дамдинсүрэнгийн байр, 8-р баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг	Утас: +(976)-70388474 Факс: +(976)-70388474
Ховд-Булган тооцооны төв	Бүрэнхайрхан баг, Булган сум, Ховд аймаг	Утас: +(976)-70432178
Өвөрхангай тооцооны төв	Оюу төв, 5-р баг, Гэндэнгийн гудамж, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг	Утас: +(976)-70322525
Ховд-Баянбүрд тооцооны төв	Баянбүрд төв, Жаргалант баг, Жаргалант сум, Ховд аймаг	Утас: +(976)-70432175 Факс: +(976)-70432175
Аршанд тооцооны төв	"Ган зам" төв, 4-р баг, Сайншанд сум, Дорноговь аймаг	Утас: +(976)-0252242792
Оюу толгой тооцооны төв	Оюу толгой камп, Ханбогд сум, Өмнөговь аймаг	Гар утас: +(976)-99032337
Цогтцэций тооцооны төв	1-7 тоот, Ямаан хүрэн баг, Цогтцэций сум, Өмнөговь аймаг	Гар утас: +(976)-99057659
Ханбогд тооцооны төв	Гоётын 1-7-р байр, Ханбогд сум, Өмнөговь аймаг	Утас: +(976)-70535148 Факс: +(976)-70535148
Гурван тэс тооцооны төв	Хүрд супермаркет, Гурван тэс сум, 4-р баг, Өмнөговь аймаг	Утас: +(976)-70536466
Сэлэнгэ тооцооны төв	Баянхан худалдааны төв, Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг	Утас: +(976)-70362318 Факс: +(976)-70362318
Баянхонгор тооцооны төв	"Баянхонгор" их дэлгүүр, Баянхонгор сум, Баянхонгор аймаг	Утас: +(976)-70444511, Факс: +(976)-70444522,





ГАДААДАД БУЙ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР

Банкны нэгж	Хаяг	Холбоо барих
Бээжин дэх төлөөлөгчийн газар	10E, CITIC building Tower A19, Jianguomen Dajie, Beijing, China 100004	Утас: +(86-10)-65033876 Факс: +(86-10) -65923727 Гар утас: +(86-139) -11737254 И-мэйл: golomt@public2.bta.net.cn
Лондон дахь Төлөөлөгчийн газар	27 Throgmorton Street, London EC2N 2AQ, United Kingdom	Утас: +(44-0)-20 7382 9900 Факс: +(44-0) -20 7382 9988 И-мэйл: jeremy.denton-clark@gbw.com И-мэйл: mail@gbw.com



ГОЛОМТ БАНК

Сайн сайхныг санхүүжүүлнэ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**Голомт Банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

Бид Голомт банк ХХК (цаашид "Банк" гэх) болон түүний охин компани (цаашид нийлүүлээд "Групп" гэх)-ийн 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтууд нь Банкны захирлын хариуцлага байдаг.

Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдэлийн үнэлгээ зэргийг багтаасан аудитуудын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг. Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Групп ба Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 91 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Банкны хувьцаа эзэмшигчдийн захиалсан аудиттай холбогдуулан Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.


Ernst & Young Mongolia Audit LLC

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Petr Markay

Петр Маркэй
Гүйцэтгэх Захирал

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 14 MAR 2012

ГОЛОМТ БАНК ХХК
**2011 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

	Тодруулга	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	4	165,165,129	165,165,129	111,156,503
Хүү болон түүнтэй адилтгах зардал	5	(116,238,120)	(116,239,705)	(81,448,479)
Хүүгийн цэвэр орлого		48,927,009	48,925,424	29,708,024
Хураамж ба шимтгэлийн орлого	6	18,213,204	18,213,204	12,655,448
Хураамж ба шимтгэлийн зардал	6	(3,760,654)	(3,760,654)	(2,742,830)
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого		14,452,550	14,452,550	9,912,618
Арилжааны цэвэр орлого	7	(1,296,376)	(1,296,376)	296,189
Үйл ажиллагааны бусад орлого	8	20,530,083	20,530,083	6,540,276
Үйл ажиллагааны нийт орлого		82,613,266	82,611,681	46,457,107
Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал	9	(8,681,120)	(8,681,120)	982,594
Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт	10	(1,450,000)	(1,450,000)	-
Үйл ажиллагааны цэвэр орлого		72,482,146	72,480,561	47,439,701
Үйл ажиллагааны зардал	11	(32,545,909)	(32,545,134)	(21,241,842)
Татварын өмнөх ашиг		39,936,237	39,935,427	26,197,859
Орлогын албан татварын зардал	12	(9,691,528)	(9,691,370)	(6,145,111)
Тайлант жилд банкны хувьцаа эзэмшигчид ногдох нийт дэлгэрэнгүй орлогыг илэрхийлэх тайлант жилийн ашиг		30,244,709	30,244,057	20,052,748
Бусад дэлгэрэнгүй орлого				
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын татварын дараах алдагдал		(1,779,837)	(1,779,837)	(272,027)
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын татварын дараах алдагдал		1,450,000	1,450,000	-
Тайлант жилийн татварын дараах бусад дэлгэрэнгүй алдагдал		(329,837)	(329,837)	(272,027)
Группийн болон банкны хувьцаа эзэмшигчдэд ногдох тайлант жилийн, татварын дараах нийт бусад дэлгэрэнгүй орлого		29,914,872	29,914,220	19,780,721
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр):				
Нэгж хувьцааны үндсэн ашиг	13	1,288.83	1,288.80	914.23
Нэгж хувьцааны шингэрсэн ашиг	13	1,030.36	1,030.34	785.15

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ГОЛОМТ БАНК ХХК

2011 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
ХӨРӨНГӨ				
Бэлэн мөнгө ба төв банк дахь харилцах	14	289,877,430	289,877,430	138,054,713
Бусад банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж	15	221,882,445	221,882,445	249,898,638
Репо хэлцэл	16	24,979,395	24,979,395	3,997,668
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	17	-	-	4,486
Санхүүгийн хөрөнгө оруулалт - арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа	18	1,061,151	1,061,151	345,472
Санхүүгийн хөрөнгө оруулалт — борлуулахад бэлэн	18	2,758,940	2,758,940	7,457,330
Санхүүгийн хөрөнгө оруулалт — дуусгавар хугацаа хүртэл эзэмших	18	304,169,951	304,169,951	355,658,482
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	19	1,245,919,223	1,245,919,223	784,604,947
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	20	-	100,000	-
Үндсэн хөрөнгө	21	29,599,628	29,599,628	24,508,983
Биет бус хөрөнгө	22	645,661	643,360	1,104,864
Бусад хөрөнгө	23	9,321,228	9,324,293	7,777,316
Хойшлогдсон татварын хөрөнгө	24	749,186	749,186	-
НИЙТ ХӨРӨНГӨ		2,130,964,238	2,131,065,002	1,573,412,899
ӨР ТӨЛБӨР				
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	25	9,228,503	9,228,503	80,833,669
Харилцагчдын харилцах, хадгаламж	26	1,840,034,920	1,840,136,411	1,317,499,322
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	17	2,570,585	2,570,585	1,506,132
Зээлээр авсан эх үүсвэр	27	63,127,467	63,127,467	28,386,592
Хоёрдогч өглөг	28	47,864,614	47,864,614	42,440,743
Бусад өр төлбөр	29	26,204,358	26,204,358	18,157,483
Хойшлогдсон татварын өглөг	24	380,420	380,420	-
Татварын өглөг		1,338,671	1,338,596	791,405
НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,990,749,538	1,990,850,954	1,489,615,346
БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД НОГДОХ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ				
Энгийн хувьцаа	30	24,591,543	24,591,543	21,934,142
Хувьцааны урамшуулал		22,344,874	22,344,874	-
Хуримтлагдсан ашиг		90,884,373	90,883,721	62,161,346
Бусад нөөц		2,393,910	2,393,910	(297,935)
НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		140,214,700	140,214,048	83,797,553
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		2,130,964,238	2,131,065,002	1,573,412,899

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ГОЛОМТ БАНК ХХК
**2011 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

	Энгийн хувьцаа мян.төг	Хувьцааны урамшуулал мян.төг	Хуримт- лагдсан ашиг мян.төг	Зайлшгүй байлгах нөөц* мян.төг	Хувьцаанд суурилсан төлбөрийн нөөц мян.төг	Борлуулахад бэлэн нөөц мян.төг	Нийт мян.төг
ГРУПП							
2011.01.01-ний өдрийн байдлаар	21,934,142	-	62,161,346	-	-	(297,935)	83,797,553
Тайлант жилийн ашиг	-	-	30,244,709	-	-	-	30,244,709
Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	-	-	-	(329,837)	(329,837)
Нийт дэлгэрэнгүй орлого/ (алдагдал)	-	-	30,244,709	-	-	(329,837)	29,914,872
Бусад нөөцрүү шилжүүлсэн	-	-	(1,521,682)	1,521,682	-	-	-
Нэмж гаргасан энгийн хувьцаа (Тодруулга 30)	2,657,401	22,344,874	-	-	-	-	25,002,275
Хувьцаанд суурилсан төлбөр (Тодруулга 33)	-	-	-	-	1,500,000	-	1,500,000
2011.12.31-ний өдрийн байдлаар	24,591,543	22,344,874	90,884,373	1,521,682	1,500,000	(627,772)	140,214,700

* Монголбанкнаас баталсан журмын дагуу ирээдүйн алдагдал эсвэл урьдчилан харах боломжгүй бусад эрсдэлүүд гэх мэт банкны ерөнхий эрсдэлүүдэд зориулсан тусгай нөөцийг НББОУС 39-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн зээлийн үнэ цэнийн бууралтын сан дээр нэмж байгуулдаг.

ГОЛОМТ БАНК ХХК

2011 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Энгийн хувьцаа мян.төг	Хувьцааны урамшуулал мян.төг	Хуримт- лагдсан ашиг мян.төг	Зайлшгүй байлгах нөөц* мян.төг	Хувьцаанд суурилсан төлбөрийн нөөц мян.төг	Борлуулахад бэлэн нөөц мян.төг	Нийт мян.төг
БАНК							
2010.01.01-ний өдрийн байдлаар	21,934,142	-	42,108,598	-	-	(25,908)	64,016,832
Тайлант жилийн ашиг	-	-	20,052,748	-	-	-	20,052,748
Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	-	-	-	(272,027)	(272,027)
2010.12.31-ний өдрийн байдлаар	21,934,142	-	62,161,346	-	-	(297,935)	83,797,553
Тайлант жилийн ашиг	-	-	30,244,057	-	-	-	30,244,057
Бусад дэлгэрэнгүй алдагдал	-	-	-	-	-	(329,837)	(329,837)
Нийт дэлгэрэнгүй орлого/(зарлага)	-	-	30,244,057	-	-	(329,837)	29,914,220
Зохицуулалтын нөөцрүү шилжүүлсэн	-	-	(1,521,682)	1,521,682	-	-	-
Нэмж гаргасан энгийн хувьцаа (тодруулга 30)	2,657,401	22,344,874	-	-	-	-	25,002,275
Хувьцаанд суурилсан төлбөр(тодруулга 33)	-	-	-	-	1,500,000	-	1,500,000
2011.12.31-ний өдрийн байдлаар	24,591,543	22,344,874	90,883,721	1,521,682	1,500,000	(627,772)	140,214,048

* Монголбанкнаас баталсан журмын дагуу ирээдүйн алдагдал эсвэл урьдчилан харах боломжгүй бусад эрсдэлүүд гэх мэт банкны ерөнхий эрсдэлүүдэд зориулсан тусгай нөөцийг НББОУС 39-ийн дагуу хүлээн зөвшөөрсөн зээлийн үнэ цэнийн бууралтын сан дээр нэмж байгуулдаг.

ГОЛОМТ БАНК ХХК
**2011 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР
БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Тодруулга	ГРУПП		БАНК	
	2011 мян.төг	2011 мян.төг	2010 мян.төг	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
Татварын өмнөх ашиг	39,936,237	39,935,427	26,197,859	
Тохируулга:-				
Үнэ цэнийн бууралтын тооцооллоос үүссэн хүүгийн зардал	5	360,744	360,744	129,165
Агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	7	1,063,189	1,063,189	(45,769)
Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	7	253,065	253,065	(78,084)
Валютын форвард хэлцлийн бодит бус гарз/(олз)	7	5,749	5,749	(4,486)
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	8	(14,889)	(14,889)	(7,861)
Валютын ханшны өөрчлөлтийн бодит бус (олз)/гарз	8	(930,690)	(930,690)	1,273,765
Харилцагчдад олгосон зээл, урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдал	9	8,620,468	8,620,468	(984,302)
Бусад хөрөнгийн үнэ цэнэ бууралтын алдагдал	9	60,652	60,652	1,708
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт	10	1,450,000	1,450,000	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл	11	2,649,241	2,649,241	1,873,137
Биет бус хөрөнгийн хорогдуулга	11	575,057	574,950	976,622
Данснаас хассан үндсэн хөрөнгө	11	9,403	9,403	12,505
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө	11	-	-	8,156
ӨБҮХХ-ийн үнэ цэнийн бууралт	11	1,219	1,219	666,837
Хувьцаанд суурилсан төлбөрийн опционы	11	1,500,000	1,500,000	-
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг	55,539,445	55,538,528	30,019,252	
Үйл ажиллагааны хөрөнгийн өөрчлөлтүүд:-				
Монголбанкинд заавал байлгах нөөц		(140,053,610)	(140,053,610)	(15,922,000)
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа		(464,107,554)	(464,107,554)	(284,263,616)
Бусад хөрөнгө		(4,272,933)	(4,275,998)	(1,831,321)
Үйл ажиллагааны пассивын өөрчлөлтүүд:-				
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж		(71,605,166)	(71,605,166)	27,902,035
Харилцагчдын харилцах, хадгаламж		522,535,598	522,637,089	522,248,314
Бусад өр төлбөр		8,046,876	8,046,876	6,046,149
Үйл ажиллагаанд (зарцуулсан)/ орсон мөнгө	(93,917,344)	(93,819,835)	284,198,813	
Орлогын албан татварын төлөлт		(9,513,028)	(9,512,945)	(6,180,496)
Үйл ажиллагаанд (зарцуулсан)/ орсон цэвэр мөнгө	(103,430,372)	(103,332,780)	278,018,317	
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт		-	(100,000)	-
Худалдан авсан санхүүгийн хөрөнгө оруулалт		(51,742,097)	(51,742,097)	(31,516,115)
Дуусгавар болсон ба борлуулсан санхүүгийн хөрөнгө оруулалтын орлого		5,198,473	5,198,473	30,517,401
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		67,484	67,484	33,552

ГОЛОМТ БАНК ХХК

2011 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	Тодруулга	ГРУПП 2011 МЯН.ТӨГ	БАНК 2011 МЯН.ТӨГ	2010 МЯН.ТӨГ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ.)				
Худалдан авсан үндсэн хөрөнгө	21	(4,968,107)	(4,968,107)	(21,072,507)
Худалдан авсан репо хэлцлүүд		(634,100,512)	(634,100,512)	740,203,868
Хугацаа дуусгавар болсон репо хэлцлийн орлого		634,100,512	634,100,512	(747,936,708)
Худалдан авсан биет бус хөрөнгө	22	(115,854)	(113,446)	(686,155)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(51,560,101)	(51,657,693)	(30,456,664)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
Хувьцаа нэмж гаргаснаас орж ирсэн мөнгө		25,002,275	25,002,275	-
Зээлийн санхүүжилтийн татан авалт		69,318,280	69,318,280	9,303,161
Зээлийн санхүүжилтийн эргэн төлөлт		(34,577,405)	(34,577,405)	(43,511,539)
Хоёрдогч өглөгийн санхүүжилтийн татан авалт		-	-	31,411,750
Санхүүгийн үйл ажиллагаан-аас орж ирсэн /(-нд зарцуулсан)цэвэр мөнгөн гүйлгээ		59,743,150	59,743,150	(2,796,628)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/ өсөлт		(95,247,323)	(95,247,323)	244,765,025
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		691,071,501	691,071,501	446,306,476
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31	595,824,178	595,824,178	691,071,501
Хүүтэй холбоотой үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
Төлсөн хүү		116,238,120	116,239,705	81,448,479
Хүлээн авсан хүү		165,165,129	165,165,129	111,156,503

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ГОЛОМТ БАНК ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 2011 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. БАНКНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Голомт банк (цаашид “Банк” гэх) болон түүний салбар (цаашид нийлүүлээд “Групп” гэх)-ийн үндсэн үйл ажиллагаа нь Монголбанкнаас олгосон 24 тоот зөвшөөрлийн дагуу банк, санхүүгийн үйлчилгээ байна. Тайлант хугацаанд банкны үйл ажиллагааны мөн чанарт томоохон өөрчлөлт гараагүй болно.

Банк нь Монгол Улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Банкны үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг албан хаяг нь Голомт банкны байр, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар хот, 210620А, Монгол Улс.

Банкны хувьцааны 89%-ийг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Бодь Интернэшнл ХХК эзэмшдэг.

ТУЗ-ийн 2012 оны 3 сарын 14-ны өдрийн шийдвэрээр Групп ба Банкны 2011 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланг баталж, нийтэд мэдээлэхийг зөвшөөрсөн.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 Тайлан бэлтгэх үндэслэл

Бодит үнэ цэнээрээ хэмжигдэх “Борлуулахад бэлэн” болон “Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа” хөрөнгө оруулалтыг эс тооцвол санхүүгийн тайлангуудыг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн болно. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд мянганы орноор, Монгол төгрөгөөр тайлагнасан.

Нийцлийн мэдэгдэл

Банкны болон Группийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс баталж гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэгдсэн болно.

Санхүүгийн тайлангийн толилуулга

Групп ба Банк нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дарааллаар толилуулсан. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараахь 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас хойшхи хугацаанд (урт хугацаанд) гарсан хүлээн авсан эсвэл хийсэн төлбөрүүдийн талаарх шинжилгээг Тодруулга 35-д толилуулсан.

Хэрэв Групп ба Банк нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд толилуулах эрхтэй. Нягтлан бодох бүртгэлийн аливаа нэг стандарт эсвэл тайлбараар шаардсан эсвэл зөвшөөрснөөс бусад тохиолдолд Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгайлан тодруулсанчлан орлого, зарлагыг дэлгэрэнгүй орлогын тайланд цэвэршүүлэн тайлагнаж болохгүй.

Тасралтгүй үйл ажиллагаа

Групп ба Банкны удирдлага Групп ба Банкны тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварыг үнэлж үзсэн бөгөөд Групп ба Банк нь ойрын ирээдүйд бизнесээ тасралтгүй явуулж чадах хэмжээний нөөцтэй гэж дүгнэсэн. Цаашилбал удирдлага нь Групп ба Банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадварын талаар эргэлзээ төрүүлж болох аливаа нэг материаллаг тодорхойгүй байдлын талаар олж мэдсэн зүйлгүй байна.

Нэгтгэл бэлтгэх үндэслэл

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Банк болон түүний охин компаний 2011-оны 12-дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн санхүүгийн тайлангуудыг агуулна.

Групп хяналтыг өөртөө авсан өдөр охин компани нь бүхэлдээ нэгтгэгддэг ба, нэгтгэл нь хяналтыг алдах хүртэл

үргэлжилдэг. Охин компаний санхүүгийн тайлангийн бодлого нь толгой компаний бодлоготой нийцтэй байх ба санхүүгийн тайлагналын хугацаа нь мөн ижил байна. Групп доторх бүх төрлийн ажил гүйлгээ, тайлан тэнцэл, орлого зарлагууд нь бүхэлдээ цэвэршүүлсэн болно.

2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүд

Банк болон Группийн нягтлан бодох бүртгэлийг хэрэглэх явцдаа удирдлага нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг тодорхойлохдоо үнэлэмж, ойролцоолсон тооцооллуудыг хэрэглэдэг. Хамгийн том үнэлэмж, ойролцоолсон тооцооллуудыг дор үзүүлэв. Үүнд:

Хувьцаанд суурилсан төлбөрийн гүйлгээ

Групп ба Банк нь ажилчдад олгосон, өөрийн хөрөнгөөр барагдуулах санхүүгийн хэрэглүүрийн өртгийг, тухайн хэрэглүүрийг олгосон өдрийн байдлаарх түүний бодит үнэ цэнээс нь хамааруулан хэмжинэ. Хувьцаанд суурилсан төлбөрийн ажил гүйлгээний бодит үнэ цэнийг ойролцоолон тооцоолох нь нөхцөлт хандивын нөхцөл, шаардлагаас хамааралтай хамгийн тохиоромжтой үнэлгээний аргыг тодорхойлохыг шаарддаг. Энэ тооцоолол нь хувьцааны опционы хүлээгдэж буй хугацаа, хэлбэлзэл, ногдол ашгийн өгөөж гэх мэт хамгийн зохистой орцуудыг тодорхойлохыг мөн шаарддаг. Хувьцаанд суурилсан төлбөрийн бодит үнэ цэнийг тооцоолоход ашигласан төсөөлөл, загваруудыг Тодруулга 33-д толилуулсан болно.

Барилгын элэгдэл

Барилгын доорхи газрын түрээсийн хугацаа 40 жилээс бага гэсэн хэдий ч барилгыг ашиглалтын ойролцоолсон хугацаа болох 40 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлдэг. Монгол Улсын Газрын тухай хуульд зааснаар Банк нь газрын түрээсийг хугацааг сунгах хүсэлтийг гаргах эрхтэй ба тодорхой шалгууруудыг хангасан тохиолдолд засгийн газрын эрх бүхий байгууллага түрээсийн хугацааг сунгадаг. Банкны удирдлага банк тэдгээр шаардлагуудыг хангаж байгаа ба Банк түрээсийн хуримтлагдсан хугацааг 40 жил гэж ойролцоолон тооцоолсон нь зохистой, бодитой гэдэгт итгэлтэй байна.

Зээл, урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдал

Групп ба Банк нь үнэ цэнийн бууралтын алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэх шаардлагатай эсэхийг үнэлэх үүднээс санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дангаараа томоохон дүнтэй зээл, урьдчилгаануудыг хянаж үздэг. Тухайлбал, үнэ цэнийн бууралтыг тодорхойлох үед ирээдүйн мөнгөн урсгалын дүн, хугацааг ойролцоолон тооцоолоход удирдлагын үнэлэмж шаардагддаг. Ийм тооцоолол нь олон тооны хүчин зүйлүүдийн талаарх таамаглалууд дээр үндэслэдэг ба бодит үр дүнгээс өөр байж болох бөгөөд энэ нь ирээдүйд сангийн хэмжээнд өөрчлөлт оруулахад хүргэж болно.

Гарсан нь бодитоор нотлогдож байгаа гэхдээ үр дагавар нь бодитоор нотлогдоогүй алдагдлуудын улмаас сан байгуулах шаардлагатай эсэхийг тодорхойлох үүднээс тусгай үнэлгээгээр үнэлж, үнэ цэнийн бууралтгүй гэж тодорхойлсон зээл урьдчилгаанууд ба дангаар том дүнтэй биш бүх зээл, урьдчилгаануудыг нийлүүлж, эрсдэлийн ойролцоо шинж чанараар нь багцлан, багцын үнэлгээг хийнэ. Багцын үнэлгээ нь тухайн багцын өгөгдлүүд (хугацаа хэтрэлтийн түвшин, зээлийн ашиглалт, зээлийн дүн ба барьцаа хөрөнгийн дүнгийн хоорондын харьцаа гэх мэт) эрсдэлийн төвлөрөл, эдийн засгийн өгөгдлүүд (ажилгүйдлийн түвшин, үл хөдлөх хөрөнгийн үнийн индексүүд гэх мэт) -ийг авч үздэг.

Зээл, урьдчилгаануудын үнэ цэнийн бууралтын алдагдлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 9 ба 19-д толилуулсан болно.

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт

Групп ба Банк нь “Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт” гэж ангилсан өрийн үнэт цаасууд нь үнэ цэнийн бууралтад орсон эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг. Энэ нь “Зээл ба авлага”-ын тусгайлсан үнэлгээнд хэрэглэсэнтэй төсөөтэй үнэлэмжийг шаарддаг.

Мөн Групп ба Банк нь бодит үнэ цэнэ нь өртгөөсөө их хэмжээгээр эсвэл урт хугацаанд тогтмол буурч байгаа, борлуулахад бэлэн өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтууд дээр үнэ цэнийн бууралтын алдагдлыг бүртгэдэг. “Их хэмжээ”, “Урт хугацаа” гэдгийг тодорхойлоход үнэлэмж шаардлагатай. Энэ үнэлэмжийг хийхдээ Групп ба Банк нь хувьцааны үнийн өөрчлөлтийн түүх, хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өртгөөсөө ямар хугацаанд, ямар хэмжээгээр доогуур байсан зэрэг олон хүчин зүйлийг үнэлж үзнэ.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, төсөөллүүд (үргэлжлэл)

Хойшлогдсон татварын хөрөнгө

Алдагдлыг ашиглах боломжтой татвар ногдох ашиг олох магадлал байгаа үед татварын алдагдал дээр хойшлуулсан татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Ирээдүйд олох татвар ногдох ашгийн хугацаа, хэмжээ ба ирээдүйн татвар төлөвлөлтийн стратеги зэрэг дээр үндэслэн хойшлуулсан татварын хөрөнгийн тодорхойлоход үнэлэмж шаардлагатай.

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ

Санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бодит үнэ цэнийг идэвхтэй зах зээл дээрээс олж авах боломжгүй байгаа үед тэдгээрийг математик загваруудыг ашиглах гэх мэт төрөл бүрийн үнэлгээний техникүүдийг ашиглан тодорхойлно. Тэдгээр загварт хэрэглэх өгөгдлүүдийг ашиглах боломжтой зах зээлийн өгөгдлүүдээс гарган авах ба ашиглах боломжтой зах зээлийн өгөгдөл байхгүй байгаа тохиолдолд бодит үнэ цэнийг тодорхойлоход үнэлэмж шаардлагатай. Үнэлэмжинд төлбөрийн чадвар, урт хугацаат үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн хувирамтгай байдал, хөнгөлөлтийн түвшин, урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээ, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өгөгдмөл хувь хэмжээний талаарх төсөөлөл гэх мэт загварын орцуудыг авч үзэх ажил багтана.

Санхүүгийн хэрэглүүрүүдийн үнэлгээний талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 32-т толилуулсан болно..

2.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ба толилуулгад орсон өөрчлөлтүүд

Шинэ ба нэмэлт өөрчлөлт орсон стандарт, тайлбарууд

2011 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхлэх дараах шинэ болон нэмэлт өөрчлөлт хийгдсэн НББОУС, СТОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын тайлбарын хорооноос гаргасан тайлбар ("СТОУТХТ")-уудыг эс тооцвол Банкны хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхтэй адил байна.

- НББОУС 24: Холбоотой талуудын тодруулга (Нэмэлт өөрчлөлт) – 2011.01.01-ний өдөр буюу түүнээс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ
- НББОУС 32: Санхүүгийн хэрэглүүрүүд: Толилуулга (Нэмэлт өөрчлөлт) – 2010.02.01-ний өдөр ба түүнээс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ
- СТОУТХТ 14: Хамгийн бага санхүүжилтийн дүнг урьдчилан төлөх (Нэмэлт өөрчлөлт) - 2011.01.01-ний өдөр ба түүнээс хойшхи хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ
- Сайжруулсан СТОУС-ууд (2010 оны 5 дугаар сар)

Стандарт эсвэл тайлбаруудыг хэрхэн авч хэрэгжүүлж байгааг дор тайлбарлав:

НББОУС 24 Холбоотой талуудын тодруулга (Нэмэлт өөрчлөлт)

НББОУС-ын Зөвлөлөөс холбоотой талын тодорхойлолтыг илүү ойлгомжтой болгосон НББОУС 24-ийн нэмэлт өөрчлөлтийг гаргасан. Шинэ тодорхойлолтууд нь холбоотой талуудын хоорондхи харилцааны тэгш хэмтэй байдлыг онцлон авч үзсэн ба байгууллагын холбоотой талын харилцаанд хүмүүс ба гол удирдах ажилтан нөлөө үзүүлж болох нөхцөл байдлуудыг тодруулж өгсөн. Үүнээс гадна энэ нэмэлт өөрчлөлтөөр засгийн газар болон тайлагнагч байгууллагын нэг адил засгийн газрын хяналт, хамтын хяналт эсвэл томоохон нөлөөлөл дор байдаг байгууллагуудтай хийсэн гүйлгээнүүд нь холбоотой талын ерөнхий тодруулгуудаас чөлөөлөгдөхөөр болсон. Энэ нэмэлт өөрчлөлтийг авч хэрэгжүүлэх нь Банкны санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд ямар нэг нөлөө үзүүлэхгүй.

НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүрүүд Толилуулга (Нэмэлт өөрчлөлт)

НББОУС-ын Зөвлөл нь байгууллагуудад гаргасан эрх, зарим нэг опцион эсвэл баталгааг өөрийн хөрөнгийн хэрэглүүрт ангилж боломжийг олгох үүднээс НББОУС 32 дахь санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг өөрчилсөн нэмэлт өөрчлөлтийг гаргасан. Хэрэв эрхийг байгууллагын нэг ангилалтай үүсмэл бус өөрийн хөрөнгийн хэрэглүүрүүдийн одоо байгаа бүх эзэмшигчдэд байгууллагын тогтмол тооны өөрийн хөрөнгийн хэрэглүүрийг тогтсон дүнтэй аливаа нэг мөнгөн тэмдэгтээр сольж авах эрхийг хувь тэнцүүлэн олгож буй тохиолдолд энэ нэмэлт өөрчлөлтийг хэрэглэж болно. Банкинд эдгээр төрлийн хэрэглүүрүүд байхгүй учраас энэхүү нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд нөлөө үзүүлэхгүй.

СТОУТХ 14 Хамгийн бага санхүүжилтийн дүнг урьдчилан төлөх (Нэмэлт өөрчлөлт)

Энэ нэмэлт өөрчлөлт нь байгууллагад хамгийн бага санхүүжилтийн шаардлага тавигдаж байгаа үед санамсаргүй үр дагаврыг арилгах ба ийм шаардлагуудад нийцэх үүднээс оруулах хувиа урьдчилан төлөх боломжийг олгосон. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь байгууллага ирээдүйн үйлчилгээний хөлсний зардлыг урьдчилан төлж байгаа бол түүнийг тэтгэврийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөхийг зөвшөөрсөн. Энэхүү хамгийн бага санхүүжилтийн шаардлага нь Европийн холбооны улсуудад хамааралтай тул Банкны санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд нөлөө үзүүлэхгүй.

Сайжруулсан СТОУС-ууд

2010 оны 5 дугаар сард НББОУС-ын Зөвлөл нь тууштай биш зүйлүүдийг арилгах, үгнүүдийг илүү ойлгомжтой болгох үндсэн зорилготойгоор өөрийн стандартуудад оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийн багцыг гаргасан. Стандарт нэг бүрт шилжилтийн үед хэрэгжих тусдаа заалтууд байгаа. Дараах нэмэлт өөрчлөлтүүдийг авч хэрэгжүүлэх нь нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо өөрчлөлт оруулахад хүргэх боловч Банкны санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд нөлөө үзүүлэхгүй.

- СТОУС 3: Бизнесийн нэгдэл: Хяналтын бус ашиг сонирхолыг хэмжих сонголтод хувилбаруудад нэмэлт өөрчлөлт хийсэн. Дампуурлын үед байгууллагын цэвэр хөрөнгөөс хувь тэнцүүгээр хувь хүртэх эрхийг эзэмшигчдээ олгож чадах өнөөгийн эзэмшлийн ашиг сонирхолыг хүчин төгөлдөр болгож буй хяналтын бус ашиг сонирхолын зөвхөн тэр бүрэлдэхүүн хэсгүүдийг бодит үнэ цэнээр нь эсвэл өнөөгийн эзэмшлийн хэрэглүүрүүдийн тодорхойлогдох цэвэр хөрөнгөд хувь тэнцүүлсэн хувь хэмжээгээр хэмжинэ. Бусад бүх бүрэлдэхүүн хэсгүүдийг худалдан авалтын өдрийн бодит үнэ цэнээр нь хэмжинэ.
- СТОУС 7: Санхүүгийн хэрэглүүрүүд – Тодруулга: Энэ нэмэлт өөрчлөлт нь барьцаанд авсан хөрөнгөтэй холбоотой тодруулгын хэмжээг багасгах, тоон тодруулгууд дээр нэмж чанарын буюу үгэн тодруулгуудыг хийхийг шаардах замаар тодруулгыг сайжруулах зэргээр тодруулгуудыг хялбар болгоход чиглэсэн. Банк эдгээр шинэ шаардлагыг Тодруулга 16-д тусгасан болно.
- НББОУС 1: Санхүүгийн тайлангийн толилуулга: Энэ нэмэлт өөрчлөлт байгууллага нь бусад дэлгэрэнгүй орлогын бүрэлдэхүүн нэг бүрийн шинжилгээг өмчийн өөрчлөлтийн тайланд эсвэл санхүүгийн тайлангуудын тодруулгын хэсэгт толилуулж болно.

Дараах стандартуудад хийсэн СТОУС-ын сайжруулалтуудаас улбаалсан бусад нэмэлт өөрчлөлтүүд нь Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогууд, санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд ямар нэг нөлөө үзүүлэхгүй. Үүнд:

- СТОУС 3: Бизнесийн нэгдэл (2008 онд шинэчлэн найруулсан СТОУС 3-ыг хэрэгжихээс өмнө бизнесийн нэгдлээс үүссэн болзошгүй нөхөн төлбөр)
- СТОУС 3: Бизнесийн нэгдэл (Солиогүй ба сайн дураараа сольсон хувьцаанд суурилсан шагналт төлбөрүүд)
- НББОУС 27: Нэгтгэсэн ба салангид санхүүгийн тайлан
- НББОУС 34: Завсар үеийн санхүүгийн тайлагнал

Дараах тайлбар, тайлбарын нэмэлт өөрчлөлтүүд нь Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогууд, санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд ямар нэг нөлөө үзүүлэхгүй. Үүнд:

- СТОУТХ 13: Харилцагчдад чиглэсэн хөтөлбөр (Шагналын кредитийн бодит үнэ цэнийг тодорхойлох)
- СТОУТХ 19: Санхүүгийн өр төлбөрийг өөрийн хөрөнгийн хэрэглүүрээр барагдуулах

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо

(1) Бизнесийн нэгдэл

Бизнесийн нэгдлийг бүртгэхдээ худалдан авалтын аргыг ашигладаг. Худалдан авалтын өртгийг хүлээн авсан зүйлийн худалдан авалтын өдрийн байдлаарх бодит үнэ цэнэ, худалдагдаж буй компани дахь хяналтын эрхгүй аливаа нэг ашиг сонирхлын дүнгийн нийлбэрээр хэмжинэ. Бизнесийн нэгдэл нэг бүр дээр Групп нь худалдагдаж буй компани дахь хяналтын эрхгүй ашиг сонирхлоо бодит үнэ цэнээр нь үнэлэх эсвэл худалдагдаж буй талын тодорхойлох боломжтой цэвэр хөрөнгийн дүнтэй хувь тэнцүүлэн үнэлэх эсэхээ сонгодог. Худалдан авалттай холбоотой гарсан зардлыг удирдлагын зардлаар бүртгэнэ.

Групп нь тухайн бизнесийг худалдан авах үед санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийг худалдан авалтын өдрийн байдлаарх гэрээний нөхцөл, эдийн засгийн нөхцөл байдал, тохирох нөхцлийн дагуу зохистой ангилж, нэрлэсэн эсэхийг үнэлж үздэг. Үүнд худалдагдаж буй тал нь үндсэн гэрээнд агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийг үндсэн гэрээнээс нь салгаж бүртгэсэн эсэхийг үнэлэх ажил багтана.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

(1) Бизнесийн нэгдэл (үргэлжлэл)

Бизнесийн нэгдэл нь үе шаттайгаар хэрэгжих тохиолдолд, худалдан авагчийн худалдагдаж буй компанид өмнө нь эзэмшиж байсан өөрийн хөрөнгийн ашиг сонирхолын худалдан авалтын өдрийн байдлаарх бодит үнэ цэнийг дахин хэмжиж, зөрүүг орлого, зарлагаар хүлээн зөвшөөрнө.

Худалдан авагч талд шилжүүлж болзошгүй аливаа төлбөрийг худалдан авалтын өдрийн байдлаарх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрнө. Хөрөнгө эсвэл өр төлбөр болж болзошгүй төлбөрийн бодит үнэ цэнэд дараагийн тайлант хугацаанд орсон өөрчлөлтийг НББОУС 39 –ийн дагуу орлогын тайланд эсвэл бусад дэлгэрэнгүй орлогын өөрчлөлт гэж бүртгэнэ. Болзошгүй төлбөрийг өөрийн хөрөнгө гэж ангилсан тохиолдолд түүнийг хэмжихгүй. Дараагийн тайлант хугацаанд хийгдсэн төлбөр тооцоог өөрийн хөрөнгөд бүртгэнэ. Болзошгүй төлбөр нь НББОУС 39–д хамаарахгүй тохиолдолд түүнийг зохих СТОУС-ийн дагуу хэмжинэ.

(2) Валютын ханшийн тэгшитгэл

Групп ба Банк нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн нэгж болох монгол төгрөгөөр гаргадаг.

Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгжрүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Арилжааны бус үйл ажиллагаанаас үүссэн ханшийн бүх зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд “Бусад үйл ажиллагааны орлого” гэж бүртгэнэ. Түүхэн өртөг нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг анхны гүйлгээний өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ.

(3) Санхүүгийн хэрэглүүр – анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт

(i) Хүлээн зөвшөөрөх өдөр

Бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг анх хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийгдсэн өдөр (Групп ба Банк тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Үүнд “хэвийн нөхцөлтэй арилжаа” буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг арилжаа орно.

(ii) Санхүүгийн хэрэглүүрийн анхны хүлээн зөвшөөрөлт

Анх хүлээн зөвшөөрч буй санхүүгийн хэрэглүүрүүдийн ангилал нь тэдгээрийн зориулалт, удирдлагын хандлага, шинж чанараас шалтгаална. “Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь орлого, зардлын дансанд бүртгэх” гэж ангилагдсан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдээс бусад санхүүгийн хэрэглүүрүүдийг анх хэмжихдээ бодит үнэ дээр гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хэмжинэ.

(iii) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь орлого, зардлын дансанд бүртгэх үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрт алтны опцион, валютын ханшны форвард гэрээ хэлцлүүд, гадаад валютын опцион зэрэг багтана. Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнийн өөрчлөлтийг “Арилжааны цэвэр орлого”-д бүртгэдэг.

Бусад санхүүгийн хэрэглүүрүүдэд агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг салгаж авч үзэх ёстой ба тэдгээрийн эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдлүүд нь агуулагч гэрээний эдийн засгийн үзүүлэлтүүд болон эрсдлүүдтэй нягт холбоотой биш, мөн агуулагч гэрээг арилжаалах зорилгоор эзэмшээгүй ба анх хүлээн зөвшөөрөхдөө “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” гэж ангилаагүй тохиолдолд тэдгээрийг бодит үнээр нь бүртгэнэ. Агуулагч гэрээнээс нь салгасан үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг арилжааны багц дахь бодит үнэ цэнийн өөрчлөлтөөр нь бүртгэх ба уг өөрчлөлтийг нь дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

(iv) Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөр

"Арилжаалах зорилгоор эзэмшиж буй" санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайланд бодит үнээр нь бүртгэнэ. "Арилжааны цэвэр орлого"-д бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тусгана. Хүүний болон ногдол ашгийн орлого эсвэл зардлыг гэрээний нөхцлийн дагуу эсвэл төлбөрийн эрх үүссэн үед нь "Арилжааны цэвэр орлого" дансанд бүртгэнэ.

Энэ бүлэгт ойрын хугацаанд борлуулах эсвэл эргүүлэн худалдан авах зорилгоор олж авсан өрийн бичгүүд, энгийн хувьцаа, үнэт цаасууд орсон.

(v) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт

Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтанд өөрийн хөрөнгийн ба өрийн үнэт цааснууд багтана. "Арилжаалах зорилгоор эзэмшиж буй" ба "бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх" гэсэн ангилалд ороогүй өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтыг "Борлуулахад бэлэн" гэж ангилна. Тодорхойгүй хугацаагаар эзэмших хандлагатай, төлбөрийн чадварын хэрэгцээг хангах үүднээс эсвэл зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас борлуулж болох өрийн үнэт цаасууд энэ ангилалд орно.

Групп ба Банк нь аливаа зээл, авлагуудыг "Борлуулахад бэлэн" санхүүгийн хөрөнгө гэж ангилаагүй. Анхны хэмжилтийн дараа борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтуудыг бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Хэрэгжээгүй ашиг алдагдлыг өөрийн хөрөнгийн (бусад дэлгэрэнгүй орлого) "Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөц"-д бүртгэдэг. Хөрөнгө оруулалтыг борлуулахад, өөрийн хөрөнгөд өмнө хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлыг орлогын тайланд "Үйл ажиллагааны бусад орлого"-оор хүлээн зөвшөөрнө. Групп ба Банк нь нэг төрлийн үнэт цаасанд нэгээс илүү удаа хөрөнгө оруулсан бол тэдгээрийг "эхэлж авснаа эхэлж зарлагдах" зарчмыг баримтлан борлуулсан гэж үзнэ. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон хүүний орлогыг үр ашигт хүүний аргыг ашиглан хүүний орлогоор бүртгэнэ. Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтыг эзэмшиж байх хугацаанд олсон ногдол ашгийг төлбөрийн эрх нь тогтоогдсон үед орлогын тайланд "Үйл ажиллагааны бусад орлого"-д хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлогын тайлангийн "Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал"-д хүлээн зөвшөөрч, борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтын нөөцөөс хасч өгнө.

(vi) Дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт

Тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөртэй, тогтоосон хугацаатай, Банк дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хандлага болоод чадвартай, үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүдийг "Дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалт" гэнэ. Эхний хэмжилтийн дараа дуусгавар хугацаа хүртэл эзэмших санхүүгийн хөрөнгө оруулалтыг үр ашигт хүүний арга ашиглаж тооцсон хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын санг хассан дүнгээр хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцдог. Хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Хүү болон түүнтэй адилтгах орлого"-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг орлогын тайлангийн "Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын алдагдал" хэсэгт хүлээн зөвшөөрнө.

Хэрэв Групп ба Банк нь бага биш дүнтэй "дуусгавар хугацаа хүртэл эзэмших" хөрөнгө оруулалтыг дуусгавар хугацаанаас нь өмнө худагдах эсвэл дахин ангилах бол (зарим нэг онцгой тохиолдлуудаас бусад) нийт бүлгээр нь "борлуулахад бэлэн" бүлэгт дахин ангилна. Үүнээс гадна Банк нь дараагийн хоёр жилд "дуусгавар хугацаа хүртэл эзэмших" бүлгээс аливаа нэг санхүүгийн хөрөнгийг дахин ангилахыг хориглодог.

(vii) Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа

"Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж" ба "Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа"-нд идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлох боломжтой төлбөрүүдтэй дараахаас бусад үүсмэл бус санхүүгийн хэрэглүүрүүд багтана. Үүнд:

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

(3) Санхүүгийн хэрэглүүр – анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт (үргэлжлэл)

(vii) Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа (үргэлжлэл)

- Групп ба Банк нэн даруй эсвэл ойрын хугацаанд борлуулах хандлагатай байгаа ба Банк анх хүлээн зөвшөөрөхдөө “Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх” гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрүүд.
- Групп ба Банк анх хүлээн зөвшөөрөхдөө “Борлуулахад бэлэн” гэж ангилсан санхүүгийн хэрэглүүрүүд.
- Групп ба Банк зээлийн үнэ цэнийн бууралтын улмаас биш өөр бусад шалтгааны улмаас анх оруулсан хөрөнгөө нийт дүнгээр нь эргүүлэн олж авч чадахгүй болсон санхүүгийн хэрэглүүрүүд.

Анх хэмжээний дараа “Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж” ба “Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа”-г үр ашигт хүүгийн аргыг хэрэглэн хорогдуулсан өртгөөс үнэ цэнэ бууралтын санг хассан дүнгээр бүртгэнэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүгийн салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэлийг оролцуулан тооцно. Хорогдуулалт нь орлогын тайлангийн “Хүү болон түүнтэй адилтгах орлого”-д багтана. Уг хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдалыг орлогын тайланд “Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдлын зардал” гэж хүлээн зөвшөөрнө.

Групп ба Банк нь богино хугацаанд зээлийг зарах хандлагатай байгаа учраас уг зээлийг “Арилжаалах зорилгоор эзэмшиж буй” гэж ангилахаар хүлээж байгаа үед Групп ба Банк зээл олгох тодорхой нэг амлалтыг гаргаж болно. Эдгээр амлалтыг үүсмэл санхүүгийн хэрэглүүр гэж бүртгэж, бодит үнэ цэнээр нь хэмжиж, зөрүүг орлого, зардлын дансанд бүртгэнэ.

(vii) Бусад банкуудад байршуулсан харилцах, хадгаламж ба харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа (үргэлжлэл)

Зээлийг татан авах үед Банк зээлийг хадгалж үлдэх ба богино хугацаанд худалдахгүй гэсэн амлалт гаргасан бол энэ амлалтыг хэрэгжүүлэх нь төвөгтэй ба алдагдал хүлээх магадлалтай (жишээ нь: харилцагч талын зээлийн үйл явдлын улмаас) үед л энэ амлалтыг бүртгэнэ.

(viii) Зээлээр авсан эх үүсвэр

Гэрээт зохицуулалтын агуулга нь өөрийн тодорхой тооны хувьцааны оронд бэлэн мөнгө эсвэл өөр ямар нэг санхүүгийн хөрөнгийг өгөх үүргийг эсвэл үүнээс өөр аргаар өөрийн өр төлбөрийг барагдуулах үүргийг Банкинд үүсгэж байгаа үед, Банкнаас гаргасан бөгөөд “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдаагүй санхүүгийн хэрэглүүрүүдийг “Зээлээр авсан эх үүсвэр” гэсэн нэрээр өр төлбөрийн хэсэгт ангилна.

Анх хүлээн зөвшөөрсний дараа, зээллэгүүдийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо зээл авах үеийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашигт хүүгийн нэг салшгүй хэсэг болж буй зардлуудыг авч үзнэ.

Групп ба Банкны зээлээр авсан эх үүсвэрүүдийн шинжилгээг Тодруулга 27-д толилуулсан.

(ix) Санхүүгийн хөрөнгийн дахин ангилал

2008.07.01-ний өдрөөс эхлэн зарим тохиолдолд үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүдийг “Арилжаалах зорилгоор эзэмшиж буй” гэсэн ангилалаас “Борлуулахад бэлэн”, “Зээл ба авлага”, “Дуусгавар хугацаа хүртэл эзэмших” гэсэн ангиллуудад дахин ангилахыг Банкинд зөвшөөрсөн. Мөн энэ өдрөөс зарим тохиолдолд санхүүгийн хэрэглүүрүүдийг “Борлуулахад бэлэн” ангиллаас “Зээл ба авлага” гэсэн ангилалд дахин ангилахыг Банкинд зөвшөөрсөн. Дахин ангилсан санхүүгийн хөрөнгүүдийг дахин ангилал хийсэн өдрийн бодит үнэ цэнээр (энэ нь хорогдуулсан шинэ үнэ болно) бүртгэнэ.

“Борлуулахад бэлэн” ангиллаас дахин ангилсан санхүүгийн хөрөнгүүд дээр өмнө нь хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөнд бүртгэсэн аливаа нэг олз гарзыг хөрөнгө оруулалтын үлдсэн хугацааны туршид үр ашигт хүүний аргаар хорогдуулж, орлого, зардлын дансанд бүртгэнэ. Хорогдуулсан шинэ үнэ, хүлээгдэж буй мөнгөн урсгал хоорондын аливаа зөрүүг мөн хөрөнгийн үлдсэн хугацааны туршид

үр ашигт хүүний аргаар хорогдуулна. Хэрэв дараагийн тайлант хугацаанд хөрөнгийг үнэ цэнийн бууралтанд орсон гэж тодорхойлбол өмнөх хугацаанд өөрийн хөрөнгөнд бүртгэсэн дүнг дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ.

Хэрэв хөрөнгө нь зээл, авлагын тодорхойлолтонд нийцэж байгаа бөгөөд Банк хөрөнгийг ойрын ирээдүйд эсвэл дуусгавар хугацаа хүртэл нь эзэмших хандлага ба чадвартай байгаа бол Банк үүсмэл бус санхүүгийн хөрөнгүүдийг "Арилжаалах зорилгоор эзэмшиж буй" гэсэн ангиллаас "Зээл ба авлага" гэсэн ангилалд дахин ангилж болно. Хэрэв санхүүгийн хөрөнгийг дахин ангилсан ба орж ирэх мөнгөний хэмжээ өссөний улмаас Банк ирээдүйд хүлээн авах мөнгөний ойролцоолсон дүнг дараагийн тайлант хугацаанд өсгөсөн бол уг өсөлтийн нөлөөг ойролцоолсон тооцоололд өөрчлөлт оруулсан өдрөөс эхлэн "Үр ашиг хүүний түвшинд хийсэн залруулга" гэж хүлээн зөвшөөрнө.

Дахин ангилал нь удирдлагын шийдвэрээс хамаарах ба хэрэглүүр тус бүр дээр тодорхойлно. Банк анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа аливаа нэг санхүүгийн хэрэглүүрийг "Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зардлын дансанд бүртгэгдэх" бүлэгт дахин ангилаагүй.

(4) Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

(i) Санхүүгийн хөрөнгө

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан, эсвэл.
- Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн, эсвэл:
- Банк хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
- Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Банк холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Банкны хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ.

Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

(ii) Санхүүгийн өр төлбөр

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Анхны санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

(5) Буцаан худалдан авах, урвуу буцаан худалдан авах хэлцлүүд

Ирээдүйд тодорхой заасан хугацаанд буцаан худалдан авах нөхцөлтэй хэлцэл ('репо')-ийн дор худалдсан үнэт цаасыг санхүүгийн байдлын тайлангаас үл хүлээн зөвшөөрөхгүй. Учир нь Банк эзэмшилтэй холбоотой ихэнх эрсдэлийг хүлээж, өгөөжийг хүртэж байна. Санхүүгийн байдлын тайланд хүлээн авсан бэлэн мөнгөө хөрөнгөөр, репо хэлцлийн хуримтлагдсан хүүг өр төлбөрөөр тус тус тусгах ба энэ нь Банкинд олгосон зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Борлуулсан ба ирээдүйд буцаан худалдан авах үнийн зөрүүг хүүний зардал гэж үзэж үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

(5) Буцаан худалдан авах, урвуу буцаан худалдан авах хэлцлүүд (үргэлжлэл)

Эсрэгээрээ, буцаан худалдах хэлцэл ('урвуу репо')-ийн дор худалдан авсан үнэт цааснуудыг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөггүй. Төлсөн мөнгөө хуримтлуулсан хүүгийн хамт тайлан тэнцэлд "Зээлсэн үнэт цаас ба урвуу буцаан худалдан авах хэлцлүүдийн бэлэн мөнгөөрх барьцаа" гэж тусгах ба энэ нь Банкнаас авсан зээл гэсэн эдийн засгийн утга агуулгыг илэрхийлнэ. Худалдан авсан ба буцаан худалдах үнийн зөрүүг "Хүүгийн цэвэр орлого" гэж бүртгэх ба үр ашигт хүүгийн аргыг ашиглан гэрээний хугацааны турш хуримтлуулна.

Хэрэв буцаан худалдах хэлцлээр худалдан авсан үнэт цаасыг гуравдагч талд худалдсан бол үнэт цаасыг буцаан өгөх үүргийг "Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр" гэж бүртгэх ба бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийн аливаа олз эсвэл гарзыг "Арилжааны цэвэр орлого"-д бүртгэнэ.

(6) Бодит үнэ цэнийн тодорхойлолт

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдаж буй санхүүгийн хэрэгслүүдийн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаарх бодит үнэ цэнэ нь аливаа гүйлгээний зардлыг хасаагүй биржийн ханш болон диллерийн үнэ (урт позицийн хувьд нийлүүлэлтийн үнэ, богино позицийн хувьд эрэлтийн үнэ) -н дээр үндэслэнэ.

Идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэгслүүдийн хувьд бодит үнийг нь тохиромжтой үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно. Эдгээр аргуудад цэвэр өнөөгийн үнэ цэнийн аргачлал, зах зээлийн үнийн мэдээ нь байдаг ойролцоо төсөөтэй өөр бусад санхүүгийн хэрэгслүүдтэй харьцуулсан арга, опционы үнэлгээний загвар, зээлийн загвар болон бусад тохиромжтой аргууд багтана.

(7) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Групп ба Банк нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангаар өдөр бүр үнэлж үзнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ойролцоолон тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ.

Үнэ цэнийн бууралтын нотолгоонд эзэлдэгч эсвэл бүлэг эзэлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийн хүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурал эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтанд орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

(i) Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүд

Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүд (банкууд дахь харилцах, харилцагч нарт олгосон зээл, урьдчилгаа, дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт)-ийн хувьд Групп ба Банк эхлээд дангаараа чухал ач холбогдолтой санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн (тусгайлан), дараа нь чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгүүдийг нийлүүлэн (бүлгээр нь) үнэлнэ.

Хэрэв Групп ба Банк нь нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд (чухал ач холбогдолтой, холбогдолгүй эсэхийг үл харгалзан) үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг. Үнэ цэнийн бууралтын нэг бүрчилсэн үнэлгээ хийгдсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжилж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (бодитоор тохиолдоогүй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүний орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан

хүүг ашиглан хуримтлуулна. Хүүний орлогыг “Хүү ба түүнтэй адилтгах орлого”-ын нэг хэсэг болгон бүртгэнэ. Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа, бүх барьцаа хөрөнгийг борлуулсан эсвэл банкинд шилжүүлсэн үед зээлийг холбогдох зээлийн эрсдлийн сангийн хамт данснаас хасна.

Хэрэв дараагийн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсөж эсвэл буурвал, сангийн дансыг залруулах замаар өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг өсгөж эсвэл бууруулна. Данснаас хассан хөрөнгө дараа нь эргэн төлөгдвөл “Зээлийн алдагдлын зардал” дансны кредитэд бүртгэнэ.

Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүгийн хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүгийн хувь нь хувьсах хүү байх нөхцөлд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүгийн хувьтай тэнцүү байна. Банк арилжааны зориулалттай хөрөнгийг “Зээл ба авлага” ангилалд дахин ангилсан бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь шинэ үр ашигт хүүгийн хувьтай тэнцүү байна. Барьцаатай санхүүгийн хөрөнгийн ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн тооцоо нь барьцааг хураан авах нь боломжтой эсэхээс үл хамааран тус барьцааг хураан авч, албадан борлуулахад гарах зардлыг хассаны дараах мөнгөн урсгалыг харуулдаг.

Үнэ цэнийн бууралтыг багцын үнэлгээг хийхдээ санхүүгийн хөрөнгийн төрөл, хамаарах салбар, газарзүйн байрлал, барьцаа хөрөнгийн төрөл, хугацаа хэтрэлтийн байдал болон бусад гол хүчин зүйлс зэрэг зээлийн эрсдэлийн шинж чанаруудыг харгалзан үзсэн банкны дотооддоо хэрэглэдэг зээллэгийн ангиллын систем дээр үндэслэн санхүүгийн хөрөнгийг бүлэглэнэ.

Эрсдэлийн бүлэг тус бүр дээр түүхэн дундаж алдагдлыг харгалзах зээлийн үлдэгдэлд нь хувааж үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцох энгийн аргачлалыг сонгосон. Өнөө үед үгүй болсон түүхэн нөхцөл байдлын нөлөөг арилгах, түүхэн алдагдлын суурилж буй жилүүдэд хамааралгүй өнөөгийн нөхцөл байдлын нөлөөг харуулах үүднээс түүхэн алдагдлын мэдээнд өнөө үед ажиглагдахуйц өгөгдлүүдэд үндэслэн тохиргоо хийнэ.

Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалын өөрчлөлтийн тооцоолол нь жил жилийн ажиглаж болохуйц холбогдох өгөгдлүүдийн өөрчлөлтүүдийг тусгасан. (Үүнд: ажилгүйдлийн түвшин, эд хөрөнгийн үнэ, өргөн хэрэглээний барааны үнэ, төлбөрийн чадавхи, алдагдлыг илэрхийлэх хүчин зүйлс бүлгээр болон ач холбогдлоор нь). Ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалыг тооцоолоход ашигласан аргачлал, таамаглалуудыг тооцоолсон алдагдал, бодитоор хүлээсэн алдагдлын хоорондын зөрүүг багасгах зорилгоор тогтмол хянана.

(ii) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтууд

Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын хувьд, Банк нь хөрөнгө оруулалт эсвэл бүлэг хөрөнгө оруулалт нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ.

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоонд бодит үнэ цэнэ нь тус хэрэглүүрийн өртгөөс их хэмжээгээр эсвэл тогтмол буурч байх явдал ордог

Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа тохиолдолд хуримтлагдсан алдагдал (худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хоёрын зөрүүнээс орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан тухайн хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжигдэх)-ыг өөрийн хөрөнгөөс хасч дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүний орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүг ашиглан хуримтлуулна. Хүүний орлогыг “Хүү ба түүнтэй адилтгах орлого”-ын нэг хэсэг болгон бүртгэнэ. Хэрэв дараагийн тайлант хугацаанд дэлгэрэнгүй орлогын тайланд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах зээлийн үйл явдлын улмаас өрийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ өсөж эсвэл буурвал, үнэ цэнийн бууралтын алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангаар дамжуулан буцаана.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

(7) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

(ii) Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө орлуулалтууд (үргэлжлэл)

“Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын хувьд, хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнэ нь өртгөөсөө их хэмжээгээр эсвэл урт хугацаанд тогтмол буурч байвал бодит нотолгоонд багтана. Үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа тохиолдолд хуримтлагдсан алдагдал (худалдан авалт ба өнөөгийн бодит үнэ цэнэ хоёрын зөрүүнээс дэлгэрэнгүй орлогын тайланд өмнө нь хүлээн зөвшөөрсөн байсан тухайн хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжигдэх)-ыг өөрийн хөрөнгөөс хасч дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө. Өөрийн хөрөнгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ бууралтын алдагдлын буцаалтыг орлогын тайлангаар дамжуулдаггүй, үнэ цэнийн бууралтын дараах бодит үнийн өсөлтийг дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана

(iv) Зээлийн шинэчилсэн гэрээ

Хэрэв боломжтой бол банк нь барьцаа хөрөнгийг хурааж өөрийн болгохоос илүүтэйгээр аль болох гэрээг шинэчлэн байгуулах боломжийг хайж байдаг. Үүнд зээлийн эргэн төлөлтийн хуваарийг сунгах, зээлийн шинэ нөхцөлийн санал болгох зэрэг ойлголтыг хамруулж болох юм.

Зээлийн гэрээг нэгэнт шинэчлэн байгуулсан бол аливаа нэг үнэ цэнийн бууралтыг зээлийн нөхцлийг өөрчлөхөөс өмнө тооцож байсны нэг адил анхны үр ашигт хүүний аргыг ашиглан хэмжих ба зээлийг хугацаа хэтэрсэн гэж үзэхгүй. Гэрээнд заасан зээлийн шалгуур нөхцөлүүд биелж буй эсэх, ирээдүйн зээл төлөлт хийгдэх баталгаа байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс зээлийн шинэчилсэн гэрээнд удирдлагын зүгээс байнгын хяналт тавин ажилладаг.

Эдгээр зээл нь зээлийн анхны үр ашигт хүүгийн хувиар тооцдог тусгайлсан болон багцын үнэ цэнийн бууралтын үнэлгээнд хамрагдсаар байна

(8) Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Хэрэв байгууллага нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр тайлан тэнцэлд толилуулах эрхтэй. Мастер цэвэршүүлэлт гэрээнүүдийн хувьд энэ нь хэрэгждэггүй ба холбогдох хөрөнгө болон өр төлбөрийг нийт дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд тус тусад нь толилуулдаг.

(9) Түрээс

Тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлохдоо гэрээний агуулга дээр үндэслэх ба гэрээг гүйцэтгэхэд тусгай хөрөнгийг ашиглах шаардлагатай эсэх ба гэрээ нь хөрөнгийг ашиглах эрхийг шилжүүлж байгаа эсэх зэргийг үнэлж үзэх шаардлагатай.

Банк түрээслэгч

Банкинд түрээслэж байгаа хөрөнгийн бүх эрсдэл, өгөөжийг шилжүүлэхгүй байгаа тохиолдолд түрээсийн гэрээ нь үйл ажиллагааны түрээс байна. Үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар бодож дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар бүртгэнэ.

Банк түрээслүүлэгч

Түрээслүүлэгч нь хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бараг бүх эрсдэлийг хүлээж, өгөөжийг хүртэж байгаа түрээсийг үйл ажиллагааны түрээс гэж ангилна. Үйл ажиллагааны түрээсийн гэрээг анх байгуулахад гарсан шууд зардлуудыг түрээслэсэн хөрөнгийн бүртгэлийн дүн дээр нэмэх ба түрээсийн хугацаанд түрээсийн орлогыг зөвшөөрөхтэй адил аргаар хүлээн зөвшөөрнө.

(10) Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх

Эдийн засгийн өгөөж нь Банкинд орж ирэх нь тодорхой болсон хэмжээгээр орлогыг хүлээн зөвшөөрөх ба орлогыг найдвартайгаар хэмжиж болно. Орлогыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө дараах тусгай шалгуурууд хангагдсан байх ёстой. Үүнд.

(i) Хүү болон түүнтэй адилтгах орлого ба зардал

Хорогдуулсан өртгөөр нь хэмждэг бүх санхүүгийн хэрэглүүрүүд, “Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан хүүтэй санхүүгийн хөрөнгүүд, “Бодит үнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдсан санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого, зардлыг үр ашигт хүүгийн хувийг (ирээдүйд төлөх эсвэл хүлээн авах мөнгөний ойролцоолон тооцоолсон дүнг санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаа эсвэл түүнээс богино хугацааны туршид санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн цэвэр дүнрүү нь бууруулах хүү) хэрэглэн бүртгэнэ.

Үнэ цэнийн бууралтад орсон зээл, урьдчилгааны хүүгийн орлогоос бусад хүүгийн орлогыг аккрузал сууриар орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогыг анхны үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр тооцож хүлээн зөвшөөрнө.

Хорогдуулсан өртгөөр нь хэмждэг бүх санхүүгийн хэрэглүүрүүд, “Борлуулахад бэлэн” гэж ангилагдсан хүүтэй санхүүгийн хөрөнгүүд, “Бодит үнийн өсөлт бууралт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх” гэж ангилагдсан санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого, зардлыг үр ашигт хүүгийн хувийг (ирээдүйд төлөх эсвэл хүлээн авах мөнгөний ойролцоолон тооцоолсон дүнг санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаа эсвэл түүнээс богино хугацааны туршид санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн цэвэр дүнрүү нь бууруулах хүү) хэрэглэн бүртгэнэ. Үнэ цэнийн бууралтад орсон зээл, урьдчилгааны хүүгийн орлогоос бусад хүүгийн орлогыг аккрузал сууриар орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнийн бууралтад орсон санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогыг анхны үр ашигт хүүгийн хувь хэмжээгээр тооцож хүлээн зөвшөөрнө.

Тооцоололд санхүүгийн хэрэглүүрийн гэрээний бүх нөхцлүүдийг (жишээ нь: урьдчилгаа төлбөрийн хувилбарууд) харгалзан үзсэн ба тухайн хэрэглүүрт шууд хамааралтай ба зээлийн ирээдүйн алдагдал биш харин үр ашигт хүүний салшгүй нэг хэсэг болж байгаа аливаа төлбөр эсвэл өсөн нэмэгдэх зардлуудыг багтаасан.

Групп ба Банк хийх төлбөр, хүлээн авах мөнгөний талаар хийсэн өөрийн ойролцоолсон тооцоололдоо өөрчлөлт оруулбал санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өр төлбөрийн бүртгэлийн дүнг залруулна. Залруулсан бүртгэлийн дүнг анхны үр ашигт хүүний түвшин дээр үндэслэн тооцоолох ба бүртгэлийн дүнгийн зөрүүг “Бусад үйл ажиллагааны орлого” гэж бүртгэнэ. Гэхдээ ирээдүйд хүлээн авах мөнгөний хэмжээ өссөний улмаас Банк ирээдүйд хүлээн авах мөнгөний ойролцоолсон дүнг дараагийн тайлант хугацаанд өсгөсөн бол уг өсөлтийн нөлөөг ойролцоолсон тооцоололд өөрчлөлт оруулсан өдрөөс эхлэн “Үр ашигт хүүний түвшинд хийсэн залруулга” гэж хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн эсвэл төсөөтэй бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн бүртгэлийн дүнг үнэ цэнийн бууралтын алдагдлын улмаас бууруулсан бол үнэ цэнийн бууралтыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахдаа хэрэглэсэн хүүний түвшинг ашиглан хүүний орлогыг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрнө

(ii) Хураамж ба шимтгэлийн орлого

Банк нь өөрийн харилцагч нарт үзүүлдэг төрөл бүрийн үйлчилгээнээс хураамж, шимтгэлийн орлого олдог. Хураамжийн орлогыг дараах хоёр бүлэгт хувааж болно. Үүнд:

Тодорхой хугацааны туршид үзүүлж байгаа үйлчилгээнүүдээс олсон хураамжийн орлого

Тодорхой хугацааны туршид үйлчилгээг үзүүлж олох орлогыг тэр хугацааны туршид нь аккрузалдэнэ. Эдгээр хураамжинд шимтгэлийн орлого, хөрөнгийн удирдлага, хамгаалалтын болон бусад удирдлага, зөвлөгөөний хураамжууд орно.

Татан авах нь тодорхой зээлүүд дээр “Зээлийн үйлчилгээний шимтгэл”-ийг хойшлуулах (өсөн нэмэгдэх аливаа зардлын хамт) ба зээлийн үр ашигт хүүний залруулга гэж хүлээн зөвшөөрнө. Татан авахгүй нь бараг тодорхой болсон зээлүүдийн “Зээлийн үйлчилгээний шимтгэл”-ийг үүрэг хүлээсэн хугацааны туршид шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрнө.

Гүйлгээний үйлчилгээний хураамжийн орлого

Гуравдагч талтай гүйлгээний талаар хэлэлцээр хийх эсвэл гүйлгээнд оролцохтой холбоотойгоор үүссэн хураамжууд (хувьцаа эсвэл бусад үнэт цаасыг худалдан авах, бизнес худалдан авах, худалдах зохицуулалт гэх мэт)-ыг холбогдох гүйлгээ дууссан үед хүлээн зөвшөөрнө. Тодорхой нэг гүйцэтгэлтэй холбоотой хураамж эсвэл хураамжийн бүрэлдэхүүн хэсгийг холбогдох шалгуурууд хангагдсны дараа хүлээн зөвшөөрнө.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

(10) Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх (үргэлжлэл)

(iii) Ногдол ашгийн орлого (үргэлжлэл)

Групп ба Банк нь ногдол ашгийн орлогын төлбөрийг хүлээн авах эрх үүсэх үед хүлээн зөвшөөрнө.

(iv) Арилжааны цэвэр орлого

Арилжааны үйл ажиллагааны үр дүнд бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн бүх олз, гарз ба холбогдох хүүний орлого, зардал, "Арилжаалах зорилгоор эзэмшиж буй" санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийн ногдол ашиг орно.

(11) Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайланд зааснаар бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд касс дахь мөнгө, төв банкин дахь хязгаарлалтгүй харилцах данс, бусад банкуудад байршуулсан харилцах ба 3 түүнээс бага хугацаатай хадгаламжууд орно.

(12) Үндсэн хөрөнгө

Бүх үндсэн хөрөнгийг анхлан өртгөөр нь бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаанд гарсан зардлыг тухайн зардалтай холбогдсон ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг Банк хүртэх магадлалтай ба өртгийг нь найдвартайгаар хэмжих боломжтой тохиолдолд л хөрөнгийн бүртгэлийн дүн дээр нэмж эсвэл зохистой бол тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөг. Аливаа сольсон хэсгийн бүртгэлийн дүнг үл хүлээн зөвшөөрнө. Бүх урсгал засварыг тэдгээрийн гарсан тайлангийн хугацааны дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр илэрхийлдэг.

Дуусаагүй барилгыг элэгдүүлэхгүй. Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь ойролцоолон тооцоолсон дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргаар элэгдүүлнэ:

Барилга	10 - 40 жил
Түрээсийн хөрөнгийн сайжруулалт	10 жил
Тавилга, тоног төхөөрөмж	10 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютер	3 жил

Үндсэн хөрөнгийн дүн, элэгдүүлэх хугацаа, арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн өгөөжийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа гэдгийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үздэг.

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр үнэ хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

(13) Биет бус хөрөнгө

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

Зөвхөн биет бус хөрөнгийн өртгийг зохистойгоор хэмжиж болох ба хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн өгөөж нь Банкинд орж ирэх нь магадлалтай болсон үед л биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулна. Ашиглалтай тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ. Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийн өртгийг дараах ойролцоогоор тооцоолсон ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан, үлдэх өртөг хүртэл нь хорогдуулна. Үүнд:

Компьютерийн программ хангамж, лиценз	3 жил
ВЭБ домэйн	3 - 5 жил

(14) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад орсон байж болох шинж тэмдэг байгаа эсэхийг Групп ба Банк тайлант хугацаа тутамд шалгаж үздэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрсэн эсвэл жилд нэг удаа хийдэг хөрөнгийн үнэ цэнийн бууралтын тестийг хийж гүйцэтгэх үед Групп ба Банк нь хөрөнгөөс цуглуулан авах боломжтой дүнг тооцож үздэг. Цуглуулан авах дүн нь хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн бодит үнэ цэнэ (борлуулалтын зардлыг хасаж тооцсон) ба ашиглалтын өртөг хоёрын аль өндөр нь байна. Хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүн хүртэл нь бууруулж бүртгэнэ.

Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг олно. Борлуулалтын зардлыг хассаны дараахь бодит үнэ цэнийг тодорхойлоходоо тохиромжтой үнэлгээний загварыг ашиглан тооцоолно. Үнэлгээний үржүүлэгч, нийтэд хувьцаагаа зардаг охин компанийн хөрөнгийн бирж дээрх хувьцааны үнэ эсвэл бодит үнэ цэнийн бусад индикаторуудаар эдгээр тооцооллыг дэмжиж болно

Гүүдвиллээс бусад хөрөнгүүд дээр, тайлагналын өдөр бүр өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал арилсан эсвэл буурсан эсэх талаар ямар нэгэн шинж тэмдэг байгаа эсэх талаар үнэлгээг хийдэг. Хэрэв тийм шинж тэмдэг илэрвэл Банк нь тухайн хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн нөхөн төлөгдөх дүнг ойролцоогоор тооцож үзнэ. Хамгийн сүүлд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн цуглуулан авах дүнг тодорхойлоход ашигласан тооцооллуудад өөрчлөлт гарсан тохиолдолд л өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг буцаана. Буцаалт нь хязгаартай байх ба ингэснээр хөрөнгийн бүртгэлийн дүн нь цуглуулан авах дүн ба өмнөх жилүүдэд хөрөнгөнд үнэ цэнийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан бол байх ёстой байсан бүртгэлийн цэвэр дүнгээс (элэгдлийг хассан цэвэр дүнгээс) хэтрэхгүй байна. Ийм буцаалтуудыг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

(15) Санхүүгийн баталгаа

Бизнесийн хэвийн нөхцөлд Банк аккредитив, баталгаа, хүлээн зөвшөөрөлт гэх мэт санхүүгийн баталгааг гаргадаг. Санхүүгийн баталгааг санхүүгийн тайлангуудад анхлан бүртгэхдээ бодит үнээр нь буюу хүлээн авсан урамшууллын дүнгээр "Бусад өр төлбөр"-т хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү анхлан хүлээн зөвшөөрсний дараа, баталгаа бүрт Банкны хүлээх хариуцлагыг хорогдуулсан урамшуулал ба уг баталгааны улмаас үүсэх аливаа нэг санхүүгийн үүргийг биелүүлэхэд шаардлагатай зардлын хамгийн сайн тооцоолсон дүн хоёрын аль ихээр нь хэмжинэ.

Санхүүгийн баталгааны холбогдох өр төлбөрийн аливаа өсөлтийг дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Үнэ цэнийн бууралтын алдагдал" дансанд бүртгэнэ. Хүлээн авсан урамшууллыг санхүүгийн баталгааны хүчинтэй байх хугацааны туршид нь шулуун шугамын аргаар тооцож дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Хураамж, шимтгэлийн цэвэр орлого" дансанд хүлээн зөвшөөрнө.

(16) Ажиллагсдын тэтгэмж

(i) Богино хугацаат тэтгэмж

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

(16) Ажиллагсдын тэтгэмж (үргэлжлэл)

(ii) Заавал төлөх даатгалын шимтгэлүүд

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол Улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь орлого, үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө. Групп ба Банк мөн өөрсдийн байгуулсан тэтгэврийн санд шимтгэл төлдөг. Төлсөн шимтгэлийг ажилтны банкинд ажилласан хугацаанд нь хувь тэнцүүлэн "Тэтгэврийн сангийн зардал" дансанд бүртгэнэ.

(17) Сангууд

Компанид (а) өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа (б) энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед санг хүлээн зөвшөөрнө. Аливаа нэг сантай холбоотой зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.

(18) Хувьцаанд суурилсан төлбөрийн гүйлгээнүүд

Групп ба Банкны ажиллагсад (ахлах гүйцэтгэх ажилтнууд орно) хувьцаанд суурилсан төлбөрийн гүйлгээний хэлбэрээр урамшуулал авдаг. Ажиллагсдын үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг өөрийн хөрөнгийн хэрэглүүрээр ("Өөрийн хөрөнгөөр барагдуулах гүйлгээнүүд") барагдуулна.

Өөрийн хөрөнгөөр барагдуулах ажил гүйлгээ

Өөрийн хөрөнгөөр барагдуулах гүйлгээг өөрийн хөрөнгийн харгалзах өсөлтийнх хамт, гүйцэтгэл ба/эсвэл үйлчилгээний нөхцөл бүрэн биелэгдэх хугацааны (энэ хугацаа нь холбогдох ажилтан уг шагналын авах бүрэн эрхтэй болсон өдөр буюу "Эрх хэрэгжих өдөр" дуусгавар болно) туршид хүлээн зөвшөөрнө. Эрх хэрэгжих өдөр хүртэл тайлант өдөр бүр өөрийн хөрөнгөөр барагдуулах гүйлгээний хуримтлагдсан зардлыг хүлээн зөвшөөрдөг ба энэ нь эрх хэрэгжих нийт хугацааны хичнээн нь өнгөрсөн ба хичнээн тооны өөрийн хөрөнгийн хэрэглүүрийн хугацаа дуусаагүй байгаа талаарх Групп ба Банкны хамгийн сайн ойролцоолсон тооцооллыг илэрхийлнэ.

Эрх хэрэгжих хугацааны туршид зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд "Боловсон хүчний зардал"-аар бүртгэх ба хугацааны эхэнд болон эцэст хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан зардлын хооронд зөрүүг илэрхийлнэ.

Өөрийн хөрөнгөөр барагдуулах шагналын нөхцлүүдийг өөрчилсөн тохиолдолд, "Боловсон хүчний зардал"-д хүлээн зөвшөөрсөн хамгийн бага зардлыг өөрчлөлт хийгдээгүй байсан бол гарах байсан зардал гэж үзнэ. Хувьцаанд суурилсан төлбөрийн гэрээний нийт бодит үнэ цэнийг өсгөсөн эсвэл өөрчлөлт хийгдсэн өдрийн байдлаар ажилтанд ашигтай аливаа өөрчлөлтөд нэмэлт зардлыг хүлээн зөвшөөрнө.

Өөрийн хөрөнгөөр төлөх шагналыг цуцлах үед, цуцлалт хийгдсэн өдөр дуусгавар болсон мэтээр авч үзэх ба хүлээн зөвшөөрч амжаагүй зардлыг тэр даруй хүлээн зөвшөөрнө. Эрх хэрэгжихгүй байх нөхцлүүд нь байгууллагын эсвэл харилцагч талын хяналтанд байдаг аливаа шагналууд үүнд багтана. Гэхдээ цуцалсан шагналыг шинэ шагналаар орлуулсан бол өмнө тодорхойлж байсны адил шинэ шагналыг анхны шагналын өөрчилсөн хувилбар гэж авч үзнэ.

Үлдэгдэл опционы шингэрүүлэх нөлөөг нэгж хувьцааны шингэрүүлсэн ашгийн тооцоололд нэмэлт хувьцааны шингэрүүлэлт гэж тусгасан (Тодруулга 13).

(19) Татвар

(i) Тайлант хугацааны орлогын албан татвар

Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

(ii) Хойшлуулсан орлогын албан татвар

Хойшлуулсан орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын хооронд түр зөрүүний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог. Дараахаас бусад бүх түр зөрүүнүүд дээр хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөр нь гүүдвиллээс эсвэл бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол.
- Охин компанид оруулсан хөрөнгө оруулалттай холбоотой татварын түр зөрүүг арилгах хугацааг хянах боломжтой ба ойрын хугацаанд тус түр зөрүү нь арилахгүй байх магадлалтай бол.

Дараахаас бусад бүх хасагдах түр зөрүүнүүд, ашиглаагүй татварын хөнгөлөлт, ашиглаагүй татварын алдагдлууд дээр, эдгээрийг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлал байгаа үед хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийгдэх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрүүдийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол.
- Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт, хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотой татвар ногдох түр зөрүүнүүдийн хувьд, үүссэн түр зөрүү нь ойрын ирээдүйд арилах ба түр зөрүүг ашиглаж болох татвар ногдох ашиг олох магадлал байгаа бол.

Хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчилэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна.

Үл хүлээн зөвшөөрсөн хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийг олж авах эсвэл өр төлбөрийг барагдуулах тэр тайлант хугацаанд хэрэглэгдэнэ гэж хүлээж байгаа (тайлант жилийн эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан татварын хувь хэмжээ, татварын хуулиуд дээр үндэслэн) татварын хувь хэмжээгээр хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжинэ.

Өөрийн хөрөнгөнд шууд хүлээн зөвшөөрсөн зүйлүүдтэй холбоотой тайлант жилийн болон хойшлуулсан татваруудыг мөн өөрийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрөх ба дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрөхгүй.

Нэг татвар төлөгч, нэг татварын байгууллагад хамаарах хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй бол хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнаж болно

(20) Энгийн хувьцааны ногдол ашиг

Энгийн хувьцааны ногдол ашгийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх ба Банкны хувьцаа эзэмшигчид баталсан үед өөрийн хөрөнгөөс хасна. Хугацааны дундуурх ногдол ашгийг зарласан, Банк буцаах аргагүй болсон үед өөрийн хөрөнгөөс хасна.

Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараа батлагдсан тайлант жилийн ногдол ашгийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах үйл явдал гэж толилуулна.

(21) Өөрийн хөрөнгийн нөөц

Групп ба Банкны санхүүгийн байдлын тайлан дээрх өөрийн хөрөнгө (бусад дэлгэрэнгүй орлого)-нд бүртгэгдсэн нөөцөд “Борлуулахад бэлэн” хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бүртгэдэг “Борлуулахад бэлэн нөөц”, “Хувьцаанд суурилсан төлбөрийн нөөц” ба “Зайлшгүй байлгах нөөц” орно.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

(22) Засгийн газрын нөхцөлт хандив

Засгийн газрын нөхцөлт хандивыг хүлээн авах нь тодорхой болсон ба дагалдах бүх нөхцлүүдэд нийцнэ гэж үзэж байгаа үед хүлээн зөвшөөрнө. Нөхцөлт хандив нь зардлын зүйлтэй холбогдож байгаа үед нөхцөлт хандивыг нөхөн олгох хандлагатай зардлуудтай тааруулахад шаардагдах хугацааны туршид орлогоор хүлээн зөвшөөрнө. Нөхцөлт хандив нь хөрөнгөтэй холбогдож байгаа үед үүнийг хойшуулсан орлогоор хүлээн зөвшөөрөх ба холбогдох хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид тэнцүү хэмжээгээр орлогод хүлээн зөвшөөрнө.

Банк мөнгөн бус нөхцөл хандивыг хүлээн авч байгаа үед хөрөнгө ба нөхцөлт хандивыг нийт нэрлэсэн дүнгээр нь бүртгэх ба хүлээгдэж буй ашиглалтын хугацаа туршид ба холбогдох хөрөнгийн өгөөжийг хэрэглэх хэлбэрээс хамааран жил бүр адил хэмжээтэйгээр орлогын тайланруу бичнэ.

Засгийн газар эсвэл холбогдох байгууллагаас зээл эсвэл төсөөтэй тусламжийг өнөөгийн хэрэгжиж буй зах зээлийн хүүгээс бага хүүтэйгээр олгож эсвэл үзүүлж байгаа үед энэхүү тааламжтай хүүний нөлөөллийг засгийн газраас олгож буй нэмэлт нөхцөлт хандив гэж үзнэ

(23) Сегментийн тайлагнал

Групп ба Банкны сегментийн тайлагнал нь үйл ажиллагааны дараах сегментүүдэд суурилдаг. Үүнд: Иргэдийн банк, Байгууллагын банк, Хөрөнгө оруулалтын банк болон Хөрөнгө зохицуулалт.

(24) Хураан авсан хөрөнгүүд

Хураан авсан хөрөнгүүдийг анхлан тэдгээрийн бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн ба холбогдох зээлийн буцаан авалт хийгдсэн өдрийн байдлаарх үлдэгдэл дүнгийн аль багаар нь хүлээн зөвшөөрөх ба холбогдох зээл, урьдчилгааг үнэ цэнийн бууралтын сангийнх нь хамт тайлан тэнцэлд үл хүлээн зөвшөөрнө. Дараагийн тайлант хугацаанд хураан авсан хөрөнгийг өртөг ба бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн хоёрын аль багаар нь хэмжиж, "Бусад хөрөнгө"-нд бүртгэнэ.

2.5. Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд

Банкны санхүүгийн тайлангуудыг гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан боловч хэрэгжиж эхлээгүй байсан стандартуудын жагсаалтыг дор үзүүлэв. Энэ жагсаалтанд Банк ирээдүйд хэрэглэхэд тодруулга, санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд нөлөө үзүүлнэ гэж зохистойгоор хүлээж буй стандартуудыг оруулсан болно. Эдгээр стандартуудыг Банк авч хэрэгжүүлнэ гэсэн хандлагатай байна.

НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга – Бусад дэлгэрэнгүй орлогын зүйлсийн толилуулга

НББОУС 1-д орсон нэмэлт өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод толилуулах зүйлсийн ангилалыг өөрчилсөн. Ирээдүйд орлогын тайланруу дахин ангилагдаж болох (жишээ нь: үл хүлээн зөвшөөрөх эсвэл төлбөр хийгдэх үед) зүйлсийг хэзээ ч дахин ангилагдахгүй зүйлсээс салгаж тусад нь толилуулна. Энэ нэмэлт өөрчлөлт нь зөвхөн толилуулгад нөлөө үзүүлэх бөгөөд Банкны санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй. Энэ нэмэлт өөрчлөлт нь 2012.07.01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

НББОУС 12 Орлогын тайлан – Холбогдох хөрөнгийг эргүүлэн олж авах

Энэ нэмэлт өөрчлөлт нь бодит үнэ цэнээр нь хэмжих хөрөнгө оруулалтын хөрөнгө дээр хойшлогдсон татварыг хэрхэн тодорхойлохыг илүү нарийн тодорхой болгож өгсөн. Энэ нэмэлт өөрчлөлт нь НББОУС 40-д заасан бодит үнэ цэнийн загварыг ашиглан үнэ цэнийг нь хэмждэг хөрөнгө оруулалтын хөрөнгө дээр хойшлогдсон татварыг түүний бүртгэлийн дүнг хөрөнгийг борлуулах замаар нөхөн олж авна гэсэн үндэслэлээр тодорхойлох ёстой гэсэн "Няцаагдаж болох төсөөлөл"-ийг танилцуулсан. Үүнээс гадна энэ нэмэлт өөрчлөлт нь НББОУС 16-д заасан дахин үнэлгээний загварыг ашиглан үнэ цэнийг нь хэмждэг элэгддэггүй хөрөнгө дээр хойшлогдсон татварыг хөрөнгийг борлуулна гэсэн үндэслэлээр үргэлж хэмжиж байх ёстой гэсэн шаардлагыг танилцуулсан. Энэ нэмэлт өөрчлөлт нь 2012.01.01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

НББОУС 19 Ажилчдын тэтгэмж (Нэмэлт өөрчлөлт)

НББОУС-ын хороо НББОУС 19-д олон тооны нэмэлт өөрчлөлтийг хийсэн. “Хонгилын механизм” ба “Төлөвлөгөөний хөрөнгөөс хүлээгдэж буй өгөөжийн талаарх ойлголт”-ыг авч хаях гэх мэт суурь өөрчлөлтүүдээс авхуулаад энгийн тодруулга хийх, найруулга сайжруулах гэх мэт энгийн өөрчлөлтүүд энд багтаж байгаа. Банк одоогоор энэхүү нэмэлт өөрчлөлтийн нийт нөлөөллийг үнэлж байна. Энэ нэмэлт өөрчлөлт нь 2013.01.01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

НББОУС 27 Салангид санхүүгийн тайлангууд (2011 онд шинэчлэн найруулсан)

Шинээр гарсан СТОУС 10 ба 12-ын улмаас НББОУС 27-д үлдсэн зүйл нь охин, хамгийн хяналттай, хараат компаниудын салангид санхүүгийн тайлангийн бүртгэлээр хязгаарлагдаж байна. Банк нь салангид санхүүгийн тайлангуудыг толилуулдаггүй. Энэ нэмэлт өөрчлөлт нь 2013.01.01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

НББОУС 28 Хараат болон хамтарсан компаниудад оруулсан хөрөнгө оруулалт (2011 онд шинэчлэн найруулсан)

Шинээр гарсан СТОУС 11 ба 12-ын улмаас НББОУС 28-ын нэрийг “Хараат болон хамтарсан компаниуд дахь хөрөнгө оруулалт” гэж өөрчилсөн ба хараат компаниудаас гадна хамтарсан компаниудад оруулсан хөрөнгө оруулалтыг өөрийн хөрөнгийн аргаар хэрхэн хэмжихийг тодорхойлсон. Энэ нэмэлт өөрчлөлт нь 01.01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга – Үл хүлээн зөвшөөрөлтийн тодруулгын нэмэлт шаардлагууд

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланг хэрэглэгчдэд үл хүлээн зөвшөөрөөгүй байгаа хөрөнгөтэй Банк ямар холбоотой болон холбогдох өр төлбөр нь юу болох талаар илүү ойлголтыг өгч чадах нэмэлт тодруулгыг шилжүүлчихсэн гэхдээ хараахан үл хүлээн зөвшөөрөөгүй байгаа санхүүгийн хөрөнгүүд дээр хийхийг шаардсан. Үүнээс гадна энэ нэмэлт өөрчлөлт нь Банк үл хүлээн зөвшөөрсөн хөрөнгүүдтэй харилцаа холбоотой байсаар байгаа бол тэдгээрийн шинж чанар, холбогдох эрсдэлийг үнэлэх боломжийг хэрэглэгчдэд олгосон нэмэлт тодруулгыг хийхийг шаардсан. Энэ нэмэлт өөрчлөлт нь 2011.07.01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Энэ нэмэлт өөрчлөлт нь зөвхөн толилуулгад нөлөө үзүүлэх бөгөөд Банкны санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.

СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүрүүд: Ангилал ба хэмжилт

НББОУС 39-ийг өөрчлөх НББОУС-ийн хорооны ажлын нэгдүгээр үе шатыг СТОУС 9 илэрхийлж байгаа ба энэ стандартыг НББОУС 39-д тодорхойлсон санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн ангилах, хэмжихэд хэрэглэнэ. Энэ стандарт нь 2013.01.01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Дараагийн үе шатуудад НББОУС-ийн хороо хэджийн нягтлан бодох бүртгэл ба санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын талаар танилцуулах болно. Энэ төслийг 2011 эцэс эсвэл 2012 оны эхний хагас гэхэд дуусгах төлөвлөгөөтэй байна. СТОУС 9-ийн эхний үе шатыг авч хэрэгжүүлэх нь Банкны санхүүгийн хөрөнгийн ангилал, хэмжилтэнд нөлөө үзүүлнэ гэхдээ санхүүгийн өр төлбөрийн ангилал, хэмжилтэнд нөлөө үзүүлэхгүй. Банк илүү дэлгэрэнгүй танилцуулга хийх үүднээс бусад үе шатуудтай холбоотой нөлөөллийг тэдгээрийг батлагдан гарсан үед тооцож үзнэ.

СТОУС 10 Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд

НББОУС 27 “Нэгтгэсэн болон салангид санхүүгийн тайлангууд”-ын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нягтлан бодох бүртгэлийг танилцуулсан хэсгийг СТОУС 10-аар сольсон. Энэ стандарт нь Стандартын тайлбарын хороо (“СТХ”) 12 “Нэгтгэл-Тусгай зориулалттай байгууллага”-т заасан асуудлуудыг мөн өөртөө багтаасан. СТОУС 10 тусгай зориулалттай байгууллага болон бусад бүх байгууллагуудад хэрэглэгдэх хяналтын нэг загварыг бий болгосон. НББОУС 27-д байсан шаардлагуудтай харьцуулбал СТОУС 10-т танилцуулсан өөрчлөлтүүд нь хяналтанд байдаг компаниуд нь толгой компанийн тайланд нэгтгэгдэх шаардлагатай эсэхийг тодорхойлоход удирдлагаас томоохон хэмжээний үнэлэмж хийхийг шаардана. Энэ стандарт нь 2013.01.01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

СТОУС 11 Хамтын зохицуулалт

НББОУС 31 “Хамтарсан компани дахь ашиг сонирхол” ба СТХ 13 “Хамтын хяналттай байгууллагууд-Хамтрагчдын мөнгөн бус хувь оролцоо”-г СТОУС 11-ээр сольсон.

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

2.5. Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд (үргэлжлэл)

СТОУС 11 нь хамтын хяналттай байгууллагуудыг хувь тэнцүүлэн нэгтгэж болох хувилбарыг алга болгосон. Үүний оронд хамтарсан компанийн тодорхойлолтод нийцэж байгаа хамтын хяналттай байгууллагуудыг өөрийн хөрөнгийн аргыг хэрэглэн бүртгэнэ. Энэ шинэ стандартыг хэрэглэх нь Банкны санхүүгийн байдалд нөлөө үзүүлэхгүй. Учир нь Банкинд хамтарсан компанид оруулсан хөрөнгө байхгүй. Энэ стандарт нь 2013.01.01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

СТОУС 12 Бусад байгууллагууд дахь ашиг сонирхолын тодруулга

НББОУС 27-д байсан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудтай холбоотой бүх тодруулгууд, НББОУС 31 ба 28-д байсан бүх тодруулгууд СТОУС 12-т орсон болно. Эдгээр тодруулгууд нь байгууллагын охин, хамтын зохицуулалттай, хараат, тусгай зориулалттай байгууллагууд дахь ашиг сонирхолтой холбоотой тодруулгууд юм. Мөн олон тооны тодруулгуудыг шинээр хийх шаардлагатай болсон. Энэ стандарт нь 2013.01.01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

СТОУС 13 Бодит үнэ цэнийн хэмжилт

СТОУС 13 нь бодит үнэ цэнийн бүх төрлийн хэмжилтүүдийн талаар СТОУС-ын хүрээнд зааварчилгаа өгөх нэгдсэн нэг эх үүсвэрийг бий болгосон. Байгууллага бодит үнэ цэнийг ашиглах шаардлагатай үед үүнийг СТОУС 13 өөрчлөхгүй харин бодит үнэ цэнийг ашиглахыг шаардсан эсвэл зөвшөөрсөн үед СТОУС-ын хүрээнд бодит үнэ цэнийг хэрхэн хэмжих талаар зааварчилгаа өгнө. Банк одоогоор энэхүү стандартын санхүүгийн байдал эсвэл гүйцэтгэлд үзүүлэх нөлөөллийг үнэлж байна. Энэ стандарт нь 2013.01.01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

3. СЕГМЕНТИЙН МЭДЭЭЛЭЛ

Удирдлагын зорилгоор Групп ба Банк нь бүтээгдэхүүн, үйлчилгээ дээрээ суурилан үйл ажиллагааны дараах дөрвөн сегментэд хуваагддаг. Үүнд:

Иргэдийн банк	- Харилцагчдын харилцах, хадгаламжийн данс, хэрэглээний зээл, кредит карт болон шилжүүлгийн гүйлгээ.
Байгууллагын банк	- Байгууллага болон аж ахуй нэгж харилцагчдад үзүүлдэг харилцах, хадгаламжийн данс, зээл болон зээлийн хэрэгслүүд.
Хөрөнгө оруулалтын банк	- Байгууллагын санхүү болон худалдан авалт, бизнесийн нэгдэл, тусгай санхүүгийн зөвөлгөө, арилжаа зэргийг оролцуусан хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээ.
Хөрөнгө зохицуулалтын хэлтэс	- Хөрөнгө зохицуулалт, санхүүжилт болон бусад төвийн үйл ажиллагаа.

Банкны удирдлага нь нөөцийн хуваарилалт, гүйцэтгэлийн үнэлгээний талаар шийдвэр гаргахдаа хэрэглэх зорилгор өөрийн бизнесийн үйл ажиллагааны үр дүнг тусад нь хянаж байдаг. Сегментийн гүйцэтгэлийг үйл ажиллагааны ашиг, алдагдал (зарим тохиолдолд санхүүгийн тайлангууд дээрх үйл ажиллагааны ашиг алдагдлаас өөрөөр хэмждэг) дээр нь үндэслэн үнэлдэг. Орлогын албан татварыг компанийн түвшинд удирддаг ба сегментүүдэд хуваарилдаггүй.

Удирдлага нь гүйцэтгэлийн хэмжүүр нь нийт орлого, зардал биш цэвэр хүүний орлого байдаг учраас хүүний орлогыг цэвэр дүнгээр нь тайлагнадаг.

Үйл ажиллагааны сегментүүдийн хооронд шилжих үнэ нь гуравдагч талтай хийж байгаа гүйлгээний нэг адил зарчмаар хийгддэг.

2011 ба 2010 онд нэг хөндлөнгийн харилцагч эсвэл талтай хийсэн гүйлгээний орлого нь Групп ба Банкны нийт орлогын 10%-иас илүү гараагүй.

Дараах хүснэгтэнд банкны үйл ажиллагааны сегментүүдийн орлого, ашиг ба зарим нэг хөрөнгө, өр төлбөрүүдийн мэдээллүүдийг үзүүлсэн болно.

Групп	Иргэдийн банк 2011 мян. төг	Байгууллагын банк 2011 мян. төг	Хөрөнгө оруулалтын банк 2011 мян. төг	Хөрөнгийн удирдлагын хэлтэс 2011 мян. төг	Хувиарлаг-даагүй 2011 мян. төг	Нийт 2011 мян. төг
Орлого						
Гуравдагч тал	2,336,502	37,670,888	243,253	42,362,623	-	82,613,266
Сегмент хоорондын	37,666,562	(9,961,029)	-	(27,705,533)	-	-
Нийт үйл ажиллагааны орлого	40,003,064	27,709,859	243,253	14,657,090	-	82,613,266
Зээлийн үнэ цэнэ бууралтын алдагдал	(4,304,781)	(4,376,339)				(8,681,120)
Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ бууралтын алдагдал	-	-	-	(1,450,000)	-	(1,450,000)
Цэвэр үйл ажиллагааны орлого	35,698,283	23,333,520	243,253	13,207,090	-	72,482,146
Үр дүнгүүд						
Хүү түүнтэй адилтгах орлого	62,318,009	62,587,877	235,161	40,024,082	-	165,165,129
Хүү түүнтэй адилтгах зардал	(43,445,609)	(39,353,724)	(46,744)	(33,392,043)	-	(116,238,120)
Цэвэр хүүгийн орлого	18,872,400	23,234,153	188,417	6,632,039	-	48,927,009
Хураамж, шимтгэлийн орлого	9,419,887	4,453,470	56,277	4,283,570	-	18,213,204
Хураамж, шимтгэлийн зарлага	(852,884)	(3,064)	(1,439)	(2,903,267)	-	(3,760,654)
Цэвэр хураамж, шимтгэлийн орлого	8,567,003	4,450,406	54,838	1,380,303	-	14,452,550
Цэвэр арилжааны орлого	-	-	-	(1,296,376)	-	(1,296,376)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(2,010,130)	(296,758)	(1,822)	(138,878)	(201,653)	(2,649,241)
Биет бус хөрөнгийн хорогдуулга	(238,296)	(112,001)	(86)	(74,182)	(150,492)	(575,057)
Сегментийн ашиг (алдагдал)	14,127,780	16,375,599	33,235	9,751,768	(352,145)	39,936,237
Орлогын албан татварын зардал	-	-	-	-	(9,691,528)	(9,691,528)
Тухайн жилийн ашиг						30,244,709
Хөрөнгө						
Капитал зардал						
Үндсэн хөрөнгө	3,323,314	9,402	5,848	5,978	1,623,565	4,968,107
Бусад биет бус хөрөнгө	-	-	-	-	115,854	115,854
Нийт хөрөнгө	600,648,456	732,433,866	491,893	765,962,644	31,427,379	2,130,964,238
Нийт өр төлбөр	509,226,622	757,607,321	497,236	718,201,335	5,217,024	1,990,749,538

3. СЕГМЕНТИЙН МЭДЭЭЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараах хүснэгтэнд банкны үйл ажиллагааны сегментүүдийн орлого, ашиг ба зарим нэг хөрөнгө, өр төлбөрүүдийн мэдээллүүдийг үзүүлсэн болно.

Банк	Иргэдийн банк 2011 мян. төг	Байгуулла- гын банк 2011 мян. төг	Хөрөнгө оруулалтын банк 2011 мян. төг	Хөрөнгийн удирдлагын хэлтэс 2011 мян. төг	Хувиарлаг- даагүй 2011 мян. төг	Нийт 2011 мян. төг
Орлого						
Гуравдагч тал	2,336,502	37,670,888	241,668	42,362,623	-	82,611,681
Сегмент хоорондын	37,666,562	(9,961,029)	-	(27,705,533)	-	-
Нийт үйл ажиллагааны орлого	40,003,064	27,709,859	241,668	14,657,090		82,611,681
Зээлийн үнэ цэнэ бууралтын алдагдал	(4,304,781)	(4,376,339)	-	-	-	(8,681,120)
Санхүүгийн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ бууралтын алдагдал	-	-	-	(1,450,000)	-	(1,450,000)
Цэвэр үйл ажиллагааны орлого	35,698,283	23,333,520	241,668	13,207,090	-	72,480,561
Үр дүнгүүд						
Хүү түүнтэй адилтгах орлого	62,318,009	62,587,877	235,161	40,024,082	-	165,165,129
Хүү түүнтэй адилтгах зардал	(43,445,609)	(39,353,724)	(48,329)	(33,392,043)	-	(116,239,705)
Цэвэр хүүгийн орлого	18,872,400	23,234,153	186,832	6,632,039	-	48,925,424
Хураамж, шимтгэлийн орлого	9,419,887	4,453,470	56,277	4,283,570	-	18,213,204
Хураамж, шимтгэлийн зарлага	(852,884)	(3,064)	(1,439)	(2,903,267)	-	(3,760,654)
Цэвэр хураамж, шимтгэлийн орлого	8,567,003	4,450,406	54,838	1,380,303		14,452,550
Цэвэр арилжааны орлого	-	-	-	(1,296,376)	-	(1,296,376)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(2,010,130)	(296,758)	(1,822)	(138,878)	(201,653)	(2,649,241)
Биет бус хөрөнгийн хорогдуулга	(238,296)	(112,001)	(86)	(74,182)	(150,385)	(574,950)
Сегментийн ашиг (алдагдал)	14,127,780	16,375,599	32,318	9,751,768	(352,038)	39,935,427
Орлогын албан татварын зардал	-	-	-	-	(9,691,370)	(9,691,370)
Тухайн жилийн ашиг						30,244,057
Хөрөнгө						
Капитал зардал						
Үндсэн хөрөнгө	3,323,314	9,402	5,848	5,978	1,623,565	4,968,107
Бусад биет бус хөрөнгө	-	-	-	-	113,446	113,446
Нийт хөрөнгө	600,648,456	732,433,866	491,893	766,065,709	31,425,078	2,131,065,002
Нийт өр төлбөр	509,226,622	757,607,321	497,236	718,302,826	5,216,949	1,990,850,954

3. СЕГМЕНТИЙН МЭДЭЭЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дараах хүснэгтэнд банкны үйл ажиллагааны сегментүүдийн орлого, ашиг ба зарим нэг хөрөнгө, өр төлбөрүүдийн мэдээллүүдийг үзүүлсэн болно.

Банк	Иргэдийн банк 2010 мян. төг	Байгуулла- гын банк 2010 мян. төг	Хөрөнгө оруулалтын банк 2010 мян. төг	Хөрөнгийн удирдлагын хэлтэс 2010 мян. төг	Хувиарлаг- даагүй 2010 мян. төг	Нийт 2010 мян. төг
Орлого						
Гуравдагч тал	(3,524,293)	34,936,902	111,273	14,933,225	-	46,457,107
Сегмент хоорондын	28,749,720	(16,126,085)	-	(12,623,635)	-	-
Нийт үйл ажиллагааны орлого	25,225,427	18,810,817	111,273	2,309,590	-	46,457,107
Зээлийн үнэ цэнэ бууралтын алдагдал	(799,728)	1,794,015	-	(11,693)	-	982,594
Цэвэр үйл ажиллагааны орлого	24,425,699	20,604,832	111,273	2,297,897	-	47,439,701
Үр дүнгүүд						
Хүү түүнтэй адилтгах орлого	43,314,938	47,242,527	32,102	20,566,936	-	111,156,503
Хүү түүнтэй адилтгах зардал	(30,137,366)	(31,981,973)	-	(19,329,140)	-	(81,448,479)
Цэвэр хүүгийн орлого	13,177,572	15,260,554	32,102	1,237,796	-	29,708,024
Хураамж, шимтгэлийн орлого	6,473,640	3,547,695	79,823	2,554,290	-	12,655,448
Хураамж, шимтгэлийн зарлага	(595,972)	(7)	(652)	(2,146,199)	-	(2,742,830)
Цэвэр хураамж, шимтгэлийн орлого	5,877,668	3,547,688	79,171	408,091	-	9,912,618
Цэвэр арилжааны орлого	-	-	-	296,189	-	296,189
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(1,126,267)	(156,363)	(404)	(82,692)	(507,411)	(1,873,137)
Биет бус хөрөнгийн хорогдуулга	(340,012)	(244,985)	-	(127,937)	(263,688)	(976,622)
Сегментийн ашиг (алдагдал)	9,910,278	15,598,729	41,424	1,418,527	(771,099)	26,197,859
Орлогын албан татварын зардал	-	-	-	-	(6,145,111)	(6,145,111)
Тухайн жилийн ашиг						20,052,748
Хөрөнгө						
Капитал зардал						
Үндсэн хөрөнгө	8,104,814	18,960	15	3,336	12,950,368	21,077,493
Бусад биет бус хөрөнгө	-	-	-	-	686,155	686,155
	8,104,814	18,960	15	3,336	13,636,523	21,763,648
Нийт хөрөнгө	314,922,780	473,411,703	422,235	757,314,429	27,341,752	1,573,412,899
Нийт өр төлбөр						
Нийт өр төлбөр	322,675,018	448,402,165	380,811	716,780,416	1,376,936	1,489,615,346

3. СЕГМЕНТИЙН МЭДЭЭЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Нийт сегментийн татварын өмнөх ашгийг Банкны татварын өмнөх нийт ашигтай тулган дараах байдлаар үзүүлэв:

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Нийт сегментийн татварын өмнөх ашиг	40,288,382	40,287,465	26,968,958
Бусад үйл ажиллагааны зардал	(352,145)	(352,038)	(771,099)
Татварын өмнөх нийт ашиг	39,936,237	39,935,427	26,197,859

Сегментүүдийн тайлагнах нийт хөрөнгийг Банкны нийт хөрөнгөтэй тулган дараах байдлаар үзүүлэв:

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Нийт сегментийн хөрөнгө	2,099,536,859	2,099,639,924	1,546,071,147
Бэлэн мөнгө ба төв банк дахь харилцах	68,679	68,679	81,630
Санхүүгийн хөрөнгө оруулалт - борлуулахад бэлэн	312,922	312,922	312,922
Ажиллагсдын зээл	2,836,406	2,836,406	2,018,004
Үндсэн хөрөнгө	18,891,203	18,891,203	15,699,587
Биет бус хөрөнгө	645,661	643,360	1,104,864
Бусад хөрөнгүүд	7,923,322	7,923,322	8,124,745
Хойшлогдсон татварын хөрөнгө	749,186	749,186	-
Санхүүгийн байдлын тайланд тусгасан нийт хөрөнгө	2,130,964,238	2,131,065,002	1,573,412,899

Сегментүүдийн тайлагнах нийт өр төлбөрийг Банкны нийт өр төлбөртэй тулган дараах байдлаар үзүүлэв:

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Нийт сегментийн өр төлбөр	1,985,532,514	1,985,634,005	1,488,238,410
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	10,526	10,526	33,439
Харилцагчдын харилцах, хадгаламж	3,113,519	3,113,519	419,357
Санхүүгийн баталгаа	92,676	92,676	88,051
Бусад пассив	281,212	281,212	44,684
Хойшлогдсон татварын өглөг	380,420	380,420	-
Орлогын албан татварын өглөг	1,338,671	1,338,596	791,405
Санхүүгийн байдлын тайланд тусгасан нийт өр төлбөр	1,990,749,538	1,990,850,954	1,489,615,346

4. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Бэлэн мөнгө ба төв банк дахь харилцах	36,121,145	36,121,145	16,949,480
Бусад банк дахь харилцах, хадгаламж	2,887,166	2,887,166	3,458,002
Урвуу репо хэлцэл	130,006	130,006	32,102
Санхүүгийн хөрөнгө оруулалт — борлуулахад бэлэн	-	-	8,482
Санхүүгийн хөрөнгө оруулалт- дуусгавар хугацаа хүртэл эзэмших	2,749,353	2,749,353	2,591,819
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	123,277,459	123,277,459	88,116,618
	165,165,129	165,165,129	111,156,503

5. ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗАРДАЛ

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Харилцагчдын харилцах, хадгаламж	110,141,057	110,142,642	74,742,974
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах хадгаламж	1,940,483	1,940,483	1,255,566
Репо хэлцэл	236,721	236,721	265,853
Зээлээр авсан эх үүсвэр	1,654,263	1,654,263	3,760,212
Хоёрдогч өглөг	1,904,852	1,904,852	1,294,709
Бусад	360,744	360,744	129,165
	116,238,120	116,239,705	81,448,479

6. ШИМТГЭЛ ХУРААМЖИЙН ЦЭВЭР ОРЛОГО

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Шимтгэл хураамжийн орлого			
Дансны үйлчилгээний шимтгэл хураамж	3,052,926	3,052,926	2,586,205
Карттай холбоотой шимтгэл хураамж	4,869,878	4,869,878	2,943,140
Зээлтэй холбоотой шимтгэл хураамж	4,900,099	4,900,099	3,365,603
Гуйвуулгын ба бусад үйлчилгээний шимтгэл хураамж	5,390,301	5,390,301	3,760,500
	18,213,204	18,213,204	12,655,448
Шимтгэл хураамжийн зардал			
Банкаар үйлчлүүлсэний зардал	(1,509,723)	(1,509,723)	(1,158,763)
Гадаад валютын шимтгэл	(2,539)	(2,539)	(11,594)
Картын гүйлгээний зардал	(2,230,068)	(2,230,068)	(1,564,692)
Онлайн гүйлгээний зардал	(18,324)	(18,324)	(7,781)
	(3,760,654)	(3,760,654)	(2,742,830)
	14,452,550	14,452,550	9,912,618

7. АРИЛЖААНЫ ЦЭВЭР ОРЛОГО/ (ЗАРДАЛ)

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт (Тодруулга 28)	(1,063,189)	(1,063,189)	45,769
Өөрийн хөрөнгө	(253,065)	(253,065)	78,084
Үнэт металл	7,532	7,532	1,273
Гадаад валютын арилжаа	12,346	12,346	171,063
	(1,296,376)	(1,296,376)	296,189

“Өөрийн хөрөнгө”-ийн орлогод өөрийн хөрөнгийн үнэт цаасыг худалдан авах, худалдах арилжааны үр дүн болон тэдгээрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтүүд орно.

“Гадаад валют”-ын орлогод своп болон форвард хэлцлийн олз, гарз орно.

8. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Ногдол ашгийн орлого	4,901	4,901	-
Үндсэн хөрөнгө худалдан борлуулсны олз	14,889	14,889	7,861
Гадаад валютын ханшийн бодит олз	19,462,783	19,462,783	7,776,906
Гадаад валютын ханшийн бодит бус олз/(гарз)	930,690	930,690	(1,273,765)
Бусад	50,120	50,120	29,274
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эргэн төлөлт (Тодруулга 23)	66,700	66,700	-
	20,530,083	20,530,083	6,540,276

9. ЗЭЭЛИЙН ҮНЭ ЦЭНЭ БУУРАЛТЫН ЗАРДАЛ

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа			
Бизнесийн зээл	3,737,522	3,737,522	794,015
Бизнесийн жижиг зээл	5,061,463	5,061,463	(1,264,022)
Хэрэглээний зээл	51,971	51,971	(384,152)
Орон сууцны зээл	(230,488)	(230,488)	(130,143)
	8,620,468	8,620,468	(984,302)
Бусад авлага (Тодруулга 23)	60,652	60,652	1,708
	8,681,120	8,681,120	(982,594)

10. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТ

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт: Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй			
Энгийн хувьцаа	1,450,000	1,450,000	-

11. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	ГРУПП 2011 мян.төг	2011 мян.төг	БАНК 2010 мян.төг
Зар сурталчилгааны зардал	1,239,770	1,239,770	982,118
Биет бус хөрөнгийн хорогдуулга (Тодруулга 22)	575,057	574,950	976,622
Харилцаа холбооны зардал	664,343	664,343	568,789
Засал чимэглэл	979,129	979,129	645,203
Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 21)	2,649,241	2,649,241	1,873,137
Хандив	36,799	36,799	88,850
Зочин төлөөлөгчийн зардал	430,169	430,169	635,580
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал (Тодруулга 23)	1,219	1,219	666,837
Даатгал	992,574	992,474	298,669
Зээлийн авлага барагдуулах зардал	235,133	235,133	190,332
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны гарз	-	-	8,156
Бусад үйл ажиллагааны зардал	1,795,738	1,795,396	536,387
Мэргэжлийн үйлчилгээний зардал	1,206,074	1,205,929	610,663
Үндсэн хөрөнгө данснаас хассаны зардал (Тодруулга 21)	9,403	9,403	12,505
Байрны түрээс	3,241,761	3,241,761	2,852,061
Үндсэн хөрөнгийн урсгал засвар	937,258	937,258	707,817
Харуул хамгаалалтын зардал	885,136	885,136	578,854
Боловсон хүчний зардлууд*	14,327,374	14,327,374	7,116,468
Бичиг хэргийн зардал	863,015	862,934	595,569
Тээврийн зардал	529,242	529,242	376,989
Томилолтын зардал	529,460	529,460	601,046
Андрайтерын сангийн зардал	30,000	30,000	-
Ашиглалтын зардал	216,854	216,854	209,499
Суутган тооцох татвар	171,160	171,160	109,691
	32,545,909	32,545,134	21,241,842
* Боловсон хүчний зардлууд			
Цалин, шагнал, урамшуулал	11,001,548	11,001,548	6,159,386
Эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэл	1,181,011	1,181,011	643,445
Тэтгэврийн сан	215,487	215,487	50,150
Ажилчдын сургалт	315,801	315,801	190,555
Ажилчдын тэтгэмж	113,527	113,527	72,932
Хувьцаанд суурилсан төлбөр (Тодруулга 33)	1,500,000	1,500,000	-
	14,327,374	14,327,374	7,116,468

12. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Тайлант жилийн татвар:			
Тайлант жилийн үр дүнд ногдох орлогын албан татвар	10,060,294	10,060,136	6,145,111
Хойшлогдсон татвар:			
Түр зөрүүний үүсэлт, буцаалттай холбоотой (Тодруулга 24)	(368,766)	(368,766)	-
	9,691,528	9,691,370	6,145,111

Банк нь санхүүгийн тайлант орлогын дүнг орлогын татварын хуульд заасан чөлөөлөгдөх эсвэл үл чөлөөлөгдөх зүйлүүдээр залруулсан дүнг үндэслэн орлогын татварын зардлыг тооцдог. Банк 3 тэрбум (2010 онд 3 тэрбум) төгрөг хүртэл ашгаас 10% (2010 онд 10%)-ийн, 3 тэрбумаас (2010 онд 3 тэрбум) дээш төгрөгийн ашгаас 25% (2010 онд 25%)-ийн орлогын албан татвар төлдөг. Засгийн Газрын бондын хүүгийн орлогод татвар тооцохгүй. Зээлийн үнэ цэнийн бууралтын алдагдал болон урьдчилгаа төлбөрүүд нь татвар ногдох орлогоос хасагдах зардал болдог.

Татварын өмнөх ашгаас хуулиар тогтоосон хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардлыг Банкинд болон Группын хувьд хүчин төгөлдөр үйлчлэх орлогын татварын хувь хэмжээгээр тооцож гаргасан орлогын татварын зардалд 12 дугаар сарын 31-ээр хэрхэн тохируулсныг дараахь байдлаар үзүүлэв. Үүнд:

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Татварын өмнөх ашиг	39,936,237	39,935,427	26,197,859
25 %-ийн орлогын албан татвар	9,984,059	9,983,857	6,549,465
Бага хувийн татвар ногдох орлогын нөлөө	(450,122)	(450,000)	(450,000)
Татвараас чөлөөлөгдөх орлого	(835,478)	(835,478)	(289,431)
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	993,069	992,991	335,077
Тайлант жилийн татварын зардал	9,691,528	9,691,370	6,145,111

Хойшлогдсон татвар

Дараах хүснэгт санхүүгийн байдлын тайлант тусгагдсан хойшлогдсон татвар болон орлогын албан татварын зардалд бүртгэгдсэн өөрчлөлтүүдийг үзүүлэв:

	Групп ба Банкны		
	хойшлуулсан өр төлбөр 2011 мян.төг	татварын хөрөнгө 2011 мян.төг	Орлогын тайлан 2011 мян.төг
Агуулагдсан үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	265,797	265,797
Үндсэн хөрөнгө-түргэвчилсэн татварын элэгдүүлэлт	-	56,186	56,186
Санхүүгийн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээ - арилжаалах зорилгоор эзэмшиж буй	-	63,266	63,266
Гадаад валютаархи форвард хэлцлийн дахин үнэлгээ	-	1,437	1,437
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн бууралт	-	362,500	362,500
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа-зээлийн алдагдлын сангийн буцаалт	(380,420)	-	(380,420)
	(380,420)	749,186	368,766

13. НЭГЖ ХУВЬЦААНЫ ҮНДСЭН АШИГ

Нэгж хувьцааны үндсэн ашгийг тооцохдоо Банкны энгийн хувьцаа эзэмшигчидэд хамаарах цэвэр ашгийг тухайн жилийн жигнэсэн дундаж энгийн хувьцааны үлдэгдэл тоо хэмжээнд харьцуулдаг.

Нэгж хувьцааны шингэрсэн ашгийг тооцохдоо Банкны энгийн хувьцаа эзэмшигчидэд хамаарах цэвэр ашгийг (хөрвөх давуу эрхтэй хувьцаанд болон хөрвөх бондонд ногдох хүүнд татвар ногдуулж тохируулсны дараа) тухайн жилийн жигнэсэн дундаж энгийн хувьцааны үлдэгдэл тоо хэмжээ дээр энгийн хувьцаанд хөрвөрөх нийт шингэрүүлсэн энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо хэмжээг нэмсэн дүнд харьцуулдаг.

Дараах хүснэгтээр нэгж хувьцааны үндсэн болон шингэрсэн ашгийн тооцоололтонд ашигласан орлого болон хувьцааны мэдээллийг үзүүлэв:

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Групп ба Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдох цэвэр ашиг	30,244,709	30,244,057	20,052,748
Хөрвөх зээлийн хүү	1,789,383	1,789,383	1,100,197
Групп ба Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдох цэвэр ашиг (шингэрүүлэлтийн нөлөөгөөр залруулсан)	32,034,092	32,033,440	21,152,945
	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Нэгж хувьцааны үндсэн ашигт ногдох энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо	23,466,782	23,466,782	21,934,142
Шингэрүүлэлтийн нөлөө:			
Хөрвөх зээл (Тодруулга 28)	7,519,608	7,519,608	5,007,196
Хувьцааны опцион	103,854	103,854	-
Нэгж хувьцааны үндсэн болон шингэрсэн ашигт ногдох энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо	31,090,244	31,090,244	26,941,338
Нэгж хувьцааны ашиг			
Тайлант жилд банкны болон группын хувьцаа эзэмшигчдийн:			
Нэгж хувьцааны үндсэн ашиг	1,288.83	1,288.80	914.23
Нэгж хувьцааны шингэрсэн ашиг	1,030.36	1,030.34	785.15

Санхүүгийн тайлангуудын бүртгэлийн болон тэдгээрийг гүйцэтгэж дуусах өдрүүдийн хооронд энгийн эсвэл боломжит энгийн хувьцаа мөн нэгж хувьцааны ашгийг дахин тайлагнах шаардлагатай гүйлгээ гараагүй болно.

14. БЭЛЭН МӨНГӨ БА ТӨВ БАНК ДАХЬ ХАРИЛЦАХ

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Бэлэн мөнгө	89,428,119	89,428,119	60,555,802
Монголбанк дахь харилцах	200,449,311	200,449,311	77,498,911
	289,877,430	289,877,430	138,054,713

Монголбанкнаас тавигддаг шаардлагын дагуу Монголбанкинд харилцах данс байршуулдаг. Монгол банкинд байршуулах бэлэн мөнгөний заавал байлгах үлдэгдэл нь 14 хоногийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн 11.0% (2010: 5.0 %) аас багагүй байдаг. 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны байлгах шаардлагатай 14 хоногын дундаж нөөцийн хэмжээ дотоод валютаар 117,466 сая төгрөг (2010: 30,651 сая төгрөг) ба гадаад валютаар 77,084 сая төгрөг (2010: 23,845 сая төгрөг) байсан.

15. БУСАД БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Бусад банк, санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	177,338,242	177,338,242	240,349,466
Зээл ба урьдчилгаа	44,544,203	44,544,203	9,549,172
	221,882,445	221,882,445	249,898,638

Бусад банк санхүүгийн байгууллага дахь харилцах хадгаламж нь дотоодын болон гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан дотоод болон гадаад валютаар илэрхийлэгдсэн харилцах дансдыг хэлнэ.

Зээл ба урьдчилгаа нь 2 хоногийн хугацаатай овернайт зээлийг илэрхийлнэ. (2010 онд 3 өдөр)

2010 онд бусад банк болон санхүүгийн байгууллагад байршуулсан 42.50 сая төгрөгийн дүнтэй хөрөнгийг зээлийн барьцаанд байршуулсан (Тодруулга 27).

16. УРВУУ РЕПО ХЭЛЦЭЛ

Урвуу репо хэлцлийн дагуу Групп ба Банк нь 25 тэрбум төгрөгийн (2010 онд 4 тэрбум төгрөг) Монголбанкны үнэт цаасыг хүлээн авсан. Үнэт цаасууд нь 3-5 хоногийн хугацаатай (2010 онд 3 хоног) ба 2012.01.02 болон 2012.01.04 (2010 онд 2011.01.03) -ний өдөр тус тус дуусгавар болно. Уг үнэт цаасны бодит үнэ цэнэ нь 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх бүртгэлийн дүнтэйгээ ойролцоо байсан.

17. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГЛҮҮР

Доорх мэдээлэлийг үүсмэл санхүүгийн хэрэслүүдийн бодит үнийг нэрлэсэн дүнгийн хамт толилуулсан байна. Нэрлэсэн дүн нь (энэ нь нийт дүнгээр бүртгэгдсэн) үүсмэл санхүүгийн хэрэгслийн салшгүй хамааралтай хөрөнгийн дүн байдаг бөгөөд үүсмэл санхүүгийн хэрэгслийнх нь бодит үнийг энэхүү хөрөнгөд үндэслэн хэмждэг. Нэрлэсэн дүн нь ажил гүйлгээний жилийн эцсийн үлдэгдлийг харуулдаг ба зах зээлийн болон зээлийн эрсдэлийн алийг нь ч илэрхийлээгүй болно.

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Хөрөнгө			
- Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа үүсмэл санхүүгийн хэрэглүүр - гадаад валютын форвард хэлцэл	-	-	4,486
Өр төлбөр			
- Өөрийн хөрөнгө ба валютын үүсмэл санхүүгийн хэрэглүүр (тодруулга 28)	2,569,321	2,569,321	1,506,132
- Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа үүсмэл санхүүгийн хэрэглүүр - гадаад валютын форвард хэлцэл	1,264	1,264	-
	2,570,585	2,570,585	1,506,132
Нэрлэсэн дүн			
- Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа үүсмэл санхүүгийн хэрэглүүр - гадаад валютын форвард хэлцэл	8,078,567	8,078,567	4,032,000

18. САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Арилжаалах зорилгоор эзэмших буй:			
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй энгийн хувьцааны бодит үнэ цэнэ	1,061,151	1,061,151	345,472
Борлуулахад бэлэн:			
Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй энгийн хувьцааны өртөг	642,922	642,922	3,712,922
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй энгийн хувьцааны бодит үнэ цэнэ	2,116,018	2,116,018	3,744,408
	2,758,940	2,758,940	7,457,330
Дуусгавар хугацаа хүртэл эзэмших:			
Монгол банкны үнэт цаас	178,576,862	178,576,862	353,616,082
Засгийн газрын бонд	50,846,777	50,846,777	2,042,400
Вексель	72,008,160	72,008,160	-
Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хувьцаа	2,738,152	2,738,152	-
	304,169,951	304,169,951	355,658,482

Монголбанкны үнэт цаас нь богино хугацаатай, хүү тооцдог, хямдруулсан үнээр гаргасан үнэт цаас юм. Монголбанкны 4.6 тэрбум төгрөг (2010онд 4.6 тэрбум төгрөг)-ийн дүнтэй үнэт цаасыг Тодруулга 27-т тодруулсан өрийн барьцаа болгон Монголбанкинд өгсөн. Сангийн яамны гаргасан, Засгийн газрын өрийн бичиг нь 2 жилээс доош хугацаатай, хямдруулсан үнээр гаргасан үнэт цаас юм.

Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй хөрөнгө оруулалт нь хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй компанид оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ. Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг бодитойгоор хэмжиж чадахгүй учраас тэдгээрийг өртгөөр нь бүртгэдэг. Үнэлгээний техникүүдийг ашиглан хийсэн бодит үнэ цэнийн тооцооллууд хоорондоо их хэмжээгээр зөрнө гэсэн хүлээллтэй байна. Энэ хөрөнгө оруулалтын хувьд зах зээлийн үнэ байхгүй ба Банк энэхүү хөрөнгө оруулалтыг урт хугацаагаар эзэмших хандлагатай байгаа.

Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй хөрөнгө оруулалт гэдэг нь Монголын хөрөнгийн бирж болон Хонг Конгын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй байгууллагуудад оруулсан хөрөнгө оруулалтыг хэлнэ. Биржид бүртгэлтэй дуусгавар хугацаа хүртэл эзэмших хөрөнгө оруулалт гэдэг нь Худалдаа Хөгжлийн Банкны Сингапур Секьюрити Трэйдинг Лимитед биржид бүртгэлтэй бондыг хэлнэ.

Вексел нь Эрдэнэс МЖЛ ХХК болон Монголын Төмөр Зам компани (хоёулаа улсын өмчит компани)-аас 31-ээс 182 хоногийн хугацаатайгаар, хямдруулсан үнээр гаргасан үнэ цаасанд оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлнэ.

19. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Бизнесийн зээл	718,725,829	718,725,829	520,767,630
Бизнесийн жижиг зээл	214,880,294	214,880,294	115,686,204
Хэрэглээний зээл	126,569,077	126,569,077	66,215,273
Орон сууцны зээл	192,879,826	192,879,826	80,108,644
	1,253,055,026	1,253,055,026	782,777,751
Хуримтлагдсан хүүний авлага	12,876,933	12,876,933	12,044,815
Нийт зээл ба урьдчилгаа	1,265,931,959	1,265,931,959	794,822,566
Үнэ цэнэ бууралтын сан	(20,012,736)	(20,012,736)	(10,217,619)
Зээл ба урьдчилгааны цэвэр дүн	1,245,919,223	1,245,919,223	784,604,947

19. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БА УРЬДЧИЛГАА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сан

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын сангийн тохируулгыг зээлийн ангилал тус бүрээр нь салган үзүүлбэл:

ГРУПП	Бизнесийн зээл мян.төг	Бизнесийн жижиг зээл мян.төг	Хэрэглээний зээл мян.төг	Орон сууцны зээл мян.төг	Нийт зээл мян.төг
2011 оны 12 сарын 31					
2011 оны 1-р сарын 1-нээр	6,696,841	2,353,077	756,209	411,492	10,217,619
Нэмэгдсэн	7,615,273	5,252,020	314,041	386,662	13,567,996
Төлөгдсөн	(3,877,751)	(190,557)	(262,070)	(617,150)	(4,947,528)
Дахин ангилсан	-	-	75,228	-	75,228
Ханшны зөрүү	542,762	489,451	32,032	35,176	1,099,421
2011 оны 12-р сарын 31-нээр	10,977,125	7,903,991	915,440	216,180	20,012,736
Тусгай үнэ цэнийн бууралт	4,957,479	5,920,551	-	-	10,878,030
Бүлгийн үнэ цэнийн бууралт	6,019,646	1,983,440	915,440	216,180	9,134,706
	10,977,125	7,903,991	915,440	216,180	20,012,736
Тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай, тусгай үнэ цэнийн бууралтын санг хасахаас өмнөх зээлийн нийт дүн	11,515,894	11,049,068	-	-	22,564,962

БАНК	Бизнесийн зээл мян.төг	Бизнесийн жижиг зээл мян.төг	Хэрэглээний зээл мян.төг	Орон сууцны зээл мян.төг	Нийт зээл мян.төг
2011 оны 12 сарын 31					
2011 оны 1-р сарын 1-нээр	6,696,841	2,353,077	756,209	411,492	10,217,619
Нэмэгдсэн	7,615,273	5,252,019	314,041	386,662	13,567,995
Төлөгдсөн	(3,877,751)	(190,557)	(262,070)	(617,150)	(4,947,528)
Дахин ангилсан	-	-	75,228	-	75,228
Ханшны зөрүү	542,762	489,452	32,032	35,176	1,099,422
2011 оны 12-р сарын 31-нээр	10,977,125	7,903,991	915,440	216,180	20,012,736
Тусгай үнэ цэнийн бууралт	4,957,479	5,920,551	-	-	10,878,030
Бүлгийн үнэ цэнийн бууралт	6,019,646	1,983,440	915,440	216,180	9,134,706
	10,977,125	7,903,991	915,440	216,180	20,012,736
Тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралттай, тусгай үнэ цэнийн бууралтын санг хасахаас өмнөх зээлийн нийт дүн	11,515,894	11,049,068	-	-	22,564,962

	Бизнесийн зээл мян.төг	Бизнесийн жижиг зээл мян.төг	Хэрэглээний зээл мян.төг	Орон сууцны зээл мян.төг	Бусад мян.төг	Нийт зээл мян.төг
2010 оны 12 сарын 31						
2010 оны 1-р сарын 1-нээр	9,950,883	5,535,479	1,993,320	561,648	73	18,041,403
Нэмэгдсэн	2,665,991	287,442	281,862	177,810	-	3,413,105
Төлөгдсөн	(1,871,976)	(1,551,464)	(666,014)	(307,953)	-	(4,397,407)
Дахин ангилсан	-	-	-	73	(73)	-
Данснаас хассан	(3,373,570)	(1,690,960)	(844,263)	(3,482)	-	(5,912,275)
Ханшны зөрүү	(674,487)	(227,420)	(8,696)	(16,604)	-	(927,207)
2010 оны 12-р сарын 31-нээр	6,696,841	2,353,077	756,209	411,492	-	10,217,619
ТУЗ нь эрсдэлийн удирдлагын үндсэн чиг хандлагыг тодорхойлж, банкны бүх үйл ажиллагааг зорилгод чиглүүлсэн эрсдэлийн стратеги, зарчимуудыг батлах мөн шаардлагатай гэж үзсэн шинэ бодлого журмыг нэвтрүүлдэг.

Эрсдэлийн стратеги болон ач холбогдол бүхий бодлогуудыг ТУЗ-аас батлаж, тодорхой давтамжтайгаар (хамгийн багадаа жилд 1 удаа) хянан хэлэлцдэг.

Аудитын хороо

Тус хороо нь эрсдэлийн стратеги боловсруулж, хүүний ханшны хөрвөх чадварын болон зах зээлийн эрсдэлүүдэд хязгаарлалтууд, зарчмыг, бүтэц, бодлогыг тодорхойлж хэрэгжүүлнэ.

ТУЗ-ийн Аудитын хороо нь Дотоод аудитын газрын үйл ажиллагаанд хяналт тавих, гадаад аудиторуудтай холбогдуулан банкны бизнес болон үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх бүхий л аудиттай холбоотой асуудлуудыг илрүүлж, хяналт тавьж ажиллана.

Эрсдэлийн хороо

Эрсдэлийн Удирдлагын Хороо нь ТУЗ-ийн банкинд учирч болох эрсдэлийг хянаж удирдахад нь дэмжлэг үзүүлж ажиллана. Эрсдэлийн Удирдлагын Хороо дараах үндсэн чиг үүрэгтэй:

- (i) Банкны бизнес болон үйл ажиллагаанд учирч болох бүх бодит болон болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлох (зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, хууль эрх зүй болон бизнесийн нэр хүндийн эрсдэл болон бусад эрсдэл) болон эдгээр эрсдэлүүдийг багасгах зорилгоор үнэлэх, мөн банкны хяналт, эрсдэлийн удирдлагын бодлогод шаардлагатай сайжруулалтыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх заавар удирдамж өгөх;
- (ii) Тодорхой нэг салбар, үйлдвэрлэлийн сектор, газарзүйн байршил болон бүтээгдэхүүнд чиг хандлага олгох;
- (iii) ТУЗ-ийг банкны салбарын бүх түвшний эрсдэлийг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл, холбогдох өгөгдлөөр хангах;
- (iv) Банкны мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхийн эсрэг банкны журмыг батлах, түүнийг хэрэгжүүлэх, улирлын тайланг хэлэлцэх ;
- (v) Эрсдэлийн Удирдлагын газрын улирлын тайлангуудтай танилцаж, хэлэлцэх ; ба
- (vi) Улирлын зохистой байдлын тайланг хэлэлцэх.

Актив, пассивын хороо

Тус удирдлагын хороо нь эрсдэлийн стратеги боловсруулж, Групп ба банкны ТУЗ, Эрсдэлийн Хороо-д санал оруулах, батлагдсаны дараа хүүний, хөрвөх чадварын болон зах зээлийн эрсдэлүүдэд хязгаарлалтууд тогтоох зарчим, бүтэц, бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх чиг үүрэгтэй ажиллана .

Зээлийн Хороо

Зээлийн хороо нь ТУЗ-д шууд харъяалагдана. Тус хороо нь ТУЗ-аас тодорхойлсон эрх хэмжээний хүрээнд зээлийн шийдвэр гаргадаг нэгж юм. Зээлийн хороо нь дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд :

- (i) зээлийн бодлого, журамд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх, батлах;
- (ii) зээлийн ангилал болон сан байгуулах түвшин хэмжээг батлах;
- (iii) зээлийн багц дах чанар, эрсдэлтэй багцыг тогтмол хянах;
- (iv) үйлдвэрлэлийн салбар болон газарзүйн бүсийн байршлын хувьд олгогдох зээлийн хэмжээг тогтоон батлах.

Эрсдэлийн Удирдлагын Газар

Эрсдэлийн удирдлагын газар нь бие даасан хяналтын системийг хэрэгжүүлэх зорилгоор эрсдэлд хамаарал бүхий бодлого журмуудыг мөрдөж, хэрэгжүүлнэ..

Тус газар нь Групп ба Банкны эрсдэлийн бодлого, журмуудын хэрэгжилтийг хангана. Бизнесийн бүхий л нэгжүүд эрсдэлийг хянан зохицуулах бие даасан албатай байх болсон бөгөөд тогтоосон лимитийн эрсдэл, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний эрсдэл болон зохион байгуулалт бүхий гүйлгээний эрсдэл зэргийг багтааж хянана. Тус алба нь мөн эрсдэлийн тооцоололт, тайлагналын систем дэх бүхий л эрсдэлийг тодорхойлж, тайлагнах чиг үүрэгтэй байна.

37. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ.)

37.1 Оршил (үргэлжлэл)

Зээлийн газар

Зээлийн газар нь Банкны зээлийн бодлогыг тусгай хариуцлага бүхий дор тодорхойлсон гурван хэлтэс нэгжээр дамжуулан бүхий л түвшинд удирдах болон хэрэгжүүлэх үүрэгтэй ажиллана:

Том байгууллагын хэлтэс ба Жижиг Дунд Бизнесийн нэгжийн хэлтэс

- (i) Зээлийн судалгаа шинжилгээг явуулах;
- (ii) Зээлийн саналыг зээлийн хороогоор оруулах болон тодорхойлох;
- (iii) Зээлийн эргэн төлөлтийн хуваарт хяналт тавих, бүх төрлийн болзлын биелэлтэнд хяналт тавих;
- (iv) Бүх төрлийн зээлийн үлдэгдлийн эргэн төлөлтийг хянах.

Хяналтын хэлтэс

- (i) Зээлийн бодлого зорилтын биелэлтэнд хяналт тавих;
- (ii) Салбарын зээлийн үйл ажиллагааг дэмжих болон хяналт тавих.

Шинжээчдийн хэлтэс

- (i) Тусгайлан бизнесийн салбар болон үйлдвэрлэлийн хүрээний бизнес төлөвлөгөө болон барьцаа хөрөнгийн үнэлгээнд хараат бус дүгнэлт өгөх, мэргэжлийн зөвлөгөө өгөх.

Дотоод Аудитын Газар

Банк дахь эрсдэлийн удирдлагыг Дотоод аудитын газар банкны зохимжтой үйл ажиллагаа болон мөрдлөг болгож буй дүрэм, журмын хэрэгжилтийг шалгах замаар хамгийн багадаа жилд нэг удаа аудит хийнэ. Дотоод аудитын газар нь шалгалтын дүнгийн талаар удирдлагатай ярилцаж, илэрсэн зүйлийг санал зөвлөмжийн хамт удирдлагын хороо болон аудитын хороонд тайлагнана.

Эрсдэлийн хэмжих болон тайлагнах систем

Групп ба Банк нь тооцоолж болохуйц болон ердийн тохиолдолд тооцож болохооргүй эрсдэл буюу статистик загварт суурилсан эцсийн эрсдэлийг аль алийг нь хэмжих аргыг ашигладаг. Загвар нь өмнөх туршлага, түүхэнд суурилсан боломжийг эдийн засгийн орчинд тохируулна. Мөн Групп ба Банкинд тохиолдох магадалал тун багатай боловч тохиолдож болох хамгийн муу төлөвүүдийг гаргадаг.

Эрсдэлийг Групп ба Банкаас тогтоосон хэмжээ хязгаарын хүрээнд хянаж, удирдана. Тус тодорхойлсон хэмжээ хязгаар нь Групп ба Банкны бизнес стратеги, зах зээлийн орчинтой болон банкны зүгээс хүлээн зөвшөөрөхүйц эрсдэлийн хэмжээтэй уялдсан байх ба зарим салбарт онцгойлон анхаардаг. Банк нь бүх үйл ажиллагаанд бий эрсдэлүүдийн нийлбэр өртөлттэй холбоотойгоор эрсдэл даах чадварыг хэмжиж хянана.

Бүх бизнесийн нэгжүүдээсээ цуглуулсан мэдээллийг эрсдэлийг эртхэн тодорхойлж, хянах зорилгоор нягтлан шалгаж боловсруулалт хийдэг. Мөн энэ мэдээлэлийг ТУЗ, Актив пассивын хороо, газар бүрийн захирлуудад танилцуулдаг. Тайланд зээлийн нийт өртөлт, зээлийн хэмжээний төлөв, тогтоосон лимитийг давах онцгой тохиолдол, VaR, хөрвөх чадварын харьцаа, ба эрсдэлийн багцын өөрчлөлт зэргийг тусгана. Сар бүр үйлдвэрлэлийн салбар, харилцагчийн эрсдэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тайлагнана. Улирал бүр газар нэгжийн захирлууд зээлийн эрсдэлийн сангийн зохистой байдалд үнэлгээ өгнө. Аудит Хороо болон Эрсдэлийн хороо нь Групп ба Банкны нийт эрсдэлийн өртөлтийг тооцож, үнэлж, хянаж болохуйц бүрэн хэмжээний тайлантай улирал бүр танилцаж үнэлгээ хийдэг.

Тусгайлан боловсруулагдсан эрсдэлийн тайланг Банкны бүх нэгжүүдэд хүргэдэг бөгөөд энэ нь бизнесийн нэгжүүдийг шинэ тутам мэдээлэлтэй байлгах зорилготой юм.

Удирдлага болон Актив пассивын хороонд VaR, хөрвөх чадварын дүн шинжилгээ, зах зээлийн лимитын ашиглалт болон бусад аливаа эрсдэл үүсгэх хүчин зүйлийн талаар танилцуулна.

Эрсдэлийг бууруулах

Хүүний ханш, гадаад валютын ханшны өөрчлөлт, зээлийн эрсдэл болон ирээдүйн үйл ажиллагаанаас үүдэж болох өртөлтийг мэдрэмжийн шинжилгээ болон VaR-ийг эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд ашигладаг. Групп ба Банк нь зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор барьцаа хөрөнгө барьцаалж авдаг.

Эрсдэлийн хэт төвлөрөл

Хэд хэдэн харилцагчид ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг эсвэл улс төр эдийн засаг болон бусад аливаа өөрчлөлт гарахад тэдгээрийн гэрээний үүргээ гүйцэтгэхэд ижил маягаар нөлөөлөхөөр байвал төвлөрөл бий болдог. Төвлөрөл нь тухайн нэг салбарт нөлөөлж буй нөхцөл байдалд Групп болон Банк хэрхэн гүйцэтгэлээ хангах мэдрэмжийг илгэнэ.

Эрсдэлийн хэт төвлөрөлөөс зайлсхийхийн тулд Групп ба Банк нь өөрийн бодлого, журамдаа олон төрлийн багцтай байх тодорхой удирдамжийг тусгасан байдаг. Зээлийн эрсдэлийн тодорхойлогдсон төвлөрөлийг хянаж удирдана. Монголбанк /Төв банк/ дараах стандарт хязгаарлалтуудыг биелүүлэхийг шаарддаг. Үүнд ::

- (i) Нэг зээлдэгч болон түүнд холбогдох хувь хүнд олгох зээлийн нийт зээлийн дүн болон зээлтэй адилтгах бусад активын хамгийн дээд хэмжээг банкны өөрийн хөрөнгийн 20%-аас хэтрүүлж болохгүй.
- (ii) Банктай ямар нэгэн байдлаар холбогдсон этгээдэд олгосон зээлийн хэмжээ болон зээлтэй адилтгах бусад активын дүн нь банкны өөрийн хөрөнгийн 5 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 20%-аас хэтэрч болохгүй.

37.2 Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэдэг нь банкны харилцагч, болон хамтрагч тал гэрээний үүргээ биелүүлээгүйгээс үүдэж банк хүлээж болзошгүй эрсдэлийг хэлнэ. Групп ба Банк нь тухайн нэг зээлдэгч болон газарзүй, эдийн засгийн салбарын төвлөрлийн хувьд өөрийн дааж болохуйц эрсдэлийн дүнд тохирсон хязгаар тогтоох, тийм хязгаартай холбоотой эрсдэлийн нийт хэмжээнд мониторинг хийх замаар зээлийн эрсдэлийг хянаж удирддаг.

Групп ба Банк нь барьцаа хөрөнгийн үнэлгээ хяналтыг хийх зэргийг багтаасан зээлдэгч талын зээл даах чадавхид гарч буй өөрчлөлтийг нэн даруй тодорхойлж байхын тулд зээлийн чанарыг хянах процессыг бий болгосон. Зээлийн эрсдэлийн зэрэглэл зээлдэгч бүрээр тогтоох зээлийн эрсдэлийн ангилалын системийг ашиглан тухайн нэг зээлдэгчийн зээл авах дээд хэмжээг тогтоодог. Эрсдэлийн зэрэглэлийг байнга хянан шинэчилж байдаг. Зээлийн зэрэглэлийг эргэн хянах процесс нь үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлсоны үр дүнд хүлээж болзошгүй алдагдалыг тогтоох, мөн түүнээс сэргийлэх зохистой арга хэмжээг авах боломжийг Банкинд олгодог юм.

Групп ба Банкны зээлийн үйл ажиллагааг удирдах, хяналт зохицуулалт хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор чанарын стандартчилагдсан формат ба тайлагналыг хэвшүүлэх, хөгжүүлж, сайжруулах нь энэхүү хяналтын нэгжийн үүрэг юм..

Зээлийн Эрсдэлийн Удирдлагын Хэлтэс нь банкин дахь зээлийн соёлын хөгжлийн нэг хэсэг гэдэг утгаараа банк доторх мэдлэг, туршлага, мэргэжлийн нөөцийг бий болгох болон Хүний нөөцийн хэлтэстэй хамтран Зээлийн Сургалтын хөтөлбөрүүдийн төлөвлөгөөг боловсруулах үүргийг хүлээнэ. Энэ нь Групп ба Банкны шаардлага болон тодорхойлсон чадвар, мэдлэгийн дутагдал, хүрэлцээгүй байдлыг нөхөх зорилготой тасралтгүй бөгөөд жил бүр эргэн хянагддаг үйл явц юм.

Зээлтэй холбоотой болзошгүй үүргийн эрсдэл

Групп ба Банк нь харилцагчийн өмнөөс төлбөр төлөх магадлал бүхий баталгаануудыг гаргах боломжийг бий болгодог. Ийм төлбөрийг аккредитивийн нөхцөлд тулгуурлан харилцагчдаас эргүүлэн татдаг. Эдгээр нь Групп ба Банкинд зээлтэй нэгэн адил эрсдэлийг учруулах ба түүнийг мөн зээлийн үйл ажиллагааны бодлого журмаар зохицуулдаг.

Эдгээр хэрэгслүүдийн гол зорилго нь харилцагчийг шаардлагатай эх үүсвэрээр хангахад оршино. Баталгаа ба нээлттэй аккредитивууд нь харилцагч гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон тохиолдолд Групп ба Банк өмнөөс нь төлбөрийг нь барагдуулах цуцлашгүй үүрэг хүлээснийг илэрхийлдэг ба эдгээр хэрэгслийн эрсдэл нь зээлийн эрсдэлтэй ижил юм.

37. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

37.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн баталгаа, батлан даалтыг тооцохгүйгээр зээлд учирч болзошгүй эрсдэлийн дээд хэмжээг авч үзвэл

Доорх хүснэгт нь тайлан тэнцлийн үзүүлэлт бүрийн хувьд зээлийн эрсдэлийн дээд хэмжээний өртөлтийг харуусан байна. Дээд өртөлтийг барьцаа хөрөнгө ашиглаж эрсдэл бууруулах нөлөөний өмнөх нийт дүнгээр илэрхийлсэн болно.

		ГРУПП Нийт өртөл- тийн дээд хэмжээ 2011 мян.төг	БАНК Нийт өртөл- тийн дээд хэмжээ 2011 мян.төг	Нийт өртөл- тийн дээд хэмжээ 2010 мян.төг
Тодруулга				
Бэлэн мөнгө ба Төв банк дахь харилцах (гар дээрх бэлэн мөнгийг оруулаагүй)	14	200,449,311	200,449,311	77,498,911
Банкуудад байршуулсан харилцах, хадгаламж	15	221,882,445	221,882,445	249,898,638
Урвуу репо хэлцэл	16	24,979,395	24,979,395	3,997,668
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр	17	-	-	4,486
Санхүүгийн хөрөнгө оруулалт-Дуусгавар хугацаа хүртэл эзэмших	18	304,169,951	304,169,951	355,658,482
Харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа	19	1,245,919,223	1,245,919,223	784,604,947
Бусад авлага	23	2,860,664	2,863,929	1,377,620
Нийт		2,000,260,989	2,000,264,254	1,473,040,752
Болзошгүй өр төлбөр	34	128,264,634	128,264,634	83,703,986
Үүргүүд	34	29,804,038	29,804,038	27,142,064
Нийт		158,068,672	158,068,672	110,846,050
Зээлийн эрсдэлд өртөж болох нийт дүн		2,158,329,661	2,158,332,926	1,583,886,802

Бодит үнээр бүртгэгддэг санхүүгийн хэрэгслийн хувьд дээрх дүнгүүд нь өнөөгийн зээлийн эрсдэлийн өртөлтийг харуулсан боловч энэ нь ирээдүйд үнэ цэнэ өөрчлөгдөхөөс шалтгаалж бий болж болох эрсдэлийн дээд хэмжээ биш юм.

Санхүүгийн хэрэгслийн анги тус бүр дэх зээлийн эрсдэлийн өртөлтийн дээд хэмжээний талаарх илүү нарийвчилсан мэдээг тусгайлан холбогдох тодруулгуудад хаанаас харж болохыг заасан байх болно. Барьцаа хөрөнгө болон бусад эрсдэлийг бууруулах арга техникүүдийн нөлөөллийг дор харуулав.

Зээлийн эрсдэлд дээд хэмжээгээр өртөх эрсдэлийн төвлөрөл

Эрсдэлийн төвлөрөлийг харилцагч тал/үйлчлүүлэгч ба эдийн засгийн салбар тус бүрээр ангилан зохицуулна. 2011 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар аливаа харилцагч тал/үйлчлүүлэгчээс учирч болох зээлийн эрсдэлд өртөх дээд хэмжээ нь 37,812 сая төгрөг (2010 онд 35,932 сая төгрөг) байв.

Бусад банк болон санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж болон бусад хөрөнгө болох 219,684 сая төгрөг (2010 онд 189,727 сая төгрөг)-өөс бусад банкны бүх хөрөнгө болон өр төлбөр нь газарзүйн хувьд Монгол Улсад төвлөрч байна.

Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн сайжруулалтыг тооцохоос өмнөх Банкны санхүүгийн хөрөнгийн эдийн засгийн салбарын шинжилгээ:

	ГРУПП Нийт өртөл- тийн дээд хэмжээ 2011 мян.төг	БАНК Нийт өртөл- тийн дээд хэмжээ 2011 мян.төг	Нийт өртөл- тийн дээд хэмжээ 2010 мян.төг
Хөдөө аж ахуй	24,567,603	24,567,603	18,957,486
Барилга	69,623,131	69,623,131	65,441,303
Өргөн хэрэглээ	321,123,855	321,123,855	150,250,984
Боловсрол	1,288,329	1,288,329	4,522,363
Эрчим хүч, газрын тос	70,300,836	70,300,836	29,156,678
Санхүүгийн үйлчилгээ	817,061,463	817,061,463	718,006,017
Эрүүл мэнд	3,369,524	3,369,524	6,664,384
Өрхийн бизнес	-	-	467,443
Зочид буудал, зоогийн газар	34,506,351	34,506,351	16,861,982
Олон улсын байгууллага	91,604	91,604	-
Засвар үйлчилгээ	19,511,366	19,511,366	5,764,651
Боловсруулах үйлдвэрлэл	116,835,549	116,835,549	74,088,332
Уул уурхай, хайгуул	161,698,972	161,698,972	133,588,123
Олон нийтийн үйлчилгээ	5,779,811	5,779,811	-
Үл хөдлөх хөрөнгө	56,052,905	56,052,905	35,971,657
Нийгмийн үйлчилгээ	17,325,500	17,325,500	15,806,291
Аялал жуулчлал	28,159,963	28,159,963	18,169,791
Тээвэр ба харилцаа холбоо	87,586,180	87,586,180	39,704,891
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	120,851,499	120,851,499	119,042,709
Бусад	44,526,548	44,529,813	20,575,667
	2,000,260,989	2,000,264,254	1,473,040,752

Барьцаа ба зээлийн бусад сайжруулалтууд

Барьцаа хөрөнгийн шаардагдаж буй хэмжээ ба төрлийг зээлдэгч талын зээлийн эрсдэлийн шинжилгээнд үндэслэн тогтооно. Зөвшөөрч болохуйц барьцаа хөрөнгийн төрлүүд болон үнэлгээний параметруудийг тодорхой удирдамж, журмаар зохицуулдаг.

Гол барьцаа хөрөнгийн төрлүүд:

- (i) Аж ахуйн нэгжийн зээл: Үл хөдлөх хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, автомашин.;
- (ii) Жижиг бизнесийн зээл: Үл хөдлөх хөрөнгө;
- (iii) Хэрэглээний зээл: Автомашин, орлого
- (iv) Орон сууцны зээл: Амьдрах зориулалттай үл хөдлөх хөрөнгө.

Мөн Груп ба Банк нь охин компанид зээл олгохдоо толгой компаниар батлан даалт хийлгэж болдог. Гэхдээ эдгээр боломжит эрсдэлээс хамгаалсан хэмжээг дээрх хүснэгтэд тусгаагүй болно.

Барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээнд удирдлагууд хяналт тавьдаг. Үндсэн гол гэрээ хэлэлцээрт зохицуулагдсанаар тухайн зээлд нэмж барьцаа хөрөнгө барьцаалахад удирдлагууд мөн хяналт тавьдагаас гадна эдгээр барьцаа хөрөнгийн зах зээлийн үнийг зээлийн үнэ цэнийн бууралтын санг зохистой эсэхийг шалгах явцдаа давхар хянадаг.

Барьцаа хөрөнгөнд тооцогдон хураагдсан эд хөрөнгийг цэгцтэй арга замаар борлуулах нь Групп ба Банкны нэг бодлого юм. Олсон орлогыг төлөгдөөгүй үлдсэн зээлийн хэмжээг багасгах, барагдуулахад ашигладаг. Групп ба Банк хураагдсан эд хөрөнгийг өөрийн бизнесийн хэрэглээнд ашигладаггүй.

37. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

37.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн ангилал тус бүрийн зээлийн чанар

Групп ба Банк нь өөрийн санхүүгийн хөрөнгийн зээлийн чанарыг дотооддоо ашигладаг зээл зэрэглэлийн системээр удирддаг. Доорхи хүснэгт нь зээлийн чанарыг хөрөнгийн төрөл тус бүрээр банкны зээлийн дотоод зэрэглэлийн системд суурилсан зэрэглэлийг харуулна.

ГРУПП	Тодруулга	Хугацаа хэтрэлтгүй ба үнэ цэнийн бууралтгүй зээл			Хугацаа хэтэрсэн эсвэл дангаараа үнэ цэнэ буурсан мян.төг	Нийт мян.төг
		Өндөр зэрэглэл мян.төг	Стандарт зэрэглэл мян.төг	Стандартаас доогуур зэрэглэл мян.төг		
2011 оны 12 сарын 31-ний байдлаар						
Бусад банк санхүүгийн байгууллагууд дахь харилцах хадгаламж	15	214,405,526	6,321,405	1,155,514	-	221,882,445
Урвуу репо хэлцэл	16	24,979,395	-	-	-	24,979,395
Санхүүгийн хөрөнгө оруулалт-Дуусгавар хугацаа хүртэл эзэмших	18	304,169,951	-	-	-	304,169,951
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа						
Банк хоорондын зээл	19	5,596,651	-	-	-	5,596,651
Бизнесийн зээл	19	657,675,443	1,184,015	11,022,881	49,468,682	719,351,019
Бизнесийн жижиг зээл	19	170,102,934	9,287,648	13,634,731	24,242,626	217,267,939
Хэрэглээний зээл	19	121,992,220	1,974,932	619,947	4,852,760	129,439,859
Орон сууцны зээл	19	154,966,411	22,282,692	10,420,945	6,606,441	194,276,489
		1,110,333,659	34,729,287	35,698,504	85,170,509	1,265,931,959
Нийт		1,639,164,792	36,161,614	56,466,835	85,170,509	1,816,963,750

БАНК	Тодруулга	Хугацаа хэтрэлтгүй ба үнэ цэнийн бууралтгүй зээл			Хугацаа хэтэрсэн эсвэл дангаараа үнэ цэнэ буурсан мян.төг	Нийт мян.төг
		Өндөр зэрэглэл мян.төг	Стандарт зэрэглэл мян.төг	Стандартаас доогуур зэрэглэл мян.төг		
2011 оны 12 сарын 31-ний байдлаар						
Бусад банк санхүүгийн байгууллагууд дахь харилцах хадгаламж	15	214,405,526	6,321,405	1,155,514	-	221,882,445
Урвуу репо хэлцэл	16	24,979,395	-	-	-	24,979,395
Санхүүгийн хөрөнгө оруулалт-Дуусгавар хугацаа хүртэл эзэмших	18	304,169,951	-	-	-	304,169,951
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа						
Банк хоорондын зээл	19	5,596,651	-	-	-	5,596,651
Бизнесийн зээл	19	657,675,443	1,184,015	11,022,881	49,468,682	719,351,019
Бизнесийн жижиг зээл	19	170,102,934	9,287,648	13,634,731	24,242,626	217,267,939
Хэрэглээний зээл	19	121,992,220	1,974,932	619,947	4,852,760	129,439,859
Орон сууцны зээл	19	154,966,411	22,282,692	10,420,945	6,606,441	194,276,489
		1,110,333,659	34,729,287	35,698,504	85,170,509	1,265,931,959
Нийт		1,639,164,792	36,161,614	56,466,835	85,170,509	1,816,963,750

БАНК		Хугацаа хэтрэлтгүй ба үнэ цэнийн бууралтгүй зээл			Хугацаа хэтэрсэн эсвэл дангаараа үнэ цэнэ буурсан		Нийт мян.төг
		Өндөр зэрэглэл мян.төг	Стандарт зэрэглэл мян.төг	Стандартаас доогуур зэрэглэл мян.төг	хэтэрсэн цэнэ буурсан мян.төг		
2011 оны 12 сарын 31-ний байдлаар		Тодруулга					
Бусад банк санхүүгийн байгууллагууд дахь харилцах хадгаламж		15	129,380,712	47,728,663	72,789,263	-	249,898,638
Урвуу репо хэлцэл		16	3,997,668	-	-	-	3,997,668
Үүсмэл санхүүгийн хэрэглүүр		17	4,486	-	-	-	4,486
Санхүүгийн хөрөнгө оруулалт-Дуусгавар хугацаа хүртэл эзэмших		18	355,658,482	-	-	-	355,658,482
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа							
Банк хоорондын зээл		19	399,715,064	73,303,926	40,648,733	15,697,475	529,365,198
Бизнесийн жижиг зээл		19	83,523,150	6,446,493	12,886,970	13,958,752	116,815,365
Хэрэглээний зээл		19	55,439,572	734,213	8,452,644	3,209,128	67,835,557
Орон сууцны зээл		19	53,965,087	13,367,225	8,032,477	5,441,657	80,806,446
			592,642,873	93,851,857	70,020,824	38,307,012	794,822,566
Нийт			1,081,684,221	141,580,520	142,810,087	38,307,012	1,404,381,840

Харилцагчдад олгосон хугацаа хэтэрсэн зээл болон урьдчилгаанд зөвхөн цөөн хэдэн хоногоор хугацаа хэтэрсэн зээлүүд орсон. Хугацаа хэтэрсэн зээлүүдийн насжилтын шинжилгээг дор үзүүлэв. Хугацаа хэтэрсэн зээлүүдийн дийлэнх нь үнэ цэнийн бууралтад ороогүй гэж авч үзсэн.

Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтад ороогүй санхүүгийн хөрөнгүүдийн насжилтын шинжилгээ

ГРУПП	30 хүртэл хоног мян.төг	31-60 хоног мян.төг	61-90 хоног мян.төг	91-ээс дээш хоног мян.төг	Нийт мян.төг
2011 оны 12 сарын 31-ний байдлаар					
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа					
Бизнесийн зээл	13,719,643	22,360,504	-	1,872,641	37,952,788
Бизнесийн жижиг зээл	6,550,675	692,848	1,597,287	4,352,748	13,193,558
Хэрэглээний зээл	2,865,815	441,403	90,106	1,455,436	4,852,760
Орон сууцны зээл	3,164,805	1,825,486	864,158	751,992	6,606,441
	26,300,938	25,320,241	2,551,551	8,432,817	62,605,547

37. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

37.2 Зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтад ороогүй санхүүгийн хөрөнгүүдийн насжилтын шинжилгээ (үргэлжлэл)

БАНК					
2011 оны 12 сарын 31-ний байдлаар	30 хүртэл хоног мян.төг	31-60 хоног мян.төг	61-90 хоног мян.төг	91-ээс дээш хоног мян.төг	Нийт мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа					
Бизнесийн зээл	13,719,643	22,360,504	-	1,872,641	37,952,788
Бизнесийн жижиг зээл	6,550,675	692,848	1,597,287	4,352,748	13,193,558
Хэрэглээний зээл	2,865,815	441,403	90,106	1,455,436	4,852,760
Орон сууцны зээл	3,164,805	1,825,486	864,158	751,992	6,606,441
	26,300,938	25,320,241	2,551,551	8,432,817	62,605,547
2010 оны 12 сарын 31-ний байдлаар					
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа					
Бизнесийн зээл	-	2,654,601	-	3,284,539	5,939,140
Бизнесийн жижиг зээл	2,806,062	1,545,344	1,954,785	3,558,440	9,864,631
Хэрэглээний зээл	1,769,288	184,363	170,095	937,119	3,060,865
Орон сууцны зээл	1,572,475	1,423,417	723,851	1,140,159	4,859,902
	6,147,825	5,807,725	2,848,731	8,920,257	23,724,538

Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтад ороогүй зээл, урьдчилгааны нийт дүнд Групп ба Банк нь 2011 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 120.65 тэрбум төгрөг (2010 онд 72.6 тэрбум төгрөг)-ийн үнэ бүхий хөрөнгийг барьцаанд авсан байна. Барьцаа хөрөнгийн төрлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 37.2 "Барьцаа хөрөнгө болон зээлийн бусад сайжруулалт"-аас харна уу.

Нөхцөл өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгүүдийн бүлэг тус бүрийн бүртгэлийн дүн

Нөхцөл өөрчлөгдсөн санхүүгийн хөрөнгүүдийн бүртгэлийн дүнг бүлэг тус бүрээр нь доорх хүснэгтэд үзүүлэв.

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа			
Бизнесийн зээл	18,564,736	18,564,736	17,156,519
Бизнесийн жижиг зээл	4,564,485	4,564,485	7,310,836
Хэрэглээний зээл	84,663	84,663	83,918
Орон сууцны зээл	179,389	179,389	610,944
	23,393,273	23,393,273	25,162,217

Үнэ цэнийн бууралтын үнэлгээ

Зээлийн үндсэн ба хүүгийн графикт төлбөр 90-ээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн, зээлдэгчийн мөнгөн урсгалд мэдэгдэхүйц хүндрэл учирсан, зээлийн үнэлгээ буурсан, зээлийн гэрээний анхны нөхцлүүд зөрчигдсөн эсэх зэрэг асуудлуудыг зээлийн үнэ цэнийн бууралтын шинжилгээ хийх явцад авч үздэг. Групп ба Банк нь үнэ цэнийн бууралтын шинжилгээг бүлгийн ба тусгайлан үнэлгээ гэж ялган авч үздэг.

Тусгайлан үнэлгээгээр үнэлсэн үнэ цэнийн бууралтын сан

Банк нь өндөр дүнтэй зээл, урьдчилгаанд нэг бүрчлэн зээлийн эрсдэлийн тохирох санг тооцдог. Зээлийн үнэ цэнийн бууралтын хэмжээг тодорхойлоход зээлдэгчийн бизнес төлөвлөгөөний тортвортой байдал, санхүүгийн хүндрэл тохиолдсон үед гүйцэтгэлээ сайжруулах чадвар, дампуурал тохиолдсон үед хүлээн авах төлбөрүүд болон хүлээгдэж буй ногдол ашгийн төлбөрүүд, санхүүгийн өөр бусад дэмжлэг авах боломжууд, барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнэ, хүлээгдэж буй мөнгөн урсгалын хугацаа зэргийг зайлшгүй авч үзлэг. Үнэ цэнийн бууралтаас үүсэх алдагдлын хэмжээг, гэнэтийн үйл явдлуудын улмаас илүү нухацтай авч үзэх шаардлагатай байгаагаас бусад тохиолдолд тайлант өдөр бүр үнэлж үзнэ.

Бүлгийн үнэлгээгээр үнэлсэн эрсдэлийн сан

Дангаараа чухал ач холбогдолгүй бүх зээл, урьдчилгаа ба дангаараа чухал ач холбогдолтой боловч тусгай үнэлгээгээр үнэ цэнэ бууралтын бодит нотолгоо гарч ирээгүй зээл, урьдчилгаануудыг бүлэглэн, бүлэг тус бүр дээр хүлээж болзошгүй алдагдлыг тооцно. Удирдлагын зүгээс бүлгийн үнэлгээг улирал бүр бүлэг тус бүрт ялгаатай шинжилгээнд үндэслэн хийнэ.

Бүлгийн үнэлгээнд тусгай үнэлгээгээр үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй боловч тэдгээрийг багтаасан багцын түвшинд оршин байх магадлалтай үнэ цэнийн бууралтыг тооцдог. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг бүлгийн алдагдлын түүхэн өгөгдөл, эдийн засгийн өнөөгийн байдал, алдагдал гарсан гэж таамаглаж буй үе болон уг алдагдлыг олж тогтоосон үе хоорондын ойролцоолсон хугацаа мөн үнэ цэнийн бууралттай гэж тогтоогдсоны дараа хүлээгдэж буй эргэн төлөгдөх эсвэл цуглуулан авах дүн зэрэг мэдээлэл дээр үндэслэн тогтоодог. Бүлгийн үнэлгээ нь нэг жилийн давтамжтайгаар хийгдэх ба Банкны удирдлага энэхүү давтамжийг өөрчлөх эсэхийг шийднэ. Зээлийн удирдлагын газар зээлийн үнэ цэнэ бууралтын сан нь Банкны нийт бодлоготой нийцэж байгаа эсэхт хяналт тавьж байна

Санхүүгийн баталгаа болон аккредитивүүдийн үнэ цэнэ бууралтыг зээлтэй адил үнэлж байгуулсан болно.

37.3 Төлбөрийн чадварын эрсдэл

Санхүүгийн хэвийн болон хүндрэлийн үед Банк харилцагчийн өмнө хүлээсэн төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй байх эрсдэлийг Төлбөрийн чадварын эрсдэл гэдэг. Ирээдүйн мөнгөн урсгал, өдөр тутмын төлбөрийн чадварт мониторинг хийх, шаардлагатай түвшинд хөрвөх актив барих, тогтвортой эх үүсвэр татах замаар банк энэхүү эрсдэлийг удирддаг. Төлбөрийн чадварын эрсдэлийн удирдлагад хүлээгдэж буй мөнгөн урсгалын үнэлэлт, шаардлагатай тохиолдолд нэмэлт эх үүсвэр татахад ашиглагдах өндөр зэрэглэлтэй барьцааг мөн хамруулдаг.

Банк бэлэн мөнгөний хүлээгдээгүй хүндрэлд орох үед зах зээлд маш хялбарханаар борлогдох төрөл бүрийн активуудаас бүрдэх багцыг барьж байдаг. Банк мөн төлбөрийн чадварын хүндрэлд орох үед ашиглах зорилгоор зээлийн шугамын эрх авсан байдаг. Үүнээс гадна харилцагчаас татсан хадгаламжийн 11% (2010 онд 5%)-тай тэнцүү дүнтэй бэлэн мөнгийг хууль ёсны дагуу Монголбанкинд (Төв банк) байршуулдаг. Төлбөрийн чадварыг зах зээлийн болон банктай холбоотой стресс хүчин зүйлсийг тооцсон янз бүрийн нөхцөл байдалд үнэлж удирддаг. Эдгээр төлбөрийн чадварын удирдлагуудаас зах зээлийн нөхцөл байдлын нөлөөг тусгасан цэвэр хөрвөх активыг харилцагчаас татсан эх үүсвэрт харьцуулсан харьцаанд лимит тавих нь банкны зүгээс хамгийн чухал удирдлага болдог. Бэлэн мөнгө, богино хугацаагаар банкинд байршуулсан харилцах, хадгаламж, түргэн борлогдох үнэт цааснаас нэг сарын дотор төлөгдөх ёстой бусад банкнаас татсан хадгаламж, зээлийг хасч цэвэр хөрвөх активыг гаргадаг. Энэ харьцаа тайлант жилийн хувьд дараах байдалтай байв. Үүнд:

	ГРУПП 2011 %	БАНК 2011 %	2010 %
12 сарын 31	38.9%	38.9%	51.2%
Тайлант жилийн дундаж	45.3%	45.3%	45.2%
Хамгийн их	50.5%	50.5%	51.2%
Хамгийн бага	38.9%	38.9%	38.1%

37. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

37.3 Төлбөрийн чадварын эрсдэл (үргэлжлэл)

Доорх хүснэгтэд 2011 оны болон 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Групп ба Банкны санхүүгийн өр төлбөрүүдийн дуусгавар хугацааг тэдгээрийн аливаа нэг хөнгөлөлтгүйгээр, гэрээний дагуу эргэн төлөх үүргүүд дээр үндэслэн харууллаа. Тодруулга 35 'Хөрөнгө болон өр төлбөрийн дуусгавар хугацааны шинжилгээ'—нээс эдгээр өглөгүүдийн хүлээгдэж буй дуусгавар хугацааг харна уу. Урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр төлөгдөх ёстой өр төлбөрийн хувьд уг мэдэгдэл тэр даруй ирсэн гэж тооцов. Гэсэн хэдий ч, Групп ба Банк нь харилцагчдын дийлэнх нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ хийхгүй гэсэн хүлээлттэй байгаа ба хадгаламжийн татан авалтын түүхэн өгөгдлүүд дээр үндэслэн Банкны хүлээж буй мөнгөн урсгалыг хүснэгтэд тусгаагүй болно.

ГРУПП						Дискаунтлаагүй санхүүгийн нийт өр төлбөр мян.төг
Санхүүгийн өр төлбөрүүд 2011 оны 12 сарын 31	Хугацаагүй мян.төг	3 – 6 сар мян.төг	6 – 12 сар мян.төг	1 – 5 жил мян.төг	5 жилээс дээш мян.төг	өр төлбөр мян.төг
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	9,311,184	-	-	-	-	9,311,184
Харилцагчдын харилцах, хадгаламж	1,353,605,570	234,781,932	270,818,516	18,188,979	-	1,877,394,997
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд	-	-	8,245	2,562,340	-	2,570,585
Зээлээр авсан эх үүсвэр	1,953,392	2,494,610	2,590,217	21,564,612	38,569,385	67,172,216
Хоёрдогч өглөг	119,631	547,154	15,491,370	37,930,935	-	54,089,090
Бусад пассив (хойшлогдсон орлого орохгүй)	21,202,401	369,343	3,942,329	2,647	-	25,516,720
Нийт	1,386,192,178	238,193,039	292,850,677	80,249,513	38,569,385	2,036,054,792

БАНК						Дискаунтлаагүй санхүүгийн нийт өр төлбөр мян.төг
Санхүүгийн өр төлбөрүүд 2011 оны 12 сарын 31	Хугацаагүй мян.төг	3 – 6 сар мян.төг	6 – 12 сар мян.төг	1 – 5 жил мян.төг	5 жилээс дээш мян.төг	өр төлбөр мян.төг
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	9,311,184	-	-	-	-	9,311,184
Харилцагчдын харилцах, хадгаламж	1,353,707,061	234,781,932	270,818,516	18,188,979	-	1,877,496,488
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд	-	-	8,245	2,562,340	-	2,570,585
Зээлээр авсан эх үүсвэр	1,953,392	2,494,610	2,590,217	21,564,612	38,569,385	67,172,216
Хоёрдогч өглөг	119,631	547,154	15,491,370	37,930,935	-	54,089,090
Бусад пассив (хойшлогдсон орлого орохгүй)	21,202,401	369,343	3,942,329	2,647	-	25,516,720
Нийт	1,386,293,669	238,193,039	292,850,677	80,249,513	38,569,385	2,036,156,283

БАНК						Дискаунтлаагүй санхүүгийн нийт өр төлбөр мян.төг
Санхүүгийн өр төлбөрүүд 2010 оны 12 сарын 31	Хугацаагүй мян.төг	3 – 6 сар мян.төг	6 – 12 сар мян.төг	1 – 5 жил мян.төг	5 жилээс дээш мян.төг	өр төлбөр мян.төг
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	70,762,777	6,727,307	4,025,713	-	-	81,515,797
Харилцагчдын харилцах, хадгаламж	898,566,566	185,758,421	262,309,950	3,596,516	-	1,350,231,453
Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд	-	-	-	1,506,132	-	1,506,132
Зээлээр авсан эх үүсвэр	1,721,579	1,126,219	2,061,345	17,569,376	10,625,097	33,103,616
Хоёрдогч өглөг	494,296	465,154	930,308	49,608,196	-	51,497,954
Бусад пассив (хойшлогдсон орлого орохгүй)	13,494,041	477,002	2,706,749	-	-	16,677,792
Нийт	985,039,259	194,554,103	272,034,065	72,280,220	10,625,097	1,534,532,744

Доорх хүснэгтэнд Групп ба Банкны хүлээж болзошгүй өр төлбөр болон үүргүүдийг гэрээт эргэн төлөгдөх хугацаагаар нь харуулав.

ГРУПП						
2011 оны 12 сарын 31	Хугацаагүй мян.төг	3 – 6 сар мян.төг	6 – 12 сар мян.төг	1 – 5 жил мян.төг	5 жилээс дээш мян.төг	Нийт мян.төг
Болзошгүй өр төлбөр	99,320,919	7,022,333	19,709,515	2,211,867	-	128,264,634
Үүрэг	473,060	12,887,701	11,102,114	5,341,163	-	29,804,038
Нийт	99,793,979	19,910,034	30,811,629	7,563,030	-	158,068,672

БАНК						
2011 оны 12 сарын 31	Хугацаагүй мян.төг	3 – 6 сар мян.төг	6 – 12 сар мян.төг	1 – 5 жил мян.төг	5 жилээс дээш мян.төг	Нийт мян.төг
Болзошгүй өр төлбөр	99,320,919	7,022,333	19,709,515	2,211,867	-	128,264,634
Үүрэг	473,060	12,887,701	11,102,114	5,341,163	-	29,804,038
Нийт	99,793,979	19,910,034	30,811,629	7,563,030	-	158,068,672

БАНК						
2010 оны 12 сарын 31	Хугацаагүй мян.төг	3 – 6 сар мян.төг	6 – 12 сар мян.төг	1 – 5 жил мян.төг	5 жилээс дээш мян.төг	Нийт мян.төг
Болзошгүй өр төлбөр	61,298,639	11,161,552	9,760,020	1,483,775	-	83,703,986
Үүрэг	15,714	8,518,961	12,700,887	5,906,502	-	27,142,064
Нийт	61,314,353	19,680,513	22,460,907	7,390,277	-	110,846,050

37.4 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь хүү, ханш зэрэг зах зээлийн хувьсагчуудад орсон өөрчлөлтөөс болж санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн урсгал өөрчлөгдөх эрсдэлийг хэлнэ. Групп ба Банк нь энэ төрлийн эрсдэлийг VaR болон мэдрэмжийн шинжилгээ хийх замаар хянаж, удирддаг. Гадаад валютын төвлөрөлөөс бусдаар зах зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц төвлөрөл байхгүй байна.

Хүүгийн эрсдэл

Хүүгийн аливаа хөдөлгөөн нь санхүүгийн хэрэгсэлийн үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөө үзүүлж болохоос хүүгийн эрсдэл үүсдэг. Тодорхой хугацаанд байж болох хүүгийн зөрүүгийн хязгаарлалтыг ТУЗ-аас тогтоож өгдөг. Хүүгийн нээлттэй позицуудыг өдөр тутам хянадаг бөгөөд тогтоосон хязгаарт байлгахын тулд хэджинг буюу хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлдэг.

Доорхи хүснэгт нь бусад бүх нөхцөл байдал өөрчлөгдөөгүй байхад хүүгийн боломжит хөдөлгөөн банкны орлого, үр дүнгийн тайланд хэрхэн нөлөөлж байгааг харуулж байна.

Орлогын тайлангийн мэдрэмтгий байдал нь 2011 болон 2010 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх хөвөгч хүүтэй санхүүгийн актив болон пассивийн хүүний түвшний өөрчлөлтийг даган өөрчлөгдөх нэг жилийн цэвэр хүүний орлогын өөрчлөлт дээр суурилсан байна.

37. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

37.4 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Хүүгийн эрсдэл (үргэлжлэл)

Валютын нэгж ГРУПП	Суурь цэгийн өөрчлөлт	Хүүгийн цэвэр орлогын мэдрэмж мян.төг
2011 оны 12 сарын 31		
Доллар	+120	(679,851)
Төгрөг	+120	(96,926)
Доллар	-120	679,851
Төгрөг	-120	96,926
БАНК		
2011 оны 12 сарын 31		
Доллар	+120	(679,851)
Төгрөг	+120	(96,926)
Доллар	-120	679,851
Төгрөг	-120	96,926
БАНК		
2010 оны 12 сарын 31		
Доллар	+120	(626,485)
Төгрөг	+120	(441,414)
Доллар	-120	626,485
Төгрөг	-120	441,414

Ханшийн эрсдэл

Гадаад валютын ханшийн хөдөлгөөн нь Групп ба банкны санхүүгийн төлөв байдал, мөнгөн урсгалд нөлөөлж болох эрсдэлд Групп ба Банк өртдөг. Групп ба Банкны удирдлагаас өдөртөө байж болох болон хоног дамжиж болох нээлттэй позицийн хязгаарлалтыг нэг валют (ихэвчлэн америк доллараар) болон нийт валютын нийлбэр дүнгээр тогтоон өдөр болгон хянаж явдаг байна..

ТУЗ-өөс гадаад валютын багцын тухайд хүлээж болох эрсдэлийн хязгаарлалтуудыг тогтоож өгсөн. 99%-ийн магадлалтайгаар банкны нээлттэй позицйг үнэлэх, Монголбанкны ханшийн өөрчлөлтийг хэд хэдэн үзүүлэлт болон төсөөлөлтэйгээр авч үзэн, үүнээс учирч болох эдийн засгийн алдагдлыг тооцоолох VaR аргыг Банк хэрэглэж байна. VaR нь тодорхой цаг хугацааны хүрээнд, тодорхой магадлалтайгаар Групп ба Банкны гадаад валютын багцын ашиггүй хөдөлгөөн, өөрчлөлтийг тооцох замаар банкинд учирч болох санхүүгийн эрсдэлийг тодорхойлох аргачлал юм.

VaR аргын зорилго, сул талууд

Өнгөрсөн нэг жилийн мэдээлэл дээр суурилан гадаад валютын багцын боломжит өөрчлөлтийг тооцоолох зорилгоор банк VaR-ын Делта нормал, Монте Карло, Түүхэн загварчлалын аргуудыг хэрэглэж байна. VaR аргачлал нь зах зээлийн ердийн нөхцөл байдалд гадаад валютын эрсдэлийг тооцоход зориулагдсан. Делта нормал, Монте Карло, Түүхэн загварчлалын аргуудад хэвийн зах зээлийн орчинд нөлөөлөгч эрсдэлийн хүчин зүйлсийн аливаа өөрчлөлт нь хэвийн тархалттай гэж үздэг. Эдгээр хоёр VaR арга нь тодорхой дутагдалтай талуудтай учир нь эдгээр аргууд нь гадаад валютын түүхэн корроляци, хэлбэлзэлд үндэслэдэг ба ирээдүйн валютын ханшийн өөрчлөлт хэвийн тархалттай гэж таамагладаг.

VaR арга нь түүхэн өгөгдөлд үндэслэдэг болохоор эрсдэлийн хүчин зүйлсийн ирээдүйн өөрчлөлтийг сайн тусгаж чадахгүй байх талтай бөгөөд хэвийн тархалтын таамаглалд эрсдэлийн хүчин зүйлсийн өөрчлөлт нь нийцээгүй

тохиолдолд гадаад валютын ханшны их хэмжээний өөрчлөлтийг дутуу үнэлж болох талтай. VaR нь эрсдэлийн хүчин зүйлсийн хоорондын хамаарал, эрсдэлийн хүчин зүйлсүүдэд тавьсан таамаглалаас шалтгаалж эрсдэлийг дутуугаар эсвэл илүүгээр үнэлэх боломжтой. Гадаад валютын позици өдрийн турш өөрчлөгддөг боловч VaR нь зөвхөн өдрийн төгсгөлд хаагдсан багцын эрсдэлийг хэмждэг ба 99% итгэх завсараас хэтэрч алдаж болзошгүй алдагдлын дүнг тооцож чадахгүй.

VaR аргын зорилго, сул талууд (үргэлжлэл)

Практикт гадаад валютын бодит үр дүнгүүд VaR тооцооллоос зөрдөг. Тухайлбал, хэвийн бус зах зээлийн нөхцөлд тооцоолол бодит ашиг алдагдалтай уялдаж чаддаггүй. VaR загварын бодит байдалтай нийцэж буйг тодорхойлохын тулд бодит үр дүнгүүдийг тодорхой хугацааны /гурван сар/ давтамжтайгаар VaR тооцооллолтой харьцуулж үзэн Backtesting хийдэг. Зах зээлийн онцгой хүндрэлийн нөлөөг Банк даван туулж чадах эсэхэд баталгаатай байх үүднээс банк гадаад валютын багцдаа тогтмол стресс тест хийдэг.

VaR таамаглалууд

Банк 99%-ийн итгэх завсар ашиглан VaR тооцдог тул гадаад валютын нээлттэй позиц нэг өдрийн турш өөрчлөгдөхгүй гэж үзвэл боломжит алдагдлын хэмжээ VaR-аас их байх бараг боломжгүй. Нэг өдрийн хугацаанд 99%-ийн итгэх завсартай VaR гэдэг нь аливаа 100 өдрийн бодит ашиг алдагдлын дүн тооцоолж гаргасан VaR-с дунджаар нэг удаа их байхыг илтгэнэ.

VaR нь банкны гадаад валютын эрсдэлийн салшгүй хэсэг тул гадаад валютын нээлттэй позицуудад VaR лимит тогтоосон бөгөөд эдгээр лимитүүдтэй нээлттэй позицийн дүнг өдөр тутам харьцуулж хянаж байдаг. Загварт Монголбанкны гадаад валютын ханшны эрсдэлийг VaR аргаар хэмжих аргачлалын таамаглалуудаас нэгтгэж өгсөн байдаг.

ГРУПП	Делта нормал мян.төг	Монте Карло мян.төг	Түүхэн загварчлал мян.төг
2011 - 12 сарын 31	94,273	82,478	146,194
2011 - Өдрийн дундаж	104,820	107,649	141,578
2011 - Хамгийн их	339,147	362,101	477,653
2011 - Хамгийн бага	8,632	9,046	11,103

БАНК	Делта нормал мян.төг	Монте Карло мян.төг	Түүхэн загварчлал мян.төг
2011 - 12 сарын 31	94,273	82,478	146,194
2011 - Өдрийн дундаж	104,820	107,649	141,578
2011 - Хамгийн их	339,147	362,101	477,653
2011 - Хамгийн бага	8,632	9,046	11,103

БАНК	Делта нормал мян.төг	Монте Карло мян.төг	Түүхэн загварчлал мян.төг
2010 - 12 сарын 31	129,230	133,856	160,262
2010 - Өдрийн дундаж	147,612	148,882	190,809
2010 - Хамгийн их	342,395	347,259	408,306
2010 - Хамгийн бага	43,671	44,471	53,374

Урьдчилгаа төлбөрийн эрсдэл

Урьдчилгаа төлбөрийн эрсдэл нь харилцагч эсвэл гэрээнд оролцогч тал төлбөрөө урьдчилж төлөх, эсвэл төлбөрөө хугацаанаас өмнө хийхийг хүссэнээс Групп ба Банк алдагдалд орох эрсдэлийг хэлнэ. Тухайлбал, тогтмол хүүтэй орон сууцны зээлийн хувьд хүү буурах үед зээлдэгчид зээлээ урьдчилж төлснөөс энэ хэлбэрийн эрсдэл үүсдэг.

Групп ба Банк өөрийн дотооддоо боловсруулсан загвар ашиглан хүүгийн цэвэр орлогодоо урьдчилгаа төлбөрийн янз бүрийн нөлөөллийг тооцоолдог.

37. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

37.4 Зах зээлийн эрсдэл (үргэлжлэл)

Урьдчилгаа төлбөрийн эрсдэл (үргэлжлэл)

Өнгөрсөн жилийн урьдчилгаа төлбөрийн түвшинг суурь болгон авч бусад бүх хувьсагчид тогтмол гэж үзэн жилийн эхэнд төлөгдөхөөр тооцон үзэхэд татварын өмнөх жилийн ашигт дараах хэлбэрийн нөлөөлөл гарч байна.

	ГРУПП	БАНК	
	Хүүгийн цэвэр орлогод үзүүлэх нөлөөлөл 2011 мян.төг	Хүүгийн цэвэр орлогод үзүүлэх нөлөөлөл 2011 мян.төг	Хүүгийн цэвэр орлогод үзүүлэх нөлөөлөл 2010 мян.төг
Харилцагчаас авах зээл ба урьдчилгаа			
Бизнесийн зээл	(1,320)	(1,320)	(880)
Бизнесийн жижиг зээл	(493)	(493)	(350)
Хэрэглээний зээл	(328)	(328)	(109)
Орон сууцны зээл	(421)	(421)	(104)
	(2,562)	(2,562)	(1,443)

Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь системийн доголдол, хүний алдаа, залилан болон бусад гадаад хүчин зүйлээс банкинд учирч болох алдагдлын эрсдэлийг хэлнэ. Хяналт сул үед үйл ажиллагааны эрсдэл нь банкны нэр хүндэд хохирол учруулах, хууль зохицуулалтын асуудалд оруулах, улмаар санхүүгийн алдагдалд хүргэх болно. Групп ба Банк хэдийгээр үйл ажиллагааны эрсдэлийг бүрэн арилгах бололцоогүй ч хяналт, мониторинг сайжруулах замаар энэ төрлийн эрсдэлийг удирдаж болно. Эрхийн хэм хэмжээг зөв тогтоох, боловсон хүчний сургалт, боловсрол, дотоод хяналт зэрэг нь хяналтын арга хэмжээнд орно.

38. ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

Групп ба Банк бизнесийн салшгүй эрсдэлийг өөрийн хөрөнгөдөө тулгуурлан үр ашигтай удирддаг. Бусад арга хэмжээнүүдээс гадна Монголбанкнаас тогтоосон дүрэм, харьцаануудыг ашиглах замаар банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хянадаг.

Өнгөрсөн жилийн турш Групп ба Банк нь өөрийн хөрөнгөд хөндлөнгөөс тавьдаг бүх шалгууруудыг бүрэн хангаж ажилласан.

Капиталын удирдлага

Групп ба Банкны капиталын удирлагын үндсэн зорилго нь хөндлөнгөөс тавигдсан зохистой харьцааны шалгууруудыг биелүүлэх ба бизнесээ дэмжиж хувь нийлүүлэгчдийн үнэлэмжийг ихэсгэхийн тулд зээлийн эрсдэлийн чансааг хадгалахад оршдог.

Групп ба Банк өөрийн хөрөнгийн бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдал болон үйл ажиллагааных нь эрсдэлийн шинж чанарт орсон өөрчлөлтүүдийг харгалзан капиталын бүтэцдээ залруулга хийдэг байна. Банк капиталынхаа бүтэцээ хадгалах эсвэл тохируулахын тулд хувь нийлүүлэгчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулах, хувь нийлүүлэгчид хөрөнгийг нь эргүүлэн төлөх, шинээр өөрийн хөрөнгийн хэрэгсэл гаргах, эсвэл өөрийн хөрөнгөд уялдан үнэт цаас гаргах зэрэг арга замуудыг ашигладаг байна.

Зохицуулалттай капитал

Монголбанкнаас арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хамгийн багадаа 6% (2010 онд 6%), өөрийн хөрөнгө эрсдлээр жигнэсэн активын харьцааг 12% (2010 онд 12%)-иас доошгүй байхаар тогтоосон байдаг бөгөөд эдгээр харьцаа нь эрсдлийн уг шинж чанараар нь тохируулсан актив болон нийт капиталыг авч тооцоологдсон байдаг. Банкны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өөрийн хөрөнгийн зохистой харьцааг дараах хуудсанд үзүүлэв:

	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
Өөрийн хөрөнгийн харьцаа	9.83%	9.83%	8.81%
Эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн харьцаа	13.25%	13.25%	13.44%
	ГРУПП 2011 мян.төг	БАНК 2011 мян.төг	2010 мян.төг
I зэрэглэлийн хөрөнгө			
Дүрмийн сан	24,591,543	24,591,543	21,934,142
Нэмэгдэж төлөгдсөн капитал	22,344,874	22,344,874	-
Хуримтлагдсан ашиг	90,884,373	90,883,721	62,161,346
Өөрийн хөрөнгийн бусад хэсэг	2,393,910	2,393,910	(297,935)
Нийт I зэрэглэлийн хөрөнгийн дүн	140,214,700	140,214,048	83,797,553
II зэрэглэлийн хөрөнгө			
Хоёрдогч өглөг	48,872,950	48,872,950	43,976,450
Нийт капитал/капиталын суурь	189,087,650	189,086,998	127,774,003

12 сарын 31-ний байдлаар эрсдэлээр нь жигнэсэн активуудыг эрсдэлийн ангилал тус бүрээр үзүүлбэл:

	ГРУПП		БАНК	
	2011	Эрсдэлээр жигнэсэн мян.төг	2011	Эрсдэлээр жигнэсэн мян.төг
%	Хөрөнгө мян.төг		Хөрөнгө мян.төг	
0	498,208,082	-	498,208,082	-
20	262,457,813	52,491,563	262,457,813	52,491,563
50	269,952,860	134,976,430	269,952,860	134,976,430
100	1,229,294,576	1,229,294,576	1,229,292,275	1,229,292,275
150	6,696,078	10,044,117	6,696,078	10,044,117
Нийт	2,266,609,409	1,426,806,686	2,266,607,108	1,426,804,385

39. ХАРЬЦУУЛСАН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тайлант жилийн толилуулгатай нийцүүлэх үүднээс зарим харьцуулсан үзүүлэлтүүдийг дахин ангилсан:

40. МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ОРЧУУЛГА

Эдгээр санхүүгийн тайлангуудыг мөн Англи хэл дээр бэлтгэсэн болно. Монгол, Англи хувиудын хооронд зөрүү ялгаа гарах тохиолдолд Англи хувийг дагах болно.

